

**ТӨВДИЙН НУУЦ
ТАРНИЙН ҮНДЭС**

Удиртгал

Хүн төрөлхтний оюун санааны хөгжилд Төвдийн соёлын уламжлалын ач холбогдол бол асар их бөгөөд өөрөөр хэлбэл, Төвд орон нь өнгөрсөн үеийн эртний соёл иргэншилтэй биднийг холбож өгдөг сүүлчийн амьд хэсэг юм гэж хэлж болох билээ. Египет, Месопотами, Грек ба инк, майя нарын далд нууц шүтлэгүүд нь эртний энэ их соёл иргэншлийн мөхлийн улмаас бөхөж доройтсон тул өнөө бидний үед бидэнд танигдаж мэдэгдэхээсээ нэгэнт өнгөрчээ.

Эртний Энэтхэг, Хятадын соёл иргэншлийн хувьд урлаг, утга зохиолын маш олон тооны бүтээл туурвилд тод томруун дүрслэн үзүүлсэн байдаг. Тус ард түмнүүдийн оюуны соёл дахь “хурц оч” нь орчин үеийн сэтгэлгээний “үнсэн дунд” ч хааяа гялсхийдэг юм. Гагцхүү, тэдний өв соёлын ололт амжилт нь нууцлаг байсан бөгөөд мөн бусад ард түмнүүдийн соёлын нөлөө хүчтэй байснаас, тэдгээрийн үнэн бодит байдлыг онцлон тэмдэглэх боломжгүй буюу анхдагч жинхэнэ мөн чанарыг танин мэдэхэд маш хэцүү байх явдал олонтоо тохиолддог билээ.

Төвд орон бол өөрийн байгалын жам ёсны тусгаарлагдмал, халдашгүй байдлынхаа ачаар (тэр тусмаа сүүлийн хэдэн зуун жил улс төрийн онцгой нөхцөл байдлаас болж бүр ч хаагдмал байгаа) өнө эртнийхээ амьд уламжлалыг зөвхөн өвлөж авсанаар зогссонгүй, түүнийгээ хадгалж уламжлан үлдсэн бөгөөд хүний сэтгэл санаан дахь нууц хүчний талаархи мэдлэг болон Энэтхэгийн гайхамшигт мэргэдийн нууц сургаал, тэдгээрийн Агуу их ололт амжилтыг хэзээ ямагт хамгаалсаар ирсэн ард түмэн гэдгээрээ онцгой алдрыг хүртэх ёстой юм.

Гэвч, ертөнц дахиныг бүхэлд нь хамарч, орвонгоор нь хувиргасан хар салхи мэт том үйл явдлуудын уршгаар, газар дэлхий дээрхи бүх улс үндэстнүүдийн амьдралд асар их өөрчлөлт гарсан бөгөөд цаашилбал, Төвд орныг ч энэ хар шуурга дайрч олон зуун жилийн халдашгүй байдлаасаа татгалзахыг хэрвээ хүчээр хүлээлгэсэн бол, тус орны оюун санааны

агуу их ололт амжилт нь үүрд устаж үгүй болох байсан юм. Хэрвээ тэгсэн бол тус орон нь бүх хүн төрөлхтний хувьд харьцангуй өндөр соёл иргэншилт ард түмэн буюу ирээдүйн соёлын сан хөмрөгийг бүрдүүлэгч гол хэсэг хэмээн тооцогдохгүй байх байсан билээ.

Орчин үеийн Төвд орны оюуны агуу их төлөөлөгчдийн нэг, дотоод гэгээрлийг номлогч Томо гэвш рэнбуучий бол ирээдүйг урьдчилан харж чадсан бөгөөд тэрээр арван хоёр жилийн турш бясалгал үйлдэж байсан уулан дахь аглаг зэлүүд газраа орхиж, Төвд оронд нууцлагдан хадгалагдаж байсан тэрхүү оюуны үнэт сан хөмрөгийг нээх цаг нэгэнт болсон гэж зарлан тунхагласан билээ. Чухамхүү, яг одоо хүн төрөлхтөнд хариуцлагатай шийдвэрийг гаргах нь зайлшгүй болоод байгаа ба үүний тулд, дараах хоёр замын аль нэгийг нь сонгох хэрэгтэй болоод байна.

Нэгдүгээрт, бидний өмнө, байгалын хүчнүүдэд хяналт тавих аргаар “засаглал тогтоох” буюу “ертөнцийг боолчлох”, өөрөөр хэлбэл, өөрсдийгээ устгахад хүргэх зам, хоёрдугаарт, өөрт буй хүчинд хяналт тавих аргаар “гэгээрэлд хүрэх зам” буюу “өөрсдийгээ төгс төгөлдөржүүлэн” аврагдалд хүргэх зам” болно. Хоёр дахь замыг заагч Бодхисадва марга-г (Бодьсадвагын мөр) бодит зүйл болгох нь Томо гэвш рэнбуучийн амьдралын гол зорилго байлаа.

Энэхүү Агуу их багш ламтаны амьд жишээний нэгэн болох бээр зохиогчид оюун санааны амьдралын дээдийн дээд урам өгч, Төвдийн нууцад нэвтрэх шидэт хаалгыг нээж өгсөн төдийгүй энэхүү номын зохиогч нь дээр дурдсан ламтанаас хорин таван жилийн өмнө анх удаа Бурханы шашны сахил хүртсэн ажээ. Түүнчилэн, тэрхүү амьд жишээ нь Төвдийн нууц мэдлэг, ухааныг эзэмшсэн нэгэн байсан бөгөөд уг мэдлэг ухааныг үгээр өгүүлж болох тэр хир хэмжээнд орчлон ертөнцийн бүх хүмүүст дамжуулахыг даалгасан байна. Аливаа үйл ажиллагаанд дутагдал доголдол байдаг ч гэсэн Анагарика Говинда бол бусад эрэлхийлэгч хүмүүст туслах оролдлого хийснээрээ, өөрөөсөө бусдыг дээдэд үзэгч хүмүүст олгодог “гүрү” хэмээгч алдрыг зүүх гавъяатай хүн юм. Ийнхүү түүнтэй хамт энэ номыг зохиогч нь түүний анхны багшийг таалал төгссөний дараа Агуу их багш ламаа дурсан санаж, түүний байр сууриар тарьж соёолуулсан үрийг нь ургуулах гэсэн хүчин

чармайлт гаргасан нь энэхүү бүтээл ажээ. Ийнхүү зохиогч маань өөрийн бүх багш нартаа энэхүү бүтээлээрээ гүн талархалаа илэрхийлэн хүндэтгэн ёсолж байна.

Бүхнийг ухааруулан гэгээрүүлэгч, түүний өлмий бат оршиг.

УМ МУНИ МУНИ МАХА МУНИ ШАКИА МУНИ ЕЙ СУУХАА

Касар Дэви Ашрам, Гималайн Кумаон, Энэтхэг,

Бурхан багш Нирваан болсны дараах 2500 оны 5-р сар

(1956 оны 10-р сар)

Нэгдүгээр бүлэг

“УМ”

Өгүүлэхүйн хүч ба үгийн ид шид

“Үзэгдэхүй бүхэн үл үзэгдэхүйтэй

Сонсогдохуй бүхэн үл сонсогдохуйтай

Хүртэхүй бүхэн үл хүртэхүйтэй

Ухагдахуй бүхэн үл ухагдахуйтай

сүлэлдэн нэгдмой.”

Новалис / Германы гүн ухаантан, яруу найрагч /

Үг - хэмээгч нь оюун ухаан, үйлдэхүйн үр дүнгийн үл мөр буюу тодруулбал, ухаан гүйцэшгүй алс тэртээгээс өнөөг хүртэл, түүнчилэн ухаан гүйцэмгүй алс тэртээ рүү замаа тэмтрэн яваа мэдрэхүйн эцэс төгсгөлгүй дараалсан гүүр билээ. Үг бол “үл сонсогдохуйтай сүлэлдсэн сонсогдохуй” бөгөөд оюун санааны хязгаар дахь оршихуйгаас урган гарсан сэтгэлгээний бодит боломж, түүний илрэх хэлбэрүүд юм.

Тийм ч учраас, үгсийн мөн чанар нь хоромхон зуурын утгаараа ч, утга санааг илэрхийлэх зууч мэт ач холбогдлынхоо харьцангуй зэрэглэлээрээ ч шавхагдашгүй юм. Гэвч үгс нь, хөгжмийн айзам хэмнэл хүнд төсөөлөн бодох ойлголт өгдөг ч, бас ойлголт өгч чадахгүй чанарыг нэгэн зэрэг агуулдагын адил шинж чанарыг үзүүлдэг бөгөөд ер нь бүхнийг үгээр болон үг хэллэгийн бусад зуучаар тодорхойлон өгүүлэх аргагүй юм. Чухамхүү энэхүү оновчгүй чанар нь бидний гүн гүнзгий мэдрэхүйг сэрээж, нууцлаг ахуйг маань өргөмжлөн, түүнийг бусадтай хамт дуурьсуулдаг билээ.

Яруу найргийн хүмүүнд нөлөөлөгч увидас бол үгийн дээрх онцлог нь яруу айзам хэмнэлтэй нөхцөлдөн зохицсоны илрэл ажээ. Энэхүү ямар нэг ер бусын чанар нь бидэнд үгийн бодит агуулгаас ч илүүтэйгээр нөлөө үзүүлэх чадвартай ба цаашилбал, бүх учир

шалтгааны ухааныг тайлах чадвар бүхий оюун ухаанаас ч илүү хүчтэй нөлөөг үзүүлдэг юм. Агуу их уран илтгэгчдийн олонхи нь юу ярьснаараа бус, яаж ярьснаараа алдар хүндийг олдог билээ. Хэрвээ хүмүүсийг учир шалтгааны болон шинжлэх ухааны дүгнэлтийн арга хэрэгслээр итгүүлж чаддагсан бол, гүн ухаантнууд хүн төрөлхтөнийг бараг бүхлээр нь өөрсдийнхөө үзэл санаанд оруулж чадах байсан биз ээ.

Нөгөө талаар, дэлхийн аугаа их шашнуудын ариун судруудтай харьцуулж үзэхэд, суу билэгт эрдэмтэн, гүн ухаантнуудын бүтээлүүд нь хэдийгээр хэмжээ том, хэлбэр агуу байсан ч нийтэд хүртээлтэй байгаагүйн учир үүнд л оршино. Иймээс бид эдгээр ариун судрын ид шид нь үгийн увидаст нуугдаж байна гэж нотолж болно.

Хэл яриа буй болохдоо, хүн төрөлхтөнийг төрүүлсэн гэж үздэг. Үг бүр нь дотоод ба гадаад урам зоригтой холбоотой сэтгэл хөдлөлийн дуун илрэл байжээ. Хэл үүсэн төлөвших урт удаан үйл явцын үндэс нь агуу их бүтээлч чармайлт байсан бөгөөд энэ чармайлтын ачаар хүмүүн нь адгууснаас ялгаран гарч чадсан юм.

Хэрвээ урлагийг хүмүүний туршлагаас дамжин гарч бодитой болсон бүтээл, түүний илэрхийлэл гэж нэрлэвэл, хэл буй болсныг соёлын агуу их ололт хэмээн нэрлэж болно. Үг бүхэн нь анхандаа бодит байсан дуу авиа, хүмүүний сэтгэл санааны амьд илрэл болон хувирч байсан хүчнүүдийн төв нь байсан юм. Ийнхүү авиа бүтэх үйл явцад “Үг” ертөнцийг эзэлж, шинэ хэмжүүр нээн, ахуйн үлэмж дээд цогцыг нээн илрүүлсэн билээ. Ингэхдээ соёлжин иргэншсэн бодгалын ухамсар нь адгуусны ухамсраас ялгарах тэр хэмжээгээр хүмүүн төрөлхтөний өнөөгийн төрх үүсэн хэлбэржжээ.

Оршихуйн үлэмж дээд бодгалыг мэдрэх нь тайлбарлаж ч боломгүй гүн нууцат тодорхой мэдрэмжтэй холбоотой. Түүнийг ямар нэг юмтай харьцуулж болохгүй төдийгүй сэтгэхүй, ургуулан бодохуйд аль нэг зүйлтэй холбож ч болохгүй юм. Гэвч ийм мэдрэмж бол бидний мэдрэхүй, хүртэхүй, харахуй, сонсохуй, үнэрлэхүйд хүртээмжтэй бүхнээс харьцангуй бодитой байдаг. Учир нь эдгээр мэдрэмж нь дээр дурьдсанаас бусад бүх мэдрэмжийг агуулдаг бөгөөд уг шалтгаанаар тэдгээрийг аль нэгэнтэй адиалгах боломжгүй

юм. Гэвч энэхүү билэг тэмдгүүд нь аяндаа үүсээгүй төдийгүй, хүмүүний оюун ухааны хамгийн гүнзгий хүрээнээс тасран гарсан илэрхийлэл ч бас биш юм.

“Орчлон ертөнц болон байгал дахь амьдралын дээд хэлбэрүүд нь лүндэн буулгагчийн үзэгдэхүйд биеллээ олж, дуучны дуу хоолойд авиа болон дуурьсаж, бидний өмнө нүдэнд харагдаж, чихэнд сонсогдох цэвэр тодорхой дүр, нээлттэй дуу хоолой болон цогцлон илэрч, бутран унадаг.

Тэдгээрийн оршин тогтнол нь зөнч - яруу найрагчийн гэгээн хүчний шинж тэмдэг юм. Зөнч мэргэний амнаас нисэн гарсан үг бол ер бусын хэл яриаг үүсгэх шабда юм. Энэ бол мантра / “тарни”- ийн өөр нэг дуудлага / буюу сэтгэлгээний дүр төлөвийг бүтээгч дотоод хүч бөгөөд өөрийн цэвэр мөн чанарт байгаа зүйл юу байна, тэр бүхнийг эзэмдэх эрх мэдэл билээ.

Тийм ч учраас энэ бол танин мэдэхүй юм. Энэхүү танин мэдэхүй нь зөв буруу төсөөллөөс үлэмж давуу ахуйн үнэн, сэтгэхүй ухамсрын чанад орших бодит ахуй мөн. Энэ бол цэвэр бөгөөд энгийн танин мэдэхүй, оршихуйн танин мэдэхүй буюу “веда” / санскрит судрын нэр боловч энд “мэдлэг” гэсэн шууд утгаар оруулжээ / билээ. Энэ нь танин мэдэж буйг ч, танигдан мэдэгдэж буйг ч нэгэн зэрэг шууд ухамсарлахуй юм. Тэрхүү ухамсарлахуй нь аливаа оюун санааны дотоод хүчний чанарт хэрхэн яаж илрэн гарч ирсэн шиг үгээр болон үзэгдэхүйгээр зөнч яруу найрагч нь эрх мэдэлтэй болдог шиг, бүхий л үеийн туршид бодит байдал нь бурханы дүртэй ч бай, үгийн тоглоом хэлбэртэй ч бай, шидэт хүчийг бодит байдалд хүргэгч мантрын үгийг хэрхэн ашиглахыг мэддэг байсан хүмүүс хаана ч тааралдахгүй байх байсан биз ээ.

Мантра гэдэг үг нь: “ман”- сэтгэх, “тра”- үг бүтээгч зэмсэг гэсэн хоёр үенээс бүтэх бөгөөд “сэтгэхүйн зэмсэг” гэсэн утгатай юм. Өөрөөр хэлбэл, “Оюуны дүр зураглалыг бүтээгч” хэмээн ойлгож болох ба өөрийн авиа дуудлагын хамт, түүний агуулга нь бодит байдлын бүрэн дүүрэн тусгал болж чадна. Мантра бол оюун ухаан эсэргүүцэж ч болох, зугтаж ч болох ердийн үг яриа биш, агуу их хүчний мөн чанар юм. Мантра нь оршин буй болон болж буй бүхнийг өөрийн дуу авиагаараа илэрхийлж байдаг. Үг өөр хаана ч биш,

гагцхүү энд л шууд илэрдэг үйл болдог юм. Жинхэнэ яруу найрагчийн хүч чадал нь түүний үг үнэн бодит байдлыг бүтээж, түүнд уриалж, ямар нэгэн бодитой юмыг нээдэгт оршино. Түүний үгнүүд нь зөвхөн хүүрнэх төдий бус, харин нөлөөлөл үзүүлж байдаг юм.” / Zimmer, 1930, 81 - р хуудас /

Үг анх төрөхдөө хүч болон бодит байдлын нэгдэл байсан бөгөөд зөвхөн хэл ярианы дадал зуршил түүнийг утга илэрхийлэх болзолт зуучийн хэмжээнд хүртэл доошлуулсан байна. Мантра нь энэхүү байдлаас тодорхой хэмжээгээр зугтаж чаджээ. Учир нь тэр ямар ч тодорхой утга санаа илэрхийлж чадахгүй байснаас, түүнийг ердийн хэрэгцээний зорилгод ашиглах боломжгүй байжээ.

Мантра тэсч үлдсэн боловч түүнтэй холбоотой уламжлал үгүй болж, түүнийг хэрхэн хэрэглэхийг орчин үед тун цөөхөн хүн мэдэж байна. Эртний соёл иргэншилд үгийн увидасыг ямар гүнзгий ойлгож байсныг болон түүний нөлөө амьдралын бүхий л хүрээнд, ялангуяа шашны хүрээнд ямар их байсныг орчин үеийн хүмүүс төсөөлж ч чадахгүй юм.

Манай эрин үед радио, сонинууд хэн нэгний бичсэн, хэлсэн үгийг сая саяар нь хувиран хамаа намаагүй цацаж байгаагаас үгийн үнэ цэнэ тэр хэмжээгээр унасан ба та биднээс хавьгүй илүү ухаалаг, шүтлэгтэй байсан соёлт иргэншлийн үеийнхэн маань өөрсдийн ариун уламжлал, оюун санааны биелэл болсон үгийг хэрхэн дээдэлж ирснийг өнөөдөр бид бүхэн төсөөлөхөд ч бэрх билээ.

Тийм соёл иргэншлийн сүүлчийн хэлтэрхийг дорно дахины орнуудаас олж болох бөгөөд ганцхан оронд л Мантрын амьд уламжлал нь өнөөдрийг хүртэл хадгалж иржээ. Энэ бол Төвд орон юм. Энд зөвхөн үг төдийгүй, түүнийг бүрдүүлэгч авиа бүхэн, цагаан толгойн үсэг бүхнийг ариун билэг тэмдэг хэмээн үздэг байна. Үг хэдийгээр орчлонгийн ердийн зорилгод үйлчилдэг ч, түүний гарал үүслийг тэд хэзээ ч мартдаггүй бөгөөд тийм ч учраас тэд бичмэл үгийг дээдлэн хүндэлж, хүн амьтны хөл дор хаядаггүй, замбараагүй шидэлдэггүй уламжлалтай ажээ. Ялангуяа, шашны шинж чанартай ямар ч үг болон бичиг, цаашилбал, тэдгээрийн өчүүхэн жижиг хэсгийг ч гэсэн хүндэтгэн дээдэлдэг бөгөөд тус хэлтэрхийнүүд нь ямар ч ашигтай зорилгод хэрэглэгдэхгүй ч гэсэн, түүнийг хэзээ ч

зориудаар устгадаггүй, харин тэдгээр нь өөрийн жам ёсоор устах хүртлээ тусгайлан барьсан ариун газар, сан хөмрөгт, эсвэл агуйд байрлаж байдаг билээ.

Хөндлөнгийн хүнд энэ нь ердийн нэг сохор сүсэг бишрэл мэт санагдаж болох юм. Гэвч төвдүүд ганц хоёр үсэг бичсэн цаасны тасархайд сүсэглэхээр тийм ч гэнэн улс биш билээ. Тэд нар мөнхөд орших, илүү бодит ертөнц буйг хүлээн зөвшөөрөхөд үндэслэсэн хувийн ухамсрынхаа баялгыг асар ихээр дээдэлж, улмаар тэрхүү ертөнц нь түүний өчүүхэн билэг тэмдэгт хүрэх төдийд сэргэн амилна гэдэгт итгэдэг юм.

Иймэрхүү байдлаар, билэг тэмдэг нь хэзээ ч энэ орчлонгийн эгэл зүйл болж хувираагүй, түүнийг баярын өдөр юм уу мөргөлийн өдөр хэрэглэхээр нандигнаагүй, харин билэг тэмдэг нь энэ орчлон, эгэл амьдралын бүхий л материалаг зүйлс болон хэрэгцээг захирдаг амьд эрин байсаар ирсэн билээ. Үнэхээр ч бидний энэ орчлонгийн “материаллаг” гэж нэрлээд байгаа зүйлүүд ердийн материаллаг чанараа алдаж, бүхий л юмс, үзэгдлийн үндэс болсон бодит байдлын амьд биелэл болох бөгөөд энэ нь бидний амьдрал үйлийг утга агуулгатай болгон, хамгийн өчүүхэн жижиг юмыг ч хорвоогийн их үйл явдлуудын их холбоонд нэгтгэдэг юм.

“Даанч өчүүхэн зүйлээс чи үнэлэн цэгнэгчийг олох авч, өөртөө байгаа бүхнээр түүнийг хөхүүлж үл чадмуй” / Рильке / Оюун санааны энэ чиг шугам нэг л газраа тасарсан бол өөрийн тулгуур нэгдлээ алдах бөгөөд үүний зэрэгцээ тогтворт хүчээ ч алдах болно.

Зөнч мэргэн, яруу найрагч болон дуучин, оюун ухаанаар бүтээгч, бие махбодоороо мэдрэгч гэгээнтэн хувилгаан хэн ч гэсэн үзэгдэж мэдрэгдэхгүйгээр илэрхийлсэн цогц хэлбэрийн мөн чанарыг үг авиагаар ухамсарладаг юм. Тэд өчүүхэн жижиг зүйлийг ч үл тоомсорлон орхидоггүй, учир нь тэд жижиг зүйлд буй том юмыг олж харах чадвартай билээ. Үүний ачаар үг нь мантра болон хувирч, түүнийг үүсгэгч авиа тэмдгүүд нь нууц хүчийг дамжуулагч болдог бөгөөд үзэгдэхүй бүхэн оюун ухааны бүтээлч багаж хэрэгсэл болж, амьдрал нь мөнхөөс мөнхөд урссан их мөрний урсгал болдог ажээ.

Заримдаа Дорно дахины санаа бодол Өрнөдөд байсан, “дотоод” буюу амьд үг, бодит байдал билэг тэмдгийн уламжлалыг манай өнөө үед ч баримталдгыг санах хэрэгтэй.

Мантрын хүчний жинхэнэ мөн чанарыг нээн үзүүлсэн Райнер Мария Рилькегийн шүлгийг энд дурьдаж болох юм.

Алгуур удаан мартагдсан зүйлээс

Аслан одсон дурдатгал дахин амилах тэр газарт

Төгсийн төгс, зөөлнөөс зөөлөн хязгааргүй

Танигдахын аргагүй тоглоом болон үлдэж

Тэнд л Бид үгийн ундрагыг ухаарч

Түүний санаа нь биднийг алгуурхан дийлж

Эргэцүүлэх ухаан, ганцаардал авчирсан тэр нь

Эргээд биднийг эвд оруулахаар тэмүүлнэ.

“Ум” хэмээх ариун үгийн гарал үүсэл,

нийтлэг чанар

Эртний Энэтхэгт үг нь их ач холбогдолтой байсныг “Чандогья Упанишад”-ын дараах бадгаар харуулж болно.

Бодисын амин сүнс нь – шороо

Шорооны амин сүнс нь – ус

Усны амин сүнс нь – ургамал

Ургамлын амин сүнс нь – хүн

Хүний амин сүнс нь – хэлэхүй

Хэлэхүйн амин сүнс нь – Ригведа

Ригведын амин сүнс нь – Самаведа

Самаведын амин сүнс нь – Удгита / = УМ /

Чанар бүгдийн дээдийн дээд – Удгита

Чанагш найм дахь тэнгэрт залармой.

Өөрөөр хэлбэл, газар усны хүч чадал түүний мөн чанар нь илүү хөгжилтэй организм болох ургамалд төвлөрсөн, ургамлын хүч нь хувьсан хүнд, хүний хүч нь дуу авиагаар дамжин оюун ухааны ухамсарлах, илэрхийлэх чадварт төвлөрөх бөгөөд дуу авиа нь

хоршин нийлж хэлэхүйн дотоод, гадаад хэлбэрийг буй болгож, үүний ачаар хүн адгууснаас ялгарсан юм.

Оюуны энэ их ололтын хамгийн үнэ цэнэтэй илэрхийлэл, нэгдмэл туршлага нь яруу найргийн / ригведа /, хөгжмийн / самаведа / хэлбэрээр илэрсэн ариун мэдлэг / веда / юм. Шүлгийн айзам хэмнэл илүү бат нэгдлийг буй болгож, ухааны хөвчийг судруулдаг учраас яруу найргийн хүнд үзүүлэх нөлөө нь хүүрнэлт зохиолынхоос их байдаг. Гэвч хөгжмийн нөлөө яруу найргийнхаас хүчтэй, хөгжим биднийг үгийн утгын хязгаараас гаргаж, төрөлх мэдрэмжийн хүрээнд оруулдаг билээ.

Айзам аялгуу нэгдэн нийлж, “Ум” хэмээх ариун үеийн гүн гүнзгий бүхнийг эзэмдэгч дуурьсал болно. Пирамидын орой энд төгсөх бөгөөд ургамлын үрэнд тэр организмын бүх чанар хадгалагдаж байдгийн адилаар, энэ оргил өөрөөсөө доошхи бүх төвшиний нуугдмал чанарыг агуулдаг. Энэ утгаар бол “Ум” гэдэг үг нь квинтэссенц, сансар хорвоогийн үет хөрөнгө үсэг / санкр, биджа - мантра /, увидаст үг, бүхнийг хамарсан ухамсарын хамгийн нийтлэг болох хүчин юм. “брахман” гэдэг үгийн хамгийн анхны утга ийм байжээ.

Ариун үгийг сансар, хорвоотой адилтгаснаар “брахман” гэдэг ухагдахуун бүхнийг хамрагч оюун ухаан, хүн амьтан, бурханы алинд нь ч байдаг боловч гагцхүү “Туулсан” бурхан л бүрэн дүүрэн цогцдуулж чадах ухамсарын хүчний эквивалент болно.

Эрт цагт тахил өргөх зан үйлд хэрэглэж байсан “Ум” нь йогийн хамгийн чухал нэг билэг тэмдэг болжээ. Тахил өргөх нууцлаг ид шид, эртний шашин сэтгэлгээний төөрөгдлөөс салсны дараа “Ум” нь анхаарал төвлөрүүлэх, дотоод нэгдлийн нэг үндсэн хэрэгсэл болсон байна. Ийнхүү “Ум” нь метафизик билэг тэмдэг байснаа сэтгэлзүйн хэрэгсэл, анхаарал төвлөрүүлэх холбогч болсон юм.

“Аалз шүлсээ дамжин өгссөөр сул чөлөөтэй болдогын адилаар йогч хүн “Ум” -ын тусламжтайгаар эрх чөлөөнд хүрдэг юм. “Мантраяна упанишада” - д “Ум” - ыг манасаар / оюун ухаанаар / өдөт сумтай зүйрлэсэн байдаг бөгөөд “ тэрхүү сум хүний бие - нумнаас тавихад үл мэдэхүйн харанхуйг нэвтлэн нисч, Дээд тэнгэрийн гэрэл цацарсан оргилд хүрдэг” хэмээжээ.

”Мандукья упанишада”- д (2.2, 3): “Ум”- ыг бүрдүүлж буй авиануудын утга, тэдгээрийн билэгдлийг ингэж тайлбарласан байна. “У” бол “а, у” хоёр авиануудын оршил иймээс “Ум “хэмээх үе нь “а – у - м” гэсэн гурван элементээс бүтнэ. “Ум” нь ухамсрын хамгийн дээд чадварын илэрхийлэл учраас түүнийг бүрдүүлэгч гурван элемент нь ухамсарын гурван түвшин болно. Үүнд: А нь хурц ухамсар / санскрит, жограт / У нь зүүд нойрны ухамсар / санскрит, свапна / ба М нь гүн нойронд зүүдлэхүйн ухамсар / санскрит, сушупти / бөгөөд “Ум” нь бүхэлдээ дөрөв дэхь түвшиний буюу дөрөв дэхь хэмжүүрийн ухамсар, өөрөөр хэлбэл, бүхнийг багтаасан сансрын ухамсар / санскрит, турия / юм.

“Хурц ухамсар”, “Зүүд нойрондоо ухамсарлахуй”, “Гүн нойрондоо ухамсарлахуй” гэсэн хэллэгүүдийг яг үгчлэн ойлгож болохгүй. Харин:

1/ Гадаад ертөнцийг ухаарахад түшиглэсэн субъектив ухамсар буюу бидний ердийн ухамсар

2/ Дотоод ертөнцийн ухамсар буюу бидний сэтгэл санаа, мэдрэмж, хүсэл эрмэлзэл, өөрөөр хэлбэл, оюун санааны ухамсар

3/ Объект, субъект гэж хуваагддаггүй, зөвхөн өөрөө өөртөө бүхнийг агуулсан, ялгаваргүй нэгдлийн ухамсар юм. Буддизмд түүнийг хязгааргүй хоосон / санскрит, шуньята / чанар гэж томъёолсон байдаг.

Харин хамгийн дээд дөрөв дэхь түвшинг / турия / гүн ухааны янз бүрийн сургуульд хамгийн эрхэм дээд зорилго / идеал / хэмээн үзэх ёстой гэсэн төсөөллийнхөө дагуу янз бүрээр тайлбарласан байдаг. Зарим хүний хувьд энэ нь саланги, тусгаарлагдмал / санскрит, кевалатва / цэвэр өөрийн оршихуй гэж ойлгогддог бол, нөгөө хэсэг хүмүүсийн үзэж байгаагаар энэ нь

дээд төвшиний оршихуйд уусах мэт юм уу / санскрит, сайужйатва /, орчлонгийн брахманы эзэн биегүй байдал, гурав дахь бүлэг хүмүүсийн хувьд энэ нь өгүүлшгүй их эрх чөлөө буюу тусгаар аврагдал / санскрит, сватантрия / гэх мэтээр тус тус ойлгогдоно. Гэвч тэд энэхүү түвшинд үхэл зовлон ч байхгүй, төрөх, өтлөх ч байхгүй гэдэгтэй санал нэгддэг. Буддизмын эрин үед хэдий чинээ бид дөтлөнө, тэр хэмжээгээр бидний “Би” буюу “Эго”

хэмээн нэрлэдэг зүйлийг бүрдүүлэгч бүхнийг таягдан хаяхгүйгээр зорилгодоо хүрч чадахгүй гэдэг нь ойлгогдоно.

Ийнхүү “Ум” нь аврагдалд хүрэх хэрэгсэл, түүний билэг тэмдэг юм. Авралын тухай ойлголт, тодорхойлолтууд нь хоорондоо ялгаатай боловч “Ум” нь гүн ухааны аль нэг урсгалд хамаарч байгаагүй билэгдлийн чанартай хэвээрээ байсан боловч уг хэлбэрийн гадна байгаа буюу хязгаарлалт, ангиллын болон тодорхойлолт тайлбарын гадна байгаа зүйлийг илэрхийлж байна. Бидний доторхи төгсгөлгүй туршлага - совин мэтээр мэдрэгддэг, үгүй бол нээгдэж буй бодит байдал мэтээр мэдэгддэг тийм зүйлийг “Ум” илэрхийлж байв.

Төгсгөлгүй нь хэмжүүр адил олон бөгөөд авралын хэлбэр нь шинж чанарын адил олон байна. Гэвч тэдгээрт нийтлэг нэгэн зүйл бий. Эрх чөлөөгүй боолчлолд зовж байгаа хүн эрх чөлөөг төгсгөлгүй өргөн боломж мэтээр ойлгодог. Түнэр харанхуйд тэмтэрч яваа хүн түүнийг хязгааргүй их гэрэл мэтээр, үхлийн өмнө ёолж байгаа хүн түүнийг ахуйн мөнхрөл мэтээр тус тус мэдэрдэг.

Гэвч, эдгээр тодорхойлолтууд өөрийн өвөрмөц чанарыг алдалгүйгээр “Төгсгөлгүй” гэсэн нэгэн чанартай байв. Хамгийн дээд ололт ч гэсэн өөрийн ургасан тэр хөрсний амтыг хадгалдаг мөртлөө өөрийн үнэ цэнийг алддаггүй учраас энэ нь маш чухал юм. Гэлээ ч гэсэн ухамсрын энэхүү туйлын байдалд ч гэсэн хатуухан хэлэхэд адил төстэй юм ч, адил төсгүй юм ч байхгүй. Харин тэдний хооронд гүнзгий амьд холбоо байгаа юм.

Ийнхүү төгсгөлгүй мэдрэмжийг эртний ведүүд сансрын, Брахмануудын хувьд ид шидэт зан үйлийн, Упанишадад идеалист монизмын, Жайнизмд биологийн, Буддизмд сэтгэл зүйн (бясалгалын туршлаганд үндэслэсэн), Вайшнавизмд бхактийн / хайр, хүндлэл, бишрэл /, Ведантизмд метафизикийн, Шайвайзмд “хоёрдомол бус” / адвайта / буюу даяанчлалын, Индуист тантризмд орчлонгийн бүтээлч билгийн эрчим хүчний/ шакти /, Буддын тантризмд сэтгэц – сансрын хүчний өөрчлөлтийн үйл явцын буюу тэдгээрийн билэг билгүүний / пражня / гэрлээр дүүргэх үзэгдлийн нэр томьёогоор тус тус илэрхийлжээ.

Дээр дурьдсанаар, илэрхийллийн янз бүрийн боломж хязгааргүй бөгөөд ингэснээр тэдгээрийн зохицол, харилцан нэвтрэх үйл явц шавхагдахгүй юм. Харин ч эдгээр чанарын олонхи нь нэгдэж, шашны сэтгэлгээ практикийн янз бүрийн системүүд их, бага ямар нэг хэмжээгээр нэгдэн нийлдэг байна. Гэхдээ тэдгээрийн аль нэгийг онцолсноор, энэ системийн элемент бүрийн өвөрмөц чанарыг товойлгодог билээ.

Ингэхлээр “Ум” нь нэг хүнд тэнгэрлэг орчлон мэтээр, нөгөө хүнд барагдашгүй эрчим хүчний билэг тэмдэг мэтээр, гурав дахид нь хязгааргүй огторгуй мэтээр, дөрөв дахьд нь мөнхийн амьдрал мэтээр төсөөлөгдөнө.

Зарим хүнд “Ум” гэдэг нь хаана ч гэрэлтэх гэрэл, зарим хүнд бүгдийг багтаасан хууль, зарим нэгэнд бүхнийг чадагч ухамсар болж төсөөлөгдөнө.

Боломжит бүх хэлбэр болон өнгөний мөн чанарыг нь өөрчлөлгүйгээр тусгагч толины адилаар “Ум” нь ямар ч шинж чанарыг тусгаж, дээд идеалын ямар ч хэлбэрт биелэхдээ, аль нэгээр нь өөрийгөө хязгаарладаггүй юм. Хэрэв энэ ариун үг ямар нэг тодорхой утгатай адилссан бол “Ум” өөрийн иррациональ чанарыг хадгалалгүй, аль нэг идеалд хамаарч байсан бол хувийн бүх хүсэл эрмэлзэл биеллээ олдог оюун ухааны тэр түвшиний билэг тэмдэг болж чадахгүй байсан юм.

Бүтээгч авианы тухай үзэл болон вибрацын онол

Билэг тэмдэг нь амьд бүхний адилаар уналт, цэцэглэлтийнхээ үеийг үзэж өнгөрөөдөг, цэцэглэлт мандалтын үе нь оргилдоо хүрэхэд буурч, өдөр тутмын амьдралын хүрээнд орж, дараа нь ердийн болзолт хэллэг болон хувирч нэг бол туйлын явцуу, нэг бол туйлын өргөн утгыг олон дахин буй болгосноор сүүл сүүлдээ өөрийн гүн нандин агуулгыг алддаг. Энэ үед тэдний байрыг өөр билэг тэмдгүүд эзэлж, өмнөх нь “ маш явцуу хүрээнд” байр сууриа хадгалан цагаа болоход дахин сэргэдэг юм.

“Явцуу хүрээ” гэдэг нь зохион байгуулалттай бүлэг хүмүүс биш, өөрсдийн мэдрэмжийн ачаар билэг тэмдгийн нарийн учрыг мэдэрдэг хүмүүсийг хэлж байгаа юм. Юмс үзэгдлийн мөн чанарыг нээгч бөгөөд аливаа бүтээлийн нууцыг тайлах түлхүүр өгөгч авиа, вибрацын далд хүчний энэ нууцыг эртний мэргэд бүрэн дүүрэн ойлгодог байжээ.

Бүтээл хийгээд бүтээгдсэний нууцыг тайлагч түлхүүр болсон бүх юмс, үзэгдлийн мөн чанарыг нээгч болсон авиа буюу хэлбэлзлийн энэхүү нууц хүчийг өнгөрсөн үеийн мэргэд болох Гималайн нуруунаа суугч асан Арш гэгээн, Месопотамын адептууд, Египетийн тайлагч нар төгс мэддэг байлаа.

Пифагорын сургаалаар бол тэнгэрийн ямар ч бие, тодруулж хэлбэл, ямар ч атом өөрийн хөдөлгөөндөө өвөрмөц авиа хэмнэл буюу вибраци үүсгэдэг ажээ. Энэ бүх авиа вибраци нь сансар хорвоогийн ерөнхий зохицлыг үүсгэх ба үүний элемент бүр өөрийн үүрэг, шинж чанарыг хадгалахын хамтаар нэгдмэл нэгэн цогц болж өөрийн хувь нэмрийг оруулдаг байна.

Бүтээлч авианы тухай үзэл санааг Логосын тухай сургаал хөгжүүлсэн юм. Жишээ нь: Иоанны Евангели “Хамгийн эхэнд үг байсан, Үг бурхан байсан... Тэгээд бүх юм үгээр дамжиж буй болсон” гэсэн нууцлаг үгээр сургаалаа эхэлсэн байдаг билээ.

Бүтээлч авианы тухай мэдлэг Энэтхэгт ч байсан. Энэ мэдлэг йогийн янз бүрийн системд хөгжиж, Буддизмын сургуулиудад төгс боловсорсон юм. Тэдгээр сургуулийн үндэс болсон Вижнянавадаг бас “Йогочара” гэх бөгөөд түүний уламжлал Төвдөөс Япон хүртэл дэлгэрсэн Их хөлгөний сургаалд хадгалагдан үлджээ.

Александр Девид Неел “Төвдийн аян” бүтээлийнхээ VIII бүлэгт “Кимвалтай” төстэй зэмсгээрээ хамгийн ер бусын янз бүрийн авиа гаргаж чаддаг төдийгүй, гүн ухааны хувьд бүх бодис юмс, өөрийн төрөлх шинж чанарт зохицсон авиа гаргаж чаддаг хэмээн Пифагорын адилаар нотолдог хүнтэй уулзсан” тухайгаа бичжээ. “Бүх бодис, объект нь хөдөлгөөнөөрөө авиа үүсгэгч бүжиглэгч атомуудын нэгдмэл цогц юм. Бүжгийн хэмнэл өөрчлөгдөхөд тэдний үүсгэсэн авиа ч өөрчлөгдөнө. Атом бүхэн өөрийн дууг дуулдаг. Авиа нь хором бүхэнд сайхан муухай янз бүрийн хэлбэрийг бүтээнэ. Бүтээгч авиануудын зэрэгцээ хөнөөгч авианууд оршино” гэж тэр хүн ярьсан байна.

Дээр дурьдсан нотолгоог материалист шинжлэх ухааны үүднээс ойлгоно гэвэл буруу юм. Мантрагын хүч нь дууны долгион буюу материйн жижиг хэсгүүдийн хэлбэлзэлтэй дүйнэ. Туршлагаас үзвэл, материйн жижиг хэсгүүд дуу авианы хүч, хэмнэл, шинжтэй яг

таг зохицсон геометрийн тодорхой бүтэц, хэлбэрт өөрсдөө ордог гэж материалист хүн хэлэх байсан буй за.

Хэрвээ мантрын үзүүлэх нөлөөллийг энэхүү цэвэр механик арга руу буулгаж болох байсан бол, тэр нь хөгжим тоглуулагчид болон эгшигт хайрцагт буй бичлэгийг бүтээгч тэрхүү хэрэглүүрийг урин дуудах байсан биз ээ. Гэвч түүнийг зүгээр л нэг давтаж хэлснээр тухайн хүн ямар ч үр дүнд хүрэхгүй. Харин мантрын хүч нь түүнийг дуудах аялгаас хамаарах бөгөөд оюуны хэлбэлзлийг өгүүлэхүйн эрхтэний авианы долгионтой хольж хутгадаг их мэдэгчийн гаргасан “хэлбэлзлийн онол” нь төөрөгдлийн эх болж байна. Харин мантрын ач тус нь тэдгээрийн дуудлага ямар байхаас хамаардагсан бол Төвдийн бүх мантранууд нь агуулга, хүчээ алдах байсан буй за. Яагаад гэвэл, Цастын оронд мантраг санскрит хэлний авианы дүрмээр бус, Төвд хэлний авианы дүрмээр дуудаг билээ. Жишээлбэл: Төвдүүд “Ум мани падме хум” гэхгүй, “Ом мани пёмэ хум” гэж дууддаг.

Энэ бол Мантрын хүч болон нөлөөлөл нь тухайн хүний мэдлэг ухаан, хариуцлагаас шалтгаалдаг болохыг харуулж байна. Шабда буюу мантрын дуудлагыг чихээрээ бус зүрхээрээ сонсох боломжтой, мөн уруулаараа бус оюун ухаанаараа дуудах боломжтой бөгөөд түүнийг тухайн мантратай холбоотой туршлага хуримтлуулсан хүн буюу өөрөөр хэлбэл, бясалгалын тусгай үе шатуудыг даван туулсан гэгээрсэн хүн л зөвхөн ойлгоно. Тодруулбал, зөвхөн гэгээрлийг олсон хүний хувьд л мантра нь хүчтэй буюу учир утгатай байна гэсэн үг юм.

Мантра бол өрнөдийн эрдэмтэд болон дорно дахины зарим судлаачдын ойлгодогчлон “тарни шившлэг огтхон ч биш, ид шидэд төгс боловсрогдсон хүмүүст ч хамаардаг эд биш. Мантра нь өөрийн увидасын хүчээр үйлчилдэггүй, харин түүнийг бүрэн дүүрэн ухаарсан оюуны хүчээр үйлчилдэг юм. Мантрад өөрт нь ямар ч эрчим хүчний нөөц байхгүй. Харин өөрөөсөө ангид орших өөр хүчийг төвлөрүүлэх хэрэгсэл болдог билээ. Томруулагч шил өөртөө ямар ч дулаан агуулдаггүй мөртлөө нарны туяаг бөөгнөрүүлж, тархай эрчим хүчийг дулааны хүчтэй урсгал болгон хувиргадагтай адил юм. Галт шил дулаан гаргаж буйг нүдээр харж болох ч, дулаан үүссэн шалтгаан, дотоод холбоог нь

мэдэхгүй хүнд бол энэ нь ид шид мэт санагдана. Тэгэхээр мантра болон ид шид хоёрыг ялгахгүй байгаа хүн бол зэрлэг хүнээс нэг их ялгарахгүй билээ. Мантрын мөн чанарыг сонгодог философи аргаар нээхийг оролдсон эрдэмтэд мантра бол хэлзүйн бүтэц ч үгүй, дэмий зүйл хэмээн дүгнэсэн учир тэдний хөдөлмөрийг лантуугаар эрвээхэй барихаар оролдсонтой зүйрлэж болно.

Мэдлэг бүхий багшгүйгээр болон хувийн жаахан ч гэсэн туршлага

үгүйгээр мантрын мөн чанар, аргыг судлана гэдэг санаанд багташгүй зүйл юм. Гагцхүү Артур Авалоны эрэлхэг хөдөлмөрийн ачаар л ертөнц анх мантрагай танилцаж, мантризм бол “дутуу төрсөн Индуизм” ч биш, “ёс заншлаа умартсан Буддизм” ч биш гэдгийг болон мантрын уламжлал нь хүний сэтгэхүйн салбар дахь гүн гүнзгий танин мэдэхүй, туршлагын илэрхийлэл юм гэдгийг нэгэнт мэдсэн билээ.

Мэдлэг боловсрол төгс багш / гүрү / -ийн удирдлаган дор тасралтгүй хийсэн бэлтгэл / практик / -ийн явцад энэхүү туршлагыг олж авч болох юм. Хэрэв мантраг тийм бэлтгэлийн үндсэн дээр хэрэглэвэл, тэр нь гэгээрэгч хүнд нуугдан хуримтлагдаж байсан бүх хүчнүүд болон зайлшгүй хэрэгтэй холбоосуудтай нэгдэж, тухайн мантрын зорилгод хүрэхэд зайлшгүй шаардагдах орчин нөхцөл буюу хүч чадал буй болох болно. Гэгээрэлд хүрээгүй хүн бол тухайн мантраг амандаа хичнээн бувтнасан ч, жаахан ч үр дүн гарахгүй билээ. Ийм учраас түүнийг номонд хэдэн мянган хувь болгоод хэвлэсэн ч мантра нь өөрийнхөө үнэ цэнэ, нууцаа алдахгүй юм.

Энэхүү “нууц” нь санаатайгаар бусдаас нууж буй зүйл биш бөгөөд харин хатуу сахилга бат, нэг юманд төвлөрөх дотоод туршлагаар буюу мантрын мөн чанарт нэвтрэх замаар олж авдаг зүйл билээ. Аливаа үнэт зүйлс мэдлэгийн адил, түүнийг хичээл чармайлтгүйгээр олох боломжгүй юм. Мантрын уламжлал гагцхүү энэ л агуулгаараа нууцлаг бөгөөд аливаа мэргэн цэцэн ухаан, өнгөц мэдлэгийн адилаар хүрмэгц нууцаа нээдэггүй бөгөөд харин хүний оюун ухааны гүнд бодит биеллээ олдог юм. Ийм ч учраас Хятадын Бурханы шашны сургуулийн нэг шавь багшаасаа “Танд нууц сургаал бий юу?” хэмээн асуухад, багш нь шавьдаа: “Миний чамд хэлж чадах бүхэн нууц биш юм. Гэвч чи

өөрийнхөө гүнд байгаа дотоод руу нэвтэрч чадвал, өөрийнхөө оюун ухаанаас нууцыг олох болно” гэж хариулсан байдаг. Нууц мэдлэг гэдэг бол чин сэтгэлээсээ өөртөө хандаж, аливаа сургаалыг атгаг санаагүй, нээлттэй ухаанаар өөртөө шингээх чадвартай хэн бүхэнд нээлттэй байдаг юм.

Гэвч их, дээд сургуульд авьяас, чадвартай хүмүүсийг элсүүлж авдагын нэгэн адил, бүхий л үеийн агуу их багш нар мантрын ухааны нандин эрдмийн нууцыг шавь нартаа нээхийн өмнө тэднээс тодорхой хэмжээний авьяас, чадварыг шаарддаг байсан билээ.. Учир нь зөвхөн цэвэр онолын шинжтэй мэдлэг буюу дутуу дулимаг мэдлэгээс илүү аюултай юм гэж үгүй буй за.

Шавь нарын эзэмшвэл зохих чанаруудыг дор дурдваас: Багшдаа шавь нь чин сэтгэлээсээ итгэдэг, багшийнхаа үзэлд үнэнч байж, оюуны бүх зүйлсийг гүнээ хүндэтгэдэг байх ёстой ажээ. Мөн ариун судрын болон уламжлалын үндсэн байдлын гүнзгий мэдлэг эзэмших, багш / гүрү / - ийн удирдлаган дор нууц эрдмийг судлах, суралцахад амьдралынхаа тодорхой хэсгийг зориулахад бэлэн байхыг шаарддаг ажээ.

4. Мантрын уламжлалын уналт

Дээд тоо, физик болон химийн тэмдэг, нэр томъёог мэддэггүй хүнд эдгээр шинжлэх ухаан нь “долоон уулын цаана” байдгын адилаар мантрын мэдлэгийг ч мөн ямар нэг хэмжээгээр нууц ухаан хэмээн нэрлэж болох юм. Гэвч, дээр дурьдсан шинжлэх ухаануудын гарамгай ололтуудыг хувийн болон улс төрийн эрх ашгийн үүднээс ашигладаг бөгөөд түүнийг сонирхсон хэсэг бүлэг этгээдүүдийн дунд / Тухайлбал, засгийн эрх баригчдын дунд / тэр нь нууц болон хадгалагдан үлддэгийн адилаар, мантрын мэдлэг ч мөн адил өөрийн цаг үедээ, нийгмийн дээд анги давхарга, улс төрийн эрх мэдлийн золиос болсоор байсан билээ.

Эртний Энэтхэгийн бярманууд мантрын мэдлэгийг өөрийн ангийн ноёрхох хэрэгсэл болгон ашиглаж, доод ангийнхныг мантрын уламжлалд сохроор захирагдахыг шаарддаг байв. Ийнхүү нэгэн цагт шашны онгодоор буй болсон тэрхүү мэдлэг үхширмэл суртал болон хувирч, эцэс сүүлдээ уг уламжлалыг дэлгэрүүлэгчийг хүртэл боолчилж байлаа.

Мэдлэг маань ердийн нэг шүтлэг болж, амьд тулгуур үгүй шүтлэг нь эцэстээ сохор сүсэг бишрэл болон хувирчээ.

Өөрийн гарал үүслийн хэлхээ уялдаа буюу утга агуулгаа алдан, учир шалтгааны болоод оюун санааны, түүхэн холбоос нь мартагдсанаас ердийн хоосон сүсэг бишрэл үүсдэг билээ. Амьд туршлага, эрүүл ухаан, бодит байдлын зохицолд үндэслэсэн дотоод гүн гүнзгий итгэл үнэмшил нь оюун ухааны аливаа үйл ажиллагааны / шинжлэх ухаан, шашин, урлаг / утгвар нөхцөл болдог. Энэ нь бидний ухамсрын бүхий л оршихуйн чиглэл болох бөгөөд тэр нь үгүй бол оюуны ямар ч дэвшил гарах боломжгүй юм. Энэ бол Будда өөрийнх нь замаар явахыг хүссэн бүхнээс шаардаж байсан “саддха” юм. “Үхэлгүй мөнхийн үүд нээлттэй байна. Чихтэй бүхэн сонсогтун. Итгэл үнэмшилд байр тавин өгөгтүн!” гэсэн үгсээр Будда нэгэн цагт сургаалаа эхлэн айлджээ. “Памуньчанту саддхам” гэдэг нь “Таны итгэл, дотоод үнэн, найдвар чинь чөлөөтэй болог, доторхи саад хаалгаа арилгаж, өөртөө үнэнийг нээгтүн” гэсэн утгатай юм.

Энэ бол атгаг санаа агуулсан дотоод сэтгэлээ ариусгаж, “Ум” гэдэг ариун үгээр сэтгэхүйн дарамтаас өөрийгөө чөлөөлөх итгэлийн хэлбэр юм. Энэхүү мантрын билэг тэмдэгт хүний оюун ухааны хөгжилд тус болохуйц нааштай бүхэн “сумны үзүүрт” бөөгнөрөх мэтээр төвлөрсөн байдаг билээ.

Гэвч, өөрсдөө ямар ч туршлагагүй хүмүүс түүний үр дүнг шинжлэхийг оролдсоны харгайгаар энэхүү бие сэтгэлийн гүн гүнзгий итгэл, нэн удалгүй онолын мөлжлөгийн золиос болсон юм. Түнэр харанхуйг устгасаны дараах ертөнцийг гийгүүлсэн гэрэл тэдэнд хангалтгүй байжээ. Харанхуйг гийгүүлэх оролдлогоос өмнө тэд гэрлийн мөн чанарын учрыг олохоор шийдэж, теологийн тулгуур систем буй болгожээ. Тэр системд “Ум” гэдэг ойлголт салгаж авахын аргагүй орооцолдсон байна. Өөрсдийн хүчинд тулгуурлахын оронд тэд ямар нэг ер бусын ид шидтэй зууч олохыг хүсчээ. Тэд зорилгоо тунхаглахдаа “Сум тавих” чармайлтыг суманд юмуу дайнд оршсон ямар нэг далдын хүч биш, өөрсдөө гаргах ёстой гэдгийг умартжээ. Тэд зохих дасгал хийхээс татгалзаж, бие ухааныхаа хөвчийг сулруулсан байна.

Үүний уршгаар Буддагын цаг үед энэхүү агуу их мантрын билэг тэмдэг нь Брахманизмын онолоор тайлагдахын аргагүй хүлэгдсэн байна.

Буддизмын хамгийн анхны бөгөөд хамгийн чухал зорилт нь зохих дасгал хийж, винайн сахилыг сахих замаар “Бие болон ухааны хөвчийг дахин шинээр чангалах” явдал байлаа. Хүн өөрийнхөө хүчинд итгэх итгэл нь дахин сэргэж, шинэ сургаал хөл дээрээ босно вэ, түүний хамтаар “Ум” хэмээх ариун сумны үзүүрээс шашны сургаал номлолын бүхий л чимэг зүүлт хагдран унаж, хүлээс нь тайлагдах ба тэрээр дахин шинээр гүн гүнзгий төвлөрөх / бясалгалын / сумыг тавих юм.

Шашин хоорондын тогтолцооны бие сэтгэлзүйн нэгэн зүйлийн дасгал болохынхоо хувьд йога нь шашны сэтгэлгээтэй сургууль бүрт нэвтэрч, бодит хувь нэмрээ оруулсан нь сайшаалтай бөгөөд түүний хөгжилтэй “Ум” нь салшгүй холбоотой болохыг бид нэгэнт дээр дурьдсан билээ. Буддизм нь үүссэн цагаасаа эхлэн йогийн дасгалыг хүлээн зөвшөөрч, улам цаашид хөгжүүлж, шашны бусад системтэй хоёр мянган жилийн туршид тасралтгүй туршлага солилцож ирсэн ажээ.

Ийм ч учраас “Ум” гэдэг үг нь билэг тэмдэг болохын хувьд утга агуулгаа түр алдсан хэдий ч, эртний буддизмын шашны практикт мантрын томъёо нь итгэлийг / саддха / сэргээх, дотоод сэтгэлийн хүлээснээс гарах, анхаарлаа төвлөрүүлэх эрхэм дээд зорилгод ашиглаж байсан гэхэд гайхаад байх зүйл үгүй билээ.

5. Эртний Буддизмын мантрист хандлага

Эртний Махасангикууд хүртэл судартаа мантрын томъёонуудыг “Дхарани буюу Видьядхара - Питака” гэсэн ерөнхий нэрийн дор нэгтгэн оруулж байжээ.

Дхарани / монголчууд тарни гэж уншдаг / нь бясалгаж анхаарал төвлөрүүлэх явцад ямарваа нэг тодорхой санаа, дүр мэдрэмжид ухамсарыг хандуулах хэрэгсэл болдог. Ухамсарын тодорхой нэг байдлыг Дхарани-гаар ямар ч үед дахин дуудан буй болгож болох учраас Дхараниг билгүүн ухааны тулгуур, түүнийг агуулагч сав / санскрит, Видьядхара / хэмээн нэрлэж болох юм. Хэрвээ “Дхарани”-гийн хэлбэрүүдийг тооцохгүй тохиолдолд, тэдгээр нь үүргийн хувьд “Мантра”-гаас огт ялгаагүй бөгөөд зарим

тохиолдолд хангалттай олон үетэй олон мантрын хослол, эсвэл “хөрөнгө үсэг” / биджа - мантра /, эсвэл ямар нэгэн ариун судрын мөн чанарыг өөртөө багтаасан байдаг. Дхарани бол анхаарал төвлөрүүлэх хэрэгсэл ч мөн, түүний үр дүн ч мөн юм. Дотоод сэтгэлийн гүнзгий бясалгал / самадхи / -д орсоноор хүн үнэнд хүрч, дхарани түүнийг тогтоон хадгалдаг.

Анхаарал төвлөрүүлэх хөтөч хэрэгсэл болсон мантра, дхаранийн ач холбогдлыг Тхераведин буддизмд онцлон тэмдэглээгүй боловч түүний үйлчлэл үнэхээр бодитой гэдэгт эргэлзээ байсангүй. Эртний Энэтхэгийн судруудад аюулт өвчнөөс сэргийлэх, хорт могой, чөтгөр шуламнаас хамгаалах, эрүүл чийрэг, баян чинээлэг амьдрах нөхцөл бүрдүүлэхэд уншдаг мантранууд тааралддаг юм.

“Маджхима Никайя”- д: дээрэмчин байгаад Бурханы номд орсон Ангулимад хүүхэд зулбадаг хуучтай нэгэн эмэгтэйг / “үнэний уншлага” буюу мантрын хүчийг ашиглан / эмчлэх үүргийг Будда өгсөн тухай өгүүлдэг. Мантрын хүчний эх булаг бол түүнийг уншиж байгаа хүний дотоод сэтгэл байдаг боловч, унших хэлбэр багагүй үүрэгтэй бөгөөд мантра унших аялга нь агуулгадаа зохицсон тодорхой айзам хэмнэлтэй, хүчтэй байх ёстой ажээ.

Энэ талаар мантрад, шад бүр нь “Энэ үнэний хүчээр сайн сайхан болох болтугай” гэсэн үгээр төгсдөг “Ратана сутта”- д төдийгүй, Тхераведин буддизм дэлгэрсэн орнуудад одоо ч уншсаар байгаа тарниудыг оруулж болно. Тэдгээрийн дуудлага, хэмнэл, агуулга бүгд ижил Будда, Дхарма, Сангха зэрэг дээд билэг тэмдэгт төвлөрсөн байдаг нь тэдгээрийн үндэс болсон Саддха - итгэл, метта – асрахуй буюу нигүүсэл нь нэгдүгээрт тавигддаг явдал нь тэднийг жинхэнэ мантра болгож байгаа хүчин зүйл болно. Тэдгээрийн хэлбэр нь илэрхийлж буй агуулгынхаа адил чухал байдаг учраас гурван удаа давтан дууддаг байна. Ингэснээр түүний хэлбэрийн зөв зүйтэйг, өнгөрсөнөөс ирээдүй рүү урсаж буй дуудагын билэг тэмдэгийн зөв зүйтэйг нотлох гэсэн хэрэг юм. Энэхүү урсгал нь тухайн хүнтэй нэгэн ижил зорилгод тэмүүлсэн өнгөрсөн үеийнхэнтэйгээ холбоотой болж байна. Мантрын үгийн ид шид болон түүний хүнд нөлөөлөгч нууцдаг засаглал үүнд л оршино.

Учир нь жинхэнэ буддист хүн бол Бурхан багш болоод түүний шавь нар миний мөргөлийг сонсох юм уу, миний гуйлтыг биелүүлэхээр ид шидээр дээд тэнгэрээс буугаад ирнэ гэж найддаггүй, ингэхлээр эдгээр тарнийн хүч нь хэлбэр, ая дан, хэмнэл, сэтгэлийн мэдрэмж - итгэл нигүүсэл, үзэл санаа - мэдлэг, туршлага, сэтгэхүйн эв зохицлоос хамаарна. Энэ тохиолдолд үзэл санаа гэдэг нь ердийн хийсвэрлэл биш, бүтээлч дүр зураг буюу бодит байдлыг тусгаж, түүнийг дахин шинээр үүсгэж буй туршлагат - мэдрэмжийн хэлбэр хэмээн үзэх ёстой юм.

Хэлбэр нь бусад шинж чанарыг агуулж, мэдрэмж нь нэгдлийг төрүүлэх учраас зайлшгүй чухал / гал нь төрөл бүрийн төмөрлөгийг хайлуулж нэгэн бодис хайлш болгодгын адил / бөгөөд агуулга нь хүний ухааныг бүрдүүлж байгаа бүхнийг амилуулан, түүн дотор зүүрмэглэж буй их эрчим хүчийг сэргээдэг субстанц болох буюу “материйн матери” болох юм. Тухайн тохиолдолд үзэл санаа гэсэн нэр томъёог ойлгохдоо ямар нэг юмыг, ямар нэгэн байдлаар төсөөлөн ердийн хийсвэрлэхүй гэж ойлгох ёстойг энд зайлшгүй тэмдэглэн бичих хэрэгтэй ба харин түүнд бодит байдал үргэлж шинээр буй болж, илэрч байдаг.

Өмнөх үеийнхний туршлагаас урган гарсан хэлбэрээс түүнийг амилуулагч агуулгын ялгаатай тал нь гэвэл, тэр нь Буддагын суут авьяасын ач гавьяа юм. Гагцхүү энэ л утгаар нь Буддагын оюуны хүч л мантрад шингэсэн гэж хэлж болох билээ. Харин сэтгэл санаа, оюун ухааны чанаруудыг нийлүүлэн гагнаж, агуулгыг амьдруулагч бүтээлч хүч нь тухайн хүнд өөрт нь байдаг. Хэрэв түүний итгэл сул байвал дотоод сэтгэлээ төвлөрүүлж чадахгүй, түүний ухаан дасгалаар бэхжээгүй бол энэхүү агуулгыг ухамсарлаж чадахгүй юм. Хэрэв сэтгэл зүйн хувьд сул дорой бол далд хүчийг сэрээж чадахгүй, анхаарлаа төвлөрүүлж чадахгүй бол оюун ухаанаа залж чадахгүй гэсэн үг юм.

Ийнхүү мантра гэдэг нь бидний амьдралын, өөрөөр хэлбэл, бидний өөрсдийн үйлийн үрийн муу дагавраас хялбархан зайлах зам биш, харин их чармайлт шаардсан арга, аврагдах хүрэх зам юм. Зөв хэрэглэсэн мантра үнэхээр үйлчилж байвал, энэ нь байгалийн хуулийг өөрчилж, үйлийн үрийн үр дагаврыг сөрөн зогсож чадна гэсэн үг биш. Харин энэ

нь зөвхөн гүйцэд төвлөрөлд орох чадвартай, бат итгэлтэй, шаардлагатай бүх мэдлэгийг эзэмшсэн хүн бол аврагдалд хүрэхгүй байх үндэсгүй бөгөөд тухайн хүн үйлийн үрийнхээ буюу өөрөө өөртөө эзэн нь болчихсон гэсэн л үг юм.

Мантрын нилээд хожуу үеийн төлөөлөгчид үйлийн үр / карма / - ийг зөвхөн амандаа мантра уншсанаар юм уу, шашны ямар нэгэн зан үйлээр, эсвэл ид шидээр зайлуулах боломжгүй бөгөөд харин түүнийг зөвхөн цэвэр ариун сэтгэлээр буюу саруул ухаанаар зайлуулж болно гэдгийг сайтар ойлгож байжээ. “Муу үйлээс зайлж болох уу, үгүй юу гэсэн асуулт сэтгэлийг тань зовоож байвал, түүнийг зөвхөн сайн сайханд тэмүүлэх чин эрмэлзлэлээр л зайлуулж болно гэдгийг мэдэгтүн” гэж авиа анирлагч агуу их багш нарын нэг Богд Миларайба нэгэнтээ хэлсэн билээ.

Бурханд бие, хэл, сэтгэл чинь нийлээгүй бол

Бурханд мөргөж, өргөл өргөөд юугаа хийнэ вэ?

Хилэнгийн мунхагаа дарж чадахгүй бол

Хилэнцээ нимгэлэх гээд юугаа хийнэ вэ?

Өрөөлийг өөр лугаа адил хайрлаагүй бол

Өршөөл гуйж мөргөл үйлдээд юуны тус болох вэ?

хэмээн түүний намтарт өгүүлдэг юм.

Үүнтэй төстэй үг өгүүлбэрийг үй олноор олж болох бөгөөд энэ нь шашны практикийн аргууд дахь он цагийн урсгалыг элээсэн агуу их өөрчлөлтүүдийг тооцолгүйгээр, Буддизмын үзэл санаа урьдын адил амьд хэвээр үлдсэнийг гэрчилж байна. Мантра нь анхаарал төвлөрөлт, оюун ухааны дасгалын хэрэгсэл байсан цагт, өөрөөр хэлбэл, мантрын дотоод агуулга, шалтгаан, үр дагаврын тухай тодорхой төсөөлөлтэй байж, түүнийг сохроор шүтэлгүй, шунахай зорилгод ашиглаагүй байсан цагт мантра нь буддизмтай зөрчилдөхгүй юм.

Гэтэл брахманизмын үеийн метафизикийн үхширмэл номлолд энэ мэдлэг алга болж, мантрын үгс ердийн болзолт тэмдэг болон хувийн хариуцлагаас чөлөөлөгдөх тохиромжтой хэрэгсэл болсон байна.

Гэвч, хүнийг сансар хорвоогийн төвд байрлуулж, аврагдалд хүргэхдээ бурхадын оролцоотойгоор биш, зөвхөн өөрийн хүчээр хүрэхийг зөвлөсөн Будда нь мантрын тогтолцоог метафизикээр дүүрсэн чигээр нь орхисонгүй бөгөөд түүний шинэ хэлбэрийг өөрсдөө олох боломжийг шавь нартаа олгосон юм. Зөвхөн өөрийнхөө бие, сэтгэлийн хатуужлаар л түүнд хүрэх замыг Будда тэдэнд зааж өгсөн билээ. Иймээс мантрыг хэн нэгэн хүн зохиох боломжгүй, харин тэр өөрөө урган гарах ёстой бөгөөд олон үеийнхний хамтын мэдлэг туршлагаас тэд урган гарсаар байдаг юм.

Тийм ч учраас, Буддын мантрын ухааны хөгжил нь брахманы ойлголтын адил давталт биш, харин оюуны өсөлтийн зүй ёсны хөгжлийнхөө үе шат бүхэнд өөрийн илэрхийллийн хэлбэрийг төрүүлж байдаг үр дагавар юм. Тэдгээр хэлбэр нь Буддизмын түрүү үед байсан хэлбэртэй адил байлаа ч гэсэн энэ нь өмнөх үеийн давтамж төдий байгаагүй, харин ч олон талт туршлагаас урган гарсан шинэ бүтээл үргэлж байсан билээ.

б. Буддизм амьд туршлага болох нь

Амьдралын шинэ нөхцөл байдал бүхэн бидний ертөнцийг үзэх үзлийн хүрээг тэлж, биднийг байнга өөрчилж байдаг. Хүн бол тасралтгүй өөрчлөгдөж байдаг бөгөөд энэ нь зөвхөн амьдралын нөхцөл нь өөрчлөгдсөнөөс үүддэг бус, гэвч хэрвээ эдгээр нөхцөлүүд өөрчлөгдөхгүй байлаа ч гэсэн энэ нь шинэ шинэ сэтгэгдлийн байнгын урсгалын үр дүн байсаар байх юм. Ингэхээр ухамсрын бүтэц нь улам эмх замбараагүй, хүнд болох болно. Үүнийг бид “дэвшил” гэж нэрлэх үү, “доройтол” гэж нэрлэх үү гэдэг нь хамаагүй ч, ялгаа ба төсөө хоёр нь бие биеэ тэнцвэржүүлдэг амьдралын энэхүү хуулийг бид хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй.

Ийнхүү хүн төрөлхтөн үе бүхэндээ өөрийн гэсэн асуудлуудтай тулгарч байсан бөгөөд энэхүү асуудлуудыг давах өөрийн гэсэн замыг хайж олох хэрэгтэй болдог байна. Асуудлууд нь түүнийг шийдэх арга хэрэгслийн адилаар, өнгөрсөн үеийн нөхцөлөөс үүсдэг учраас тэдгээртэй холбоотой ч адилхан байх албагүй. Тэдгээр нь бүх талаар адилхан биш ч, бас огт өөр биш бөгөөд байнгын зохицох үйл явцын ул мөр юм.

Шашны асуудлуудын хөгжлийг ч гэсэн ийм байр сууринаас авч үзэх нь зөв бөгөөд түүнийг “дэвшил” буюу “доройтол” хэмээн үзсэн ч хөдөлбөргүй хатуу хэлбэрт хүчээр оруулах боломжгүй, оюуны амьдралд тэд зайлшгүй байсаар байх болно.

Шашны болоод гүн ухааны агуу их номлолууд нь хэн нэг гарамгай хүний бүтээл биш бөгөөд гарамгай хувь хүмүүс түүнд эхний түлхэцийг өгч чадах ч, тэрхүү номлолууд нь бүтээлч үзэл санаа, агуу их тэвчээр хатуужил, ухаарлаас төрөн гардаг юм. Тэдгээр нь олон үеийн туршид өөрийн дотоод жамын дагуу мод болон бусад амьд организмын нэгэн адил хөгжин цэцэглэдэг. Үүнийг “оюун санааны жам ёсны хөгжил” хэмээн нэрлэж болох ба тэдний өсч, төлжиж, боловсроход цаг хугацаа хэрэгтэй юм. Хэдийгээр мод нь үр хэлбэртэй далд орших боловч нүдэнд харагдах хэлбэрт ортлоо ургахад цаг хугацаа хэрэгтэй байдгын адил гэж энд ойлгож болно.

Буддагийн үгээр номлож чадсан зүйл нь тэрбээр, өөрийн биеэр ганцхан удаа ирж, амьд үлгэр жишээ үзүүлэн бусдыг сургасны зөвхөн нэг хэсэг нь бөгөөд энэ бүгд түүний оюун санааны туршлагын өчүүхэн хэсэг төдий юм. Будда өөрөө үг ярианы дутуу дулимаг, хязгаарлагдмал талыг мэддэг байсан учраас сургаал номлолоо айлдахдаа, хүний оюун бодлоор болон ердийн учир шалтгааны ухаанаар ойлгож боломгүй, тийм эмзэг нарийн, гүн гүнзгий үгээр номлохыг зүрхэлдэггүй байсан байна.

Энэ бүх бэрхшээлүүдийг харгалзан үзээд Будда “зовлонгоос үүдсэн үнэн”-ийг билгийн мэлмий нь дөнгөж нээгдэж буй цөөн хэдэн хүнд нээхээр шийджээ. Будда хүмүүний оюуны боломж хүршгүй асуудлаар ярихаас үргэлж зайлсхийдэг байв. Тэр зөвхөн энэ бүх асуудлыг шийдвэрлэхэд хөтлөх замыг зааж өгсөн юм. Будда өөрийн сургаалын мөн чанарыг сонсогчдынхоо оюуны боломжинд тохирсон хэлбэрээр тайлбарладаг байсан бөгөөд гар урчууд болон газар тариаланчидтай тэдний хэлээр буюу мэргэжлийн онцлогт нь тохирсон жишээг татан ярьдаг байжээ. Тухайлбал: Брахмануудтай ярихдаа, философийн хэлээр, тэдний шашны зан үйл, орчлонгийн тухай тэдний төсөөлөлтэй холбоотой жишээ татаж, харин хотын иргэд болон гэрийн аж ахуй эрхлэгсдэд болохоор иргэний үүргийн буюу гэр бүлийн амьдралын сайн сайхан үйлийн

талаар ярьдаг байв. Өөрийн сургаал болон туршлагын харьцангуй гүн гүнзгий талуудыг, тэрбээр зөвхөн цөөн тооны шилдэг шавь нартаа тайлбарладаг байлаа.

Буддизмын хожуу үеийн сургуулиуд ч гэсэн энэ зарчимд үнэнч байв. Буддын гүн ухаан улам нарийн түвэгтэй, өргөн хүрээтэй болох тусам хүмүүн тус бүрийн оюун ухаанд тааруулж номлох олон арга туршлагад боловсорсон Буддизмын хожуу үеийн сургуулиуд нь Будда багш шавь нараа алхам алхамаар ахиулсан лугаа адил, мэдлэг боловсролын өндөр түвшинг шаардсан сургаалын хүнд төлөвүүдийг, дээрх шаардлагыг хангасан буюу анхан шатны сургалтанд хамрагдсан шавь нарт зориулан номлодог байжээ.

Нилээд өндөр түвшиний энэхүү сургалтыг “нууц эрдэм”-ийн сургаал хэмээдэг байсан боловч, энэ нь хэн нэгнээс эрхэм дээд гэгээрэл, мэдлэгийг нууцлахын тулд биш, харин тэрхүү эрхэм эрдмийг дадлага туршлагаар олж авахыг эрмэлздэггүй, дан ганц ухааныхаа хүчээр эзэмшихийг оролддог хүмүүсийн дэмий яриа, хоосон номлолоос зайлсхийсэн хэрэг байлаа.

Будда хэнээс ч, юуг ч нуугаагүй гэдгээ болон аливаа хүмүүнийг тэнэг, ухаантай гэж ялгалгүй, сургаалыг маань дагахыг хүссэн бүхнийг өөрийн сургаалаар сургана гэдэг байсан хэдий ч, ямар нэгэн хэмжээгээр ялгавар байсаар байв. Гэхдээ энэхүү ялгавар нь түүний сургаалыг сонсогч шавь нараас өөрсдөөс нь болон тэдний аливааг ойлгох чадвараас нь үүдэн гардаг байлаа. Будда өөрийнхөө мэддэг зүйл буюу номловол зохино гэж үзсэн зүйлийнхээ хооронд зааг тогтоожээ.

Бурхан багш нэг удаа Симсапын төгөлд явж байхдаа газраас атга навч аваад шавь нартаа харуулж : - “Миний атганд байгаа навч энэ төглийн бүх навчтай харьцуулахад өчүүхэн багын адил, миний та нарт зааж байгаа эрдэм миний мэддэгийн дэргэд маш өчүүхэн бөгөөд би та нарыг гэгээрэхэд хэдий хэр эрдэм хэрэгтэй вэ, тэр хэмжээний эрдмийг л заана” гэсэн байдаг.

Ялгахуйн энэ төрлийг номлогч бүр ерөнхийд нь болоод тухайн тохиолдолд хэрэглэж байсан юм. Дхармад шүтэн дурлаагүй хүн, түүнд хүрэх ухаан эрдмийг төгсөөгүй хүн,

түүнийг нээж чадахгүй, гагцхүү дээд эрдэмд тэмүүлж хэрэгтэй цагт нь, хэрэгтэй газарт нь номлож чадах хүн л номлох ёстой.

Энэ бол эрин үе ба улс орон бүрт, Буддизмын амьд үзэл санааг хадгалан үлдэхийн тулд Буддын сургаалыг номлох илэрхийллийн хэлбэр, өөрийн гэсэн аргатай байвал зохино гэсэн үг юм. Энэ “үзэл санаа” бол философийн сэдэв ч биш, метафизик үхширмэл суртал ч биш, энэ бол ертөнц болоод бидний ухамсрын үзэгдлүүдийг хоёрдмол байдлаар ч биш, бүрэн бүтнээр нь ойлгох ёстой гэсэн оюун ухааны шинэ байдалд өгч буй түлхэц юм. Ухамсарт гарсан энэ эргэлтийн ачаар бүх юмс гэнэт цоо шинээр төсөөлөгддөг. Учир нь хөгжлийнхөө янз бүрийн түвшинд, янз бүрийн ертөнцийг туулж өнгөрдөг, бидний ухамсарт дотоод, гадаад хоёр ертөнц адил тэгш, харилцан хамааралтай үзэл болдогт байгаа юм. Гэвч хөгжлийн түвшин нь “би” хэмээх хуурамч үзэгдэл болон амин хувийн эрх ашгийн үүднээс ертөнцийг харж, бүх юмсын дотоод хэлхээ холбоог зөрчих явдлыг гэтлэн давахаас хамаарна. Үзэн ядах, шунах, зовохын эх булаг болсон би-г баримтласан хар амиа хичээх хуурамч үзэгдлийг гэтлэн давах замаар оюуны төгс тэнцвэрийг олох нь гэгээрэл юм. Гэгээрэл тийш хөтөлж байгаа бүхэн бол Буддагын зам билээ. Энэ зам нь хөдөлбөргүйгээр яг таг тогтоочихсон зам биш, цаг хугацаа болон бие хүнээс хамаардаггүй зам ч биш, Бурхан багшийн заасан зорилго тийш хөтлөн, үргэлжийн хөдөлгөөнд оршдог тийм зам юм.

Сургаал нь төгс боловсронгуй байлаа ч, түүнд хандагч нь төгс боловсроогүй байдаг учраас Буддагын сургаалын хамгийн төгс томъёоллыг ч түүний шавь нар шинээр томъёолох шаардлагатай болдог.

Энэ бүхнээс гадна бид Буддагын сургаалыг тэр цаг үеийн хэлээр, тухайн үеийн хүмүүсийн төсөөлөлд ойр дөт хэлбэрээр илэрхийлсэн гэдгийг мартаж болохгүй. Бурхан багшийн сургаалыг хадгалж үлдсэн бүх хүн архад

/ гэгээн / байлаа ч гэсэн, тэдний дамжуулсан сургаалд томъёологдож байсан үеэсээ зохиомж, хэлний талаар хамааралтай байсан баримтыг өөрчилж чадахгүй. Хараахан үүсээгүй байсан асуудлыг ч тэд ойлгох боломжгүй нь мэдээж бөгөөд тэд үүнийг урьдчилан

харж чаддаг байлаа ч үгээр илэрхийлж чадахгүй. Учир нь тэр асуудлыг илэрхийлэх хэл бас л төрөөгүй байлаа.

Будда өөрөө МЭӨ ҮI зуунд биш харин МЭ VI зуунд амьдарч байсан бол сургаалаа өөр аргаар илэрхийлэх байв. Энэ нь Буддагын номлох ёстой Дхарма буюу “үнэн” нь өөр байх байсан бус, харин тэрхүү сургаалыг сонсох ёстой хүмүүс арван зууны турш түүхэн болоод практик, оюун санааны хөгжлийн замыг туулж, тэдгээрийг илэрхийлэх ойлголтын буюу авьяас чадварын их нөөцтэй болох байсан төдийгүй, өөр асуудлуудтай тулгарч тэдгээрийг шийдэх өөр аргуудтай болох байсанд оршино.

Үгэнд сохроор итгэдэг хүн, түүнчлэн түүхэн цаг үеийг үнэнээс чухалд үздэг хүн бол үүнийг хэзээ ч ойлгохгүй. Тийм хүн хожуу үеийн Буддизмын сургуулиудыг Бурхан багшийн сургаалаас холдоо гэж шүүмжлэх болно. Гэтэл үнэн хэрэгтээ, зөвхөн Будда болон түүний тухайн үеийнхний төсөөллөөс тэд холдсон хэрэг юм.

Оюун санааны зүйлийг амьд зүйлийн адил “тэмдэглэх” боломжгүй, өсөлт зогсоход амьгүй цогцсоос өөр юу ч үлдэхгүй. Бид занданшуулсан шарилыг түүхэн үзмэр болгон хадгалж чадах авч, амилуулж чадахгүй шүү дээ. Тэгвэл бид үнэнийг эрэхдээ, түүхийн бодит гэрчид тулгуурлаагүй бол энэ нь тэрхүү хэлбэрийг хадгалан дамжуулсан хүмүүст юм уу, баримтад үл итгэснийх бус, харин мянган жилийн өмнө буй болсон хэлбэрийг шууд хүлээн авч болохгүй гэсэн үг юм. Хичнээн сайн хүнс ч удаан хадгалбал хор болно. Оюуны тэжээл ч үүнтэй ялгаагүй билээ. Үнэнийг “хүлээж авч” болохгүй, түүнийг үргэлж шинээр байлгах хэрэгтэй. Түүний оюуны тэжээллэгийг хадгалахын тулд илэрхийлэх хэлбэрийг нь байнга сольж байх хэрэгтэй болно. Энэ нь оюуны өсөлтийн мөнхийн хууль юм.

Хэрэв оюуны өсөлтийн энэхүү хуульд давтагдах юм уу, хувь хүн бүр түүнийг өөртөө шингээж байвал, энэ нь тэрхүү бие хүн өнгөрсөн, одоо хоёрыг холбогч болох төдийгүй, өнгөрсөн нь одоо сэргэн залуужиж, ирээдүйн бүтээлч чадавхийн үр хөврөл болж байна гэсэн үг юм. Ийнхүү түүх өнөөгийн амьдралд шинээр хэлбэржиж, бидний ахуйн нэг хэсэг болж байна.

Бид жам ёсны өсөлтийн учрыг ойлговоос, янз бүрийн үе шатыг зөв, буруу, үнэ цэнэтэй, ашиггүй гэх мэтээр тодорхойлохоо болино.

Бид тухайн нэг сэдэв юм уу, “шалтгааны” дүрсийн хувирлын нийтлэг хүчин зүйл, түүний үндсийн жинхэнэ мөн чанарыг тодотгоно гэсэн дүгнэлт хийж болно. Жишээлбэл: Модны үндсэн чанар нь түүний иш, үндэс, мөчир, навч, үр, өнгөөр хязгаарлагдахгүй, харин энэ бүх бүрдэл хэсгийн харилцан холбоо буюу орон зай, цаг хугацааны хөгжил, түүний нэгэн цул бүтцээс хамаарна.

Үүнтэй нэгэн адилаар, Буддизмын үндсэн мөн чанар нь хийсвэр санааны түгжигдмэл ертөнцөд биш, эртний үнэр ханхалсан үхширмэл сурталд биш, харин түүний цаг хугацаа, орон зайн дахь хөгжилд болон түүний хөдөлгөөний хязгааргүйд, амьдралын бүхий л талд үзүүлэх нөлөөнд, товчхон хэлбэл, түгээмэл нийтлэг чанарт нь оршино.

7. Махаянын нийтлэг байр суурь ба Бодьсадвын үзэл санаа

Юуны өмнө, шашны болон гүн ухааны сургаалуудад илрэлээ олсон Буддизмын нийтлэг талыг Махаяна буюу Их хөлгөний уламжлалд ухамсарт зарчмын түвшинд хүртэл өргөн мандуулсан билээ. Их хөлгөний уламжлалын бүхий л сургууль үзэл санааны ялгааг сэтгэхүйн янз бүрийн хэв шинжит ойлгох чадварыг илэрхийлэх чухал хэрэглэгдхүүн хэмээн зөвшөөрсөн юм.

Буддагийн дүрийг шашны амьдралын төв дэхь Дээд бодьгал хэмээн тахин шүтэх болсон нь Бодьсадвын үзэл санаа үүссэний ач тус юм. Ертөнц бодитой эсэх, оюуны туршлагад хандах хандлага, эрх чөлөөний байдал нь түүний хязгаарыг ямар ч замаар тодорхойллоо ч гэсэн нэг л зүйл юм. Ариусал, Гэгээрэл, Бурханлиг чанарт хүн өөрөө хүрсэн бөгөөд энэ нь хүн бүхэн түүнд энэ л замаар явж хүрнэ гэсэн “үнэн” хувиршгүй хэвээр үлдэв. Энэ талаар Буддизмын бүх сургууль уламжлал санал нэгтэй байна.

Энэ зам бол ертөнцөөс ангижирч байгаа хэрэг бус, харин ч түүнийг билгүүн ухааны өсөлт, идэвхтэй дур хүсэл, нигүүлсэхүйн сэтгэлээр даван туулж байгаа хэрэг юм. Энэ замыг Бурхан багшийн урьд төрлийн намтар болох Жатака-д дэлгэрэнгүй өгүүлсэн юм.

Бид энэхүү намтрын түүхэн үнэ цэнийг хүлээн зөвшөөрөхгүй байсан ч, тэр нь эртний Буддистуудын байр суурь төгс гэгээрлийн замын тухай тэдний төсөөллийг харуулдаг билээ.

Дундад зууны эртний Буддизмын Бага хөлгөн “Тхеравадин” буюу “Ахмад гэлэн нарын сургаал”-д, төгс гэгээрэлд хүрсэн гурван янзын хүмүүсийн тухай өгүүлдэг. Энэ нь нэгдүгээрт: Ариуссан буюу архад бологсод нь - шунал тачаал, хувиа хичээх хуурамч үзэгдлийг гэтэлж даван гарсан боловч бүхнийг хамарсан мэдлэг, бүхнээ нэвтрэгч төгс ухамсрыг эзэмшээгүй хүн, хоёрдугаарт: Паччекабуддха / Пратьекабуддха / буюу “дуугүй гэгээрсэн” нарын хувьд бол Бурхан багшийн мэдлэгийг эзэмшсэн боловч түүнийгээ бусдад хүргэх чадваргүй хүн, гуравдугаарт нь: Саммасамбуддха / Самьяksamбудда / буюу үнэхээр гэгээрсэн Будда юм. Энэ бол гэмээс ангижирсан билгүүн ухаантан, сэрсэн гэгээнтэн төдийгүй, оюун ухааны хувьд төгс гэгээрсэн, бие махбодын хувьд эглийн хязгаарыг давж бүх чадвар нь төгөлдөржсөн, ухамсар нь төгсгөлгүй орчлонг багтаасан “хэмжье гэвээс хэмжүүр олдохгүй, хэлье гэвээс үг олдохгүй” тийм төвшинд хүрсэн хүн буюу бурхан юм.

“Архад”, “Пратьекабудда”, “Самьясамбудда” хэмээх үгс нь эхлээд тухайн түвшинд хүрсэн хүмүүсийг нэрлэж байжээ. Гэвч, Буддагын Сургаал ёсоор, аливаа хүнийг бүх ааш араншин, зан чанартай нь нэгмөсөн бүтээгээгүй, тэдгээр нь үргэлж хувьсан өөрчлөгдөж байдаг болохоор, дээрх гурван түвшинг мэдсэнээр, гурван өөр үзэл санаа төлөвших нь зайлшгүй бөгөөд тэдгээр нь хамгийн дээд үзэл санаа байх нь гарцаагүй. Энэ байдал нь тоо томшгүй олон амьд бодыг төрөх, үхэхийн ертөнцийн харанхуй далайг гаталсан авралын гэрэл гэгээнд дуудаж, түүний үр дүнд хувь хүнийг энэхүү авралын замд хөтөлсөн сургаал буюу архадын үзэл санаа нь Хинаяна буюу Бага хөлгөн хэмээн нэрлэгджээ.

Бурханы шашны олон урсгалын төлөөлөгчид цугларч авралд хүрэх үзэл санаа, түүний зам мөрийг хэлэлцэж байсан манай эриний I зуунд Канишка хааны удирдсан хурал дээр, анх Хинаяна болон Махаяна гэдэг нэр томъёо үүсчээ. Энд ч гэсэн Махаянагийн үзэл санаа Буддизмын янз бүрийн сургуулиудын хооронд гүүр болж чадах цорын ганц үзэл санаа

болохоо харуулсан юм. Тиймээс тэр хуралд оролцогсдын олонхи нь Махаяныг шилж, Хинаяныг сонгож авсан цөөнхи удалгүй сургуулийн хувьд устсан юм.

Гэвч, энэ хурал дээрх Тхеравадчууд нэгдэх боломж байсангүй. Учир нь Тэд Бодьсадвын үзэл санааг үгүйсгэдэггүй байсан юм. Тхеравадчуудын үзэл санааг Цейлоны Буддизмын нэг удирдагч ийнхүү тайлбарлажээ.

“Буддизм гэдэг бол зовлонгоос өөрийгөө аврахын төлөө хөдөлмөрлөх хүсэлтэй хүмүүст ч, бусдыг аврахын төлөө хөдөлмөрлөхийг хүсч байгаа хүмүүст ч нэгэн адил хандсан сургаал юм.

Бидний дотор ертөнцийн зовлонгоос ангижирч, авралд хүрэх өчүүхэн боломжийг ч хайж байдаг хүн олон ажээ.

Гэтэл, амьдралын бүх зовлонг ойлгох төдийгүй, мэдэрдэг хүмүүс ч бий бөгөөд тэдний сэтгэл агуу уудам учраас өөрийгөө аврахаас татгалзаж, амьдралаа хүн төрөлхтөнд үйлчлэх эрхэм дээд зорилгод зориулдаг юм.

Энэ бол бодьсадвын эрхэм ариун үзэл санаа бөгөөд ертөнцөд хамгийн цэвэр, хамгийн сайхан нь билээ. Бодьсадвын энэхүү үзэл санаа Буддад хамгийн ойрхон үзэл санаа гэж хэлж болно.” хэмээсэн юм

Гэвч, ойр дотнын хүмүүстээ үйлчлэх нь эрхэм дээд зорилгод тэмүүлэхээс татгалзаж байгаа хэрэг биш юм. Энэ үзэл санааг үндэслэгч Миларайба нь “юуны өмнө өөрөө үнэнд хүрээгүй цагт бусдын төлөө зүтгэх гэж хэтэрхий яарах хэрэггүй. Хэрэв бид ийнхүү яарах аваас сохор хүн сохор хүнийг хөтөлж яваатай адил болой. Тэнгэр байгаа цагт амьд амьтанд төгсгөл гэж үгүй, хүн бүр ийнхүү зүтгэх боломж олдоно, ээлж тань болоогүй цагт зөвхөн ганцхан зүйлд, тухайлбал, амьд бүхний тусын тулд Буддагын хүрсэн оргилд хүрэхийг эрмэлз гэж би хүн бүрт хэлмээр байна” гэсэн байдаг. Ингэхийн тулд Бодьсадвын дээд буяныг үйлдэх шаардлагатай.

Энэ нь муу муухайгаас зугтах төдий бус, бусад амьд амьтны зовлонг өөрийн зовлон мэтээр мэдрэн, хамаг амьтны зовлонгийн галд төрсөн амь хайргүй өгөөмөр сэтгэлдээ сайны үр бүхнийг соёолуулна гэсэн үг ээ. Бодьсадва бусдыг сургах зорилт тавьдаггүй,

өөрийн оюуны замаар ойр дотныхноосоо анхаарал салгалгүй урагшилдаг юм. Тэр ийнхүү эрхэм дээд зорилгод хүрэх замдаа өөрөө боловсорч, бусдыг ч мөн энэ л замаар урагшлахад зоригжуулдаг.

Бусдын төлөө өөрийгөө золиосолж байгаа нэг ч хүн балран доройтохгүй, тэр ч байтугай золиос болгож буй этгээдүүд түүний зүтгэлийг урвуугаар ашигласан ч балран доройтохгүй. Өөрийгөө золиослох үйлдэл бүхэн нь өөрийн эрх ашгаас татгалзаж, өөрийгөө ялж буй ялалт учраас авралд хүрэх үйл юм. Гадаад тал нь ямар ч байлаа гэсэн ийм үйлдэл бүхэн бидний тавьсан зорилго өөд нэг шат ахиулж, анатма хэмээх үзэл санааны онолын ойлголтыг амьд мэдлэг туршлагаар олж авсан итгэл болгоно. Хүн “би”-гээс хэдий чинээ холдож, өөрөө өөртөө барьсан шуналын шоронгын ханыг нураах тусам амьдралын гэрэл гэгээ ч тодорно. Үүний ачаар бид бусдад өглөг өгч, сайхан үг хэлж, шашны ном айлдсанаас илүүгээр амьтанд туслах болно.

Гэвч, амьдралаас зугтдаг хүн өөрийгөө золиосолж, арайхийж олж авсан зүйлээсээ татгалзах нь бусдын төлөө зүтгэх өргөн боломжийг алддаг. Ингэхлээр бусдад туслах, өөртөө туслах хоёр нь салшгүй холбоотой нь эндээс харагдаж байна.

Гэхдээ бид ёс суртхууны давуу талаа мэдэрснээс сайн үйлээ бусдад тулгах ёсгүй, бид жинхэнэ харамгүй сэтгэлийн үүднээс урсгалаараа энэ бүхнийг үйлдэх ёстой.

Чухамхүү ийм л эрдмийг Миларайба ёс суртхууны болон Бодьсадвын буянт үйлсийн үндэс гэж үзсэн юм. Гагцхүү энэ эрдэм л Буддаг урьд төрлүүдэд нь гэгээрлийн замаар хөтөлж, зөвхөн өөрийн туршлага, олон төрлийн зовлонгоор дамжин төгс ариусгахын тулд өөрөө түргэн зуур ариусахаас татгалзахад хүрсэн юм.

Гагцхүү энэ л эрдэм амьд бүхэнд гэгээрэх чадвар буй хэмээн сургасан гэрэлт номлолоо айлдахын тулд Гэгээрлийн модноос холдоход хүргэсэн билээ. Уг чадвар нь аль нэгэн амьд амьтны ухамсарт хүчтэй болоход Бодьсатва төрдөг юм. Энэхүү ухамсрыг сэргээх нь Буддагын амьдралын гол зорилго байлаа. Ийм л шалтгаанаар Будда өөрөө эрх чөлөөнд, цэнгэлийн дээдийг эдлэхийн оронд тэнүүлчийн хүнд бөгөөд урт удаан амьдралыг туулахад хүрсэн байна.

8. Ум хэмээх ариун үгийн нийтлэг

зам буюу дахин сэргэлт

Буддаг шууд залгамжлагчид түүний анхны шавь нарын үг бүрийг, тэдний амьдралын хэвшлийн юм бүхнийг хадгалж үлдэхийн тулд лам нарын амьдралын үй олон дүрэм, хэм хэмжээ зохиосноор, үг үсэгтэй хөөцөлдөн үнэн агуулгыг мартагдахад хүргэжээ. Өөрийгөө үл хайрлагч, итгэл дүүрэн номлоочид, орон гэргүй Даяанч нарын оронд сайн зохион байгуулалттай, сэтгэл хангалуун, ертөнцөөс тасархай лам нарын нийгэм буй болж, тэд хүмүүсээс болон ертөнцөөс таслагдсан хангалуун тохилог хийдүүдэд шигдэн сууцгааж, амьдралын бэрхшээл тэмцлээс зугтааж байлаа.

Буддизмын түүхийн эхний зуун жилийн бүх хагарал, санал зөрөлдөөний шалтгаан нь Буддагын сургаалын гол асуудлууд бус, харин Сангагын дүрэм горим, зарим нэг ухагдхууны цэвэр онолын дүгнэлт, эсвэл Буддагын сургаалын аль нэг талыг хэт дөвийлгөсөн зүйлс байв.

Буддаг таалал төгсөнөөс хойш, зуун жилийн дараа Вайсалын хийдэд анхны хагарал гарсан бөгөөд Бага хөлгөнийхний чиглэлийг тууштай баримтлагч бүлэг нь харьцангуй цөөн тооны хуврагын тайлбар, эрх ашгийн төлөө олонхын саналыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж, Буддын хуврагын чуулганы гол бүрэлдхүүнээс тусгаарлагдсан байна. Харин олонхын тохиролцсоны дагуу Бурханы номын үзэл санаа, хувь хүний бодьгал мэдрэмжинд онцгой анхаарах нь зүйтэй гэж үзжээ. Энэ талаар гарамгай хоёр түүхчийн гаргасан саналыг дор дурьдаж болох юм.

“Вайсалын хийдийн түүх хичнээн үнэн бичигдсэн хэдий боловч шийдэж боломгүй зүйл байсан юм. Учир нь бидэнд мэдэгдэж буй гэрчлэх баримтууд олон зүйл дээр харилцан зөрж байгаа бөгөөд ер нь л Бага хөлгөнийхний ашиг сонирхолд чиглэгдэж байсан билээ. Буддистууд энэхүү хагарлыг Бурханы сургаал дахь зөрчил биш, харин хуврагуудын сахилга баттай холбоотой зөрчил хэмээн дүгнэсэн нэг л баримт тэдгээрээс хамгийн чухал нь байв гэжээ.” / Glasenapp. Н, 1936, 51 - р хуудас /

Бага хөлгөнийхний гэрчилснээр, зөрчилдсөн зүйлүүдийн ихэнхи нь хэдийгээр бүдүүлэг байсан ч, тэд нар тийм ширүүн маргаанд бусдыг уриалж чадсан нь гайхалтай байв. Энэ талаар түүхч, судлаач Рис Дэвидс хатагтай үнэн зөв тэмдэглэж хэлэхдээ:

“Үнэндээ уг хэрэг нь шатлан захирах ёсны төвийн тэргүүний үзэл санаа зөрчилдсөн хэрэг бөгөөд өөрөөр хэлбэл, бие хүний болон тэрхүү зах хязгаар нутаг дахь хуврагын чуулганы эрхийг хамгаалсан асуудал байсан юм. Хэдийгээр тэдний амьдрал нь бүлгээрээ амьдардаг нэгэн маягын хэв загвартай ч гэсэн, мөн гэлэн хүний хувьд дэг ёсыг хатуу баримтлах учиртай байсан боловч тэдэнтэй бусад хуврага нарын адил хүндтэй байр сууринд, хүний ёсоор харьцах ёстой байсан юм. Тэд бусдын адил Бурханы сургаалд зааснаар / Агта - Дхаммо / өөрийн дотоод сэтгэлийг сонссоны дагуу сонгох болон шийдвэрлэх эрхээ эдлэх бүрэн бололцоотой болох ёстой байсан юм” / Rhys Davids, C. A. F, 1931, 355 - р хуудас / гэжээ.

Амьдрал үйл ажиллагаа нь, сургаалынх нь хамгийн амьд илэрхийлэл болсон Буддагын дүр буддистүүд илүү ухамсартайгаар хандах болсоны дараа л Буддизм өөр хоорондоо сөргөлдөгч олон урсгалаас дэлхийн том шашин болж өссөн билээ. Эрс тэс зөрчилтэй урсгал, үзлүүдийн сөргөлдөөн дунд Буддагын үлгэр жишээг дагахаас өөр үнэн зам юу байх билээ. Түүний үгийг янз бүрийн эрин үед янз бүрээр тайлбарлаж болно. Харин түүний амьд жишээ нь хүн төрөлхтөн оршин байгаа цагт эрин үе бүхэнд ойлгогдох мөнхийн хэлээр ярьдаг юм. Буддагын оройн дээд болсон гэгээн дүр, түүний үнэн бодитой хийгээд домгийн амьдралын гүн гүнзгий билэгдэл бол хүн төрөлхтөнд философийн бүх тогтолцоо, Абхидхармын бүх хийсвэр онолоос хязгааргүй илүү чухал билээ. “Би” хэмээх бодит зүйл байхгүй тухай, хутагтын найман зам, дөрвөн дээд үнэн, арван хоёр шүтэн барилдлагын хууль, гэгээрэл буюу авралын тухай сургаал зэрэг Буддагын өөрийн амьдралын жишээгээр харуулсан сургаалуудаас илүү гүн гүнзгий сургаал гэж юу байх билээ.

“Хамаг амьтаны тусын тулд би хүмүүний ухааны хамгийн төгс боловсронгуйг цогцлооно” гэдэг бол Бодьсадвын мөн чанар юм.

Зураач хүн агуу их мастериин ур чадварт хүрэх эсэхээс үл хамааран, түүнээс үлгэр жишээ авдагын адилаар, оюун ухаанаа хөгжүүлэхийг зорьсон хэн ч гэсэн, ой тойндоо байгаа хамгийн дээд үзэл санааг өмнөө тавьж явах ёстой. Ингэж байж л амжилтын оргилд хүрэх болно. Учир нь тухайн хүний авьяас чадварын хэмжээ хязгаарыг хэн ч урьдчилан хэлж чадахгүй бөгөөд үнэн хэрэгтээ бидний хүсэл эрмэлзлэлийн хүч нь тэр хязгаарыг тогтоодог биз ээ. Дээдийн дээд зорилгод тэмүүлсэн хүн л хязгааргүй хүчтэн болох ба үүгээрээ өөрийн авьяас чадварын хүрээг хязгааргүй болтол тэлж, хязгаартайг хязгааргүй болгож чадна. Энэ нь түүнийг эрхэм дээд ололт бүхэнд зоригжуулна. Тиймээс тухайн хүний авьяас чадварын хязгаар хаана байгааг хэн ч хэлж чадахгүй бөгөөд зөвхөн бидний хүсэл эрмэлзлэлийн хүч л энэ хязгаарыг тодорхойлж чадна. Дээд зорилгод тэмүүлж байгаа хүн л дээд зэргийн хүчийг олох ба үүгээрээ өөрийн авьяас чадварын хүрээг хязгааргүй болгон тэлж, төгсгөлгүйг төгсгөлтэй болгож, төгсгөлтэйг төгсгөлгүй болгоно.

Махаяны энэхүү нийтлэг байдлыг илэрхийлэхийн тулд тухайн хүн “Ум” хэмээх ариун үгийн тусламжтайгаар Бурханд хандсан залбирлын үг бүхнээ боловсруулдаг. Ийм байдлыг “Ум” -аас өөр ямар ч билэг тэмдгээр илэрхийлэх боломжгүй юм.

“Ум”-ын тухай Рабиндранат Тагор, “Эцэс төгсгөлгүй бөгөөд төгс, үхэшгүй мөнхийг илэрхийлсэн билэг тэмдгийн үг байдаг юм. Тэр нь авианы хувьд төгс боловсронгуй бөгөөд бүх юмсын цогц нэгдлийг төлөөлдөг. Бидний бүх бясалгал “Ум” -аар эхэлж, “Ум” -аар дуусна. “Ум” нь мөнх боловсронгуйн мэдрэмжээр оюун ухааныг дүүргэж, түүнийг аминч явцуу ертөнцөөс чөлөөлөхийн төлөө үйлчилдэг юм” гэж хэлсэн нь бий.

Буддизм дэлхийн хэмжээнд үйлчлэх үүргээ ухамсарлах дэлхийн гол шашнуудын нэг болоход “Ум” шашны амьдралыг хөдөлгөгч хүч дахин болж, эрх чөлөөнд тэмүүлэх бүхнийг хамарсан тэмүүлийн билэг тэмдэг болсон билээ. Түүнд шингэсэн нэгдэл, нийтлэгийн мэдрэмж нь эцсийн зорилт биш, жинхэнэ аврагдал, төгс гэгээрлийн угтвар нөхцөл болсон юм. Тэр бол өөрийгөө аврах юм уу, хэн нэгний оюуныг ертөнцийн оюунтай нэгтгэхэд биш, амьд бүхэн, юмс бүхэн нэг нэгэнтэйгээ салшгүй холбоотой, “өөрийн” ба “бусдын” хэмээн ялгаж зааглах нь төөрөгдөл ба бид эхлээд энэхүү төөрөгдлийг арилгаж, бүхний

нийтлэг ухамсараар өөрийгөө дүүргэн, дараа нь аврагдах хөдөлмөрийг дуусгаж чадна гэдгийг ойлгосныхоо үндсэн дээр гэгээрэлд тэмүүлэхийн билэг тэмдэг болох юм.

Иймээс “Ум” нь Буддизмын мантрын тогтолцооны туйлын дээд нь төдийгүй, Бодьсадвын замын эхэнд байх үндсэн билэг тэмдэг юм. Тиймдээ ч Ум нь бүх мантра, бүх тарнийн эцэст биш, зөвхөн эхэнд байдаг юм. Буддагын зам “Упанишада”-гийн дууссан цэгээс эхэлдэг гэж хэлж болно. Гэхдээ энэхүү хоёр тогтолцоонд “Ум” гэдэг нэг л билэг тэмдэг байх бөгөөд түүний утга аль алинд нь хэвээр байна. Иймээс “Ум” бол Буддизм дахь Брахманизмын уламжлалын үлдэгдэл гэх юм уу, Упанишада руу буцаж буй хэрэг хэмээн ойлговол туйлын буруу. Нирваан гэдэг үг буддистуудад ч, индиустуудад ч ялгаагүй гэж үзэх нь том алдаа биз ээ.

Махаянад “Ум” -ыг сэргээснийг зөвхөн нийт тогтолцоо, мантрын дадлага туршлагыг бүхэлд нь авч үзсэнээр л ийнхүү ойлгож болно. Энэ тохиолдолд оюун ухаан, санаа сэтгэлийг чөлөөлөгч энэ ариун үгийг заахад л хангалттай. “Ум” нь “би” хэмээх аминчхан, зохиомол хаалтыг нурааж, бидний төрөлх чанар хязгааргүйг, бид амьд бүхэнтэй нэгдмэл болохыг ухамсарлуулдаг.

“Ум” бол цаг хугацаанаас үл хамаарах бодит байдлын анхны авиа юм. Энэ бол бүх юмсын төрөлх хуулийн авиа, бүх хөдөлгөөний мөнхийн хэмнэл бөгөөд уг хуулийг төгс, эрх чөлөөний илэрхийлэл болгодог хэмнэл юм.

Иймээс ч “Шурангама судар” – т: “Та бурхан багшийн үгийг нь сонсон, сургаалыг нь судалж цээжиллээ. Тэгсэн мөртөө та яагаад Бурхан багшийн сургаалын “өөртөө байгаа Дхарма”-ын дууг чагнан байж чин сэтгэлийн угаас судлаагүй юм бэ? хэмээн асуусан байдаг. / Buddhist Bible, 1938, 258 - р хуудас /

Жинхэнэ үнэн сүсэгтэн хүн рүү, зүрхэнд нь нэгэн жигд дуудагдаж буй “Ум” хэмээх авиа нь, амьтай бүхнийг тэврэхээр дэлгэсэн гарын адил юм. Тэрбээр, ганцхан өөрийгөө дээдлэх бус, харин дэлбээ юугаа хэний ч нүднээс үл харамлан дэлгэгч цэцэгс лугаа адил, хорвоог бүхэлд нь багтаасан мэдрэмжийг илэрхийлдэг. Тэрбээр өгөхийн зэрэгцээ авдаг,

гэхдээ харамч шуналаас ангид бүхнийг авч, бусдад хүчээр нөлөөлөхийг үл оролдогчид өгдөг билээ.

“Ум” ийнхүү амьд бүхнийг үл ялгаварлан авралын үүдээ нээж, хэн бүхэнд хэрэгцээнийх нь дагуу, мөн чанар, сонгосон замд нь тохируулан тусалдаг хорвоогийн байр суурийн билэг тэмдэг болсон юм. Ийм үзэл санаа нь хүн бүхний өөрсдийнх нь сонгосон замыг дэмждэг учраас үхширмэл үзэл санаанаас ялгаатай байдаг билээ. Гэхдээ үүнийгээ ямар нэгэн түүхэн гэрчилгээгээр бус, одоо цагийн үнэ цэнээр олддог логик баталгаа нотолгоогоор бус, харин өөрийн урамшуулагч чадвараар, ирээдүйд нөлөөлөх бүтээгч нөлөөгөөр баталдаг юм.

Хоёрдугаар бүлэг

“МАНИ”

Философийн чулуу ба “Мөнхийн рашаан”

Маанийн билэг тэмдэг нь зарим нэг хэл, иргэншлийн соёлын хүрээнээс үүсч, тухайн нэг газар орон, үндэстэн ястанд үүсээгүй, хүн төрөлхтөний соёл иргэншил, шашин шүтлэгийн аль нэг үетэй холбоогүй, харин хүн төрөлхтөний нийтийн хүртээл болсон огт өөр шинж чанартай билэг тэмдэг билээ. Ийм билэг тэмдэг нь нэгэн газар алга болж, бүхэл бүтэн зуунаар ч сураггүй байснаа, өөр газарт шинэ бөгөөд илүү боловсронгуй хэлбэрээр дахин үүсч чадна. Тэдгээрийн нэр, тэр ч бүү хэл агуулганд нь чухам ямар тал давалгайлж байгаагаас хамааран өөрчлөгдөж болох ба ингэхдээ өөрийн анхны чиглэлээ алддаггүй. Учир нь билэг тэмдгийн мөн чанар нь түүний үүсч гарах хөрс болсон амьдралын адил олон талтай бөгөөд түүний шинж чанар ба амьд нэгдэл нь хэвээр үлдсэн байдаг юм.

Тэдгээр билэг тэмдгийн дотроос хамгийн их дэлгэрсэн нь нэгэн зүйл бол хийсвэр геометрийн дүрс, шугаман хэлбэрээр, эсвэл, шашны шүтээний объект маягийн нүдэнд үзэгдэх хэлбэрийг олсон билэг тэмдгүүд юм. Гэвч зөвхөн оюун ухаанд төсөөллийн хэлбэрээр орших үл үзэгдэгч билэг тэмдгүүд ч бий.

“Философийн чулуу” нь тийм үл үзэгдэгч билэг тэмдгүүдийн нэг бөгөөд философи, шинжлэх ухааны салбарт хамгийн олон үзэгдэгч билэг тэмдэг бөгөөд агуу их нээлт, шинэ санааны эхлэл болдог учраас хамгийн сонирхолтой, хамгийн нууцлаг билэг тэмдэг ч байж мэдэх юм. Түүний ард байгаа мөнхийн зүйл бол нөгөөх “прима матери” буюу мөнхийн бодьгал, ертөнцийн дээд зарчим мөн. Хэрэв энэ санааг баримталбал, ертөнцөд оршин буй юмс бүхэн, бүх элемент, бүх үзэгдэл нь нэг л хүч буюу бодьгалын олон янзын хувилбар болно. Түүнийг ялгаж, салгаж төрөлжүүлэх явцад давхарлан бүрхсэн олон чанараас нь салган цэвэрлэвээс, жинхэнэ уг дүр төрхөөр нь сэргээж болно. Иймээс түүний цэвэр хэлбэрт нь нэвтэрч чадвал, бүхий л элемент үзэгдлийн өөрчлөх зарчим дээр тогтоосон бүх бүтээгч хүчний нууцад нэвтрэх түлхүүрийг атгана.

Өрнөдийн шинжлэх ухаанд энэхүү үзэл санааг өчигдөрхөн дундад зууны хийрхэл хэмээн дооглож байсан бол, өнөөдөр цөмийн физикийн салбарт хийсэн шинэ нээлтээр төрсөн ойлгож болохуйц онол гарч ирэв. Тус нээлтийн нөлөө орчин үеийн сэтгэлгээний бүхий л салбарт нэгэнт мэдрэгдэх болж, орчлонгийн тухай шинэ төсөөллийг бий болголоо.

Хүн төрөлхтөний сэтгэлгээний бүр эхэн үеэс ертөнцийн мөн чанарыг шинжлэх судалгаа нь эсрэг тэсрэг хоёр замаар явсан юм. Нэг талаас материйг, нөгөө талаас хүний сэтгэл санааг судалж ирлээ. Өнгөц харахад энэ нь огт өөр хоёр үйл явц мэт харагдавч, үнэн чанартаа нэг их ялгаатай биш юм. Зөвхөн хүнийг л санаа сэтгэлийн хүчтэй амьтан гэж үзэж байсангүй. Бас амьтан ургамал төдийгүй, “амьгүй матери”-ийг ч ийнхүү үзэж байв. Үнэт эрдэнийн чулуу, төмөрлөг нь хүний сэтгэхүйд нөлөө үзүүлдэг гэсэн итгэл манай үед ч байгаа билээ.

Ийм хүчин хаанаас үүсдэг талаар, хүний санаа сэтгэлээс үү, эсвэл хүн нэг хэсэг нь болсон байгалийн элементүүдээс үү гэдэг нь, тийм ч чухал биш байгаа юм. Энэ хоёр тохиолдлын аль алинд үр дүн нь нэг л байх бөгөөд хоёр талд адилхан нөлөөлөх байлаа. “Прима материйг” нээж чадсан хүн үүгээр байгалийн нууцыг тайлж, элементүүдийг нь эрхэндээ авах төдийгүй, “мөнхийн рашаан”-ыг олох байлаа. Учир нь материйн анхны эх

булаг хүртэл нь нэвтэрч чадсан юм чинь, дараа нь түүнийг жаахан ч гэсэн боловсронгуй болгох юм уу, зарим нэг шинж чанар нэмэх замаар юу дуртайгаа үүсгэж болох байв.

Грекүүд, дараа нь Арабууд, дундад зууны Алхимичид иймэрхүү байдлаар төмөрлөгийг өөрчлөх онолоо үндэслэж, түүнийгээ туршлагаар нотлохыг оролдож байх үед, Энэтхэгт энэ зарчмыг оюун ухаанд хэрэгжүүлэхийг оролдон, хүн бүрт байдаг хамгийн анхны дээд зарчимд нэвтэрч чадсан хүн л гадаад ертөнцийн элементүүдийг өөрчлөх төдийгүй, өөрийнхөө махбодыг ч өөрчилж чадна, ингэснээр тэр хүн оюун санааны ч, эд материалын ч хүрээнд адилхан хүчин төгс “сиддхи” буюу “шид” хэмээх гайхамшигт хүчийг олно хэмээж байв. Тийм ч учраас дээд зэргийн чадвар эзэмшсэн йогууд өөрийгөө сорьж, материаллаг зүйлсийг өөрчлөх дасгалаар туршиж байсан гэдэг.

Эдгээр гайхамшигт хүчийг олсоны дараа Сиддхи буюу төвдөөр: Дүбчин хэмээн нэрлэгдэх болсон Сангасва нарын намтар, түүх сургаал Төвдийн уламжлалаар дамжин бидэнд иржээ. Гэвч Лалынхан Энэтхэгт довтлохдоо, тэдгээрийн намтар бүтээлийг нарийвчлан устгасан учраас Энэтхэгийн уран зохиолд л үлдэн зөвхөн хоцорчээ. Гэвч, Төвдөд тэднийг “Наян дөрвөн шидтэн” гэж мэддэг юм. Гэхдээ тэдгээр намтар бүтээлийг Энэтхэгт “Сандхьябхаша” хэмээх билэгдлийн тусгай хэлээр бичсэн байдаг. Санскрит хэлний энэ үг нь “бүдэг”, “бүрхэг” гэсэн утгатай байдаг нь нэг үг хоёрдмол утгатай гэдгийг илтгэнэ.

Билэг тэмдгийн энэхүү хэл нь нэг талаас мунхаг харанхуй этгээд йогийн арга болон сэтгэхүйн хүчийг урвуугаар ашиглахаас сэргийлэх, нөгөө талаас оюун ухааны эрхэм дээд мэдрэмжийг ердийн хэлээр илэрхийлэх аргагүй байдлыг харуулж байна. Энгийн үгээр тайлбарлах аргагүй тэрхүү зүйлийг гагцхүү ялгуусан ухаантан аналог, парадоксоор дамжуулж ойлгоно.

Иймэрхүү юмыг би өөрийн түрүүчийн бүтээллүүддээ заасан шидтэнгүүдтэй түүх, оюун ухаанаар холбоотой Японы Зэн буддизм, эсвэл Хятадын Чань буддизмээс олж болох юм. Тэр ч байтугай хамгийн нарийн домог хууч ярианд ч тусгагдсан байх, цэвэр оюуны

өрөөсгөл тайлбар оруулахгүйн үүднээс энэ хоёр чиглэлд ер бусын жигтэй санаа, ашиглах, хэтрүүллийн арга зэрэг юмс дүүрэн орсон байх ажгуу.

Шидтэнгүүдийн билэг тэмдгийн хэлэнд бясалгалын тушлага болон гадаад үйл явдалд оюуны дотоод үр дүн гайхамшигтай ер бусын дүрээ хувьсгаж, харин зүйрлэлүүд нь түүхэн үнэнээс гажсан юм шиг харагддаг. Энд жишээлбэл, тодорхой шидүүдэд өгүүлэхдээ, тэд нар сарны хөдөлгөөнийг зогсоосон, эсвэл Ганга мөрний урсгалыг зогсоосон гэж гардаг. Энэ бүхэн нь тэнгэрийн эрхэсүүд, эсвэл Энэтхэгийн ариун мөрөнтэй ямар ч холбоогүй. Харин сэтгэхүйн эрчим хүч нар, сарны урсгалтай холбогдож, тэдгээрийг йогчдын биенд үүссэн онцгой чанар гэх мэтийг нэгтгэсэн зүйл болдог. Шидтэнгүүдийн алхимийн нэр томьёо болох “Гүн ухааны чулуу”, “Мөнхийн рашаан”-ы талаар хийсэн тэдний эрэл хайгуулыг бид ийм л байдлаар ойлгох ёстой.

Багш Нагаржунай болон “шидтэн”-үүдийн алхими

Наян дөрвөн шидтэний нууц алхимитэй холбоотой бүх намтар түүхийн төвд нь их багш Нагаржунай байдаг. Тэрбээр долдугаар зууны дунд үед амьдарч байсан бөгөөд харин түүнийг Мадхьямикагийн философийг үндэслэгч / II зуунд амьдарч байсан / нэр нэгтэнтэй нь андуурч болохгүй юм. Нагаржунай нь төмөр уулыг зэсэн уул болгон хувиргаж чадсан нэгэн байсан бөгөөд алт хүмүүсийн шуналыг шатааж, өөр хооронд нь эвдрэлцүүлэхээс, тус болохгүй хэмээн Бодьсадва Манзушри хориглоогүйсэн бол алтан уул ч болгон хувиргаж чадах байсан гэдэг.

Буддизмын үүднээс бол алхимийн материаллаг тал ямар ч утгагүй зүйл гэсэн энэ анхааруулга удахгүй нотлогджээ. Нагаржунай туршилт хийсээр байгаад төмөр аягаа алтан аяга болгож чаджээ. Гэтэл нэгэн удаа их багш Нагаржунай алтан аягандаа манз барьж байтал, үүдээр нь явж байсан нэгэн хулгайч алтан аягыг нь харангуутаа хулгайлах санаа төржээ. Хулгайчийн санааг мэдсэн Нагаржунай алтан аягаа цонхоор гарган шидчихжээ.

Тэгэхэд хулгайч мэл гайхаж, ихэд ичсэндээ Нагаржунай оромжинд орж ирээд, их багшийн хөлд нь сөгдөөд ийнхүү өгүүлжээ. “Та юунд ингэв ? Би хулгай хийх гэж л ирсэн. Гэтэл та сая миний зорьж ирсэн олзыг хог мэт хаяж өгсөн болохоор, түүнийг хулгайлах

гэсэн их хүсэл минь унтрав. Хулгай хийх ямар ч утгагүй, ашиггүй боллоо” гэхэд, Их багш “Би өөртөө байгаа бүхнийг хүнтэй хуваалцах ёстой. Чи хулгай хийхгүйн тулд энд байгаа бүхнээс юу дуртайгаа ав, идэгтүн, уугтүн” хэмээжээ.

Их багшийн өгөөмөр сэтгэл, сайхан санааг биширсэн хулгайч түүнд шавь орж ном заалгая гэхэд, Нагаржунай түүний сэтгэл үнэхээр хоёргүй үнэн авч, оюун ухаан нь сургаал номыг тогтоох болоогүйг мэдээд, “Чиний хүссэн юм болгон, толгой дээр чинь ургасан эвэр гэж бод. Хэрэв ингэж бодож чадвал, маргад эрдэнээс гарсан мэт их гэрлийг үзэх болно” гэж өгүүлээд оромжныхоо хаяа руу нэгэн атга эрдэнийн чулуу шидээд хулгайчийг дэргэд нь суулгаад ховсдож орхижээ.

Хулгайч байсан эр Их багшийн сургаалыг даган хүссэн бүхнээ толгойд ургасан эвэр хэмээн төсөөлж суусаар, энэ итгэл нь бүрэн батжих тэр л үед толгой дээр нь үнэхээр эвэр ургав гэнэ.

Эхлээд тэр амжилтаараа бахархаж байсан боловч эвэр нь томрох тусам сэтгэл нь түгших болжээ. Эвэр улам томорсоор сүүлдээ дааж явахын аргагүй хүнд болоход баяр хөөр нь оргүй алга болж гэнэ. Арван хоёр жил болоод Их багш түүн дээр эргэн ирж, шавиасаа “Бие чинь ямар байна ?” гэж асуухад, тэрбээр “Маш муу байна” хэмээн хариулжээ.

Тэгэхэд нь Нагаржунай ихэд инээж: “Чи толгойдоо эвэр ургасан гэж бодоод санаагаар унасны адилаар, бүх амьтан хуурмаг юмыг бодитойгоор төсөөлөн түүнтэй зууралдаж, аз жаргалаа алддаг юм.

Амьдралын бүх хэлбэр, шуналын бүх объект нь тэнгэрийн үүл лугаа адил билээ. Тэр ч бүү хэл төрөх, амьдрах үхэх ч гэсэн төөрөгдлөөс ангижирсан хүнийг дийлэхгүй. Хэрэв чи ертөнц дээрх бүх баялагыг бодитой бус, хэрэггүй хуурмаг юмс гэж мэдвэл үхэх, төрөхийн эргүүлгээс чөлөөлөгдөнө” хэмээн өгүүлжээ.

Тэгмэгц шавийнх нь нүдийг бүрхэж байсан зүйл алга болж, эргэн тойрны бүх юмс болон толгой дээрх эвэр нь ч алга болжээ. Ийнхүү тэрбээр төгс ариусч, шидтэн болсон бөгөөд Гуру Нагабодхи буюу Нагаржунайн их шавь нь болсон гэдэг.

Нагаржунайн өөр нэг шавь нь брахман Вьяли гэгч байсан гэнэ. Тэрбээр багш шигээ алхимич байсан агаад “мөнхийн рашаан” / амриту / - ыг олох гэж мэрийдэг байжээ. Тэр энэ ажилдаа бүх насаа зориулаад ямар ч үр дүнд хүрсэнгүйд эцэс сүүлдээ гутран, алхимийн томъёотой номоо Ганга мөрөн рүү шидэж орхиод гуйлгачин болжээ.

Гэтэл тэр ном нь Ганга мөрнийг уруудаж явсаар, нэгэн хотод иртэл тэнд усанд орж байсан ядуу эмэгтэй тэрхүү номыг нь олоод түүнд авчирч өгчээ. Тэр эмэгтэй түүний хөдөлмөрлөх урмыг дахин сэргээсэн учир дахиад л нөгөө ажлаа хийж толгой өөд таталгүй сууж, хичээнгүйлэн зүтгэсэн боловч бас л амжилт олсонгүй гэнэ. Тэгж байтал нэгэн өдөр нөгөө ядуу эмэгтэй ирж, алхимичид хоол бэлдэж өгч байгаад санамсаргүйгээр хийж байсан юм руу нь ногооны шүүс дусааж орхитол, эрдэмтэн алхимичийн 14 жил оролдоод олоогүй зүйл нь ядуу эмэгтэйн нэгэн удаагын болгоомжгүй хөдөлгөөнөөр буй болсон гэдэг.

Уг түүхийн далд утга нь гэвэл, амьдрал байгалийн мөн чанар, үхэлгүй мөнхийн нууцыг цэвэр оюун ухаан, аминч хүслээр илрүүлж чадахгүй бөгөөд харин байгалийн мөн чанараа алдаагүй байдал шүргэх төдийд л төрөлх мэдрэмжийнхээ хүчээр аливаа нууцыг илрүүлж болно гэсэн утгатай юм.

Цааш нь хувь заяаны гэнэтийн энэхүү цохилтонд бэлэн бус байсан брахман тэрхүү эрдэнэсийг хэнтэй ч хуваалцахыг үл хүсэн нууцаа нандигнан хайрлаж, өөрийгөө ертөнцөөс тусгаарлаж байгаа тухай ёгтлон өгүүлсэн байдаг. Тэрбээр аймшигт хавцлын дундах хясаан дээр “мөнхийн рашаан” –тайгаа суурьшина.

Харин Нагаржунай Бодьсавын үлгэрийг даган, энэхүү үнэт эрдэнийг хэрэгтэй болгонд нь өгөх зорилготойгоор олж авахыг хүсчээ. Тэр шидийнхээ хүчээр тэр даяанчийг олж уулзаад нууцаа бусадтай хуваалцахыг ятгадаг.

Уран сэтгэмж, нууцат билэг тэмдэг, түүхэн хүмүүсийн тухай өгүүлэмж холилдсон энэхүү түүхийг дэлгэрэнгүй өгүүлэх нь чухал бус, харин энэ тухай өгүүлсэн Төвдийн нэгэн гар бичмэлд мөнгөн усыг тэрхүү брахман сорилдоо хэрэглэж байсан хамгийн чухал субстанц хэмээсэн нь чухал юм. Мөнгөн усыг “Прима-матери” -тай салшгүй холбоотой

хэмээдэг Египет, Грекийн алхимичдийн уламжлалтай, Энэтхэгийн алхимичдийн уламжлал холбоотой болохыг энэ баримт гэрчилж байна.

Мани бол “Философийн чулуу” болон

“Прима-матери” мэт оюун ухааны үнэт баялаг мөн.

Алхимийн нууцлаг хэлэнд мөнгөн усыг “прима матери” -тай адиалгадаг боловч энэхүү тохиолдолд материалаг бус, Аристотелийн дөрвөн элемент шороо, ус, гал, хий буюу энэ дөрвийг төлөөлж буй, энэ дөрвөөр материалаг ертөнцийг бидэнд нээж буй тэдгээр чанаруудаас ангижирсан мөнгөн усны мөн чанар, амин сүнснийг хэлж байгаа юм.

Буддистуудын хувьд энэ дөрвөн элемент нь хатуу, шингэн, хийн байдалтай гэрэл цацруулагч зарчмууд буюу өөрөөр хэлбэл, бидний нүдний өмнөх материалаг ертөнцийг бүрдүүлж буй бодисуудын орших дөрвөн үндсэн байдлуудыг тодорхойлж буй тогтохуй, барьцалдахуй, түгэхүй, хэлбэлзэхүй чанар юм.

Энэ дөрвөн элементийн үзэл санаа, тодорхойлолт Грекийн философид орж ирсэн эх сурвалжийн тухайд ямар ч эргэлзээ байхгүй. Алхимийн зорилт нь туршиж буй объектийн элементүүдээс шороо, ус, хий, галыг салгах явдал гэдгийг бид санаж байгаа бол дундад эртний Энэтхэгийн “Кеваддха сутту”, “Дигха-Никайя” судруудыг санахгүй байхын аргагүй. Тэдгээрт мөн л үүнтэй адил зорилт: материалаг элементүүдийг уусгах зорилт байсан бөгөөд “Дхъяна” буюу бясалгалд орсон нэгэн гэлэн бүх сансар хорвоогоор аялдаг боловч энэхүү зорилтыг шийдвэрлэх гээд үл чадав. Тэрбээр эцэст нь Бурхан багш дээр очиж: ус, шороо, гал, хий, хаана дуусдаг вэ ? Энэ дөрвөн элемент хаана бүрэн алга болох вэ ? гэж асуухад:

Бурхан багш: Асуултыг ийм маягаар тавьж болохгүй. Харин эдгээр дөрвөн элемент хаана тулгуургүй болох вэ ? хэмээн асуух ёстой. Хариулт нь: үзэгдэшгүй, төгсөшгүй, гэрэл цацарсан ухамсарт эдгээр дөрвөн элемент тулгуургүй болно. / Виньянам, анидассанам, анантам, саббато - пабхам /

“Анидассанам” буюу “үзэгдэшгүй” гэдэг нэр томъёо нь ухамсар бутарч гадна өнгөөр тодрон үзэгдэх ертөнцөд орж биежин, материалаг хэлбэрийг олдог бөгөөд түүнийг бид

бие хэмээн нэрлэдэг. Үнэхээр ч энэ нь бидний өнгөрсөн ухамсрын үзэгдэх илрэл, үр дүн мөн гэсэн баримтыг сануулж байна.

“Виньянам анидассанам” нь бүрэн бүтнээрээ, субъект объектод хуваагдан салаагүй ухамсар хэмээн ойлгож болно. “Висуддхимагга”-г зохиогч Буддхагхоша энэхүү ухамсарыг Нирваантай адилтгасан байдаг. Ухамсар нь гагцхүү объектуудаар хязгаарлагдаагүй үед буюу “би”, “би үгүй” хоёрыг даван туулсан цагтаа л төгсгөлгүй болж чадах учраас энэхүү үзэл санааг “анатма” гэдэг нэр томъёо баталж байгаа юм. Ухамсарын энэ байдлын цэвэр тунгалагийг “саббатопабхам” буюу зүг бүхэнд туяа цацруулан, бүхнийг гэрлээр нэвтлэгч гэсэн нэр томъёо тодотгож байна. Өөрөөр хэлбэл, энэ нь гэгээрлийн байдалд орсон ухамсар юм.

Будда “Удане” судрынхаа VIII бүлэгт: “хатуу ч үгүй, шингэн ч үгүй, халуун ч үгүй, тогтвортой ч үгүй, энэ ертөнц ч үгүй, өөр бусад ертөнц ч үгүй нар ч үгүй, сар ч үгүй газар л ... жинхэнэ хаанчлал байна. Шавь нар минь энэ бол төрөөгүй, үүсээгүй, бүтээгүй бүрдээгүй юм. Эд байхгүй бол төрсөн, үүссэн, бүтсэн, бүрдсэн бүхэн энэ ертөнцөөс аврагдах боломжгүй байлаа” гэсэн нь мөн дээрх байдлыг өгүүлжээ.

Үүнийг ухамсарласан хүн бол үнэхээр хүний ухааны “Философийн чулуу” үнэт эрдэнэ / мани /, “прима матери”- г олсон хүн мөн. Энэ бол “Меркурий” нь дээд ухамсарын бүтээлч хүчин буюу төгс цэвэр, гэрэл цацарсан гэгээрлийн байдалд хүрэх зорилгоор материйг бүрдүүлэх элементүүдээс ангижруулах хүчин гэдгийг мэддэг агуу их алхимичдийн цорын ганц зорилго байлаа.

Энэхүү санааг наян дөрвөн шидтэний нэг, багш Канканапын намтараар илэрхийлжээ. Нэгэн цагт Энэтхэгийн дорнод нутагт эд баялгаараа барддаг нэгэн хаан байжээ. Гэтэл тэрхүү хаанд нэгэн йогч хандан: “Ертөнцийг гай гамшиг ноёлж байхад хаан чиний эрх мэдэл, эд баялаг юу юм бэ? Төрөх, өтлөх, үхэх гурав ээрүүлийн дугуй шиг эргэж байна. Дараачийн эргэлтэнд юу болохыг хэн ч үл мэднэ, жаргалын дээдэд ч хүрч болно, зовлонгийн мухарт ч хаяж болно. Өнөөдрийн баялгаар бүү бард” хэмээжээ.

Хариуд нь хаан хэлж гэнэ: “Өнөөдрийн энэхүү өндөр суудлаас би Дхармад үйлчилж чадахгүй ч, чи миний өнөөгийн байдал, хувийн чанарт тохирсон, гадаад амьдралтай минь зөрчилдөхгүй зөвлөлгөө өгч чадах юм бол, би чиний зөвлөлгөөг дагахад бэлэн байна” гэжээ.

Хаантан эрдэнийн чулуунд ихэд шунадагыг тэрхүү йогч мэддэг байж гэнэ. Тэгээд тэрхүү сул талыг нь ашиглажээ.

“Бугуйвчныхаа очир эрдэнийг нүд цавчилгүй харж бүх анхаарлаа түүнд төвлөрүүл, очир эрдэнээс солонгын бүх өнгө цацрах боловч эдгээр өнгө өөрийн мөн чанаргүй юм. Түүнтэй адилаар бидний төсөөлөлд гадаад ертөнцөөс өөрийн гэх ямар ч мөн чанаргүй янз бүрийн хэлбэрүүд үйлчилдэг. Гагцхүү ухаан л гэрэл цацруулсан үнэт эрдэнэ бөгөөд бүх юм түүнээс өөрийн дүр төрхийг авдаг юм” гэжээ.

Тэгтэл хаан зүүн гарынхаа бугуйвчинд йогчийн хэлснээр хамаг анхаарлаа төвлөрүүлэн бясалгалд орж, тэрхүү жинхэнэ цэвэр гэрэл гэгээт эрдэнийг олж гэнэ.

Хаан нэг л өөр болсныг ордныхон ажиж мэдээд нэг удаа цоожны нүхээр шагайж харвал, хаан нь тэнгэр тэргүүтэн үй олон амьтадын дунд сууж байв гэнэ. Ийнхүү хаан нь шидтэн болсныг ордныхон мэдээд адис тавьж, ном айлдахыг гуйхад хаан: “Би эд баялагийн хүчээр хаан болсонгүй, өөрийн чармайлтаар, оюун ухааны замаар ийм болов. Миний дотоод сэтгэлийн жаргал бол миний хаан төр” гэж айлдаж гэнэ. Тэр цагаас хойш тэрхүү хааныг Канканапа хэмээх болжээ.

Бүр эртний Буддизмд жинхэнэ үнэт эрдэнэс бол гэгээрэхүйн сав буюу Гэгээрэл / Будда /, Үнэн / дхарма /, Хуврага / сангха / гэсэн билэгдэл болдог бөгөөд бид гэгээрлээр дамжиж дхармад хүрдэг, сангхи (хуврага) нь гэгээрлийн мөрөөр орсон хүн хэмээн үздэг байв. Чухамхүү энэ л шалтгаанаар тэдгээрийг “гурван эрдэнэ” гэдэг билээ.

Энэхүү гэрэл цацруулсан эрдэнийг олсон хүн үхэх, төрөхийг ялж мөнхрөх болно. Гэвч энэхүү үнэт эрдэнэ нь “бадма” буюу тухайн хүний өөрийнх нь зүрхэнд л оршихоос бус өөр хаана ч байдаггүй ажээ.

Ингэхлээр “Мани” бол үнэхээр “Философийн чулуу” буюу “Хүслийг биелүүлэгч” чандмань эрдэнэ билээ. Буддизмын хожуу үед үнэт эрдэнийн үзэл санаа Очир хөлгөн болсон юм. Очир нь анх Энэтхэгийн Индра бурханы сүлд байсан билээ.

Өөрийн цаг үеийн ертөнцийн үүслийн тухай сургаалын үзэл санааг үгүйсгэлгүйгээр, энэхүү үзэл санаанд шинэ үнэ цэнийг өгч чадсан нь Буддизмын оюун санааны онцлог юм.

4. Мани бол Очир - эрдэнэ мөн

Индра болон Энэтхэгийн бусад бурхад цагийн урсгалд мартагдан, Будда хэмээх аугаа их бие хүнд байр сууриа тавьж өгөв. Аянга цахилгаан буулгагч Индра бурханы сүр хүчний билэгдэл байсан Очир оюун ухааны хаанчлалын билэг тэмдэг болсон юм. Энэ утгаараа Очир нь олон орчуулагчийн хэлсэнчлэн “Аянгын цохилт” биш болох нь ойлгогдож байна. Хэрэв Очир нь аянгын эзний сүлд гэж бодвол тэдний зөв юм. Гэтэл буддын уламжлалд ийм юм огтоос байдаггүй. Очир бол оюун санааны ялагдашгүй дээд хүчний билэг тэмдэг мөн билээ. Иймээс ч түүний ямар ч бодисыг зүсч чадах, ямар ч бодисоор үл зүсэгдэх Очир / алмааз / эрдэнэтэй зүйрлэжээ.

Буддизмд Очирыг алмаазтай зүйрлэдгийн өөр нэг учир нь, түүний хувиршгүй цэвэр тунгалаг чанарт оршино. Будда гэгээрлийн оргилд хүрсэн газрыг “Очир эрдэнийн суурин” гэдэг. “Маргаантай бүх ухагдхууныг зүсч гэгээрлийн эрэгт хүргэх Алмааз мэт хатуу, түүн лугаа адил хурц учраас энэ ариун сургаалыг “Очироор огтлогч” хэмээн нэрлэв” гэж Махаянын хамгийн гүн гүнзгий агуулгатай судрын тухай өгүүлсэн байдаг билээ.

Энэхүү сургаалыг Шашны амьдралын төвд оруулсан сургаалыг Важраяна буюу Очир хөлгөн нэртэй болсон юм.

Очир нь Төвд хувилбараар “Рдо-рже” буюу “Дорж” болох бөгөөд “Рдо” нь чулуу, “Рже” нь хаан гэсэн утгатай ажээ. Ингэхлээр “Дорж” нь “Чулууны хаан” буюу хамгийн үнэтэй, хамгийн хүчирхэг чулуу гэсэн үг юм.

Очирын хэлбэр, дүрс нь гүйцэтгэх үүрэгтээ нийцсэн байдаг. Түүний төв нь Орчлонгийн үр хөврөлийн тодорхойгүй “Биндү” / цэг, тэг, дусал / хэлбэрээр дүрсэлсэн байдаг. Энэхүү төвөөс гарсан ороомог түүний хүчийг илэрхийлнэ.

Төвөөс хоёр тийш гарсан Бадам цэцгийн дэлбээ хэлбэртэй хоёр туйл нь ухамсарт ахуйн туйллаг чанарыг илэрхийлнэ. Огторгуй буюу бидний гурван хэмжүүрт ертөнц эндээс эх авах бөгөөд түүнийг гол дунд Сүмбэр уулаар тэнхлэг хийсэн “Орчлонгийн дөрвөн тал” оршино. / Энэ талаар дараах бүлэгт дэлгэрэнгүй өгүүлэх болно. / Орон зайн энэхүү хуйлрал нь бидний ухамсарыг бүрдүүлэгч таван хэлбэрээр илэрсэн гэгээрлийн зарчим, тэдгээртэй харьцах Дхьяни-Буддад нийцэж байгаа юм. Гэгээрлийн ухамсар нь түүнд призмээр нэвтрэх гэрлийн адил тусна. Хоёр лянхуа цэцгээс эрчмийн таван цацраг туяаран гарч, төв цацрагийн оргил үзүүрт нийлэн, хоёр талаас Очирын үзүүрийг үүсгэж байна. Бадам цэцгийн хоёр дэлбээ дөрвөөс найм хүртэл нэмэгдэж болох бөгөөд дөрөв байвал таван үзүүрт Очир, найм байвал есөн үзүүрт Очир болно. Мандалын адилаар Төв нь ямагт энэ тоонд багтана. Үнэн хэрэгтээ Очир бол Мандалын хийсвэр давхар хэлбэр юм.

Очирын гол үзэл санаа бол гэгээрлийн утга санаа буюу ариун бөгөөд гэрэлтэй, эвдрэшгүй бат бэхийн туйл болоход оршино. Очир эрдэнэ бүх өнгийг цацруулах боловч өөрөө өнгөгүй билээ. Энэ нь Буддагын хэлсэнчлэн, төрөөгүй, үүсээгүй, бүтээгүй, бүрдээгүйг оюун ухааны ямар нэг тодорхойлолт болзолгүйг билэгдэж байна.

Ухамсрын дээд болон ердийн байдлыг зарим алхимичид Очир эрдэнэ, ердийн нүүрс хоёрын хоорондын уялдаа холбоотой зүйрлэдэг. Энэ хоёр бодис хоёулаа нүүрстөрөгчөөс бүрддэг ажээ. Энэ нь бүх бодисын тулгуур нэгдлийг болон тэдний дотоодод байгаа шилжих чадварыг зааж байгаа юм.

Материаллаг ба материаллаг бус ертөнц хоорондоо тун адилхан. Байгалийн болон оюун санааны хуулиуд нэгдмэл хэмээн үздэг алхимичийн хувьд, энэхүү шилжих чадвар хосгүй ач хобогдолтой билээ. Түүнийг материйн органик бус хэлбэрт ч, амьдралын органик хэлбэрт ч, түүнчлэн энэ хоёрын аль алиныг нь нэвт гардаг сэтгэхүйн хүчинд ч хэрэглэж болно гэж үздэг байв.

Ийнхүү шилжилтийн гайхамшигт хүч нь хүсэл бүхнийг биелүүлэгч “философийн чулуу”, амьдралыг төгсгөлгүй үргэлжлүүлэгч “мөнхийн рашаан” гэж хүмүүсийн төсөөлдөг

байсан тэр зүйлийн хүрээнээс хол давжээ. Энэ шилжилтийг туулсан хүнд хүсэх юм үгүй болж, тэртэй тэргүй мөнхөрсөн хүнд мөнхийн ус ч хэрэггүй болохтой адил юм.

Энэ талаар шидтэнүүдийн намтарт байнга тэмдэглэгдсэн байдаг юм. Гайхамшигт хүчний тусламжаар олж авсан юм бүхэн олдсон цагаасаа эхлэн ямар ч хэрэгцээгүй болох бөгөөд уг тохиолдолд зорилго нь аргаа зөвтгөхгүй, харин арга нь зорилгоо зөвтгөнө.

Хэнд ч үл ялагдах шидэт илдтэй болохыг хүссэн нэгэн дээрэмчин бясалгалд орж, тэрхүү илдээ олж авсан ч түүнийгээ хэрэглэж чадсангүй. Учир нь бясалгал тэрхүү дээрэмчинг ариусган, гэгээнтэн болгосон хэмээн нэгэн түүхэнд өгүүлсэн байдаг билээ.

Их багш Нагаржунай мөнхийн усыг олж авсан хэдий ч түүнийг насаа уртасгахад хэрэглэсэнгүй, харин шавь нартаа өгчээ. Эх оронд нь аюул нөмөрсөн үед их багш дотны хүмүүсийнхээ төлөө өөрийнхөө амьдралыг золиослохоор шийдсэн байна.

Нагаржунай гол шавь Салабандха хаан бээр өөрийгөө бүү золиосол хэмээн Багшийгаа ятгасан боловч Нагаржунай:

“Төрсөн бүхэн үхэх тавилантай, бүтсэн бүхэн бутрах жамтай. Мөнхийн усыг дуугүй уу” гэжээ. Хаан хариуд нь: “Би зөвхөн Багштайгаа түүнийг хувааж ууна. Багш таныг үгүй бол би мөнхрөөд яах билээ. Оюун ухааны удирдагч үгүй амьдрал ямар ч үнэ цэнэгүй билээ” хэмээж байгаа бүхнээ бусдад өгсөн их Багш хамгийн сүүлд амь биеэ өгөхөд, хаан тэрбээр Багшийнхаа өлмий дор төрөл арилжсан гэдэг.

Ухаант мэргэд мөнхийн усыг насаа уртасгахын төлөө бус, харин үхлийн айдасгүй, ахуйн дээд түвшинд хүрэхийн тулд ашигладаг. Түүнийг зөвхөн насаа уртасгахын төлөө хэрэглэсэн хүн нь дотроо үхэж, амьд хүүр төдий болно. Хар амиа хичээгчийн гарт орсон мөнхийн ус хүртэл хор болох бөлгөө.

Харин гэрэл цацруулсан эрдэнийн чулуу “Мани”-ийг олсон хүн, үхэх ухамсараа мөнх ухамсар болгож, төгсгөлтөйд төгсөөгүйг олж, сансар хорвоог нирваан болгон хувиргана хэмээн Очир хөлгөнд сургажээ.

Санаа ба матери

Бидний ухамсарт хамгийн их үнэт эрдэнэ болсон “Мани”- ийг олохын тулд бид ухамсрынхаа мөн чанарыг анхааралтай судлах хэрэгтэй. Эртний Энэтхэгийн шүлгэн судар “Дхаммапада”- гийн эхний бадагт: “Бүх үзэгдэл ухамсараар нөхцөлдөж, ухамсараар залагдан бүтдэг” гэж эхэлдэг. Буддын гүн ухаан, сэтгэлзүйг системтэй тайлбарлах гэсэн нилээд эртний оролдлого болох “Абхидхамма”- д ертөнцийг ухамсарын үүднээс тайлбарласан байдаг юм.

Ертөнц гэдэг бол бидний ухамсарт ертөнц болон төсөөлөгдөж байгаа зүйл хэмээн Будда тодорхойлсон билээ. Тэрбээр субстанцын ухагдхууныг үгүйсгээгүй боловч энэ нь түүнийг сэтгэцийн үйлдлүүдэд сэргүүлэн тавьсан хэрэг биш юм.

“Энэ бие нь үхэх тавилантай, овор өчүүхэн боловч ухамсартай, ухаантай, түүний дотор ертөнц багтдаг, ертөнцийн өсөх, хоргодох, түүнээс гарах зам ч багтдаг” гэж “Ангутгара - Никайя” II, “Самьютта – Никайя” I -д өгүүлжээ.

Буддистүүд сэтгэлзүйн ийм байр сууринаас материйн мөн чанарын бус, харин бидэнд материйн тухай төсөөлөл төрүүлж байгаа мэдрэмж, ойлгоцын мөн чанарыг судалж байжээ.

“Гадаад үзэгдэл хэмээгчийн мөн чанарын тухай асуудлыг угтан шийдвэрлэж болохгүй, мэдрэмжийн болон оюун санааны талууд хоорондоо нийлэхгүй боловч нийтлэг нэгэн эх сурвалжтай. Ямар ч гэсэн үйлийн үрийн онолд өгүүлснээр, бидний харж буй гадаад ертөнц бие хүний бүрэлдхүүнд орно” / Розенберг, 1991, 148 - р хуудас /

Ийнхүү оюун ухаан, матери хоёр тохиолдлоор нэгдсэн хоорондын уялдаа нь онцгой нөхцөлдсөн гэж үздэг дуализмаас Буддизм зайлсхийсэн байна. Иймээс “Рупа” гэдэг үгийг энэ тохиолдолд матери гэх юм уу, материалагын зарчим хэмээн орчуулж болохгүй, харин “мэдрэмжийн” гэсэн утгаар орчуулах ёстой гэсэн Розенбергийн саналыг бид хүлээн зөвшөөрч байгаа юм.

“Рупа” гэдэг үг нь дүрс гэсэн үг бөгөөд ингэхдээ тэр материалаг эсэхийг нь бодитой юм уу, мэдрэмжээр төсөөлөгдөж байгаа юм уу, эсвэл ухаанаар ойлгогдож байгаа юм уу гэдгийг заагаагүй байна. Дараачийн бүлэгт бидний үзэх “Рупа Скандха” гэдэг үг нь голдуу

“Дүрсийн цогц”, “материаллаг агрегат”, “биет хэлбэрийн агрегат” гэж ойлгогддог бол “Руппавачара-Читта” нь “Дүрстийн орны ухамсар буюу сэтгэл”, “Рупа-Дхьяна” нь анхаарал төвлөрүүлэх бясалгалын үе дэх оюун ухааны байдал хэмээн ойлгогдоно. Эдгээр идеал хэлбэрт хамаарах оршихуйн ертөнц болон мужуудыг “нарийн материаллаг хүрээ” гэж тодорхойлсон бөгөөд жирийн хүний нүдэнд харагдахгүй, зөвхөн үзмэрчид л харагдах учраас материалагийн тухай ердийн төсөөлөл байхгүй юм. Тэгэхээр Рупа бол цэвэр материаллаг бус ухамсар юм. “Иймээс Рупа гэдэг ухагдхуун нь материас хавьгүй өргөн юм. Материаллаг объектууд хэмээгч нь мэдрэмжийн ойлголтын салбарт хамаарах боловч, мэдрэмжийн тал нь материаллаг чанараас шавхагдахгүй. Материйн үндэс болж буй зүйл нь заавал материаллаг байх албагүй. Матери, материаллаг чанар нь заавал анхдагч байх албагүй.” / Розенберг / Дээр нэгэнтээ дурьдсан “их элементүүд” / Махабхута / -ийг заримдаа материаллаг утгаар ойлгож байсантай энэ байдал харшлахгүй.

Эдгээр элементэд субстанц бодит чанар ерөөс байхгүй бөгөөд дэс дараа, харилцан үйлчлэлүүдийн тодорхой хуулиудын дагуу буй болж, мөн алга болж байдаг юм. Тэд тасралтгүй урсгал үүсгэх ба тэр нь амьд юмс мэдрэмжийн эрхтэнээ хөгжүүлэх чадвартай байдагтай холбоотойгоор амьд юмсын хувьд ухамсартай болдог. Тийнхүү бүх үзэгдэл хоромхон зуурт үүсдэг тухай үзэл баримтлал нь материйн үзэл баримтлалын өмнө мухардалд орохгүй. “Абхидхамма”-д бичсэнээр, санаа бүрэлдэх арван долоон агшин нэг бүр нь цахилгаан цахихаас (хоёр хургуугаар нэг инчдэх төдий) ч богино хугацаа бөгөөд хүртэхүйгээс үүдсэн ухамсарлахуйн үргэлжлэх хугацааг үүсгэдэг байна. Энэхүү онолоор санааны арван долоон агшин нь материаллаг үзэгдлийн үргэлжлэх хугацаа мөн хэмээн Буддизмын философи үздэг.

“Их элементүүд” - ийг заримдаа материаллаг агуулгаар нь хоёр үзлийн үүднээс судалж болно. Үүнд:

Ойлгоцын явц дахь үе шат, өөрөөр хэлбэл, мэдрэмжийн ойлгоцоор юм уу, хэд хэдэн мэдрэмжийн ойлгоцоор үүдсэн ухамсарын явц дахь эхний цэг юм.

Давтагдаж буй мэдрэмжийн ойлгоцын үр дүн билээ.

Эхний тохиолдолд бид хатуу, зөөлөн, чийгтэй, хуурай, халуун, хүйтэн, тогтвортой болон хөдөлгөөнтэй байдал гэх зэрэг өөрөөр хэлбэл, хүртэхүйн мэдрэмжинд хатуу зөөлнийг мэдрэх, харахуйн мэдрэмжинд өнгө гэрлийг мэдрэх, сонсохуйн мэдрэмжинд дуу авиаг мэдрэх, үнэрлэхүйн мэдрэмжинд үнэрийг мэдрэх, амтлахуйн мэдрэмжинд амтыг мэдрэхийг ярьж байна. Гэхдээ матери болон материалаг объектийн тухай ойлголтууд нь зөвхөн зохицуулах, дамжуулах мэдээлэлд үүсдэг.

Ингэхлээр бид материд гараа хүргэнэ гэвэл, солонгонд гараа хүргэхтэй адил юм. Солонго бол хоосон үзэгдэл, гэхдээ огт хий хоосон зүйл биш, учир нь түүнийг харах мэдрэмжтэй хүн болгон үзэж, зургийг нь буулгаж болно. Энэхүү үзэгдэл тодорхой хуульд захирагдаж, тодорхой нөхцөлд үүсч буй болдог. Үүнтэй нэгэн адилаар, бидний ухамсрын гадаад, дотоод бүх объект түүний дотор бидний “материалаг” гэж нэрлэдэг зүйл зөвхөн харьцангуйн утгаар бодитой байдаг билээ.

Хүний биеийн махбод, сэтгэхүйн организм ч мөн үүнтэй адил юм. Энэхүү организм нь Буддагын үзэл баримтлалаар бол өнгөрсөний биежсэн ухамсар юм. Ухамсарын энэ зарчим нь үр дагаврын нэгэн адил нүдэнд үзэгдэх дүрстэй болдог.

Ийнхүү бие махбод нь ухамсарын бүтээгдхүүн бөгөөд харин ухамсар нь гадаад ертөнцийг мэдрэхүйн эрхтэнээрээ дамжуулахын хувьд л махбодын бүтээгдхүүн гэж хэлж болно. Сэтгэгдлийг хүлээн авч ойлгох нь бидний ухамсарын сэтгэлийн болон ухааны хариу үйлдэл бөгөөд ийм хариу үйлдлийн шийдвэр нь урам зоригийн байдлаас хамаарах юм. Чухамдаа шийдвэр, зориг нь үйлдэл болох ба түүнээс хамаарч үзэгдэх, мэдрэгдэхүйн үр дагавар гарна.

Дүрс болон улирч байгаа зүйл нь зөвхөн өнгөрсөнд хамаарах учраас оюун санааны хувьд үүнээс дээгүүр түвшинд хүрсэн хүнд нэг л хол хөндий мэт мэдрэгдэнэ. Санаа матери хоёр бие, сэтгэл хоёрыг хоёрдмол бус байдлаар хандах нь энэ мэдрэмжинд тулгуурлах ба энэ шалтгаанаар оюун санааны хувьд нилээд хөгжсөн хүн дундаж хүнийг бодвол түүнийг илүү мэдрэмтгий байдаг. Ухамсар нь өнгөрснийг давж чадаагүй хүмүүсийн хувьд бол

тэдний бие махбод одоо цагт “хамаарна” хэмээн хэлж болох юм. Одоо цаг нь үнэндээ ухамсарын одоогийн байдалд л таардаг билээ.

Гэвч, амьдралын аль нэг үеийн дотор оюун санааны дэвшил хэдий чинээ хурдан бол, бие махбод, оюун санааны хоорондын зай төдий чинээ их байна. Учир нь бие махбод илүү нягт учраас хөдөлгөөнт чадвар нь бага байх ба үүний улмаас тогтонги чанар нь их байх учир оюун санаанаас хоцорч байдаг. Махбодын дасах чанар удаан, органик өсөлтийн нөхцөл, материйн бүтцийн хууль, түүний анхдагч элементүүдийн мөн чанараас хамаарч тодорхой хязгаарт явагдана.

Махбодыг хүнд дүүжинтэй зүйрлэж болох юм. Дүүжинд анхдагч түлхэх хүчин үйлчлээгүй байсан ч тэр нь нилээд хугацаанд савлан хөдөлсөөр байдаг. Дүүжин хэдий чинээ урт, хүнд байвал савлах хөдөлгөөний хурд төдий чинээ бага байна. Оюун ухаан, тайвшрал, зохицолд хүрсэн байлаа ч өмнөх үйлдлүүдийн үр дагавар удаан хугацаанд байсаар байна.

Орчин үеийн Энэтхэгийн Хинди шашны нэг гарамгай сэтгэгч Шри Ауробиндо оюун санааны хөгжил дэхь махбодын үүргийг тайлбарлахдаа, “Биеийн тал, оюун санааны талтай эсрэг тэсрэг хэмээх нь биеийн талыг үгүйсгэх нотолгоо биш, яагаад гэвэл бидний хамгийн их бэрхшээл нь, бидний хамгийн шилдэг боломж юм. Ингэхлээр махбод төгс боловсрох нь сүүлчийн ялалт болно” гэжээ. “Амьдрал нь хэмжээ хязгааргүй, амгалан, хангалуун, хүчирхэг болох ёстой. Түүнд бидний хуучин, сохор, явцуу хазаар жолоогүй байдал, би болон амьдралын өчүүхэн хүсэл эрмэлзлэлийг ялгах аргагүй болно. Тэр ч байтугай бие махбод өөрчлөгдөж, ухамсарт зарц, ариун зэвсэг, оюун санааны амьд тээгч нь болох ёстой.” / Sri Aurobindo, 1955, хуудас - 10,82 /

6. Таван Скандх ба ухамсрын номлол

Буддын сэтгэлзүйч “бие хүн”, “хувийн” гэдэг ухагдхууныг таван скандха / цогц / - гын хамтын үйл хэмээн тодорхойлсон нь хувь хүний ухамсрын идэвхтэй үйлийг тэдгээрийн нэмэгдэж буй өсөлтийн дараалалд тайлбарласан төдий хэрэг байв. Эдгээр скандханууд нь:

1. Рупа скандха нь / монголоор: Дүрс цогц , төвдөөр: Цхор-ба и пхунг- по / махбодын бүлгийг бодвол илүү үнэн бөгөөд махбодиор төлөөлөгдсөн ухамсрын өнгөрсөн элементүүдийг хамарсан мэдрэмжийн нийлбэр юм. Энэхүү тодорхойлолт нь мэдрэхүйн эрхтэнүүд, мэдрэмжийн объектууд болон тэдгээрийн харилцан холбоо, сэтгэхүйн дэс дарааллыг багтаана.

2. Ведана - скандха нь / монголоор: Сэрэхүй цогц, төвдөөр: Цхорба пхунг – по / мэдрэхүйн эрхтэнүүдээр хүлээж авсан, түүнчлэн дотоод шалтгааны үр дүнд буюу өөрөөр хэлбэл, сэтгэл ханах, өвдөх, баярлах, гуниглах зэрэг шалтгаануудын үр дүнд үүссэн сэтгэл хөдлөлд хариу өгөх үйлдлийг багтаасан мэдрэмжийн бүлэг юм.

3. Санджня – скандха нь / монголоор: Хуран мэдлийн цогц, төвдөөр: Душеский пхунг - по / оюун ухааны талыг хамарсан, түүнчлэн төрөлх мэдрэмжийн талыг ч хамарсан, ухамсар төсөөлөлд хамаарах ойлгоцуудын бүлэг юм.

4. Санскара – скандха нь / монголоор: Хуран үйлдэхээр хураагдсан цогц, төвдөөр: Ду - биедский пхунг - по / ухамсарын идэвхтэй зарчим, хувь хүний зан чанарыг төлөөлсөн хүсэл зоригийн чиглэлийн хүчийг бүрдүүлэгч оюун санааны үүсгэлүүдийн бүлэг юм.

5. Виджняна – скандха нь / монголоор: Тийн мэдлийн сүнс цогц, төвдөөр: рНампар шеспа ба пхунг – по / өмнөх бүх үйлдлүүдийг хамаарч зохицуулагч ухамсарын бүлэг буюу ямар нэг агуулгаар дүүргээгүй цэвэр ухамсар юм.

Эртний судруудад зааснаар, 5 дахь бүлэгт ухамсарын зургаан төрлийг тодруулж болно.

1. Үзэх ухамсар
2. Сонсох ухамсар
3. Үнэрлэх ухамсар
4. Амтлах ухамсар
5. Хүргэх ухамсар
6. Сэтгэх ухамсар

Эдгээр зургаан ухамсар нь өөрсдийн объектуудын дагуу тодорч болох авч таван скандхагын хувьд ийнхүү тодрох боломжгүй юм. Таван скандха нь ухамсрын аливаа төгссөн явцад байдаг таван үе шаттай нийцнэ. Эдгээр нь:

1. Хүрэлцэх
2. Мэдрэх
3. Ойлгох
4. Сэрэх
5. Бүрэн ухамсарлах юм.

Гэвч эдгээр нь, бие биетэйгээ үүргийн хувьд холбоотой учраас тэдгээрийг бие хүнийг цогцлоон бүрдүүлэгч “ангид хэсгүүд” хэмээн үзэж болохгүй. Скандха бол “орших”, “эс орших” гэсэн тодорхойлолттой нийцэшгүй, үл хуваагдах нэгэн үйл явцын янз бүрийн тал юм. Мэдрэмж, ойлгоц, сэтгэхүй нь ухамсарын нэгдмэл хэсгүүдийн хувьд бас зургаан хэсэгт хуваагдана. Гэхдээ энэ нь үзэгдэх объектод юм уу сэтгэгдэл, авиа, үнэр, амт зэргийн чухам алинд нь тулгуурлаж байгаагаас хамаарах болно.

Таван скандхагын харилцан холбоог Пали судар “Мадджхима -никайя” - гын 43-рт өгүүлэхдээ, “Мэдрэхүй, ойлгоц зэрэг нь ямагт харилцан холбоотой байдаг учраас тэдгээрийн хоорондын ялгааг харуулахын тулд нэгийг нь нөгөөгөөс салгах боломжгүй юм. Учир нь гэвэл, мэдрэгдэж, ойлгогдож байгаа бүхэн, тэрчлэн ойлгоц өөрөө ухамсарлагддаг” гэжээ.

Солонгын өнгүүдийг ялгаж болохгүйн адилаар, тэдгээр нь өөрийн оршихуйгүй, өөртөө бодитойгоор оршиж чаддаггүй юм.

Гэвч, гадаад ертөнц бодитой эсэх асуудлыг энд өгүүлэхгүй. Яагаад гэвэл, мэдрэмжийн бүх элемент түүний дотор материалаг биеийн эрхтэнүүд эцсийн эцэст ухамсарт үндэслэдэг учраас тухайн ухамсар бүхэн, бие даасан бодит байдал мөн үү? гэсэн асуулт тавигдана.

Энэхүү асуултанд Буддизмын янз бүрийн сургууль өөр өөр аргаар хариулж байлаа. Будда өөрөө тухайн “би” буюу мөнхөд хувирашгүй “эго” бол хуурамч хий үзэгдэл гэж

үзсэн бөгөөд тогтворгүйн зарчим бологч амьдралын бүх үзэгдэл, хэлбэрийн мөн чанар гэж сургасан юм. “Вишуддха - Маггагын 8 - рт дараах үгүүд бий, “Хатуухан хэлбэл, амьд бодисын амьдрах хугацаа туйлын бага бөгөөд бодол үргэлжлэх хоромхон эгшинээр хэмжигдэнэ. Тэрэгний дугуй эргэж байхдаа зөвхөн ганцхан цэгт тулдагын адилаар, амьд бодисын амьдрал ганцхан санааны хугацаагаар хэмжигдэнэ. Тэрхүү санаа нь үгүй бөгөөд ирээдүйд ч буй болохгүй. Ирээдүйн хоромд буй болох санаа ирээдүйд байх болно. Харин одоо байхгүй, өмнө нь ч байгаагүй. Өнөөгийн хоромд байгаа санаа өнгөрсөн хоромд байгаагүй, ирээдүйд ч буй болохгүй.”

“Нэг голын урсгалд хоёр дахин орж болохгүй” гэсэн Гераклитын хэлсэн үг байдаг. Энэ үг бүх юмс үзэгдэл байнгын бус гэдгийг үзүүлэхийн хамтаар, өөрчлөлтийн мөн чанарыг нэгэн чиглэлийн тасралтгүй урсгал, эргэж буцалтгүй хөдөлгөөн, тодорхой хуулиас хамаарах хамаарлыг тодруулж байна. Өөрчлөлт бол эмх замбараагүй хөдөлгөөн биш, тодорхой дэс дараатай, өөрөөр хэлбэл, үзэгдлүүдийн харилцан хамаарлын хуульд буюу арван хоёр шүтэн барилдлагын хуульд захирагдана гэж Будда сургасан юм.

Ухамсарын болоод ахуйн тогтвортой чанар эндээс үүдэн гарах бөгөөд түүний элементүүд нь тасралтгүй өөрчлөгдөж байгаа ч гэсэн хөдөлгөөнийхөө чиглэл, харьцангуй ижил чанарыг хадгалдаг голын урсгалтай зүйрлэж болно. Энэ урсгалыг Тхеравадинууд Абхидхаммын өөрсдийнх нь тайлбараар “Бхаванга - сота” буюу ахуйн зөнгөөрөө урсах урсгал буюу нарийвчлан хэлбэл, ухамсарын бүх туршлага, агуулга мөн байж зохих нөхцөл бүрдсэн цагт дахин сэргэж байдаг урсгал хэмээн үзэж байна.

Ийм урсгал үргэлж байраа сольж, элементүүд нь байнга өөрчлөгдөж байх боловч, тийм урсгал байдаг нь эргэлзээгүй хэрэг билээ.

Энэхүү тасралтгүй урсгалыг ажигласны дүнд бидний өөрийн ухамсар үүсэх бөгөөд Виджнянавадинууд түүнийг долоо дахь ухамсар буюу / сэтгэхүйн ухамсар, мано - виджняна / ердийн зохицуулалт мэдрэмжийн ойлгоцыг хослуулснаас ялгаатай ухамсар гэдэг байв.

Ухааны хоёрдмол үүрэг / Манас /

Ийнхүү ухамсарын долоо дахь төрөл / манас / бол мэдрэхүйн ертөнц биш, харин үүсэн тогтохын мөнх урсгал, үхэх төрөхөөр ч, илрэхүйн хэлбэрүүдээр ч хязгаарлагдадаггүй “гүний ухамсар” юм. Үхэх, төрөх хоёр нь нэг амьдралыг, нөгөө амьдралаас заагласан хаалга учраас үүгээр дайран өнгөрөх ухамсарын тасралтгүй урсгал нь учир шалтгаанаар нөхцөлдсөн ухамсарын байдлыг төдийгүй, түүний байж болох бүх байдлыг эхлэлгүй “өнгөрсөний” нийт дүнг гадаргуудаа агуулдаг. Чухамхүү үүнийг л найм дахь ухамсар буюу “Нандин эрдэнийг агуулагч ухамсар” / Алайя Виджняна / гэдэг юм.

“Ланкаватара” сударт зургаа дахь ухамсарыг мэдрэмжийн таван төрлийн ухамсарыг нэгтгэн дүгнэдэг оюун ухааны ухамсар хэмээн тодорхойлсон байдаг. Үүний дараа шуналын болон дур гутахын ухамсар, түүнчлэн бодит ертөнцийн төөрөгдөл залгана.

Нөгөө талаас, ерөнхий ухамсарыг далайтай зүйрлэх ба түүний мандалд урсгал, давалгаа, эргүүлэг үүсч байвч гүнд нь хөдөлгөөнгүй, нам тайван байдал ноёрхож цэвэр тунгалаг байна гэж үздэг. “Ерөнхий ухаан” / Алайя - Виджняна / аливаа зааг ялгаврын гадна оршино. Ерөнхий ухаан бол тогтворгүйн алдаанаас ангид бөгөөд хөдөлбөргүй, биг-г баримтах аминч үзлээр бохирлогдоогүй, ялгаж салгах, хүсч эрмэлзэхээс ангид язгуур чанараараа туйлын цэвэр юм. / Buddhist bible, 1938, 306 - р хуудас /

Оюун санааны ухамсар / манас / нь ерөнхий болон хувийн эмпирик ухамсарын хооронд зууч нь болдог. Тэрээр / манас / ерөнхий болон хувийн гэсэн хоёр ухамсарын аль алинд нь оролцдог байна. “Манас “ бол өөртөө ухамсарын тогтворжуулах элемент, тэнцвэрийн цэг агуулдаг бөгөөд тэдгээрийг бүрдүүлж байдаг зохицуулагч хэмжүүрийн дэнс юм. Чухамхүү уг шалтгаанаар гэгээрлийг олоогүй хүн нь хувийн сонирхолынхоо дагуу “би” гэгчийг хэт баримталснаас, өөрийн биеийн бодит, байнгын Төвд орших энэхүү хэмжүүрийн хуурамч цэгийг алдаатай хүлээж авдаг байна. Тийм ч учраас үүнийг “Махаяна Сампариграха шастра” -д “бохирдсон сэтгэл” / клишта - манас / гэж нэрлэдэг бөгөөд байнгын тасралтгүй үйл явцын дүнд батжин бэхжиж байдаг сэтгэхүйн хувийн сонирхолыг баримтлагч “би” гэгчид буюу эсвэл аминч үзлийг “Төв”-өө болгодогт түүний мөн чанар оршино. “Ланкаватара” сударт “манас” -ын эрдэм мэдлэгт агуулагдах авралыг авчрагч зөн

билгийн болон эсрэг талыг дараах байдлаар таниулан үзүүлсэн байдаг юм. Үүнд: Билэг билгүүн / Ария - жняна / -д, оюун ухаан ба зөн билгийн ухаан болох манас нь харьяалагдах тул, тус шалтгаанаар ерөнхий ухаан / Алайя - вижняна / - тай нэгдмэл бөгөөд мөн түүнчлэн, мэдрэхүйн таван эрхтэнтэй буюу олон талт мэдлэгийг хүлээн авахад зуучлагч - оюун ухаантай нэгдмэл нэгэн цогц болдог ажээ. / Вижняны зургаан төрлийн ангилал ёсоор / Билгүүн ухаан нь өөрийн гэсэн биегүй, түүнийг ялгаж таних ямар нэгэн шинж тэмдэггүй билээ. Харин ерөнхий ухаан нь түүний шалтгаан ба тулгуур нь болдог хэдий ч тэр нь “би”- г хэт баримтлагч үзэлтэй болон түүнд хамаарах бүхэнтэй буюу өөрөөр хэлбэл, тэрхүү үзэл нь юунд тээглэн торж, юуг тольдон тусгадагтай хутгалддаг байна.

Дээр дурьдсанаар “манас” нь өөрийн гэсэн биегүй, ерөнхий ухамсартай нэгдмэл байдгын нэгэн адил, хувийн эмпирик ухамсартай нэгдмэл юм. Нарийвчлан хэлэхэд, ерөнхий ба хувийн ухамсарын давхцаж буй хэсгийг л манас гэж ойлгож болно.

/ Зураг орно. /

Үүгээр “манас” -ын хоёрдмол шинж чанар тайлбарлагдах ба манас нь өөртөө хувийн шинж тэмдэг хэдийгээр хадгалдаггүй боловч, хэрвээ тэр нь / манас / ерөнхий ухамсараас хувийн ухамсар руу буюу өөрийн ухамсарт чиглэгдвэл, алдааны эх үүсвэр болно. Харин эсрэгээр нь хувийн ухамсараас ерөнхий ухамсарт чиглэгдсэн тохиолдолд билэг билгүүнд хүрэх ба гэгээрэхүйн эх сурвалж болдог ажээ. Энэ хоёр чиглэлийн эцсийн үр дүнгийн ялгааг байгалийн янз бүрийн байдал, өнгийг харж өөрийгөө түүнээс ангид болохыг мэдэрч байгаа хүн, эргэн тойрныг үл анзааран тэнгэрийн гүн мандал руу харж, үүгээрээ хязгааргүй огторгуй, “хоосон чанар” -ыг ухамсарлаж буй хүнтэй зүйрлэж болно.

Манас бол нэг талаас хувийн шинж чанар, нөгөө талаас оюун санааны ерөнхий шинж чанар хоёрын хоорондын тэнцвэрийг барьж байгаа ухамсарын элемент бөгөөд биднийг мэдрэмжийн ертөнцтэй холбож, эсвэл түүнээс ангижруулж байдаг зүйл юм. Энэ бол ид шидийн хүчээр алт болон хувирч байдаг алхимийн “үндсэн металл” буюу Очир эрдэнэ болон хувирч байдаг “нүүрс”, мөн “мөнхийн ус” болон хувирч байдаг хор юм.

Гэвч жинхэнэ шид бол дотоод өөрчлөлтөд, ухамсарын хамгийн гүний эргэлтэнд оршино. “Ланкаватара” сударт өгүүлснээр, энэ бол чиглэлээ өөрчлөх, шинэ байр суурь, объектуудын гадаад ертөнцөөс дотоод ертөнцөд ухааны бүгдийг хамарсан ерөнхий чанарт хандсан хандлага юм. Энэ нь шинэ төлөв, “зүрхний чиглэл” / Рильке ингэж хэлсэн байдаг /, эрх чөлөөний урсгалд орох үйл явц юм. Буддагын хүлээн зөвшөөрснөөр, бусад бүх ид шид үүний дэргэд зөвхөн тоглоом төдий юм.

Иймээс шидтэнгүүдийн намтрын судрыг уншихад, эхлээд хүслийн дээд болж байсан ид шид биелэхээрээ түүнийг хэрэгжүүлж буй хүний хувьд ямар ч үнэ цэнэгүй зүйл болж хувирдаг. Учир нь, тэр үед ид шидтэний сэтгэлд түүнтэй зүйрлэшгүй үнэ цэнэтэй “дотоод эргэлт”, болдог тухай жишээ олон тааралддаг билээ. Бидний уналтын шалтгаан болж байсан зүйлс, дараа нь биднийг дахин өндийлгөх зүйлс болдог. Их багш нар шавийнхаа сул талыг чухам яахаараа надаас ийм их хүч гарваа гэж шавь өөрийгөө ч гайхмаар тийм шавхагдашгүй хүч чадлын эх булаг болгож байдаг билээ.

Манас бол ерөнхий ухамсар өөрөө өөрийгөө тулах, мэдрэмжийг объектоос нь зааглах зарчим юм. Ингэхлээр бидний үүсэн тогтнох үйл явц гэж нэрлээд байгаа зүйл маань Пифагорын хэлсэнчлэн “хязгааргүйн давших хязгаар” юм. Аврагалд хүрэх нь үүний урвуу буюу хязгаарлалтын давшилтыг устгахад оршино.

“Дигха Никайя”-гын “Агганья-суттанта”- д, бидний эцэс төгсгөлгүй гэрэлт ухамсарын хязгаардмал алгуур үйл явц нь Вижнянавадын сургаалд төсөөлсөний адилаар гүн утгат домог үлгэрийн хэлбэрээр бичигдсэн байдаг юм. Дээр нэгэнтээ өгүүлсэн шиг Вижнянавадын талыг баримтлагчдын үзэл санаа эртний пали хэлээр бичигдсэн Бурханы сургаалд анх үүссэн бөгөөд тэр цаг үед тийм тодорхой биш хэдий ч, сэтгэлийн учир шалтгааны ухаан нэгэнт бий болчихсон байжээ.

“Өнгөрсөн үед, бид оюун санааны бодит чанар, ухааны бүтээл байлаа. Бид орон зайд хөвж байлаа. Бид ийм байдлаар урт удаан үед байсан юм. Дараа нь төгсгөлгүй цаг хугацаа өнгөрч, усан дотроос амтат газар гарч ирсэн юм. Газар нь өнгөтэй, үнэртэй, амттай байлаа. Бид түүнээс базан авч иддэг байлаа. Гэвч, бид түүнийг идсээр, өөрөөсөө цацарч

байсан гэрлийг алдав. Тэр гэрлийг алга болоход нар, сар, одот тэнгэр, өдөр, шөнө, жил, сар, өдөр хоног үүссэн юм. Бид амтат газар шороонд шунан жаргаж, түүгээрээ хооллож, удаан амьдарлаа” хэмээн “Агганья - сутта”- д өгүүлсэн нь бий. Үүний дараа нь энэ хоол унд улам бүдүүлэг болж, ингэснээр бодисын бие материалжин эр, эмийн ялгаа үүсчээ. “Түүнчлэн бидний дунд муу зүйлс, ёс журамгүй дадал зуршил буй болсоноор газрын тансаг байдал устаж, амт үнэрээ гээсэн бөгөөд дэлхий дээр газрын амт үнэр бүхий төрөл бүрийн үр жимс буй болжээ.

“Бидний дунд муу муухай зүйл нэмэгдэх тусам газрын үр шим алга болж, муудсаар идэх юм үгүй болж, хоол тэжээлийг хүнд хөдөлмөрөөр олоход хүрэв. Ийнхүү хөдөлмөрийн хуваарь, хил хязгаар, “миний, чиний”, “би, чи” болон үүний хамтаар эд хөрөнгө, атаа хорсол, шунал тачаал үүссэн байна.

Ухамсрын гүн рүү хийх эргэлт

Манас нь зөвхөн мэдрэмжээр хүлээн авах туршлагын эмпирик ухамсарын тусгал болох үедээ уг ухамсар нь жүжигчин, үзэгч аль аль нь мэт үзэгдэх ба “би” болон өөрийгөө ухаарах гэдэг гүн ухааны нэр томьёонд тохирно. Гэтэл манас нь мэдрэмж буюу туршлагын ухамсараасаа эргэж, анхаарлаа ахуйн жинхэнэ шалтгаан руу, бүх ухамсарыг хорвоо ертөнцийн эх булаг руу хандуулах тэр мөчид “би” / эго / гэдэг аминч үзлийн ойлголтын хуурмаг болох нь тодорхой болж, хоосон чанарын туршлага бүхий л хэмжигдхүүнээрээ тодорч нээгдэнэ.

Далдыг ухаарч, мэлмийг нээх энэхүү үйл явц нь сэтгэлзүйн утга, оюун ухааны задлан шинжилгээ, сэтгэлзүйн дүгнэлтээр бус, харин оюун ухааны бүхий л үйл ажиллагааг бүрэн дайчилж чадах, тэгснээрээ бодит байдлыг шууд мэдрэх нөхцөлийг бүрдүүлнэ. Бодит байдал гэдэг ойлголт нь байгаа юмс тухайлбал, бүхий л ухамсар, бүх амьдрал, бидний нэрлэж болох бүх юмсыг бүхэлд нь хамарсан бүрэн нэгдэл багтах бөгөөд тэдгээр нь хязгааргүй үргэлжлэх тухай зөнч туршлага буюу ойлголт юм. Тэгж байж л бидний төсөөлдөг гурван хэмжигдхүүнт ертөнцийн нэршил, тодорхойлолт дуусч өндөрлөнө. Энд л бид үгээр илэрхийлэх ижил төстэй хэрэглэгдхүүнийг өнөө хир хараахан олоогүй байгаа

дээд зэргийн хэмжүүрийн хязгааргүй тууштай дэс дарааллыг танин мэднэ. Гэхдээ бид эдгээр дээд зэргийн хэмжүүр байдлыг өөрсдийнхөө шууд зөнч ухамсарын хөгжиж чадаагүй эрхтэнүүдийнхээ тусламжтайгаар мэдэрч болох талтай. Ямар нөхцөлд тэгж мэдэрч болох вэ? гэвэл, одоогоор хөгжил нь гүйцээгүй эрхтэнүүд дотор шилжин гүйж байдаг манасыг гадаад мэдрэмж болон оюун ухааны эргэцүүлээс ангижруулж холдуулж чадсан тохиолдолд тэгж болно.

Энэхүү эрхтэнг гагцхүү бясалгалаар хөгжүүлж болно. Тэгэхдээ бид оюун ухааныхаа үйл ажиллагаа, дотоод сэтгэлгээ, таамаглал эргэцүүлээ цөмийг нь тайвшруулаад өөрсдийнхөө дотоод хараанд хандах шаардлагатай. Бидний дотоод хараа нь олон талтаас нэгдмэл рүү, хязгаарлагдмалаас хязгааргүй рүү, оюун санаанаас зөн билэг рүү, “би” - гээс “би бус” рүү тус тус чиглэгдсэн байх ёстой. Түүнчлэн бидний дотоод хараа тодорхой биетээс хязгааргүй орон зайд чиглэгдэж, бид уг хязгааргүйд хүрч очих буюу ингэж аминч үзлийн ташаа мэдрэхүйд автагдахгүй болтол үргэлжлүүлэх шаардлагатай.

Бид задлан шинжлэх сэтгэлгээний арга, оюун ухааны задлан шинжилгээг хэрэглээд байвал, бясалгал нь зөвхөн мэдрэмжээр хүлээн авах туршлагын ертөнцөөс чөлөөлөхөд нэмэр болохгүй, харин ч уг ертөнцөд улам бүр хүлэх учир, бид оюун ухааныхаа зүг чигийг өөрчлөхийн оронд өөрсдийнхөө анхаарлыг тухайн ертөнцийн үзэгдлүүдэд хүлж бэхлээд нөгөө л “эго” буюу “аминч үзэл” гэх буруу үзлийг баримтлах нь улам бүр хүчтэй болно. Мэдрэмжээр хүлээн авах туршлагын үзэгдлүүдийн задлан шинжилгээ нь та биднийг уг үзэгдлүүдийн жинхэнэ үнэн гэдгээр нь хүлээн авах явдлаас чөлөөлж эс чадах бөгөөд гагцхүү тэдгээрийн ач холбогдлыг огоорсон цагт л зорьсон зорилгод чинь хүргэж чадна. Гэвч мэдрэмжээр хүлээн мэдрэгдэх үзэгдлүүд харилцан холбоотой нь үнэний хувьтай ч байгалийн үзэгдлүүдийн эцсийн дүнгийн талаар ямар нэгэн нааштай ухамсар олгож чадахгүй.

Биеийн бүрэлдхүүн хэсгийн задлан шинжилгээ, эсвэл гар, хөл, мөч, эрхтэн гэх мэт зохиомол ажиллагаа болон тэдний амьд нэгдлийг эс анхаарвал “эго” мэт үндсээрээ хуурамч, өөрсдийгөө мэхэлсэн аргаар бид бие махбод, түүний бүх үүрэг ажиллагааг

ойлгож чадахгүй, тэгснээрээ бие махбодын бүдүүлэг матери, өөрсдийгөө бүдүүлэг материализмд улам ч төөрөлдсөн тэнэглэлийн хэмжээнд доош унагаахаас өөр ямар ч ашиггүй.

Манай эгэл оюун ухааны үүрэг ажиллагааны задлан шинжилгээ ч ийм л байдаг юм. Зарим нэгэн үзэгдлийг ялгаж ангилах юм уу, тайлбарласнаар бид амжилт олоо гэж болох хэдий ч, энэ нь өөрсдөө тэдгээрээс чөлөөлөгдөх гэсэн үг бус бөгөөд зөвхөн тэдгээрийн дотоод шалтгаан, ач холбогдлын ухамсарт хөгжлийн өрнөх цар хүрээг хязгаарласан хэрэг болохоос биш, хэрэг дээрээ бидний даван туулахыг горилсон оюун ухааны үүрэг ажиллагааг хүчтэй болгох дасгал л үйлдэж байгаа юм.

“Ланкаватара сутра” - д дурьдсанаар, ертөнцийн үзэгдлүүдийн тийм “бодит” дасгал, тийм үр ашигтай оюун ухааны буюу сэтгэлийн задлан шинжилгээ нь биднийг сансрын ташаа мэдрэхүйн гүн рүү хөтлөх юм. Ингэж ертөнцийн эсрэг өөрийнх нь зэвсэгээр тэмцэхийг оролдох тутам бид ертөнцийн үзэгдлүүдийн үнэнд итгэмтгий болж, тэдгээрийн боол болж хувирна. Иймд “Ланкаватара” сударт өгүүлэхдээ:

“Ялгаж салгаж буй оюун ухааны үйл ажиллагааны улмаас ийм алдаа үүсч, бодит ертөнц биднийг эрхэндээ оруулж улмаар “эго” буюу сэтгэл санаа гэдэг ойлголтыг багтаадаг” гэжээ. / Buddhist bible, 1938, 307- р хуудас /

Энэхүү ялган салгаж буй ухамсар нь мано - вижняна, манасыг “эго” / Би-г баримтлах аминч үзэл / мэтээр хүлээн авахад хүргэсэн ухаан санаа мөн бөгөөд яагаад гэвэл, тэрбээр ухамсарын өмнөх мөчийг тусгасан харьцааны байнгын төв гэдэг утгаар ойлгогдоно. Энэ талаар “Ланкаватара сутра”- д манас нь Алая - вижняна буюу түгээмэл ухамсар шиг алдааны эх үүсвэр байж чадахгүй. Өөрөөр хэлбэл, манас хэдийгээр “эго”- гийн тухай ойлголт буй болоход нэмэр болсон боловч, түүнд өөрийгөө ухаарах ухамсарын үүрэг байдаг бөгөөд ухамсарын өнгөрсөн ба одоо цагийн хооронд холбоо барьж тогтвортой мэдрэхүйг үүсгэдэг болохоор, алдааны шалтгаан гэгдэх юм уу, тэр тусмаа алдааны жинхэнэ үүсвэр гэж нэрлэгдэх ёсгүй, гагцхүү зөв тусгасан гэдэг итгэл үнэмшил төрүүлээд, харин алдаанд хүргэдэг толь мэтийн нөхцөлд тооцогдож болох төдий юм. Гэтэл энэ алдаа

нь толинд бус, толийг харж буй ширтэгчийн ухаанд байдаг билээ. Манас нь алдаа гаргах боломжгүй, алдааг оюун санаа л төрүүлдэг, тийм ч учраас Клишта - мано -вижняна буюу “гайхал бишрэл”, “алдаатай”, “оюун санааны ухамсар” гэж нэрлэнэ.

Манасын хоёр талт мөн чанар нь дээр өгүүлсэнчлэн, хувь хүн болон мэдрэхүйн туршлага, их ухамсар тэргүүтэнд оролцдогын хувьд Манас ба мано - вижняна үе үе андуурагдахаар барахгүй, заримдаа ижил утгатай үгнүүд гэгддэг талтай. / Төвд хэлэнд, хоёр үгийн аль алиныг нь “ийд” гэж орчуулна. Тухайлбал: “ийд” ба “ийд-кий нампар шеспа” гэгдэх ба тэр ч байтугай Буддист бус санскрит утга зохиолд манасыг түүний дээд ба доод язгуур нь чухам хаашаа чиглэснээр нь ялгах ажээ. /

Ийм учраас “Махаяна - шраддхотпада шастра” - д өгүүлэхдээ: “Ухаан санаа / манас / нь үйл ажиллагаа болж гадагшлахдаа хоёр үүдтэй байдаг. Нэг нь ухааны цэвэр мөн чанар / Алая вижняна / - ыг хэрэгжүүлэх, нөгөө нь үүсэх, устаж үгүй болох, үхэл амьдралын учир шалтгааныг тодруулах зориулалттай ажээ. “Ухааны цэвэр мөн чанар буюу ариун увидас гэж чухам юуг хэлнэ вэ ? Энэ бол үнэн ба бодь мөрийн дээд зэргийн ариун нандин нэгдэл түүний / ”үнэн”- ий / бүхнийг хамрагч бүрэн бүтэн байдал, мөн чанар нь болно. Оюун ухааны мөн чанар нь үхдэг ч үгүй, шинээр төрдөг ч үгүй, тэрбээр бүтээгдэшгүй, мөн үүрд мөнх орших болно. Ухамсарт ухааны үзэл баримтлал нь хуурамч эргэцүүлээр санаанаасаа зохиосон хуурамч зүйл болно. Хэрэв ухаан нь ялгаж таних сэтгэлгээнээс ангид чөлөөтэй байсансан бол дүрс, оршихуй болон нөхцөл шалтгааныг үүсгэж өгдөг дур зоргоороо зөн билгийн утга заяахгүйсэн билээ” гэсэн байдаг.

Гэвч, эдгээр сануулга нь гүн ухаантнууд, даржин тайлбарлагчдын будилах үндэс болгохгүйн тулд уг сэдэвт цааш нь дурьдахдаа, ухааны уг төрхийг зураглан хэлэх үг байхгүй, түүнийг ядаж ойролцоогоор ч дүрслэх үг олдохгүй, яагаад гэвэл үнэн чанартаа ухаан гэдэг нь бариад авах юм үгүй, нэрлэх нэргүй зүйл гэдгийг урьдчилан сануулах нь зүйтэй юм. Гэвч бид учир утгыг ойлгох үүднээс үг бий болгон хэрэглэдэг юм.

“Ланкаватара сутра”-д өгүүлсэнээр, ухамсар оршихуйн гүнд бүрэн эргэлт хийсэн цагт л дур зоргоор таамаглах оюуны хязгаарыг гэтлэн давах юм. Хүнийг гадна талаас нь хараад

дүгнэдэг зуршлыг гэтлэн давж шууд мэдрэх ухамсрын дотор түүний эрхэм дээд үнэнтэй холбох журмаар сэтгэл оюуны шинэ төлөвийг бүрэлдүүлэх ёстой. Эх мэдлэгийн энэхүү шууд мэдрэх ухамсар бүрэлдээгүй нөхцөлд зөвхөн туршлагын чанартай мэдрэмжээр өөрийгөө хязгаарлаж явцууруулах үйл явц үргэлжилсээр байх болно.

Энэ бол мэдрэмжийн үйл ажиллагааг үгүйсгэж, мэдрэмжийн ухамсарыг дарж дарамталж байгаа хэрэг биш, харин түүнтэй харьцуулбал дур зорго, зөн совин, хүсэл мөрөөдөл, таавар сэлт буюу өөрөөр хэлбэл, энэ нь үнэндээ энэхүү ертөнцөд хадагдаж, үхэж төрдөг хорвоо болох сансрын хий үзэгдлийг буй болгох, үйлийн үрийн тойрогийг гэтлэн давахад чиглэгдсэн цоо шинэ байр суурь юм.

“Хязгаарлалт” гэдэг нь аливаа юмыг зөвхөн өөрийн “эго” гэгч явцуу үзлийн үүднээс харахаас бус, ухамсар болон түүний объектийн нэгдмэл чанар, бүрэн бүтэн байдлыг олон талаас нь, өргөн утгаар нь авч үзэх чадваргүй байдлыг хэлж байгаа юм. Гагцхүү туршлага болон мэдлэгийн ачаар л бид бүхэл бүтэн юмны нэг хэсэг нь гэдгээ ухаарах бөгөөд тэгснээрээ нилээд чөлөөтэйгөөр үнэний ертөнцөд нэвтрэх болно. Гэгээрлийг олоогүй бие хүн гэдэг бол өөрийнхөө тавьсан торон сүлжээнд улам бүр төөрөлдсөн хирнээ өөрийгөө төөрөөгүй байна хэмээн хоосон хий мөрөөдөгч буюу ойд төөрсөн сармагчин адил нэгэн билээ.

9. Бүхэл бүтэний шилжилт, биелэл

Ариун номын “Ум” үсгээр илэрхийлэгдсэн үл төгсөхүйн сургаал нь агуу их хүрдний үндэс болон эргэлдэх цэгийг үүсгэж, бүхий л амьдрал ухамсар нь дотоод нэгдэл, бүхэл бүтэн байдлын туршлагаар нэгэнт нотлогдсон зүйл юм. Энэ нэгдэл нь хувийн ухамсар, бусад юмсын / гадны / ухамсар хоёрыг дур зоргоороо ижилсүүлсэнээр буй болгохгүй, гагцхүү “өөрийн” ба “өөрийн бус”, “би” ба “би бус”, “хувийн” ба “хувийн бус”, “харийн буюу “хүний” гэдэг үзэл баримтлалууд нь бидний өнгөцхөн ухамсар дээр тогтсон гэдгийг гүн гүнзгий ойлгосны үр дүн бөгөөд хүн ба амьтны ижил чанар болох “самата” нь тэдгээрт тус бүрт нь далд байдлаар орших дээд зэргийн бүхэл бүтэний хэрэгжилт гэдгийг мэдэх ёстой билээ.

Ийм учраас Буддист хүн “өөрийнхөө ахуйг эцэс төгсгөлгүйн дунд уусгах” төгс ухамсараа бүхний ухамсарт хандуулах буюу сэтгэл санаагаа бүх нийтийн сэтгэл санаанд нэгтгэхийг үл эрмэлзэнэ. Тэгэхээр Буддист хүний зорилго бол түүний / ахуй болон сэтгэл санаа / мөнхийн оршихуй, үл хуваагдах бүхэл бүтэнийг ойлгож ухамсарлах явдал болно. Ахуй болон сэтгэл санаанд нэмэх зүйл байх ёсгүй бөгөөд түүнээс / тэдгээрээс / авч хасах зүйл ч байж үл болно. Ахуй, сэтгэл санааг зөвхөн бясалгаж бодох буюу их бага, ямар нэгэн зөв замаар танин ухаарч болно. Амьд амьтны хөгжлийн ялгаа нь энэхүү мэдлэг ба бясалган бодох хэр хэмжээгээр тодорхойлогдоно. Төгс төгөлдөр гэгээрэл гэдэг бол энэхүү бүхэл бүтэний төгс мэдлэгт нэвтэрхий болсон хүнийг хэлнэ. Ийм учраас бүх бурхадад тэрхүү бүх чанар бүрэн дүүрэн шингэсэн байх бөгөөд харин тэдгээр нь тухайн цаг үе болон нөхцөл байдлын шаардлагатай уялдуулж, төрх араншингынхаа аль нэг төлөвт онцгой давуу тал өгч болно.

“Мани”- ийг уран сайхны хэллэгээр “Лянхуан шүүдрийн дусал” гэсэн нь буй. Түүнчлэн Эдвин Арнольдын “Азийн гэгээ” ном нь “Их далайн мандалд дусал ус бөнжигнөнө” гэсэн үгээр төгсдөг юм.

Хэрэв энэхүү яруу сайхан зүйрлэлийг эргэцүүлэн бодвол, эрхэм дээд хэрэгжилтийг өгүүлсэн Бурханы үзэл баримтлал болохсон билээ. Тухайлбал, энэ бол далайд бөнжигнөж буй дусал биш, харин дусалд бөнжигнөж буй далай юм. Бие хүнд орчлон ертөнц ойлгогдох ба харин орчлон ертөнцөд бие хүн ойлгогдохгүй, энэ үйл явцад бүхэл бүтэн гэдэг ойлголт буй болж, улмаар та бид хувь хүн буюу бие хүн, эсвэл бүхий олныг хамарсан нийтлэгийн талаар ярих шаардлагагүй болно. Ийм тохиолдолд бид ведийн номын эцсийн болон эцэс төгсгөлгүйн хооронд ямар ч хэлхээ холбоо байхгүй гэдэг ойлголтонд тулгуурласан хүсэл эрмэлзлэлийн дээд зорилго “Ум”- ын чанадад буюу нөгөө талд ямар ч гэсэн гарчээ гэж хэлж болно. Гэвч, бусдыг аврахын тулд сум нь нумаа орхих лугаа адил нэгэн зүйлийг үлдээхийн учир нь “энд ба тэнд”- ийн хоорондохыг нээж, хязгааргүй орон зайд нэвтэрч, эцсийн зорилгодоо хүрэх явдал юм.

Гэтэл Вижнянавадин сургаалыг практикт нэвтрүүлэхийг оролдогч Йогачараг баримтлагчид, түүний дотроос ялангуяа, нууц тарнийн ёс, ид шидийн замыг эрхэмлэгч Сиддхи нар “энд, тэнд”-ийн хооронд гүүр барихыг хичээсэн юм. Ингэснээрээ тэд “энд, тэнд”-ийн ялгааг хэмжээд зогсоогүй, басхүү манай ертөнцийн амьдралыг судалж, чухамдаа амьдрал нь оюун санааны нууцыг тайлах онцгой увидастайг судалж шинжлэх эрхэм зорилго тавьжээ.

“Өөрийн бие” ба “орчлон ертөнц” гэдэг нь тухайн нэгэн зүйл хуурмаг үзэгдлийн дотоод, гадаад хоёр дүр төрх төдий юм. Гэтэл бүхэл бүтэний хэрэгжилт буюу биелэл нь гадаад сансарыг оруулалгүй, бүхий л түгээмэл шинж чанарыг хадгалах ба тийм учраас бие хүний туршлагын үндсэн шинж чанар, “эго” буюу “би”-гийн бодит үнэнийг үл тайлна. Бүхэл бүтэний хэрэгжилтийн “биелэл”-ийн үзэл санаа нь “би”, “би бус” хоёрын нэгдмэл болон олон талт хоёрдмол ойлголт буюу эсвэл, та бид туршин мэдрэхүйн бодит үнэний төвшинд хөдөлж байгаа цагт аливаа нэгэн эсрэг тэсрэгийн хослолыг нотлохоос зайлсхийдэг юм.

Ийм үзэл санаа нь, бүх материалаг биетээс дээд оюун ухаант туршлагын тоо баримтаас метафизик ойлголтын түвшин хүртэлх бүхий л юмс, амьтдын оршихуйн түвшинд тохирох талтай. Бүхэл бүтэний мөр болох дарж устгахын мөр “зам” бус, харин та бидний бүхий л авьяас чадварыг хөгжүүлэн дэлгэрүүлэх мөр буюу дутуу дулимаг дүгнэлт хийж, буруу үр хүртэхээс зайлсхийх мөр болой.

Нууц сургаалын орчин үеийн өрнөдийн мэргэд дээрх үзэл санааг цэцнээр өгүүлэхдээ: Яаруу сандруу, дутуу дулимаг үйлдэл нь хаана ч гэсэн ахуйн гүнд унагана. Ийм учраас л манай дэлхийн бүх хэлбэрүүдийг цаг хязгаартай мэдрэмжээр ашиглах ёстой төдийгүй, та бид хамтран оролцож буй / эсвэл бид нэг хэсэг нь болж буй / энэхүү үзэгдэл нь дээд зэргийн ач холбогдолтой гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Гэтэл энэ нь Христос шашинтны мэдрэмжинд бус, харин газар дэлхий болон баяр бахдалаар бялхсан газар дэлхийн ухамсар, та бидэнд байгаа болон бидэнд харагдах хамгийн өргөн утгаараа та бидний үргэлж харьцаж байдаг орчлон ертөнцөд оршино. Чухам иймд та бид газар

дэлхийд сүүдэр тусах талынх нь үүдийг татах бус, харин орчлон ертөнц та бидэнд юутай хайрлаж байна, тэр бүхний үүдийг татвал зохино. Бидний өдөр тутмын ашиглаж хэрэглэдэг зүйл бол байгаль дэлхий даруй мөн бөгөөд энэ бүхэн нэг л мэдэхэд шилжиж өөрчлөгдөх жамтай төдийгүй, харин бид “энд” оршин буй нөхцөлд тэдгээр нь та бидний хань нөхөд, хөрөнгө баялаг, та бидний өвөг дээдсийн үед ямар байсан тэр лугаа нэгэн адил, жаргал зовлонгоо хуваалцагч болой. Чухам ийм учраас та бид манай ертөнцөд ноогдох бүхий л юмсыг харлуулж муулах, үл үнэлэх явдлаас татгалзах ёстой төдийгүй, өмнөх үеийнхний сөрөг үзэгдлийг дотоод мэдрэмжээрээ мэдэрч өөрчлөх хэрэгтэй. Өөрчлөнө гэж үү? – Тийм, тийм, өөрчлөх хэрэгтэй. Яагаад гэвэл, өмнөх үеийнхний дадал заншил өвлөн уламжлагдсаар та бидэнд анзаарагдахгүйгээр дахин сэргэх тавилантай тул, түүнийг ухаалгаар өөрчлөх шаардлагатай бөгөөд хүмүүсийн ойлголт ч ингэж өөрчлөгдөх тавилан буюу жам ёстой нь одоо нэгэнт тодорхой болжээ. Үзэгдэж харагдаж буйг үл үзэгдэхэд шилжүүлэх энэхүү эрхэм дээд зорилгыг зөвхөн та бид биелүүлэх ёстой.” / R. M. Rilke, Letters from Muzot, 371 - р хуудас /

Бүхэл бүтэн нь зөвхөн бидний ухаанаар гүйцэлдэх бөгөөд тухайлбал, манай бие хүмүүсийн бүрэн шилжилтийн замаар биелэгдэх учиртай. Үүнийг Бурханы номын нэр томъёогоор “Скандхагын шилжилтийн зам” буюу өөрөөр хэлбэл, бие хүний хувиа бодох үзлийн хатуу хальсыг материаллаг бус болгох замаар, хувиа бодох үзлийн бүх үндэс / ашрайд / - ийг өөрчлөх явдал юм. Энэ бол амьд амьтан бүрт байдаг далд хүчин чадлыг сэргээж, гэгээрэлд хандуулах, дотоод сэтгэхүйг нь гэрэл гэгээ, эрх чөлөөт аврагдалд тэмүүлдэг болгох аргаар хэрэгжих үндэстэй болгоно. Үүнийг зүйрлэвээс, өвс ургамал үндэснийхээ хүчээр газрын гүнээс чийг тэжээл авч ургаад, улмаар нар, агаарт тэмүүлж, навч цэцэг дэлгэрдэгийн нэгэн адил бодь сэтгэл / бодхичитта /-ийн үр хөврөл нь хоёр давхар саад бэрхшээлийг гэтлэн давдгын нэг нь үйлийн үрийн зовлон гамшиг / клеши - варана / , нөгөө нь бодит ертөнцийн хуурмаг үзэгдэл / жнейя - варана / болно.

Гэгээрлийн мөр - энэ бол бүхэл бүтэнд хүрэх зам бөгөөд энэхүү замаар замнаж гэгээрлийг олох боломжтойг Бурхан багш болон түүний үй олон шавь нар үлгэр

жишээгээрээ нотлон харуулаад тийм боломж зарчмын хувьд хүн бүрд буй бөгөөд “шороо, гал, ус, хий” -ний алинд ч байхгүй тийм чадал буюу туршлагад бие хүн шилжих, язгуур махбодоо дээд зэргийн бодит үнэнд хүргэх сургаал хайрлажээ. Энэ агуу их шилжилтийн замыг Сиддхи / шидтэн / нар Нууц тарнийн ёсны алхимидээ жирийн төмөр металлыг эвдэж хувиргах замаар шижир алт болгон хувиргахтай нэгэн адил эвдэршгүй ухааны цаглашгүй үнэт эрдэнэ / Мани / юм гэж зүйрлэн бичсэн нь бий.

Энэ шилжилт хэрхэн явагддаг вэ? Урьд бид үзсэнчлэн, хязгаартай ба хязгааргүйн хоорондын тэнцвэр баригч нь манас болно. Тийм учраас манас бие хүн / Ашрайя-Паравритти / -ийг шилжүүлэхдээ өөрийнхөө үүргийг хувь хүн буюу бие хүнчлэх зарчмын ухаарлаар солиод бусад бүх ялгарал / дефференциаци / - аа бүхий л амьдралын мөн чанарын нэгдэл хийгээд дотоод тэнцэтгэл / самата / нь бүх амьд амьтны хамт сэтгэл догдлох, гансрах шалтгааны үүрэг гүйцэтгэдэг байна.

Тийнхүү Манас нь дотоод чиглэл буюу хандлагаа өөрчилсөн агшиндаа үнэт эрдэнэ, гэгээрсэн ухамсар бодь сэтгэл буюу “бодхичитта”, “гүн ухааны чулуу” болж харьцсан бүхнийхээ ухамсрын элементийг гэгээрлийн хэрэгсэл буюу зэмсэг / бодхьянга / болгоно. Үүний дараагаар хувиа бодох хандлага болон мэдрэмжийн хүсэл тачаал / камачанда буюу амьдралын цангаа, эгээрэл / нь чөлөөлөгдөхийн хүсэл зориг, хэрэгжилт буюу биелэлийг эрмэлзэгч / Дхармачанда / болж хувирна. Үүний нэгэн адил бие хүний ухамсар / вижняна-скандха / түгээмэл хуулиуд болон дээд бодит үнэн / Дхарма - дхату - жняна / - ий мэдлэг болж өөрчлөгдөнө. Ийм өөрчлөлтийг төвдөөр “ Чхос-кий бингс-кий йешес “ гэдэг нь дхьяний бурхан Вайрочана / монголоор: Маш гийгүүлэн зохиогч / хайрласан номын хүрд / Дхарма чакра / - ний билэгдлийн билэг тэмдэг гэсэн далд утга агуулжээ.

“Дхьяни бурхан” хэмээх нэр томъёог бурхан ба бодьсадва нарын номын ба билэгдлийн дүр хоёрыг ялгаж ойлгох зорилгоор өрнөдийн бурханы шашин судлалын шинжлэх ухааны тогтсон тааллаас зохиосон түүхтэй ажээ. Тухайлбал, Түүхэн бурхан Шакиамуни, түүний урдах болон хойдох дүүрүүд дотроос бясалгалын үед нүднээ үзэгдэгч болон сэтгэл санаандаа бодох Дхьяни бурхадыг ялгаж таних үүднээс дээрх нэр гарчээ.

Төвд судар бичгүүдэд, түүхэн бурхадын манлай ялгуусан Шакиамуни / Шагжатуба / - гаар, нөгөө дхьяний бурханыг, түүхэн бурхадын нэгэн адил тэмдэгээр буюу өөрөөр хэлбэл, “ялгуусан”, “туулсан” бурхан гэх мэтээр тэмдэглэдэг ажээ.

Дараа нь манай хараа мэдрэх ертөнцийн объектоос дархан хэлбэр, архетип, бүх юмны цөм буюу хөрөнгө / виджа / орших ухамсар эрдэнэсийн эх булаг / Алая вижняна / тийш эргэнэ. Дараагаар нь далай мэт од гаригийн гадаргуу дээр үүссэн долгио намдаж, туяат толинд хувирах буюу түүнтэй усны гадарга нийлэх үед бүх хэлбэр дүрс / рупа / ямар ч гажиггүй талст цэвэр байдлаараа тодорно. Энэхүү материаллаг хэлбэр дүрс цогц нь / рупа -скандха / нь мэдрэмжийн чанадад орших зүйлсийг харуулна. Тэр нь хоосон чанар / шуньята / болон дүрсгүйн эхлэл болох бөгөөд зүйрлэвэл дуу чимээ нь нам гүмд шингэж, нам гүмийг үүсгэдэгтэй ижил юм. Ийм ч учраас “Маха -пражня - парамита - хридая сутра”- д ялгагдана. Тийнхүү үнэн хэрэгтээ хоосон чанар нь хэлбэр дүрс болно” гэжээ. Ахуй юмсын олон янзын хэлбэр дүрс нь бодит үнэн, шаантаг бичигт зураг мэт танигдана. Тийнхүү Васувандху- гын бичсэн “Вижняпти - мантра - сиддхи шастра” - д дурьдсанаар бол, ухамсар Алая нь Их толь мэт билгүүн ухаантай / Махадаршажняна - сампраюкта- читта- варга / холбоо бүхий ухамсарт шилжинэ. Үүнийг төвдөөр: “Ме-лонг та - буй йешес” гэж нэрлэх ба түүнийг Дхьяни бурхан Акшобхьягаар билэгдэнэ. Энэхүү бурхан нь уг билгүүн ухааны гарцаагүй үнэн гэдгийн илэрхийлэл болно. Түүнд усан элемент / Ухамсар - эрдэнэс нь тайван байдалтай далай лугаа адил / орших ба билэг тэмдэг нь Ваджра / Очир / болно.

Сэрэхүй цогц / ведана / буюу өөртөө төвлөрүүлсэн мэдрэмж нь одоо өрөөл бусдын мэдрэмж рүү хандана. Ингэснээр билгүүн ухаан холбоотой бүхий л мэдлэгийн их урсгал үүсгэнэ. Энэхүү тэгш адилтгалын билгүүн / самата – жняна - сампраюкта - читта - варга / нь Дхьяний бурхан Ратнасамбхавад тодорсон бөгөөд түүний Дана-мутра / өгөөмрийн тэмдэг /, эрдэнэсийн билэгдэл / ратна - мани / - ээр дүрслэгдэнэ. Юмсын дотоод нэгдэл нь хайр асрал (майтри) - аас илүү тодорхой мэдрэгдэхгүй. Мөн бусдын зовлон, жаргалыг

мэдэрснээр өгөөмөр сэтгэл тодрох бөгөөд тийм нөхцөлд ухаант хүн нь өөрт байгаа бүх юмаа үл барам, өөрийн биеэ ч зориулж болно.

Сэтгэл санааны туршилтат эмпирик ухамсар / мано-вижняна / нь дотоод ертөнцийн билгүүнд ямар ч саад / асанга / үгүй шууд шилжинэ. Үүнийг ялгаж таних мэдлэгтэй холбоо бүхий / пратъя - векшана - жняна -сампраюкта - читта - варга / ухамсар гэж нэрлэнэ. Өөрөөр хэлбэл, юмыг тус тусад нь ялгаж таних билгүүн ухаан гэсэн үг юм. Энэхүү билгүүн ухааны тусламжтайгаар бид юмсын далд учир шалтгааныг илрүүлэн харж чадна.

Тийнхүү ялган таних билгүүн ухаан нь дхьяни бурхан Амитабхад шингэсэн байна. Түүнийг бясалгал / дхьяни - мутар / хийж буй байдлаар дүрсэлдэг ба билэг тэмдэг нь бүрэн дэлгэрсэн лянхуа / бадам цэцэг / болдог.

Мэдрэмжийн ухамсарын категорид багтах бусад таван анги ухамсар нь Бодьсадвын амьдралын хэрэглэгдхүүн, багаж зэмсэг нь болно. Бодьсадвын тийм амьдрал нь гэгээрлийг олоход зориулагдсан байдаг. Үүний тулд үйлдэж буй мөргөл ёслол нь амиа бодсон зүйл бус, харин хамаг амьтны тусын тулд болно. Энэхүү утгаараа гэгээрэл нь “би өөрөө” болон “бусад” гэсэн ойлголт бүхий “альтруизм” – аас давуу талтай юм. Нөгөө талаар Христосын үзэл болон аль нэгэн нийгмийн үйлчлэлээс үндсээрээ ялгаатай болно. Тэдгээр нь үйлийн үр / карма / - ийг төрүүлж, аль нэгэн үйл явдалтай ямар ч холбоогүй юм. Харин хэнийг ч гэсэн үйлийн үрээс нь ангижруулахад чиглэгдэнэ.

Хуран үйлдэхээр хураагдсан цогц / санскара - скандха / буюу сэтгэл санааны ариусгалын үүрэг нь тийнхүү сэргэн, билгүүн ухааны ачаар биеллээ олно.

”Ийм мэдлэг нь бүх арван зүгт / од гариг, орон зайд / дэлгэрч гурван төрөлд ач буянаа хайрладаг - сахил санваартай билээ. / “Вижняптиматра -сиддхи - шастра” /

Энд дурьдсан сахил санваар нь эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын тулд гэгээрлийг олдог Бодьсадвын санваар болно. Бодьсадвын төгс гэгээрлийг олсоноор / самьяк самбодхи / зөвхөн өөрийгөө бус, бусад олныг буюу бүх амьтныг аварч өршөөхийн төлөө байдаг.

Үйлийг хийгч гурван зүйл байх энэ нь бие, хэл, сэтгэл гурав болно. “Бие” гэдэгт түгээмэл, орчлон ертөнцийн бие буюу / дхармакайя - Бурханы номын бие / бүх амьд бодис агуулагдана. “Хэл” нь үг буюу хэлний хүчийг, тэгэхдээ ариун үг / мантра / - ийг агуулна. Мөн түүний нэгэн адил сэтгэл нь түгээмэл ухамсар, Гэгээрсэн ухамсар болох “билгүүн”-ийг агуулна.

Тэдгээр нь, орон зайн арван зүгт үйлчилнэ. Тухайлбал: Үндсэн дөрвөн зүг, мөн завсар хоорондын туслах дөрвөн зүг буюу дөрвөн зовхис, тэнгэр эрхэсийн дээд цэг / зенит / , газар дэлхийн доод цэг / надир / - т тус тус үйлчилнэ. Энэхүү дээд, доод тивд үйлчилдэг хүчийг, хосолсон Очир буюу Элдэв - Очир / Вишва - Ваджра / - оор билэгдэл болгомой. Түүний төлөөлөгч нь дхьяни бурхан Амогхасиддхи буюу “Тус бүтээгч” болно.

Энэхүү чанадын билгүүнийг нээгч нь их Мантрын гуравдагч билэгдэл болдог “Бадма” - тай холбогдох тухай дараачийн бүлэгт гарах болно.

Гуравдугаар бүлэг

“БАДМА”

Бадам цэцэг - оюун ухааны

задралын билэг тэмдэг

Бадам цэцэг нь оюун ухааны задрал ба цэвэр ариуны билэг тэмдэг юм. Буддагын намтар - домогт өгүүлснээр, Хунтайж Сиддхартха төрөнгүүтээ газар гишгэн, долоо долоо алхахад гишгэсэн мөр бүр дээр нь Бадам цэцэг дэлгэрсэн гэдэг. Ингэхээр Бодьсадвын оршсон агшин бүр нь оюун ухаан задрах үйлдэл байсан юм. Бурхан багшийн дүр бидний өмнө бадам цэцгийн суудлаар сууж, ухааны мэлмий нээгдсэнийг нь дэлбээгээ бүрэн нээсэн Бадам цэцгээр билэгддэг бөгөөд түүний гол болон дэлбээнүүд нь янз бүрийн бурхан, Бодьсадва нарын дүр, хэрэгсэл, тарнийг төлөөлдөг билээ.

Хүний бие дэхь ухамсарын төвийг бас л бадам цэцгийн дэлбээгээр төлөөлүүлэх бөгөөд түүний өнгө нь хувийн чанарт, дэлбээний тоо үүрэгт нь зохицдог юм.

Энэхүү билэгдлийн анхны утга нь дараах тайлбараас тодорхой болно. Бадам цэцэг нь усны мандалд ургаж, уснаас ил гарсан хойноо дэлбээгээ нээх учраас шавар, ус тэргүүтнээр үл бохирддогын адил, хүний ухаан биеэс төрөхдөө жинхэнэ мөн чанараа шунал тачаал, харанхуй бүдүүлгийн балчигаас гарсаныхаа дараа нээдэг бөгөөд бүдүүлэг харанхуйн хүчийг гэгээрсэн ухамсарын ариун хүч болох бодхичитта, хосгүй үнэт эрдэнэ “мани”, цэцгийн дэлбээ “бадам” болгодог. Энэ ертөнцөд Арилсан гэгээн бээр ингэж тодорно. Хэдийгээр түүний үндэс нь энэ ертөнцийн харанхуй гүнд байх авч, тэргүүн нь гэрэл гэгээний зүг улам тэмүүлэх болно. Тэр бол гүн бөгөөд өндөр, харанхуй бөгөөд гэрэлтэй, материаллаг бөгөөд оюун санааны, явцуу бөгөөд хязгааргүйн нэгдэл буюу сансар, нирвааны нэгдэл юм. Нагаржунай төгс гэгээрсэний тухайд “оршихуй” ч, эс оршихуй ч гэгээрсэний шинж чанар биш. Ариун гэгээн бол бүхий л эсрэг тэсрэгийн нөгөө талд байдаг” хэмээн айлджээ.

Хэрэв гэрэлд тэмүүлэх тэмүүлэл, харанхуй газрын гүнд нуугдсан үрэнд оршдоггүйсэн бол, бадам цэцэг хэзээ ч гэрэл өөд эргэхгүй байх байсан биз ээ. Хэрэв дээд ухамсар тэмүүлэх тэмүүлэл хамгийн харанхуй бүдүүлэг гүнд байгаагүйсэн бол, ариуссан гэгээн хэзээ ч сансрын харанхуйгаас гарч чадахгүй байсан билээ.

Гэгээрлийн үр хөврөл ертөнцөд хэзээ ямагт байсаар байсан төдийгүй, ертөнцийн өмнөх эрин үеүдэд бурхад төрж байсан шиг өнөө үед ч, ирээдүйд ч ариуссан гэгээнтнүүд төрсөөр байх болно.

Тийм ч учраас, Бурхан багшийг цорын ганц, хосгүй гарамгай хүн мэт бус, харин гэгээрэгсдийн гинжин хэлхээний нэгэн залгамж хэмээн үздэг билээ. Иймд гэгээрсэн хүн нь хүн төрөлхтөний оюун санааны ухамсарт мөнхийн хүчит бодит байдал болон тодорч байдаг Буддизмын ерөнхий шинж тэмдэгтэй уялдуулж авч үзвэл, Бурхан багшийн түүхэн шинж чанар нь хоёрдугаар зэрэгт тавигддаг юм.

Хүн төрөлхтөнийг тодорхой нэгэн бурхан шүтэхээс ангижруулах гэсэн Будда Шакиамуни нь Буддизмын нилээд хожуу үед өөрөө бурханчлагдсан хэмээн шүүмжлэх нь бий. Тэгж шүүмжилж буй хүмүүс, шүтээн болсон Будда бол Сиддхартха Гуатама гэдэг

түүхэн хүн биш, хүн бүхэнд нуугдамал байдлаар оршдог бурханлиг чанарын амьд биелэл байсан гэдгийг, түүний өмнөх тоо томшгүй олон бурхадын адилаар, тэр хүнд тэрхүү бурханлиг чанар илүү тод тусгагдсан гэдгийг ойлгодоггүй юм. “Бурханлиг” гэдэг үгнээс эмээх хэрэггүй, Будда хүртэл оюун санааны хамгийн дээд чанаруудыг практикт төвлөрүүлэн нэвтрүүлэхийг “бурханлиг байдалд орох” хэмээн нэрлэж байсан нь эртний Энэтхэгийн судруудаас харагддаг.

Иймээс, Гаутама гэдэг хүнийг бурханы зиндаанд өргөмжлөөгүй, харин хүний хүч чадлыг илрүүлэх чадавхи болсон “бурханлиг чанар”-ыг л өргөмжилсөн хэрэг юм. Ингэлээ гээд бурханлиг чанарын үнэ цэнэ буураагүй, харин ч хийсвэрлэлээс амьд бодит байдал, ухааны объектоос биеэр туулсан бодит байдал болсон юм.

Ийм ч учраас, Будда болон Бодьсадва нарыг байгалийн хүчийг төлөөлсөн бурхадтай болон эрт балар цагийн хүмүүсийн ойлгодог бусад бурхадтай адилтгаж болохгүй билээ. Учир нь тэдгээр бурхадыг зөвхөн адгуус буюу хүнчлэх үеийн дүр төрхөөр нь буй болгосонд байгаа юм. Хэдий тийм боловч тэдгээр нь хүн төрөлхтөн өөрсдөө өргөмжлөн хэрэглэж ирсэн, цаашид ч хэрэглэж болох дээд мэдлэг, билгүүн ухаан, уян хатан зохицолт байдлын анхны дүр төрх нь билээ.

Эдгээр бурхад нь түүхэн цаг үе, тодорхой нөхцөлд үүссэн, эсвэл бясалгал дахь хүний оюун ухааны онгон төлөв, Дхьяни бурхад гэж нэрлэгдэх агаад энэ нь зах хязгаар дахь үйлдэл, үл гүйцэлдэх үзэл бодлын зохиомол нэр ч биш, харин хүний оюун ухааны бүрдэлийн үзэгдэх биетэй, өнгө дүрстэй ойлголт болно. Билгүүн ухаан нь амьдралд нэвтэрч, хүн оршин тогтнох нэг болзолт хэсэг нь болсон цагт л “Бодит зүйл” болох юм.

Их хөлгөний багш ялангуяа тантрын Важраяны багш нар чухам үүнийг ихэд эрхэмлэж ирсэн ба яагаад гэвэл, тэд оюун санааны амьдралд хоосон хийсвэрлэх явдлын хор уршиг, аюулыг андахгүй мэддэг байжээ. Шуньявада, түүнтэй холбоотой йогачара болон вижнянавадын гүний сэтгэлзүй зэрэг өндөр хөгжсөн гүн ухаанд хоосон хийсвэрлэхийн аюул бүр ч бодит зүйл болдог ажээ.

Тантрын хүнчлэх билэгдлийн ёс

Философийн үзэл баримтлал, оюун ухааны дүгнэлтийн хийсвэрлэлийг шууд туршлага, анхаарал төвлөрүүлэх дасгал, өдөр тутмын амьдралаар байнга шалган засамжилж байх ёстой. Иймээс ч Важраянад хүнчлэх дүрслэл үүссэн ухааны байр сууринаас бодит байдлыг шууд ухамсарлах гэсэн ухамсарт үзэл санаа, зорилт тавьсанаар үүнд хүрэхгүй, зөвхөн оюун ухааны логик дүгнэлт, ухаалаг сэтгэлгээгээр ойлгож үл болох бидний оюун ухааны тэр төвшинд ухамсартайгаар нэвтэрсэнээр л үүнд хүрнэ. Гэхдээ зөвхөн дотоод үзэхүйн хүчний нөлөөгөөр л ийнхүү нэвтэрч болно.

Ийм үзэхүй нь цэвэр субъектив чанартай, түүнд эрхэм дээд юм юу ч байхгүй мэт санагдаж болно. Гэвч, үг хийгээд үзэл санаа тэргүүтэн нь бас ч тийм эрхэм дээд зүйл биш бөгөөд тэдэнтэй адилсахын аюул үлэмж их юм. Яагаад гэвэл, үгс нь хязгаарлагдах, явцууруулах хандлагатай бол биеэр мэдрэх, жинхэнэ үзэхүйн билэг тэмдгүүд нь бидний дотор сэтгэлд амьдарч, ургаж төлжиж байдаг билээ.

Түүгээр ч зогсохгүй өөрийнхөө хүрэнээс хальж байдаг. Түүнчлэн, хэт материаллаг бус, хэт “тунгалаг” бөгөөд түүнийг “барьж аваад” тодорхойлж, тайлбарлаж болохгүй. Түүний хэрэгсэл нь янтра, мантра, мутар гурав юм. Эдгээр нь үзэгдэхүй, сонсогдохуй, мэдрэгдэхүй гурвын зэрэглэл юм. Энэ гурав бол бие / кая /, хэл / вак, вача /, сэтгэл / чигта / гурвын үзүүлэлт болно.

Энд “янтра” нь “мандал гэсэн утгаар хэрэглэгдэх бөгөөд энгийн нүдээр хийгдэх үйл явц дээр үндэслэсэн, дэс дараатай эмх цэгцтэй байдлын билэг тэмдэг юм. Тэр нь дөрөв, найм, арван зургаан дэлбээ бүхий бадам цэцэг буюу бясалгал хийх үеийн харааны төв цэг болдог юм.

Мантра / тарни / нь, оюун санааны бодит үйл явцад зориулсан зан үйлийн үед, багшаас шавьдаа дамжуулж буй ариун үг, авиа юм. Энэхүү ариун үг авиагаар шавийн ухамсарт үүссэн дотоод вибраци, түүний ухааныг дээд хэмжүүрт хөтөлнө.

Мутар нь, биеийн / үндсэндээ, гарын / дохио бөгөөд түүнийг зан үйлийн хөдөлгөөн, ариун үг түүнчлэн дотоод байршил дагалдана.

Энэ бүхнийг зөвхөн бага зэрэг зохицуулан өөрийн оюуны бүтээлийг бүтээж, үзэхүйгээ бодитой болгож чадна. Энэ нь хэт их сэтгэл хөдлөл, чөлөөт ургуулан бодохуй биш, гэнэтийн тохиолдол, тодорхойгүй сэтгэл хөдлөл, төөрөгдөлд байр үл олдох Бодьжилтын чиглэлд ухамсартайгаар чиглүүлсэн оюун ухааны бүтээлч үйл явц юм.

“Эртний Бурханы шашны сургаал буюу тодруулбал, бие, хэл, сэтгэл гурвын тусламжтай гүйцэтгэх үйлдэл нь хүний хүслийн зоргоор бүтээгддэг “үйлийн үр”-ийн цаад туйл нь тухайн үедээ болж байсан хэдий ч, Важраянад шинэ учир холбогдолтой болсон юм. Энэ нь харьцангуй чухал зан үйлд хамаарах ба өөрөөр хэлбэл, бие, хэл, сэтгэл гурваар үйлдэх үйлийн зохицуулалт нь орчлон ертөнцийн тогтворгүй хүчнүүдийн зүг амьдралд өөрийгөө авч явах боломжийг олгодог бөгөөд тэдгээрийг өөрийн зорилгод ашиглахын тулд дуулгавартай болгох хэрэгтэй юм.” / Н. Von Glasenapp, 1936 /

Орчлонгийн тогтвортой хүчнүүд нь хүний сэтгэл санааны хүчнээс аль нэг талаараа ялгаатай биш эдгээр хүчнийг ухаарч, өөрийн ухаанд хамаг амьтны тусын тулд тусгах нь Буддизмын тантрын зорилго юм.

Буддын шашинтан, гадаад ертөнцийг тусдаа бие даасан ертөнц гэж үздэггүй. Тухайлбал гадаад, дотоод ертөнц бол нэгэн биеийн доторхи түүний агуулгыг нөхцөлдүүлэгч хоёр тал юм. Энд бүх хүчнүүд, үйл явдал, ухамсарын бүх хэлбэр, түүний агуулгын хэлхээнүүд харилцан нөхцөлдсөн эцэс төгсгөлгүй харилцааны сүлжээ болон нэгдсэн байдаг.

Тантра хэмээх үг нь “нэхсэн”, “сүлжсэн” гэдэг утганд хамаарах үг ба түүнд бүх юмс үзэгдэл харилцан сүлжилдэж, байгаа бүхэн бие биеэсээ хамаарч шалтгаалан, үр дагавар тасралтгүй солигдон, түүхийн болон хувь хүний амьдралын дундуур нэвтрэн гардаг учиртай. Буддизмд тантрын нэрээр орсон судрууд цөм нууцлаг нэгэн чанартай байдаг нь юмсын дотоод холбоог тогтоож байдагт оршино.

Тантризмын энэхүү мөн чанар нь учир шалтгааны зүй тогтолтой хамт хөгжсөн ба энэ нь вижнянавада болон йогочарын сургаалыг баримтлагчдын шашны зан үйлээс урган гардаг юм. Эхнийх нь онолын болон гүн ухааныг голлон анхаардаг бол, хоёр дахь нь

Буддизмын их хөлгөний нэгэн адил амьдралыг үзэх төлөвийг онцлох ажээ. Үлэмж их давалгаа адил тантрын ертөнцийг үзэх үзэл Энэтхэг орон даяар тарсан бөгөөд Буддизм болон Индуизмд тэрхүү үзэл нь дэлгэрэхдээ тэдгээр шашнуудын олон ялгааг арилгаж өөрчилж чаджээ.

Билгүүн ба хүч буюу Шактийн эсрэг Пражня

Буддизмын тантризм Индуизмд нөлөөлсөн нь маш гүнзгий учраас Өрнөдийн Дорно дахиныг судлаачдын ихэнх нь одоо ч гэсэн тантрын ёс гэдэг нь Буддын тогтсон таалаар түүний бараг уналтын үед гарч ирсэн Индуйст бүтээл гэж үздэг юм.

Гэтэл Буддизм дахь бүтээлч урсгалууд нь, маш эртнээс дэс дараатай хөгжиж ирсэн явдал дээрх хандлагыг няцааж байна. Бүр эртний Махасангхики гэхэд л, “Дхарани - питака” болон “Манзушри мула калп”-даа мантрын томьёоллын тусгай цуглуулгатай байсан бөгөөд тэр нь зарим эрдэмтдийн нотолж буйгаар, МЭ-ний анхдугаар зуун жилд хамаарах ажээ. Түүнд мантра, Дхаранигаар / тарни / маш олон тооны мандал, мутар байсан ажээ. “Манзушри мула калп”-ийн он цаг нь төдий л тодорхой биш хэдий ч, Бурханы шашны тантрын ёс МЭ-ний III зууны сүүлчээр төлөвшин тогтсон гэдгийг алдарт “Гухьясамажа тантра”-гаас мэдэж болно.

Бурханы шашны тантризмыг Шивайзмаас үүдэлтэй гэж нотлох нь, тантрын эх зохиолтой танилцах боломжгүй хүмүүсийн хийж буй хэрэг билээ. Бурханы шашны тантрыг Индуизмтай харьцуулан гадна талаас нь харахад, зарим төстэй тал байвч арга барил, зорилгын хувьд асар их зөрөөтэй нь мэдэгдэх төдийгүй, Буддист тантрын сэтгэл оюуны болон түүхэн давуу тал, өвөрмөц тогтолцоо сэлт нь тодорхой байдаг.

МЭ-ний IX зууны үед амьдарч байсан Энэтхэгийн агуу их гүн ухаантан Шанкара Ачаръягын бүтээлүүд бараг бүх Шиваит гүн ухааны үндсийг тавьсан бөгөөд тэрээр Нагаржунай болон түүнийг залгамжлагчдын үзэл санааг маш гүнзгий ашигласан учраас, түүнийг Индуйстууд Буддизмыг нууцаар даган баясдаг гэж харддаг байжээ. Үнэндээ, Индуйст тантра нь Буддист тантрын арга зарчмыг авч, түүнийг өөрийн хэрэгцээ шаардлагадаа тохируулан зохицуулсан ажээ. Ийм дүгнэлт нь Төвд уламжлал болон түүний

утга зохиолын судалгаагаар нотлогдохоор барахгүй, Энэтхэгийн тогтсон тааллын Буддизмын тантрын эрт үеийн санскрит бичмэлүүдэд хийсэн шүүмжлэлт судалгаагаар, түүний Индуйст тантратай түүхэн ба үзэл суртлын холбоотой зэрэг нь харагддаг юм.

“Буддын эзотеризмын оршил” гэдэг номондоо Бенойтош Бхаттачарья дүгнэлт хийхдээ, “Тантрыг анх эхэлж шашиндаа нэвтрүүлсэн нь Буддистууд, түүнийг Буддистуудаас Индуйстууд хожим зээлдэж авсан бөгөөд ийм ч учраас, хожуу үеийн Буддизм Шивайзмаас үүсэлтэй гэж ярих нь буруу гэж, айх зүйлгүй мэдэгдэж болно” гэжээ. / В. Bhattachua, 1932, 147- р хуудас /

Индуйст ба Буддист тантрын гадна талын зарим төсөөтэй зүйлд үндэслэсэн, энэхүү алдаатай үзлийг дэврүүлэгчдийн нэг бол Төвдийн Буддизмын мэргэжилтэн гэгдэх Остин Велл юм. Түүний санаагаар бол, Буддист тантризм нь ердөө л “Шиваг шүтэгч баримал бурханд мөргөгчид, Шакти буюу охин тэнгэрийн хүчийг шүтэгчид, лус савдагт итгэгчид болохоос өөр юу ч биш. Түүний мантра, дхарани гэгч нь ямар ч утгагүй холион бантан, түүний нууц тарнийн ёс буюу мистицизм гэдэг нь авах юм огт үгүйн этгээд хоосон дүр ба мандала хэмээх “ид шидийн дугуй”, түүний йога нь буддизмын овоо дориун цэвэр тулгууруудыг няц дарж хордуулсан Их хөлгөний ёсонд амь бөхтэй зууралдсаар байгаа, бусдын хүчээр амьдрагч лус савдаг, төв үзлийн номлол нь хэрэггүй хуурамч үгүйсгэх үзэл, мөн Цагийн хүрдний сургаал нь бидний мэдэх, бүх гүн ухааны дотроос хамгийн өөдгүй нь” гэжээ. / L. A. Waddell, 1895 /

Төвдийн Буддизмын талаар, Өрнөдийнхөн иймэрхүү “нэр хүндтэй”-чүүдээс анхны мэдэгдхүүнээ авсан болохоор, тэдний утга зохиолд, Буддист тантризмын эсрэг зүйлүүд, элбэг байдаг нь гайхалтай зүйл огт бишээ.

Бурханы шашны тантрын сургаал нь Индуйст тантризмтай үйлдэл, үүсэл нэг гэж батлах явдал буюу ялангуяа, Шактизмын зарчим зэрэг нь үнэн байдалд үл нийцэхээр үл барам, бүхэлдээ алдаатай үзэл бөгөөд учир нь энэ хоёр систем, огт өөр нөхцөл байдалд үүсч хөгжсөн түүхтэй билээ.

Бурхан Шакиамуни сургаалынхаа үндсэнд Энэтхэгийн домог үлгэрийг иш татаж, дэвсгэр болгосон боловч, түүнийг нь хэн ч зэмлэдэггүй билээ. Тэдгээр домог үлгэр нь бясалгалын эрхээр үүсэх тодорхой хүч, сэтгэл догдлол, гансралын билэг тэмдэг, эсвэл арай өндөр төвшинд буй ухамсарын илэрхийлэл болдогыг энд дурасуу.

Ямар нэгэн шашны сургаал, хөдөлгөөнийг үнэн мөнөөр нь ойлгоё гэвэл, тэр сургаал хөдөлгөөнд хүнлэг, үнэнч, чин сэтгэлээс хүндэтгэлтэй хандах ёстой. Эс тэгвээс, уг сургаалыг ойлгож мэдэж чадахгүй болно. Ер нь эрдэмтэн мэргэдийн нэн чухал шинж тэмдэг нь ном сургаалд маш хүндэтгэлтэй ханддаг зан чанар юм. Ийм учраас аливаа сургаалыг үүсэл гарал, үзэл бодол, үндэс язгуураар нь гүн гүнзгий судлах хэрэгтэй. Дараа нь уг сургаалаа өөр бусад сургаалтай харьцуулж үзнэ. Сургаалын гүнд нь оролгүй, гадна талаас нь өнгөцхөн хараад тийм, ийм төрлийн сургаал гэж өгүүлэх аваас, буруу дүгнэж алдах явдал ч гардаг. Хэл шинжлэлийн дүгнэлт, бурханы хөрөг зургийн харьцуулалт зэрэг нь, хэдийгээр ашигтай боловч, сургаалын үндсийг ухаж мэдэхэд гол арга болж чадахгүй.

“Буддистуудаас тантрад оруулсан шинэ зүйлс буюу тухайлбал, урлаг нь Индуйст нарт хялбархан ойлгогдож, оюун ухаанд нь амархан бууж, шашны номлол, бясалгалыг ихэд хөгжүүлсэн түүхтэй. Гэтэл тийм шинэчлэлийг Буддистууд анх бурханы шашныхаа тусын тулд бүтээсэн билээ. Индуйсын тантра гэдэг нэрийн дор гарч ирсэн, судар бичгүүд нь буддист үзэл санааны дараахан л гарч ирсэн байдаг.” / В. Bhattachuua, 1932, 50 - рт /

Буддист тантра болон Төвдийн уламжлал, түүх судар, зураг хөрөг сэлтийг судалж үзээд, Б. Бхаттачарья / дээр дурьдсан / цааш тодруулан нэмж бичихдээ, “Буддын тантризм нь, Индуйст тантрын сэдэвт нөлөөлсөн үндсэн эх сурвалж мөн гэдэг нь хангалттай батлагдсан зүйл учир Буддизмыг Шивайзмаас үүсэлтэй гэж нотлох ямар ч боломжгүй юм. Нөгөө талаас, Индуйст тантра нь, Очир хөлгөнөөс үүдэлтэй бөгөөд тэдгээр нь цөм буддист тантрыг дуурайлгасан хуулбар гэдгийг тэмдэглэх нь зүйтэй” гэжээ. / Дээрх номын, хуудас 163 - рт /

Иймд “Буддист тантра нь гаднаас нь харвал, Индуйст тантратай зарим талаар төстэй мэт боловч, үнэн хэрэг дээрээ ижил юм маш бага байдаг. Ялангуяа, сэдэвчилсэн хуваалт,/

тематика / гүн ухааны номлол, шашны дэг зарчмын хувьд, таарах юм бараг байхгүй. Буддист, Индуйст хоёрын зорилго, санаа сэдэл / мотив / нь асар ялгаатай болохоор, хоорондоо таарах юм төдийлөн байдаггүйд гайхах зүйлгүй.” / Мөн дээрх номын, хуудас 47- рт /

Гол ялгаа нь юу вэ ? гэвэл, Буддист тантризм бол Шактизм бишээ. “Шакти”- гийн тухай ойлголт бол, эрхэм дээд Бурхан Шивагын бүтээлч эмэгтэй дүр буюу Бурханы хүчинд итгэх гэсэн ойлголт юм. Өөрөөр хэлбэл, Буддизмд Шакти ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй бол, Индуйст тантрад, Шакти -гийн хүчний тухай ойлголт чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Тэгвэл, тантрын Буддизмын гол үзэл санаа нь, Пражня буюу зөн совин, зөн билэг, билэг билгүүн, мэргэн ухаан болно.

Буддистуудын хувьд, Шакти / дагина / гэдэг нь “Майя” буюу ташаа мэдрэхүйн хүч бөгөөд түүнээс биднийг зөвхөн сэтгэлийн ариусал чөлөөлж чадна. Иймээс Буддистуудын зорилго бол, орчлон ертөнцийн тийм хүчтэй танил тал болох, түүнтэй өөрийгөө холбох буюу түүний гар, хөл болохыг эрмэлзэн эзэгнэхэд биш, харин бүр өөрийг чинь амьдрал, үхлийн цагираган эргэлтэнд хадаж, сансарт шоронгийн хоригдол мэт үүрд байх хүсэлтэй, тийм хүчнээс өөрийгөө чөлөөлөхийг хичээхэд чиглэх ёстой. Гэвч, тэрээр тийм хүчтэй тэмцэхдээ, уг хүчийг үгүйсгэж огоорох буюу устгаж арилгах бус, гагцхүү түүнийг Билгүүний гал дөлд оруулж, Гэгээрлийн хүч болгон хувиргах ёстой бөгөөд тэгж чадсанаар, шакти-гийн элдэв араншинг орвонгоор нь эргүүлж, хөдөлгөөнийг нь огт эсрэг тийш нь хандуулж, бүрэн бүтэн байдал, нэгдэл нягтрал, тэгш дүүрэнд тэмүүлдэг болгох ёстой юм.

Эс тэгвээс, “Шакти / дагина / - тай холбогдох нь зөвхөн хүчийг үүсгэнэ” гэж Индуйсын “Кулачудамани тантра” - д өгүүлжээ. Гэтэл буддистууд нь дэлхийг бүтээх тэтгэхэд бус, харин “шуньята”/ хоосон чанар / -г “бүтээгдээгүй, засамжлаагүй” байдалд нь эргүүлж буцаахыг эрмэлзэх бөгөөд тийн эрмэлзэхийн учир бол, чухамхүү “бүтээгдээгүй, засамжлаагүй” байдал л бүхнийг буй болгож, тэдгээр нь / хэрэв хүний хэлээр үл илэрхийлэгдэх зүйлийг томъёолж болдог юм бол / тэрхүү бүх бүтээгдхүүний нөгөө талд нь

оршиж байдаг ажээ. Хоосон чанарын энэхүү ухаарал / төвдөөр, стонг - па - нийд / нь сэтгэлийн ариусгал – пражня- / төвдөөр, шес раб / буюу билгийн дээд хязгаар болно. Энэхүү дээд зэргийн билгийг амьдралд биелүүлж хэрэгжүүлэх нь Гэгээрэл буюу Бодь мөр / бодхи / болох бөгөөд өөрөөр хэлбэл, хэрэв / пражня эсвэл, шуньята / бүхнийг хамрагч билгийн зарчим нь, орчлон дэлхийн нигүүсэл, зовлон жаргалын идэвхтэй аргын зарчимтай нэгдвэл, тэр нь пражня болон хоосон чанарын биелэлийг олох хэрэглэгдхүүн / упайя, төвдөөр: тхабе / болох бөгөөд улмаар Бурхан багшийн жинхэнэ дүрийг олно. Ийм болохоор мэдрэмжгүй оюун санаа, дур хүсэлгүй мэдлэг, зовлонгүй ухаан нь цөм ялгаагүй үгүйсгэл, догматизм, цаашилбал ухаан санааны мөхөл хоосролд хүргэх ба нөгөө талаар ухаан бодолгүй мэдрэмж, мэдлэггүй дур хүсэл / сохор дурлал /, ойлголтгүй зовлон бэрхшээл нь бүрэн эмх замбараагүй байдал / хаос / - д буюу улмаар уналтанд хүргэнэ. Гэвч, хоёр тал нь нийлсэн зүрх сэтгэл, мэдрэмж, оюун санаа, дээдийн дур хүсэл, гүн гүнзгий мэдлэгийн агуу их холбоо бат оршсон тийм нөхцөлд, хаана ч гэсэн жинхэнэ гэгээрэл хэрэгжиж, бодит биеллээ олно.

Гэгээрлийг олох үйл явдлын хамгийн эрхэм бөгөөд хамгийн нийтлэг, иж бүрэн билэг тэмдэг нь, чухам юугаар илэрхийлэгдэх вэ ? гэвэл: эр эмийн дурлал дахь хүчин зүйл элемент / упайя / нь эр дүрсэнд, “идэвхтэй бус” / пражня / нь эм дүрсэнд нь байх явдал болно. Энэ зарчим нь Индуист тантратай эмийн талыг “Шакти” мэт, өөрөөр хэлбэл, идэвхит зарчим, эрийн талыг “Шива” буюу цэвэр бурханлиг ухамсар, ахуй өөрөөр хэлбэл, төрөлх төлөв араншингаараа оршиж буй, зарчим мэт үздэг болно.

Бурханы билэгдлээр бол, Хамгийг мэдэгч / Бурхан / багш нь өөрийнхөө мэдлэг / пражня, билэг билгүүнтэй / хайр дурлалын хүчинд эр, эм хоёр нэгэн зүйл болдог мэт / нэгдмэл болдог байна. Ингэж нэгдэн нийлэх явдал нь, жирийн үгээр өгүүлж барамгүй, дээдийн жаргал / Махасукха буюу төвдөөр, Дэмчог / болно. Дхьяны бурхан буюу өөрөөр хэлбэл, Бурхан ба Бодьсадва нар бясалгалын явцад дүрслэгдэхдээ, гэгээрэлд идэвхтэй тэмүүлэгч болж тодрон хайр дурлал, зовлон жаргалыг бүгдийг нь хамарсан “упайя” - гийн

байдалд орших учир, дээдийн дээд Билгүүнийг агуулагч нь, Дагинын билэгдэл Пражнятайгаа янаглан буйгаар дүрслэгдэнэ.

Тийнхүү Индуйстын билэгдэл нь “эр, эмийн туульсыг бурхан болон түүний итгэл бишрэлийн үүднээс зориуд сольсон, явдлын хэрэгцээ нотлогдсон нь үгүй. Хэрэв тийм өөрчлөлт оруулсан бол, тэдний Буддизмд нэвтрүүлэх гэсэн үзэл баримтлал нь түүнд харшилж, талаар болох тавилантай байжээ. / Г. Зиммер, “Формы выражения и Йога индийском изобразительном искусстве” номын, 75 - р хуудас / Учир нь, тийм үзэл баримтлал бол, үндсэн утга агуулгаараа, Буддист тантризмын бүхий л системийн үндэс суурьтай, үнэ цэнийг харуулсан зарчмын тууштай хавсралт байх ёстой ажээ.

Үүний нэгэн адил, Индуйст тантра ч Индуйзмын үндсэн үзэл санаанд нэвтрүүлсэн тууштай хавсралтууд байх бөгөөд тэдгээрт, уг зорилгодоо зохицон тохирох Буддист аргыг авч хэрэглэсэн нь буй. Харин, хоёр өөр системийн хэрэглэсэн, шашны тэр арга нь яваандаа гарцаагүй зөрчилдөх үндэстэй бөгөөд өөрөөр хэлбэл, хүссэн үр дүнг нь өгч чадахгүй, харин ч сөрөг нөлөө үзүүлнэ. Учир иймд пражня / эм /, упайя / эр / гэдэг үгсүүдэд, хэлзүйн хүйс зохицуулах мэт, хиймэл аргаар хандах шаардлага байхгүй. Дээрх мэт тайлбар бол, зөвхөн Буддист тантра нь Индуйст тантрын дуураймал хувилбар гэдэг алдаатай ойлголтоос хичнээн түргэн сална, Буддизмд “шакти” хэмээх үзэл баримтлал холбогдолгүй гэдэг нь, төдий чинээ тодорхой болно.

Хэрвээ “анатта” гэдэг нэр томъёог / санскрит, анатман / эсрэг утгад нь оруулаад, брахманы ойлголтоор “атман” болгож сольсон буюу ялгаагүй Тхеравадин, атманы үзэл санааг хүлээж авсан гэж тайлбарлахад хүрвэл, / тийм тохиолдолд, Буддизм нь зөвхөн Брахманизмын нэгэн хувилбар болохсон билээ / Тхеравадин уламжлалынхан хэлэх үггүй болох байсан лугаа нэгэн адил, Төвдийн Буддизмыг баримтлагчид нь, тэдний унаган шашны уламжлалд хэзээ ч байгаагүй, түүний ариун номонд хэзээ ч ашиглаж байгаагүй “шакти” гэдэг нэр томъёо ороод ирэх буюу өөрөөр хэлбэл, “пражня” гэдэг ойлголт буюу билгийн зарчмаар Дхьяни бурхан болон Бодьсадва нарыг төсөөлөх явдал гарч ирвэл, бас л хэлэх үггүй болох байсан биз ээ.

Бодит хүнийг “Бурхан буюу бурхан бүтээгч” хэмээн шүтдэг “Тейст” системийн нэр томъёог, уг ойлголтыг үндсээр нь үгүйсгэдэг “Тейст бус” систем руу дур зоргоороо хөрвүүлж болохгүй.

Эцсийн эцэст, нэр томъёог энэ мэт хольж хутгаснаас болж, сүүлийн үеийн тантрад, Ади бурханыг / Анхдагч бурхан / бурханчилж, бурхан бүтээгчийн дүрээр харуулсан алдаатай үзэл санаа гарч ирсэн явдал нууц бишээ. Ади бурханыг ингэж дүрслэх нь, Буддизмын байр суурийн үүднээс хэрхэвч хүлээн авч боломгүй зүйл юм. Тэгвэл, Ади бурхан нь гэгээрсэн ухааны өргөн цар хүрээ, цагийн болон “тэгш дүүрэн”- ий гаднах билэгдэл буюу Г. Гюнтерийн нилээд онож хэлсэнээр, “Орчлон ертөнц болон хүн төрөлхтөн нь Ади бурхан гэсэн нь, цаг нөхцөөх гэж, дэлхий ертөнцтэй шагай тоглож буй бурхан хараахан биш юм. Түүний тухай ойлголт бол, эрт үеийн огт бурхангүй Буддизмд гаднаас чихэж оруулсан, Монотейзмийн төрөл ч биш билээ. Ади бурханы тухай ойлголт бол, мэргэжлийн Семантикч / үг үсгээр хөөцөлдөгч / үзэлтэний алдаа юм. Онолоор хөөцөлдөх буюу нэр томъёог онолжуулахыг, Буддизм үл тэвчинэ. Тэрээр, бидний ахуйн гүн дэхь нууцад нэвтэрч, Очир / алмаз лугаа / цацруулж буй, далд гэрлийг нь илрүүлэхийг хичээдэг юм. Ийм учраас Ади бурханы тухай ойлголтыг хүний жинхэнэ уг чанарыг нээх гэсэн, утгаар хөрвүүлэх нь зүйтэй болно.” / N. V. Guenter, 1952 /

4. Важраяны билэгдлийн хэлэн дэхь

арга, билгийн зарчмын туйл

Тантрын буюу нууц тарнийн ёсны Буддизм нь Индуйзмд асар гүн нөлөөлсөн учраас Өрнөдийн судлаачид, одоо болтол Тантризмыг Буддизмын тогтсон таалал уналтынхаа үед шүүрэн авсан Индуйст бүтээл хэмээн үздэг юм. Буддист тантрыг индуйст тантризмтай хольж хутгаснаас, маш их будлиан үүсч, одоог хүртэл ийм будлиан Бурханы хөрөг зураг, утга зохиол аль алинд нь байх төдийгүй, ялангуяа шидтэний утга зохиолд нилээдгүй оршиж байна. Энэ нь Важраянаг билэг тэмдгүүдийнх нь хамт ойлгоход саад болсоор байна. Өмнө нэгэнт өгүүлсэн Сиддхи / наян нэгэн шидтэний тухай / - гийн утга зохиолд “нууц хэл” гэгчийг ашигласан байх ба түүнд, эрхэм дээдэс гуйлгачин ядуу байдлаар, эрхэм

ариун үйлстэн арчаагүй дорой байдлаар, тасархай үзэлтнийг хорвоод байдаггүй хэлбэрээр дүрсэлсэн бол, гүн гүнзгий мэдлэгийг үлгэр мэт, үл үнэмшигдэх гажуу хэлбэрээр тус тус илэрхийлсэн байдаг.

Энэ бол бүхэлдээ тусгай хэллэг / “өгт хэллэг” / байсан төдийгүй, хэрэг дээрээ, тэр үеийн шашин - гүн ухааны амьдралыг өргөн цар хүрээтэй оюунжуулж байсантай холбогдон гарч ирсэн, цочроох эмчилгээний төрөл юм. Бурхан багш өөрөө эрх дархтаны номчирхолын явцуу бясалгалын эсрэг тууштай тэмцэгч байсны нэгэн адил, Сиддхи нь бодит амьдралаас аль хэдийнээ салж хагацсан, энэрэн нигүүлсэгч гэгдэх лам хуврагын ихэрхүү зангийн эсрэг, эрс хатуу тэмцэгч байв. Тэдний хэл амьдралтай нь адилхан, ямар ч баримжаа тоймгүй бөгөөд үгийг нь махчилан ойлгосон хүн, нэг бол жигшин зэвүүцэхдээ муурч унах нь холгүй бөгөөд эсвэл хүч чадал, ид шид болон хөрөнгө баялагийн төлөө тэмцлийн тухайд төөрөгдөлд ордог байжээ. Иймд, энэхүү утга зохиол ор тас мартагдсан буюу ардын тантризмын бүдүүн бараг, тачаангуй хэлбэрт шингэсэн нь гайхалтай зүйл бус билээ.

Тантризмын энэхүү уналтын хэлбэрүүдэд түшиглэн, Буддист тантра / эсвэл жинхэнэ Индуист тантра / - гын байр суурийн талаар дүгнэлт хийхээс илүү, алдаатай юм гэж байхгүй. Энэхүү байр суурийг онолын хувьд, харьцуулж үзээд ч, эртний утга зохиолыг судлаад ч, ойлгох боломжгүй бөгөөд гагцхүү Төвд, Монгол хийгээд Сингон, Тэндай гэх мэт Японы зарим нэг тогтсон таалалтай нийцүүлж, тантрыг эдүгээ үе хүртэл залгамжлагдан ирсэн уламжлалт аргуудыг хэрэглэж байж, туршлага / практик / - ын замаар л ойлгож болно. Сүүлчийн хоёр тогтсон тааллыг авч үзээд, Глазенапп тэмдэглэсэн нь: “Мандалд орших эмэгтэй Бодьсадва нар, түүнчлэн Пражня Прамита / бурханы нэр / болон Чунди / гарьд / нь эр, эм аль нь ч биш бөгөөд эртний уламжлалын дагуу тэдгээрээс эр, эм хүйстэний тогтсон таалууд нь бидний мэдэх Бенгали, Балба, Төвд дэхь эр, эм зарчмын туйлын онцлог тогтсон таалуудаас эрс ялгаатай юм. / Н. Glasenapp, 1936 /

Бенгал, Балба, Төвд улсууд энд нэг дор, хамт дурьдагдаж байгаа нь Бенгал, Балбын тантризм нь Төвдийнхтэй гарал нэгтэйг харуулах бөгөөд зохиогч хэдийгээр Шактизм,

Тантризм хоёрыг ялгаатай гэдгийн чухалыг хүлээн зөвшөөрдөг боловч эцсийн дүгнэлт хийсэнгүй. Тухайлбал, билэгдэл нь эр, эмийн туйл дээр тогтож байдаг Буддын тантра нь, билгийн зарчмыг Шакти хэмээн хэзээ ч үзээгүй бөгөөд харин хэзээ ямагт түүний эсрэг зарчим болох Пражня буюу “Юмыг учир шалтгаангүйгээр мэдрэх чадвар”, Видья / мэдлэг / болон Мудра / хоосон чанарыг шалгах, дотоод оюун ухааны байр суурь /-г баримталж ирсэн юм. Үүгээрээ, тэд Шактизмын гол үзэл санаа, ертөнцийг бүтээгч “Эго”, эротизм буюу тачаангуйг няцааж байна. Важраяна тантрад арга, билгийн зарчмын туйл нь математикийн рациональ ба рациональ бус хэмжигдхүүн хийгээд тодорхой илэрхийлэлд нөлөөлдөг нэмэх, хасах тоон тэмдэг мэт, бэлгийн хэвийн харьцааны хүрээнээс хамаагүй хол түвшинд үүссэн байна.

Төвдөд эр, эм Дхьяни бурхад ба Бодьсадвуудын эр, эмийн харьцааг, Японы тогтсон тааллын нэгэн адил, маш хомсхон боловч авч үзсэн байдаг. Тэгтэл нэгдлийн тал / санскрит, юганаддха буюу төвдөөр яб-юм, монголоор, эцэг, эх бурхан / нь Гэгээрлийн явцад дээд оюуны бодит үнэнтэй нягт холбоотой байх ба түүнийг үндэслэлгүй гэж үзээд махбодын эр, эм явдлын хүрээнээс бүрмөсөн хассан байдаг.

Дүрсийн тусламжтайгаар эдгээр билэгдлүүд нь хүмүүний биеийг дүрсэлсэн бус, харин бясалгалын туршлага, үзэгдлийн дүрслэл гэдгийг мартаж үл болно. Энэ тухайд ч гэсэн “эр, эмийн явдал” гэж нэрлэмээр зүйл ер үгүй, гагцхүү оюун ухаан, бие махбодын бүхий л үйл ажиллагааг жолоодогч, эрхэм дээд туйл орших бөгөөд тэр нь, зөвхөн нэгдэл нягтралын дээд шат, хоосон чанарын биелэлээр арчигдаж цэвэршинэ. Ийм төлөв байдлыг Махамудра / төвдөөр, Пхьягр Гья чхенпо / гэж нэрлэнэ. Төвд дэхь гэрээрлийн чухал системийн нэг нь агуу Их тэмдэг буюу Их билэгдлээр нэрлэгджээ.

Энэтхэгийн Буддист тантризмын эртний хувилбарт Махамудраг “Мөнхийн залуу эмэгтэйн зарчим” мэтээр харуулсан байдаг. Түүнийг Адвайяважра - гын тодорхойлолтоос мэдэж болно. Түүнд “Агуу их”, “Мудра” гэдэг үг хавсарч “Махамудра” гэдэг нэр томьёо үүсчээ. Тэр нь ямар нэгэн өчүүхэн зүйл / нихсвабхава / бус, “махамудра” нь ямар нэгэн утга учиргүй зүйл бус юм. Түүнд, аль нэгэн танин мэдэх объектийг хааж халхалсан хальс

бүрхэвч байхгүй. Тэрээр, намрын сарын өдөр дундын цэлмэг тэнгэр лугаа адил гэрэлтүүлэн гийгүүлэх бөгөөд түүний бие Энэрэл нигүүлсэл / каруна / төдийгүй, Агуу их амар жаргалын нэгдэл / махасукха - каруна / юм.” / Адвайяважра, “Чатурмудра”, Н. Guenther, 1952,187- р хуудас /

“Пражнопайявинишчая-сиддхи” судрын хамгийн будлиантай нэгэн хэсэгт Анангаважрад хэлэхдээ, “бүх эмэгтэйчүүд бүгд садхак / дадлага хийгчид / -чуудын цэнгэлийн объект байх ёстой” гэсэн нь, махбодын цэнгэлийг хэлэлгүй, сонгож авсан мэт объектоор хязгаарлагдахгүй өөртөө ч, бусдад ч байдаг, бүх “эмэгтэй” чанарыг олж харах чадвартай дурлалын хамгийн дээд хэлбэрийг хэлсэн нь тодорхой. Өөрөөр хэлбэл, эх бурхан “Пражняпарамита” / Туйлын билгүүн ухаан, тасархай зөн совин буюу “билэг барамид” / хэмээн үзвэл зохино.

Уг судрын өөр нэг хэсэгт, төрсөн эх, эгч, эгчийнхээ охинтой харьцсан садхак нь эрхэм дээд зорилгодоо амархан хүрнэ гэснийг үгчилж ойлгож болохгүй. Тэгээд ч юу санасан есөн хүсэлдээ хүрэх нь хялбархан байдаг. / Анангаважра, Пражнопайявинишчаясиддхи. У, 25: Ийм зүйл “Гухьясамажа - тантра”- д ч бий. Түүнээс Анангаважра энэ ишлэлийг онцолжээ. /

“Эх”, “эгч” эсвэл “эгчийн охин” гэдэг илэрхийллийг энд үсэгчлэн ойлгохтой агаар нэгэн, утгагүй зүйл бас байх ажээ. Тэрхүү шүлэгт, багш бярман нь эцэг, эхээ ба кшатри, кастын хоёр хааныг алж, хаант улсыг бүх хүнтэй нь сүйтгээд нүглээс ангижирсан тухай өгүүлдэг. Гэтэл энд эцэг, эх гэдэг нь аминч үзэл буюу “би” - г баримтлах үзэл ба шунал, тачаал хоёрыг / палигаар, асмимана ба танха / , хоёр хаан гэдэг нь бүрэн устахуй, мөнх оршихуй хоёр / учхеда ва сассата диттхи / - ыг, хаант улсыг бүх иргэдийнх нь хамт гэдэг нь ухамсарын арван хоёр шижим / двадасайтанани / - ийг буюу “брахман” гэдэг нь чөлөөлөгдсөн бхикшу / багш / - гийн тухай тус тус өгүүлжээ.

Эдгээр томъёолууд нь Бадмасамбхавагын бүтээлд ч давтагдсан байдаг. Тэрбээр, агуу том эрдэмтэн бандида байсан бөгөөд МЭ-ний VIII зууны дунд үед Төвдөд Бурхан шашныг дэлгэрүүлж, анхны хийдийг байгуулсан ариун үйлстэн билээ. Бадмасамбхава нь

догшин бурханд хувилж ирээд, хаант улсыг эвдэж, Дхармын дайсан болсон бүх хүмүүсийг нь алаад, бүх эмэгтэйчүүдийг нь үлдээж, тэдний нүглийг ариусгаад, Бурханы шавь нарын ээж болгохыг зорьсон хэмээн, хожим мэдэх болсон Сандхьябхашын бичсэн намтарт ёгт хэллэгээр өгүүлжээ. Энд Бадмасамбхава нь нэг улсын бүх хүн амыг хүйс тэмтрээд, эр, эмийн харьцааны хэм хэмжээг зөрчжээ хэмээн ойлгож болохгүй нь мэдээж байна. Энэ нь түүний бүтээлүүдэд харш зүйл болох байсан ба эдгээр бүтээлүүдэд

ёс суртахуун, ёс зүйн хэвшмэл зүйлүүдтэй мэдрэмжийн нягт нямбай шалгуур дээр үндэслэсэн, оюун ухааны гүн гүнзгий ойлгож ухаарсан зүйлүүдтэй юм. Энэ бол эртний бусад олон зохиолынхтой адил, Сандхьябхашын тодорхойлолтуудын нэг бөгөөд гадаад үйл хэргийн хэлбэр дэхь бясалгалын туршлага / Мара болон түүний шулмын дайчидтай, Бурхан багшийн хийдэг тэмцэлтэй адил / мөн. Бадмасамбхава нь догшин бурханы дүрийг олсныг өгүүлсэнээрээ, муу муухай юмсын хүчтэй түүний хийх тэмцэл нь, түүнд өөрт нь явагдаж байсныг харуулж буй хэрэг бөгөөд дотоод харшилын явцад, билгийн талын зарчмуудыг таньж мэдэх нь түүний биетийн хоёр тал нэмэгдэж буй байдалд байгаа юм гэдгийг харуулж байна. Үүнд, идэвхтэй хөдөлгөөнт / упайя / чанарын “аргын”, “билгийн” / пражня / гэсэн хоёр зарчим байдаг. Үүнийг бид дараачийн бүлэгт үзэх болно.

Тантрын Буддизмыг залгамжлагчид цус холидох, ёс бус үйлдэл хийх болсон гэдэг нотолгоо бол, эцэг эхийгээ алах болон бусад аймшигт хэрэг үйлдсэн хэмээн тхеравадинуудыг буруутгасантай адил мулгуу зүйл билээ. Хэрэв бид мэдрэмжийн хяналт, ариун ёс зүйг дээд зэргээр баримталдаг Төвдийн олон мянган сүм хийд, даяанчдын тосгон сууринд одоо хүртэл хадгалагдаж байдаг шиг, тантрын амьд уламжлалыг хуурмаг биш, жинхэнэ бодит хэлбэрээр нь судлах ажлыг өөртөө хүлээх юм бол, тантрыг мэдрэхүйн хүрээнд оруулахыг оролдогч хэн бүхэн, хичнээн айхавтар эндүүрч байсныг ойлгох болно.

Төвдийн тантрын уламжлалын үүднээс бол дээр дурьдсан жишээнүүд нь зөвхөн йогийн нэр томъёогоор л тайлбарлагдана. “Бүх эмэгтэйчүүд” гэдэг нь бидний сэтгэхүй, махбодын “билгийн” зарчмыг бүрдүүлж буй бүх элементийг хэлж байна. Нөгөө талаас, эдгээр зарчимтай “аргын” зарчмууд тоогоор тэнцүү байна. Арга, билгийн дөрвөн зарчим

нь шороо, гал, ус, хий гэсэн дөрвөн их язгуур махбодын амьдралын хүчнүүдийг төсөөлсөн, онцгой бүлгүүдийг үүсгэнэ. Хүний биеийн доторхи ухамсарын төвшин бүрт эр, эм зарчмуудын нэгдэл буй болж, ингэснээрээ тав дахь дээд түвшинд хүрнэ. Иймээс бидний биеийн гадна оршиж буй “эмэгтэйг” олж харсанаас, өөрийн дотор байгаа “эмэгтэйг” олж хайх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, / өөрийнхөө гэр бүл дотор / бясалгалын явцад эр, эм шинж чанарыг давхцуулах аргаар эрж хайх ёстой. Энэ нь, Наропын алдарт “Зургаан сургаал”-д тодорхой батлагддаг бөгөөд тэрхүү сургаалд, бясалгалын суут мэргэдийн дотор алдаршсан, ариун даяанч Миларайбын хэрэглэсэн, нилээд чухал арга үндэслэгддэг юм. / “эр, эмийн харьцааны” талаар Миларайбаг буруушаах нь утгагүй юм. / Хэдийгээр бид энд, энэхүү йогийн практик үйл ажиллагааг нарийн мэдэх ёсгүй ч, дараах ишлэл үг бидний үзэл баримтлалыг нотолж чадна. Үүнд, Таван цогц / скандха, төвдөөр: пхунг-по / - ын амьдралыг тэтгэгч хүч нь, Бурханы эрэгтэй талд хамаарах бодит шинж байдлаараа зүүн талын сэтгэцийн суваг /лалана-нади /-аар дамжин илэрдэг. Таван махбодын / дхату, төвдөөр: бхунг - ва / амьдралыг тэтгэгч хүч нь Буддын зарчмын эмэгтэй талд / билгийн талд / хамаарах бодит шинж байдлаараа баруун сэтгэцийн суваг / расана нади, төвдөөр: ро ма ца / - аар дамжин илэрдэг. Амьдралыг тэтгэгч хүч нь энэхүү хоёр талын нэгдэлд байхдаа дунд суваг / авандуди, төвдөөр: Бу-ма ца /-т бууж ирэх үед, аажмаар Биелэл эхлэх бөгөөд Агуу их тэмдэгийн / Махамудра / гаднах жаргал цэнгэл, эрэгтэй эмэгтэй зарчмуудын холбоо нь Бурханы онцгой чанарын дээд байдалд хүрнэ.” / W. V. Evans - Wentz, 1935, хуудас – 200 /

Иймэрхүү байдлаар, эр, эмийн явдлын талаархи туйлшрал нь олон үйлт туйлшралын зөвхөн ганц нэгхэн тохиолдол болох ба олон талт туйлшрал нь бүх түвшиндөө тогтоогдсон байх ёстой. Мэдлэгийн тусламжтайгаар, түүнийгээ давж чадсан байх ёстой. Үүнд, билгийг таньж мэдэхээс эхлээд Махамутра буюу Хоосон чанар болох “Мөнхийн билгийн шинжийн” мэдлэг хүртэлх, Билэг билгүүнд орохыг хэлнэ.

Орчлон ертөнцийн хэтийн төлөвт, бид бие болон оюун санааны төрөл холбоог буюу бие бялдарын болоод оюун санааны харилцан үйлдлийг олж мэдээд, энэ замдаа “би”,

“миний” гэсэн явцуу үзлийг, биднийг тус тусдаа байгаа “бие хүн” гэсэн хуурмаг бодлыг төрүүлдэг, тэрхүү хувиа бодсон мэдрэмж, бодол санаа, төсөөллийн бүх бүтцийг ялан давж чадсан тэр л цагт, бид Бурханы онцгой чанарын хүрээнд орж чадах юм.

Тантрууд бол, шашны мэдлэг туршлагын атгаг бодлыг, хийсвэр хүрээнээс доош нь буулгаж, мах цусанд нь шингэтэл боловсруулна. Гэхдээ, түүнийг өөрчилж солих бус, харин шашны бодол сэтгэмжийг идэвхтэй хүч болгож байгаа хэрэг юм. Мэдлэг нь дутуу ухаарсан хүсэл эрмэлзэл, дур сонирхлын хүчнээс илүү, дотоод мэдрэмжинд суурилдаг бөгөөд “пражня” нь “шакти”- гаас илүү хүчтэй, тэгээд ч шакти нь матери ба ялгарал бий болох нягт ертөнцөд улам гүн ордог тийм ертөнцийг тэтгэгч сохор хүч / майя / мөн гэдгийг, Тантрыг номлогчид мэдэж байсан юм. Түүний нөлөө нь, зөвхөн туйлшруулагдсан буюу сөрөгцүүлэн өөрчилсөн байж болох юм. Өөрөөр хэлбэл, үүсэн буй болох хүчийг Авралын хүчин болгон хувиргадаг, дотоод мэдрэмжийг сэргүүлэн тавьсан байна.

5. Дотоод мэдрэмж – бүтээлч бодит зүйл болох нь

Авралын хүч рүү тэмүүлж буй, ертөнцийг бүтээгч энэхүү харанхуй хүсэл тэмүүллийн бүрэн өөрчлөлт нь, дотоод мэдрэмжийн төгс төгөлдөрөөс буюу дотоод мэдлэгийн өргөн цар хүрээнээс шалтгаална. Ертөнц болон түүнийг бүрдүүлэгч хүчийг ухаж ойлгосноор, бид түүний эзэн болдог. Энэ хүч нь идэвхи хөдөлгөөнгүй бөгөөд бидэнд түүнийг судалж мэдэх арга боломж байхгүй үед, бид тэр хүчийг мэдэрч чадахгүй юм. Иймээс тэрхүү хүчийг хөдөлгөөнд оруулж, дүрс хэлбэртэй, үзэгдэж мэдрэгдэхээр болгох хэрэгтэй. Энэ зорилгод нийцсэн билэгдлүүд бол, химийн урвалыг түргэвчилсэн, эсвэл удаашруулах үйлдэлтэй катализатор адил үйлчлэлтэй бөгөөд түүний тусламжтайгаар / катализаторын / шингэн биет гэнэт талстжин хатуу биет болон хувираад, ингэснээрээ өөрийнхөө үнэн дүр төрх, байдал бүтцийг харуулна.

Бясалгалын бүтээлч үеийг буй болгогч, оюун санааны талстжих үйл явц нь бүтээлч юм уу, эсвэл дэвжих үйл явц, / санскрит: утпанна - крама, төвдөөр: жидрэм, монголоор: үүсгэлийн зэрэг / буюу үгчилбэл, үүсч буй эхлэх үе шат юм. Гэвч, хатуу байдалд орж,

нүдэнд үзэгдэхүйц болох хэдий ч, ухамсарт төсөөллийн хэлбэрүүд нь, энэхүү үйл явцын нөлөөгөөр талстжсан хэлбэрээс эргээд шингэн байдалд орж, амьдрал ухамсарын хэвийн урсгалд ордог гэсэн арга ухаан байдаггүйсэн бол, оюун санааны хувьд чулуужсан, үхмэл гэсэн бодол төрүүлэх байсан юм.

Энэхүү аргыг шингэрүүлэх үйл явц буюу Дуусах үе шат / санскрит: сампана крама, төвд: Зогрим, монголоор: Төгсгөлийн зэрэг / гэж нэрлэдэг. Тус арга нь “би” - гэсэн ангижирсанаар, мөн чанар / субстанц / бусаар, шүтэн барилдлагаар, хоосон чанар болон бүх хэлбэрийн харьцангуй зэрэглэлээр, буюу тогтмол харьцангуй чанараар тодорхойлогддог юм. Энэ бол Төвдийн уламжлалт бясалгалын дасгалуудад бүгдэд нь алган дээр буй мэт байдаг. Тийм ч учраас үл ойлгогдох ямар ч зай завсар буй болдоггүй бөгөөд хувийн туршлагад болон ололт амжилтанд шүтэлцээ холбоо байдаггүй / энэ нь бурханы шашны бус, нууц сургаал баримтлагчдыг отоож байдаг аюул / юм.

Тулгарсан зүйл гэдэг нь бидний “бодит зүйл” хэмээн нэрлэдэг бүхэн ой ухаанд / “мано пуббангама дхама” гэж / эхэлдэг, бидний хувийн үйл ажиллагааны үр дүн мөн гэдгийг ухааж ойлгосон, хэн боловч өөрөө өөртөө оршин тогтнодог буюу “тухайн бодит зүйл” болох ертөнцийн материалист үзэл баримтлалаас бүрэн салангид байдаг ажээ. Энэ нь гүн ухааны юм уу, учир шалтгааны ухааны нотолгооноос арай илүү үнэмшилтэй юм. Энэ бол дадлага туршлага мөн бөгөөд хамгийн хүчтэй оюун ухааны үнэмшлээс ч илүүтэй, хязгааргүй гүн гүнзгий үйл ажиллагаа мөн билээ. Тэгээд ч нүдэнд үзэгдэж буй юмсыг, ой ухаандаа бас үзэгдэж харагддаг зүйл болгон хувиргадаг үйл ажиллагаа мөн бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь гадны юмсыг шууд мэдрэх үйл ажиллагаанаас эрс сөргүү үйлдлийг гаргадаг байна. Оюун ухаанаараа мэдрэх энэхүү явдал нь, тухайн юмс үзэгдлийг бодит байдлаар нь мэдрэх үйлдлээс ялган салгадаг бөгөөд ялгаат салгалтыг өөрөө ухааж ойлгож чадахуйц болгодог юм.” / Ludwig Klages /

“Хүний ухамсарыг материаллаг байдлаар нүдэнд үзэгдэх мантрын шинж чанараар нь дамжуулан явуулдаг хувиргах үйл ажиллагаа нь шүтэх / пужа / үед хэрэгждэг. Дүр болон бурхан бус, бурханлаг мөн чанар нь түүнийг ид шидээр дуудсаны дараа, зан үйлээр үйлдэх

үеэр гаднаас, хаа нэгтэйгээс дүрийн гол цөмд ордоггүй юм. Энэ нь бидний сэтгэл бодолд, дүрс хэлбэртэй бууж байгаа бурханы мөн чанарыг сэтгэлдээ бодох сүсэглэл бөгөөд уг сүсэглэл нь, тухайн сүсэгтэн хүнд буй болдог. Энэ бүхэн бол үг хэлээр дамжиж илэрдэггүй, тэгээд ч дотоод сэтгэлийн боловсролт гэдэг бол дур хүслээс тусдаа ангид байдаг юм. Жирийн хүний нүдэнд үзэгдэж харагдахгүй байдаг бурханы мөн чанар бол, дотоод сэтгэлийн хүрээ хязгаарт байдаг, хүний хир хэмжээнээс хэтэрсэн тус бодит байдал нь хүний ухамсарт тусаж байдаг юм.” / Н. Zimmer, 29 - р хуудас /

Юмс үйл хөдлөлд байдаг тул, оршин тогтнож байгаа билээ. Бодит байдал гэдэг бол их чухал юм. Оюун ухааны идэвхтэй дүрс буюу билэгдэл нь бодит зүйл бөгөөд энэ утгаараа бясалгаад буй Дхьяни бурхад бол бодитой оршин байгаа / тэднийг буй болгогч, оюун ухаан бодитой байдгын нэгэн адил / бөгөөд бид ой ухаандаа боловсруулж бүтээж байдаг, түүхэн онцгой шинж чанартай бурхад бол энэхүү утгаараа бодитой биш юм. Үйл хөдлөл нь сайндаа л засал чимэглэлийн хийц буюу үзэл бодол, эсвэл өнгөрсөн үед хамаатай үйл явдлыг дурсан санаж байгаа явдал юм.

Иймээс Төвдийн уламжлал дахь бүхий л чухал бясалгалууд бол, бурхадыг ой ухаандаа төсөөлөн бодогч сүсэгтэний даяанч үйлийн билэгдэл юм. Сүсэглэн үйлдэгч нь өөрийнхөө зорилгыг адилтгаснаар, бясалгалын оюун мэдлэг, арга барилынхаа олон тооны хэлбэрүүдийг орхидог. Харваач хүн байг онохдоо, мэргэн онохыг хичээж сайн гэгч онилдогын нэгэн адил, сүсэглэгч хүн эхлээд зорилгоо төсөөлөн бодож өөрийгөө тэрхүү төсөөлөлтэй бүрэн адилтгаж үзэх ёстой. Энэ нь түүний дотоод хүсэл эрмэлзлэлээ чиглүүлж, дэм өгөхөд тустай. Сүсэглэгч ямар ч арга ухаан сийлсэн ямагт зорилгоо бүтээхийн төлөө хийсвэр задлан шинжлэх явцдаа ч, өөрийн бодол эргэцүүлэлд ч үл автана, эцсийн аюулаас ч зайлж болно. Учир нь төрж буй болох, үйл явцын хөрвөх арга гэж байдаг. Дүрсийг дотоод сэтгэлдээ үзэж, дахиад түүний хуучин байдалд нь оруулах явдал бол, бүх онцгой зүйлийн үнэн шинж чанар нь мэдэрч болох чадвараас салангид байдаг гэдэг оюуны нотолгоотой харьцуулахад шилдэг нотолгоо юм.

Гэвч, бид энэ төвшинд хүрэхээсээ өмнө, дотоод сэтгэлдээ үзэгдэх дүрсийг буй болгох, бүтээлч үйл ажиллагааг гаргах ёстой. Энэ үе шат нь мандал / төвдөөр: жилхор / хэмээх доод сууриндаа, лянхуа цэцгийн дөрвөн дэлбээ агуулсан байдаг. Энэхүү бүтээлч үе шат нь төгс боловсорч ил гарсан оюун ухаан буюу Бурханы эрхэм дээд чанар бөгөөд түүнд төгс гэгээрсэний / Бурханы / шинж чанарууд нь, сүжиглэж буй хүний хүслийг илэрхийлэн, нүдэнд үзэгдэх байдалд тавигдсан байдаг юм.

Нарны гэрлийн шинж чанар буюу нарны бүх шинж байдлыг ойлгож мэдье гэвэл, түүний туяаг гэрлийн хугаралд оруулж задлах хэрэгтэй. Үүний нэгэн адил, Төгс гэгээрсэний шинж байдал буюу Бурханын ухамсарыг ойлгох гэвэл, өөрийн дотоод сэтгэлээ ийм байдалд чиглүүлэх хэрэгтэй. Учир нь төгс гэгээрч чадаагүй сүсэгтэн, оюун ухаанаа энэ зүгт бүрэн төвлөрүүлж үл чадна. Зөвхөн зарим нэг хэсгээ л төвлөрүүлж чадах юм. Эдгээр хэсэг нь төсөөлөгдөж буй төвшин, олон талт харьцаанд үйлчлэх хүрээ хязгаар, оюун ухааны холбоо харьцааныхаа ачаар, илүү өргөн, гүн гүнзгий ойлголтонд хүргэдэг.

Оюун ухааны шинж чанар, ахуйн бүрдэл хэсгүүд болон тэдгээрийн билэгдэл тусгалууд, дүрсүүд, дохио зангаанууд, өнгөнүүд тодорхой асана -нууд / йогийн завилгаа / гэх зэргийн хоорондын дотоод холбоог тогтоох нь, дүрслэн бодох бүтэшгүй тоглоом юм уу, чөлөөт үл биелэх зүйл бус, харин тоо томшгүй, олон үеийнхний шашны үйл ажиллагаагаар эмхэтгэгдэж баталсан, үзэгдэж харагдах дүр, илрэх төсөөлөл юм. Тэр нь бодит байдлын хуурмаг буюу олон хэлбэрт ухамсар бөгөөд тэгээд ч иймэрхүү туршлага мэдлэг нь идэвхт байдлын материалаг биелэг, сэтгэлзүйн болон хийн түвшин дэхь оюуны бүх хүчний баримжааг тодорхойлон харуулж байгаа юм.

Ийм харьцангуй тэнцвэр нь уялдаатай бөгөөд гагцхүү төрөлжилт буюу хүчнүүдийн хоорондох холбоог сөрөн, бүдүүлэг, хувиа хичээсэн мунхаглал байхгүй үед тэрхүү тэнцвэрт уялдаа байх болно. Ийм учраас энэхүү анхдагч зарчим / төв / - д эдгээр хүчнүүдийг нийлүүлэх болон тэдгээрийн хоорондын тэнцвэрийг хадгалах ёстойг бүрэн ойлгож, зориго бүхий үйл ажиллагаа явуулах шаардлагатай юм.

Хүний ухамсарын зэмсэг гэдэг бол, ямагт хөг аялгууг нь тохируулж байдаг хөгжмийн зэмсэгтэй адил бөгөөд ингэж хөг аялгууг нь тохируулах нь даруулын цохилт буюу сүсэглэж байгаа зүйлдээ өндөр мэдрэмжтэй байхыг шаарддаг, гүйцэд бүрэн мэдрэмжтэй байх мэдлэг ухаанаас шалтгаална.

Энэхүү мэдлэг ухааны таньж мэдсэн зүйлийн янз бүрийн түвшинд дамжуулж өгнө гэдэг нь, дотроо болгоон сэтгэх тантрын бүх аргуудын гол зорилго юм. Эдгээр янз бүрийн түвшин бодитойгоор оршин тогтнох, харилцан шилжих, энэ үүргүүд нь цаг хугацааны хувьд зэрэгцэн байхыг оюун ухааны үүднээс янз бүрийн хэмжилт, цаг хугацааны дараалалд оруулж ялгадаг бөгөөд цаг хугацаа нь танин мэдэх үйл явцад илэрч болох ба мөн хэсэг хэсгээрээ болон тус тусдаа үе шатаараа илэрч болно.

Гүн ухааны болон оюун санааны үр дагавар нь уг асуудлыг янз бүрийн талаас нь, янз бүрийн үзэл бодлын үүднээс, ойлгосоны дараа “төвлөрөлт” хэмээх аргаар асуудалд хандах, хувийн үзэл бодол, хувийн шийдлээс үүдэлтэй тэнцвэрт бус байдал нь, дотоод ерөнхий сэтгэц бодол буюу бүх талуудыг нэгтгэн үздэг дээд хэмжүүрээр холбогддог нэгэн бүхэл бүтэн юмны төсөөлөл буй болсоноор, алдаа мадаг нь залруулагдана. Тиймээс энэхүү зарчмыг хөдөлгөөнгүй нягталваас, бидний оршин тогтнож байгаа тухай асуудал нь бүрэн сэрж мэдрэх явдалд л байхаас биш, ертөнц болон түүний тухай асуудлын гагцхүү тусгаарлан салж, хөндийрөхөд буюу үгүйсгэх үзэл, оюун санааны зогсонги байдал, үхэлд хүргэдэг байр суурийг баримтлахад байдаг бус болой.

Иймээс үгээр болон ухуулан таниулж ойлгуулах, сэтгэж бодуулах гэдэг бол учир дутагдалтай юм. Ярьж тайлбарлана, ухаж ойлгуулна гэдэг нь нилээд ул суурьтайгаар, мэдлэг ухааныг эзэмшүүлэхээс ч дутмаг зүйл болно. Угтаа энэ нь онолын хувьд нийцэл гэдгийг ойлгож мэддэг ч түүнээсээ таашаал буюу хөгжмийн бүтээлийн аялгууны нийцэд таашаалыг хүртэж чадахгүй гэсэн үг билээ.

Таван скандха / рупа, ведана, санжня, санскара, вижняна /, гүн ухаарлын ухамсарын таван шинж болон тэдгээрийн холбогдох Билгүүн ухаанд төрлөө олно гэдэг бол, үр

хэлбэрээрээ байгаа цэцэгтэй адил, боловсролтын түвшинд байгаа, ахин дэвших шинж чанар хэмээх суурь зарчмыг нээж өгч буй хэрэг юм.

Иймээс сайхан болон ариун бус, мэдрэмжийн болон соён гэгээрэлт, сансар болон нирваан зэрэг нь туйлын эсрэг тэсрэг зүйлүүд биш, харин нэг л бодит юмны ар, өвөр талууд юм.

б. Дхьяни таван бурхад болон таван билгүүн

Ийнхүү ертөнцөөс бүхэлдээ тасардаггүй, ертөнцийг хамарч нийлж болохооргүй эсрэг тэсрэг зүйл хэмээн үздэггүй, харин мэдрэмжээр ухаж ойлгох ердийн цаг хугацааны ертөнцөөс, цаг хугацааны гаднах Мэдлэг ухааны ертөнцөд хүртэлх гүүр болдог бөгөөд энэ нь эл ертөнцийн гадагш чиглэсэн зам юм. Уг зам нь үзэн ядах болон үгүйсгэх байдлаар бус, харин бидний жинхэнэ оршин тогтнох нөхцөл, чанарыг цэвэршүүлэн ариусгах байдлаар хүргэх зам юм.

Таван цогцын нэгдэл / скандха / ба ганцаарчилсан оршин тогтнох хэсгүүдийн үүднээс үзвэл, энэ нь бидний дээр дурдсанчлан, Гэгээрэлд хүрэх замд мэдрэмжийн язгуур / рупа /, сэтгэл хөдлөлийн язгуур / ведана /, мэдрэхүйн язгуур / самскара / - ын хөдөлгөгч махбодууд, мөн ухамсар / вижняна / бол гэгээрүүлэгч ухамсар болох Бодь сэтгэлийн / бодхичитта / холбогдох шинжүүд болж хувирдаг.

Олон талт хууль / дхарма / -ийг таньж хэрэгжүүлэх замаар, хувийн ухамсарын явцуу хязгаарлагдмал би / эго / нь Вайрочана “Маш гийгүүлэн зохиогч” / төвдөөр: Намбар нанзад / -ийг дүрсээр харуулан, сансрын ухамсарын байдалд ургаж орно. Ингэхдээ, хувь хүний биеийн язгуур махбодууд нь бүх юмсын хэлбэрийг өөртөө агуулсан олон талт бие болон хувирч, тэдгээр юмс нь аугаа их хоосон чанарын үзэгдлүүдийн хэлбэрээр байх ба түүний өөрсдийнх нь мөн чанараар Толь мэт мэргэн чанарын ухамсараар танигддаг. Энэхүү Толь мэт билэг билгүүн нь бүх юмсын хэлбэр дүрсийг тэдгээрт хүрэлгүй, тэдэнд хүртээлгүйгээр, тэднээс хөдөлгөн авахгүйгээр тусгаж байдаг.

Энэ талын хэсэг нь “Үл хөдлөгч” - Акшобхья / төвдөөр: Мижидба / -ийн дүрээр харуулсан байдаг. Нугаршгүй бат бэх шинж чанарынх нь тэмдэг болгож, баруун мутрынх

нь долоовор хурууг газарт / бхумиспарша мутра / хүргэсэн байдаг билээ. Тэгээд ч газар бол хувирашгүй, хатуу, тодорхой бүрдлийн билэгдэл юм. Тэр нь Акшобхьягын пражня болон Их толь мэт билгүүнтэй нэгдмэл юм. Акшобхьягын билгүүн нь түүний тэвэрсэн Лочана / үзэгч / хэмээх “Бурханы мэлмий” юм. Тэр эх нь юмс “оршихуй”, “эс оршихуй” гэсэн үзэлд байдаг агуу их Хоосон чанарын хэрэгжилт болно. Хэдийгээр толины гадна юм уу, дотор талын алинд нь байдгыг хэлэх боломжгүй боловч, тэрхүү хоосон чанарт юмс буй болж байдаг ажээ.

Иймэрхүү байдлаар өөр рүүгээ чиглэсэн бодол мэдрэмж нь бусдын мэдрэмж, амьд бүхний зовлон болон хувирна. Тэгэхдээ энэ нь үнэт эрдэнэсийн эх булаг болсон Ратнасамбхава / төвдөөр: Ринжүн, монголоор: Эрдэнийн орон / Дхьяны бурханы дүр шингэсэн, агуулгын төгс мэргэн чанараар дамждаг байна. Тухайлбал, ертөнцөд гурван эрдэнэс / Триратна буюу Гурван эрдэнэ / буй болох эх булаг буюу Бурхан, ном, хуврага гурав байдаг. Ратнасамбхава тэрчлэн, баруун мутраар газарт шүргэсэн байдаг юм. Гэвч тэрээр мутраа гадагш харуулж байх лугаа адил, өглөгийн мутраа сунгажээ. Тэрээр ертөнцөд гурван эрдэнийг түгээж байгаа бөгөөд тэрхүү гурван эрдэнэд Хоосон чанар буюу Акшобхьягын билгүүн болон “би” нь байхгүй байгаа нь амьд бүхэнтэй адилтгах үндэс болдог. Иймээс тэрээр өөрийн пражня / төвдөөр: юм / -тай салшгүй тэврэлдсэн байдаг байна. “Пражня” нь түүнийг тэвэрсэн эх бурхан Мамакийн хэлбэрээр байгаа “Тэгш мэргэн чанар” болно. Түүний нэр бол бүх амьд юмсыг өөрийнхөө үр хүүхэд буюу өөрөөр хэлбэл, өөртэй нь мөн чанарын хувьд ижил хэмээн үздэгийг илтгэн зааж байгаа юм.

Дотоод нэгдлийн билгүүн ухаанаас төрсөн ижил төсөөтэй гэсэн энэхүү бодол бол “Вижняпти матра сиддхи шаштра” сударт гардгаар онцгой үндэс / ашрая / юм. Зөвхөн энэ үндсэн дээр их нэгдлийг бүрэн ухаарсанаар юмсын ерөнхий холбоо шүтэлцээг умарталгүй, тус биеийн үнэн чухаг мэдлэг эзэмшихэд өөрийгөө зориулж болно.

Эндээс мэдрэмжээр ойлгох ба оюуны ялгаа хоёр нь бясалгалын практик дахь дотоод ухаарал, оюуны ялгаралын гаднах чадвар болон хувирч байгаа гэсэн дүгнэлт хийж болно.

Бясалгал нь Дхьяны бурхан Амитабха / төвдөөр: Одбагмид, монголоор: Цаглашгүй гэрэлт / - гын үүрэг юм. Тэрээр ялган салгаж, тод ухаарах Билгүүн, түүнийг тэвэрсээр “празня” –

тайгаа Пандарашни хэмээх эх бурхан “Цагаан орхимж” хэлбэрээр нэгдлийг харуулсан байдаг.

“Жнянь сиддхи” сударт Индрабхути өгүүлэхдээ энэхүү Билгүүнийг “прагъявекшана - жняна” гэж нэрлэдэг. Тэгээд ч тэр нь анхнаасаа цэвэр ариун, бүтээгдэж бий болоогүй, өөрөө гэрэлтдэг, юм бүхэнд нэвтэрдэг ажээ.

Бид энэ оюуны чадварын тухай биш, харин цэвэр зөн билгийн тод танин мэдэхүйн тухай, зөрчишгүй логик ба оюун ухааны тодорхойлолтуудын тухай ярьж байна гэдгийг дээрх тодорхойлолт харуулж байна. Пали хэл дээрх сударт, “паччавекхананяна” хэллэгийг мөн адил “өнгөрсөн цаг үе рүү хандсан мэдлэг” мэтээр бясалгалын тухай ойлголтыг холбож үзсэн байдаг. “Өнгөрсөн цаг үе рүү хандсан мэдлэг”-т оюун санааны дүрсүүд, сэтгэгдэл болон бодлын ой тогтоолтыг дурдсан байдаг.

Иймээс хэрэв бид Амитабхагын Билгүүнийг задлан шинжлэх гэж нэрлээд түүний толь мэт билгүүны “эргэцүүлэл / тусгал / талд болон тэгш Адилтгалын билгүүнийг “адил агуулагч” / нэгтгэн дүгнэх / талд сэргүүлэн тавьж үзэх юм бол, энд гол төлөв “прагъявекшана” гэсэн ухагдхууны орчуулга болох “задлан шинжлэх”, “ялган салгах”, “шинжлэн судлах” гэсэн нэр томъёонууд нь гүн ухааны буюу шинжлэх ухааны задлан судалгааны замаар хийгдэж, онцгой ертөнцийн тухай логик утга учиргүй зүйлд хүргэсэн ойлголт юм. Иймэрхүү арга нь үл бүтэх зүйл гэдгийг Бурхан багш ч өөрөө ойлгож байсан ажээ. Үүнээс болж Бурхан багш нь өөрийнхөө үеийн ид шидтэнгүүд болон гүн ухаантнуудын метафизик ашиг хонжоог эсэргүүцэж байжээ. Энэ бол Бурханы шашин гэдэг нь аливаа метафизик үндэслэлгүй цэвэр оюун ухааны номлол мөн юм гэсэн дүгнэлтэнд / одоогын эрин зууны / зарим Энэтхэг судлаачдыг хүргэсэн баримт байна. Хэрэв эртний Энэтхэгийн схоластик ном зохиолтой танилцах юм бол баталгаа нотолгоо гэдэг нь худал зүйл болох / Уг сургаал нь метафизикээс ангид юм шиг /, энэ асуудлууд

метафизикийн холбогдолтой гэж үзсэн тул, Буддизм үүнийг үгүйсгээгүй юм. Харин метафизикийн үзлийн үүднээс Бурхан багш өөрөө хариулт өгөх боломжгүй учраас ийм ажээ. / О. Розенберг, 58 - р хуудас /

Розенберг тайлбарлахдаа, европын ном зохиол туурвигчид эрт үеийн буддизмд метафизик чиглэл байсан хэмээн шамдуухан хэлэлцэж байжээ. Тэд нэг талаас Христос шашныг өөр шашны сүсэгтнүүдэд дэлгэрүүлэх талаар ажилаж байсан болохоор, өөрсдийн ном зохиолд санамсаргүй болон санаатайгаар Буддизмд метафизикийн чиглэл байхгүй гэж онцлон тэмдэглээд, үүгээрээ Буддизмыг боловсронгуй бус шашны систем гэж сүсэгтнүүдэд ойлгуулахыг хичээж байв. Нөгөө талаар ертөнц дахины тухай орчин үеийн шинжлэх ухааны үзэл бодолд метафизикийн чиглэл байхгүй гэснээрээ сайн талтай хэрэг болсон билээ. “Европд Буддизмыг судалж эхэлсэн цаг үе бол метафизикийн гүн ухааны уналт болон материалист систем үүсч байсан цаг үетэй давхцаж байсан юм гэдгийг мартаж болохгүй” / Мөн дээрх номонд /

Үнэн чанартаа, Бурхан бол логик сэтгэлгээг амжилттай хэрэглэж байсан болохоор, энэ сэтгэлгээний дайсан биш байсан юм. Гэвч, Буддизм нь, уг сэтгэлгээний хязгаарлагдмал байдлыг ойлгож байсан учраас, уг сэтгэлгээний хүрээнээс халих нь чухал гэдгийг онцлон тэмдэглээд шууд, дам бусаар танин мэдэх, аливаа үр өгөөжтэй зүйл / витерка вичара / - ийг давж чаддаг оюун ухааныг бясалгах танилтыг / дхьяна / онцолж байсан юм. Энэ нь Амитабха болон түүний пражнягын дүрсийг мэдрэмжээрээ нарийн ойлгох, цэвэр сайхан гадна байдлыг ойлгохоор илэрхийлсэнд оршино.

Ийм дотоод бодлын үндсэн дээр, үйлийн үрээр нөхцөлдсөн идэвхжил болон хувирдаг. Энэ ариун эрхэм нь хүсэл тэмүүлээр жолооддоггүй бурхан, бодьсадва биш, ертөнцийн зовлон гуниг юм. Ийм хандлага нь “зорилтыг хэрэгжүүлэгч” Амогхасиддхи / төвдөөр: Дондов, монголоор: Үйл бүтээгч / -ийн дүрд шингэсэн болно. Түүний “пражня” нь “Аврагч” Дарь эх / төвдөөр: Дулмаа, монголоор: Ногоон дарь эх / бүгдийг үйлдэгч мэргэн бурхан юм. “Аврагч” -тай тэрээр салшгүй холбоотой бөгөөд тэгэхдээ, тэрээр

өөрөө аймшиггүй зоригт цэцэн мэргэний / абхайя мутра / амьд бүхэнд сайн сайхныг хүсэн ерөөгч болно.

Бурхан гэдэг үгийг хэрэглэхдээ, бид “Бурханы сүсэг бишрэл” гэдэг утгаар биш, ердийн ухан ойлголтын гадна байгаа “эрхэм дээд зүйлтэй адилтгах” утгаар нь ойлгох хэрэгтэй. Энэ нь ердийн танин мэдэхүйгээс хол давж гарсан, эрхэм дээд оюун ухааны танин мэдэхүйд хамаарах юм. Ингэж ойлгосноор бид “юм” буюу “ юм чог” хэмээх Дхьяны бурханы эмэгтэй тал гэсэн төвд үгийг “Эх бурхан “ гэж ойлгоно. Үүний нэгэн адилаар ерөнхийдөө “Дева” / эрхэм дээдийн оршин тогтногч / гэдэгтэй утга нийцэх “Лха” гэдэг төвд үг нь “Бурхан” / дээд төрөлт христиан зэрэглэлийнхэнтэй харьцуулж үзэх / гэдэгтэй дүйцэж байгаа бөгөөд Дхьяни бурхан болон Бодьсадваг тодорхойлоход ч хэрэглэдэг. Иймээс “Лха” гэсэн үгийг “Бурхан” хэмээдэг барууныхны үзэл бодолтой тааруулах нь янз бүрийн бурхадыг “Бурхан” гэж нэрлэхээс төстэй юм болохгүй. Ингэх нь бүтэлгүй юм гэдгийг нэг бус удаа харуулсан болно. “Лха” гэдэг үгийн утга бол тухайн өгүүлэмжинд дурьдагдаж байгаа зүйлээс шалтгаалах бөгөөд дараах тодорхойлолтууд тохирсон утгатай байх юм. Үүнд:

1. Ямар нэг хэмжээгээр хүнийг давж гарсан, оршин тогтнолын дээд зэрэглэлийхэн / дэва буюу тэнгэр / бол сансрын / хорвоогийн хүлээс / хуульд захирагдсан байдаг.

2. Зарим газрын болон нэгжийн суу билэгтнүүд, газраар хязгаарлагдсан сүнснүүд / лус, савдаг /, чөтгөрүүд орно.

3. Дхьяни бурхад болон тэдний адил бусад болох ухаанаас төрсөн хэлбэрүүд, хүчнүүд орно.

7. Төвдийн бясалгалын систем дэхь Дарь эх,

Акшобхья ба Вайрочана

Билгүүн ухааны эмэгтэй хувилгаан дүрүүд / пражня / дотор Дарь эх бол онцгой байр суурийг эзэлж байдаг. Дарь эх нь Дхьяни бурханы билгийн талын хэсэг болохын хувьд чухал төдийгүй, бусдаас ялгарах онцгой шинжтэйн улмаас Төвдийн шашны амьдралд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг байна. Тэрээр, үнэнч хайрын мөн чанар бөгөөд энэ нь шүтлэг

/ пужа /-ийн хамгийн энгийн үйлдлээс эхлээд бясалгалын хамгийн дээд шатны дасгал сургуулилт хүртэлх, шашны бүхий л үйл ажиллагааны үндэс суурь нь болдог байна. Иймээс тэр / Дарь эх / бол, Төвдийн Бурхадын чуулганы / Бурханыг байгальтай адилтган, байгалийг бурхадын бүрдэл хэмээн үздэг шашны гүн ухааны сургаалаар буй болсон / хамгийн алдартай хөргүүдийн нэг нь юм. Тэрээр Мадоннагын хүмүүнлэг болон бурханлаг дүр төрхүүдийг нэгтгэсэн байдаг бөгөөд бүхий л амьд амьтныг үйлдсэн гавьяа зүтгэлээс нь үл хамааран эхийн хайраар хайрладаг билээ. Нар нь дулаан гэрэл илчээ нүгэлтэнд төдийгүй буянтанд ч адилхан түгээдэг лугаа адил, Дарь эх өөрийн хайр халамжийг сайн ба саар үйлстэнд ч, мунхагууд болон мэргэдэд ч нэгэн адил хүртээдэг юм. Тийм ч учраас Төвдүүд түүнийг Дамциг Дулмаа - Чин үнэнч Дарь эх хэмээн нэрлэдэг ажээ.

Дарь эх нь - чин үнэнч сэтгэлийн биелэл бөгөөд энэ нь хайр энэрлийг төрүүлж, өөрийн сахил санваараар амьд бүхнийг авран чөлөөлөхийн тулд тэднийг бэхжүүлж байдаг. “Дамциг” / самайя / гэдэг төвд үг нь ариун, баяр бахдалын сахил санваар” гэсэн утгатай бөгөөд гэхдээ, ид шидийн хэлээр тантра гэдэг нь “уулыг ч хөдөлгөх чин үнэнч сэтгэл” буюу билгүүний зүрх нь юм. Энэ нь зарим талаараа “бхакти” хэмээх санскрит нэр томъёотой дүйцэх бөгөөд энэхүү үг нь Бурханы шашны Энэтхэг оронд бурхантай нэгдэж, үнэнч хайр сэтгэл өөрөө өөрийгөө бүрэн чөлөөлөх гэсэн утгатай юм. Иймээс тэр нь шраддха-гаас илүү, өөрөөр хэлбэл, энгийн итгэлээс ч илүү юм. Учир нь тэрбээр хайраар нэвт шингэсэн байдаг. “Бхакта” гэдэг бол “хайрлагч” гэдгийн адил, мөн “зориулагдсан” гэсэн үг юм. Энэ үгийн “Дам” гэдэг үе нь “холбоотой”, “нөхцөлдсөн”, тухайлбал, “андгай тангарагаар, амлалтаар, зөвшилөөр буюу нөхцөлөөр холбогдсон” гэсэн утгатай юм. Гэхдээ энд бол үнэнч хайрын хүчээр дамжин, дотоод элгэмсэг төрлийн хэлхээ холбоог зааж байна. Тэрээр Дхьянд өөрийгөө зориулж, бясалгалын мандлын төвийг үүсгэдэг бурхантай өөрийгөө адилтгаж, эсвэл хэрэгжүүлэх аргын объект “садхана” болдог юм.

“Дамциг” гэдэг үгийн бодит утганд шашны суурь зарчим оршдог бөгөөд “лигаре” - “холбох” гэсэн үгнээс гаралтай “религио” гэдэг латин үгийн утган дахь дотоод

холбоогүйгээр ямар ч бясалгал буюу зан үйл утга учиргүй, ач холбогдолгүй болох юм. Энэ нь үг болон бодлыг давсан болгоны өмнө гүн гүнзгий хүндлэлийн байр суурь буй бөгөөд ийм байр суурьгүйгээр билэгдлүүд нь өөрийн хүч, ач холбогдлоо алдах байсан юм.

Төвдийн шашны амьдралд, “Дамциг” нь голлох үүрэг гүйцэтгэдэг бөгөөд сүсэг бишрэлийн нууц болон бясалгалын арга техникийн талаарх нарийн ширийн зүйлийн тухай юм ярилгүй дуугүй байх, нууцыг чандлан хадгалах гол шалтгааны нэг нь юм. Хэрэв өөрийгөө бурханд зориулсан сүсэгтэн биш л бол, сүсэглэл үйлдэгчээс энэ талын юм асуух хэрэггүй. Учир нь, эдгээр зүйлс нууцлагддаг төдийгүй, нууцыг алдвал өөрийн “дамциг”- аа ч алдах буюу өөрөөр хэлбэл, оюун ухаанаас хальсан зүйлийг гутаах төвшинд илэрхийлэхийг оролдсоноороо дотоод сэтгэлийн эрч хүчээ ч алдах юм.

Нууц сургаалын тухай бусдад олон юм ярьснаараа, бид өөрсдийнхөө дотоод дахь цэвэр ариун байдлыг эвдэж, сүм дуганыг нээх түлхүүр нь болох гүн хүндлэлээ ч эвддэг. Нууц сургаалын дурлалын явдлын тухайд дурлалт хосууд энэ талаар өөр бусадтай шүүн хэлэлцддэггүй шиг, дотоод хувирлын нууц сургаал нь, түүний билэгдлийн хүчнүүд мунхагийн нүднээс болон орчлон хорвоогийн хөл хөөрцөг болсон асуудаас далдлагдсан тийм тохиолдолд ч буй болдог.

Төвдийн бясалгалын системд, харагдах бүтээлч шатандаа гарч ирдэг, мандлын төвлөрсөн тойргийг дүүргэдэг Бурханы хэлбэрүүд нь “ие – шей -па” болон “дамцигпа” буюу өөрөөр хэлбэл, Билэг / жняна / ба Итгэгч / самая Бхакта / хэмээн хуваагддаг. Энэ бол бясалгалын хоёр гол хүч болох мэдрэмж ба мэдлэг, этос ба логос мөн бөгөөд энэхүү хоёр хүчтэй холбоо нь Төгс гэгээрэлт болон Авралыг төрүүлдэг.

Үндсэн таван дэлбээт / нарийн харвал дөрвөн дэлбээтэй ч төв хэсэг нь бас нэг дэлбээнд тооцогддог / мандлын гадаад дөрвөн Дхьяны бурханы Акшобхья, Амитабха / зүүн баруун төв / ба мэдрэмжийг / дамцигпа / онцолсон Амогхасиддхи, Ратнасамбхава / хойд, өмнөд төв /, гол төвд нь буй Вайрочана бол Дхьяни бурхадын тухай өгүүлэхэд гарсан болон тэдгээрийн интеграл юм. Өөрөөр хэлбэл, Вижнянавадины сургаал ёсоор бодит байдалд ердөө ганц скандха (мэдрэхүйн цогц) байдаг. Чухамдаа энэ нь вижняна

бөгөөд бусад дөрвөн нь вижнянагын хувилбарууд буюу Орчлонгийн ухаарлын онцгой хий үзэгдлүүд болох ухамсарын дөрвөн / эсвэл найман / ангиллын хувилбарууд юм. Иймээс “Вижняпти матра сиддхи шаstra” бол зөвхөн Дөрвөн билгүүний тухай л өгүүлдэг. Тэгээд ч ухамсарын дөрвөн хэлбэр болон тэдгээрээс шалтгаалдаг дөрвөн скандха өөрчлөгдөхийн чацуу ухамсарын дөрвөн зарчмын хувиралт болдог. Өөрөөр хэлбэл, Таван билгүүн, Бурханы цэвэр гадаад мэдлэг, олон талт хуулсан хэрэгжилт буюу Дхарма дхату жняна болон бүрэн нийлбэр ч мөн бөгөөд Дөрвөн билгүүний эх булаг ч бас мөн. Тэр нь зэрэглэлийн эхэнд ч, адагт ч байрлаж болно. Энэ нь тусгаарлагдаагүй байгаа байдлын төвөөс идэвхтэй, ялгавартай ахуйд чиглэсэн Бурханы билэг чанарыг нээн харуулах байдлаар, дөрвөн билгүүнийг бид авч үзэж байгаа бил үү, эсвэл Билэг чанарын идэвхтэй хэсгээс / Бүхнийг үйлдэгч билгүүнээс болон Дотоод бүтээлч билгүүний мэдрэмжээс / харьцуулшгүй Бурханы шинж чанарын дотоод биелэл рүү чиглэсэн хэмээн үзэж байгаа бил үү гэдэг талаар үзэх хэрэгтэй.

Эхний тохиолдолд, Акшобхья нь Бурханы билэг чанарыг нээн харуулах эхний үе шатыг үзүүлж байгаа бөгөөд энд бүхий л юмс хоосон чанараас үзэгдэж харагдах тодорхой байдалд, эх үүсвэр их хоосон чанартай холбогдсон хэлхээ холбоогоо алдалгүйгээр шилжиж байгааг харуулж байна. Хоёр дахь тохиолдолд Акшобхья нь хүний мэдлэг ухаанд сэргээж бодох дээд хэмжээг харуулж байгаа бөгөөд энд бүх үзэл бодлын хязгаарлалтын “хоосон чанар” болох Дхармагын хүрээний бодит илрэлд тусгагдаж байдаг. Энэхүү тохиолдолд, Акшобхья нь Вайрочанаг хувийн ухамсарын дээд түвшинд Хоосон чанарын үүднээс бясалгалд орсоны тусгал болдог.

Толь мэт Билгүүн / адаржажняна /-ийг “Жнянасиддхи” сударт нягтлан үзээд Индрабхути хэлэхдээ “Хэн ч өөрийгөө болон өөрийнхөө дүрийг толинд шинжин хардаг шиг, Дхармакайя нь Толь мэт билгүүнд харагддаг” гэжээ.

Ийнхүү Акшобхья нь ертөнцийн зүг хандаж “оршихуй”, “эс оршихуй”-

гаас хөндийрч, юмсын энэхүү шинж байдлыг тусган харуулах агаад Дхарма - дхату - д хандаж Вайрочанагын шинж байдлыг тусган харуулж байгаа юм.

Акшобхьягын идэвхтэй тусгал болох нууц буюу “Важрасатвагын дотоод зам”-ыг дагалдан зөвшөөрч, Очир хөлгөний чиглэлүүдэд Акшобхья болон Вайрочанагын үүргүүд солигддог. Тэдгээр чиглэлүүдэд нэгтгэгдсэн билгүүний эрчим, цацраг нь дахин сэргээгддэг Акшобхьягын идэвхтэй тусгалд дагалдан ордог. Энэ тохиолдолд Важрасатва - Акшобхья ухамсарын цэвэр залгамж болон нийлж өөрчлөгдсөн скандхануудын эзэгнэгч нь болдог. Ингэхэд Вайрочана нь мэдрэмжийн хэлбэрийн цэвэршсэн залгамжийг эзэгнэгч болсон байхад буюу өөрөөр хэлбэл, орон зайн үргэлжлэл буюу зарчим, бүхий л мөн чанарын оршин тогтнолын удиртгал мэт болсон байх үе юм. Үүгээрээ Вайрочана бол их, бага хэмжээгээр бүхэлд байдаг / Хоосон чанарын хэсэгт / олон талт “тоо бүртгэлийн ухамсарын”-ын үүрэг, өөрийн тунхаглалаас өмнө оршин байсан бүх хэлбэрүүдийн анхдагч шалтгаануудын үүргийг гүйцэтгэдэг. Энэ үед Важрасатва - Акшобхья нь энэ байдлыг бүрэн ухамсарласан байдаг. Эдгээрийн ялгааг нарийн гаргах гэвэл, үгээр илэрхийлэхэд төвөгтэй бөгөөд буруу тодорхойлсоноор, хувийн зорилгоо бусниулахгүйн тулд тэдгээрийн ялгааг маш нарийн тодорхойлох хэрэг гарна.

Үгээр илэрхийлэхэд, иймэрхүү ойлголтуудыг бүдүүлэг мэт болгох хандлагатай болгоно. Тэгээд ч үнэн чанартаа тодорхойлолт, үг хэллэгүүд өөрчлөлт хийх үндэслэлүүд нь, логик шаардлагаас үл хамаарч, харин бясалгалын хувийн анхны цэгээс шалтгаалах бөгөөд аливаа оюун ухааны байр сууринаас үл шалтгаална.

Жишээлбэл, Вайрочана болон Акшобхьягын оронд бясалгалууд нь Амитабхагын төвлөрлөөр эхэлдэг ёс бий. Энд үүнээс болоод бүхий л мандалууд нь бүр өөр хэтийн зорилготой болдог. Хөгжимд нэг л зохиомж нь янз бүрийн тайлалтай болчихдогтой нэгэн адил буюу.

Энэ нь төвдөөр бижа-мантра буюу Хри-г агуулсан Амитабхагын мандлыг дүрсэлсэн байх ба тухайн хэсгийн гадна талд зурагддаг. Харин Вайрочанагын “Ум” бол хойд талын дээд дэлбээнд, Амитабхагын анхдагч байранд байрладаг. Төвдийн зурмал дүрсэнд мандалын орон зайн чиглэлүүд нь дараах байдлаар байрладаг. Үүнд: “баруун” тал нь дээд

хэсэгт, “зүүн” тал нь доод хэсэгт, “өмнө” тал нь зүүн гар талд, “хойд” тал нь баруун гар талдаа / хэрэв мандалтай зураг нь хананд өлгөөстэй байвал / байрладаг.

“Бардо тойдол”-ыг зохиогч Бадмасамбхавагын нэвтрүүлсэн Төвдийн Буддизмын нэн эртний чиглэл болох Улааны шашныг загалмайлагчид нь Вижнянавадагын уламжлалыг дагадаг бөгөөд энд Вайрочана нь ухамсарын ялгаж салгадаггүй зарчмыг эзэмшигч болж тавигдсан байдаг. Тэрээр өөрийнхөө “пражня” болох хязгааргүй орон зайн эх бурхантай салшгүй холбогдоно. Энэ нь бүхнийг эзэгнэгч агуу их Хоосон чанарын биелэл болох Акшобхьяд ухамсарын цэвэр зарчмын арай идэвхтэй үүрэг оногддог. Англи орчуулгандаа, лам Сандувын ашигласан манускрипт нь, Төвдийн судар “Бардо тойдол” - ын нийтээр мэдэх баримт нотолгооноос арай ялгаатай байдгыг үүгээр нотолж болно. “Бардо тойдол” дахь нилээд эртний уламжлалд үндэслэгдсэн бөгөөд Вайрочанад ухамсарын зарчмыг хамааруулдаг. Чухамхүү энэ зарчмаас л Вижнянавадыг баримтлагчдын сургаалд тохирдог тэр бүх хэлбэр, мэдрэмж, ойлголт сэдэлтийн язгуур цогц нь үүсч гардаг. Нөгөө талаас, Каржүдбагын уламжлалын үндсэнд чөлөөт бус шинэлэг зүйл байдаггүй, харин гол төлөв хоосон чанарын метафизик талын хэсэг түшиглэсэн байдаг. Метафизик талын хэсгийг Шуньятавадинчуудаас нэн эртний Важраянагынхан хүлээж авсан бөгөөд Бурханы шашны тантрын оюуны амьдралд, үндсэн гол чиглэл болж үлджээ.

8. Огторгуй, өнгө, язгуур махбод, мутрийн дохио болон

оюуны шинж чанаруудын билэгдэл

Бясалгалын явцад Дхьяни Бурхадууд дотоод мэдрэхүйн бүтээлч үе шатанд гарч ирдэг хэлбэрүүдийг болон янз бүрийн өнгөнүүдийг бид харьцуулж үзсэн бөгөөд энэ нь гэрэл хугалагчаар нэвтрэн орсон нарны цацраг тэр олон өнгөөр ялгардаг. Иймээс өнгө болгонд тус бүрийн шинжүүд илэрдэг лугаа адил юм. Бурхадын биеийн өнгөнүүд нь Дхьяни бурхадыг гарч ирэхэд чухал үүрэгтэй байдаг учраас энэхүү зохицуулалт чухал юм. Эдгээр өнгөнүүд нь тодорхой шинж чанар, холбоог заах бөгөөд тэрхүү шинж чанар, холбоо нь

сүсэгтэн хүний хувьд, хөгжмийн мэдлэгтэй хүнд нот чухал байдагтай адил, тийм л ач холбогдол, учир утгатай юм. Тэдгээр нь онцгой доргилтыг дамжуулах ба өөрөө ухаж ойлгон таних мэдлэгийн хэсэг бүрийн тодорхойлолтыг мөн дамжуулдаг. Эдгээр нь дуу, авианы талд бол холбогдох дохио зангаагаар, харин эрхэм билгүүн талд бол холбогдох оюуны байр сууриар тус тус илэрдэг.

Харилцан холбогдох сүлжээ нь оюуны болон хүрэлцэх мэдрэмжийн бүх талуудаа хүртээмжтэй, мөн тэдгээрээс үүдэн гарах ухагдхуунуудад ч гэсэн хүртээлтэй юм. Иймээс дэлхийн ухамсар замбараагүй байдаг юмнаас аажмаар сайн зохион байгуулагдсан, шинэ цэвэр хяналттай Сансар үүсдэг.

Энэхүү сансрын үндэс болох элемент нь Огторгуй юм. Огторгуй гэдэг бол дээд зэргийн бүхнийг хамарсан мөн чанар бөгөөд түүний шинж төрх нь хоосон чанар мөн бөгөөд тиймээс бүхнийг өөртөө багтааж, бүхнийг хамарч чадна. Огторгуйд махбодын ялгарлын “юмсын мөн чанар”-ын зарчим сөрөг тавигддаг. Гэхдээ огторгуй үгүйгээр юу ч оршин тогтнохгүй. Огторгуй гэдэг бол аливаа материалаг болон материалаг бус хэлбэрээр орших зүйлсийн зайлшгүй нөхцөл мөн юм. Тэгээд ч бид аливаа объект юмуу, амьд юмыг орон зайгаас тусад нь төсөөлж чадахгүй билээ. Иймээс огторгуй гэдэг нь аливаа зүйлийн байгаа байдлынх нь гарцаагүй нөхцөл болох төдийгүй, бидний ухамсарын үндэс суурь нь болсон шинж чанар юм.

Бидний ухамсар бол бидний амьдран буй огторгуйн тэр төрлийг тодорхойлсон байдаг. Огторгуй хязгааргүй, ухамсар хязгааргүй гэдэг нь адил төстэй юм. Амьд юмс өөрийнхөө ухамсарыг ойлгож мэдэх цагт, тэрээр огторгуйг ч ойлгож мэддэг, ухамсарын хязгааргүй чанарыг ч ойлгодог билээ.

Нэгжээс хэрэв огторгуй нь бидний ухамсарын шинж чанар мөн бол үүнтэй адил үндэслэл дээр огторгуйн тухай эргэцүүлэл нь оюуны идэвхжил болон ухамсарын дээд хэлбэрийн шалгуур болно. Огторгуйн тухай бид хэрхэн төсөөлж, эсвэл түүний талаар бидэнд мэдээ баримт байгаа явдал бол, бидний ухамсарыг хэмжих хэмжүүрийг гэрчилж байна. Бид оюунаараа, мэдрэхүйн эрхтэнээрээ мэдэрч байгаа тэрхүү гурван талт орон зай

бол олон тооны боломжийн бүх хэмжүүрүүдийн зөвхөн нэг нь л юм. “Цаг хугацааны огторгуйн” тухай бид ярихдаа, дээд зэргийн хэмжүүрийг зааж байгаа хэрэг бөгөөд өөрөөр хэлбэл, мэдрэх эрхтэнээрээ биечлэн мэдэрч болохооргүй, тийм хэлбэрийн орон зайг зааж байгаа хэрэг юм.

Хэрэв бид бясалгалын үе дэхь огторгуйн тухай гарах эргэцүүллийн талаар ярьж байгаа бол, тэс өөр хэмжигдхүүний тухай бодож байна гэсэн үг. “Энэ тухай бидний мэдэх “гуравдагч” нь ижил зүйл буюу гарааны цэг мэтээр хэрэглэгдэж байгаа юм. Огторгуйн тухай энэхүү эргэцүүлэлд цаг хугацааны дараалал нь агшин зуурын зэрэгцэн оршилт, юмс бөөрөө нийлүүлсэн мэт харилцан бие биедээ нэвтрэн орж, оршин тогтнож байгаа байдалд хувирч өөрчлөгдөж байдаг болно. Огторгуй бол хөдөлгөөнгүйгээр оршин байдаггүй, гэхдээ тэнд амьд, тасралтгүй хөдөлгөөн хувиралт явагдаж байдаг. Энд цаг хугацаа, огторгуй бол ухаан санаанд багтаж барахааргүй тийм дээд нэгдэлд ордог. Үүнийг төвдөд “тигле” гэж нэрлэдэг / санскрит, бинду, монголоор дусал / бөгөөд нэр томъёоны ухаан буюу бясалгалын практикт чухал байрыг эзэлдэг. Энэ үг нь бясалгалын үед, дотоод орон зайг илрүүлэн нээх төвлөрсөн анхдагч цэг, Дээд нэгдлийн эцсийн цэг гэсэн үг бөгөөд эндээс дотоод, гадаад орон зай үүсч гардаг, уг орон зай нь нэгдмэл нэгэн зүйл болдог цэг билээ.

Хүн тэнгэрийн уужим зайг онцлон харж, бурхан тэнгэр тэнд байгаа гэж бодон хүчийг нь дуудах үедээ үнэхээр өөрийнхөө дотор байгаа хүчийг дуудаж байгаа, тэрхүү хүч нь өөрөөс нь гадна байна гэж төсөөлсөн хэрэг юм. Өөрөөр хэлбэл тэрхүү хүчийг сансарын орон зай гэж мэдэрч төсөөлдөг явдал юм. Иймээс хэрэв бид тэнгэрийн ариун гүн хөх байдлыг тунгаан бодно гэдэг нь үнэндээ бид өөрсдийнхөө дотоодод байгаа зүйлийн, өөрсдийнхөө бүхнийг хамарсан нууц далд ухамсарын цэвэр увидасын хүчийг тунгаан бодож байгаа хэрэг билээ. Энэ нь бидний бодол сэтгэл, оюуны төсөөллөөс шалтгаалдаггүй, гадна талаас нь хандаж хүссэн, хүсээгүй гэж хувааж ангилахаас өөр зүйл болно. Ингэж тунгаан боловсруулалт хийх нь биднийг эзэмдсэн тэрхүү тайлбарлан өгүүлж болмооргүй зүйлийг танин мэдэх аз завшааныг бий болгож байна.

Ийм мэдлэгтэй болсноороо бид гүн хөх тэнгэрийг бясалган бодохдоо тэр нь билэгдлийн төв, гарааны цэг гэж ойлгож эхэлнэ. Энэ нь Дхарма-дхату - гын бясалгаж олсон, билгүүний гэрэл гэгээ юм. Энэхүү гэрэл гэгээ нь ухамсар болон Билэг билгүүний аливаа чадварын эх булаг, хязгааргүй огторгуйн адил бүхнийг хамрагч Вайрочанын төвөөс хөх гэрэл цацруулсан эх булаг юм. Энд Вайрочанын төв нь Дхьяни бурханы мандалын гол байх бөгөөд дөрвөн дэлбээт лянхуан төвд байрлана.

“Бардо тойдол”-д өгүүлэхдээ, чадавхит үрнээс / тигле / гүн хөх огторгуйн төв хэсэгт, Ариун сэтгэлт Вайрочана гарч ирдэг. Тэр нь цагаан арслангуудаар түшүүлсэн, хүндтэй сэнтийд заларч, гартаа найман зүүтэй цагираг барьсан байх бөгөөд хязгааргүй огторгуйн Эх бурханыг тэвэрсэн байдаг. Дхарма-дхату билэг билгүүний нандин хөх гэрэлийг ухамсарын анхдагч байдал болон цэвэр язгуур махбодтой адилтгадаг бөгөөд үүний хамт Агуу их хоосон чанарын чадавхиар билэгддэг. Үүнийг Чангийн Буддизмын (Хятадын шашины VI их ламтан Хуэй нэн) уран үгээр илэрхийлэхдээ:

“Хоосон чанарын тухай миний ярихыг та сонсвол, намайг дотроо огт юмгүй хов хоосон зүйл яриад байна гэж битгий бодоорой. Та ингэж болгоовол нэн чухал. Учир нь, хүн тайван суугаад өөрийн оюунаа хоосон байлгавал, тэр нь “үл ялгаврын хоосон” чанарын байдалд орох болно. Орчлонгийн хязгааргүй хоосон гэдэг бол янз бүрийн хэлбэр дүрс, хэмжээтэй пирамидуудыг агуулж чадна. Үүнд: нар, сар, одод, олон ертөнцүүд, гол горхи, уул хад, ой мод, бут сөөг, хавар намар, сайн муу хүмүүс, сайхан муухайг хамарсан хууль, тэнгэрийн түвшин, тамын орон, их далайнууд, Махамеру / Сүмбэр / уул бүтнээрээ, энэ бүхэнд орон зай бий бөгөөд ийнхүү энд шинж байдлын “хоосон чанар” гарч ирдэг. Бидний ярьдагаар, ухааны уг мөн чанар хязгааргүй арвин юм. Учир нь тэдгээр бүх юмсыг хамарч байдаг билээ.”

Гэвч, бид хэдийгээр орон зайн дотор амьдарч, түүгээр дүүргэгдэн, хүрээлэгдэж, зүрхэндээ түүний хязгааргүй чанарыг агуулж байгаа ч гэсэн, орон зайг тайлбарлан бичиж болдоггүйн адил, түүнийг нэгэн бүхэл бүтэн цогц зүйл хэмээн тайлбарлан тодорхойлж болдоггүй, харин үүнийг сүсэглэн үйлдэж буй над мэтийн хүний хувьд хийж болох л юм.

Дээд ухамсар болон бурханы байдал төрхөөр түүний шинж байдлыг тодорхойлдоггүй, мөн түүний хэсгүүдийг ялгаж салгахгүйгээр бидэнд ойлгогдохоор болгож чаддаггүйтэй адил юм.

Бид орон зайд баримжаа авахдаа дорнод, өмнө зүг, баруун болон хойд зүг гэхчилэн зүг бүрийн чиглэлийг нарны тодорхой байрлалтай холбож үздэг. Ингэснээр орон зайн нэгдлийг үгүйсгэдэггүй, гэрлийн эх булаг нь байрлал бүхэндээ адил байдаг гэдэгт эргэлздэггүй. Яг иймэрхүү байдлаар, бид өөрсдийн дотор буй мэдлэгийнхээ орон зайд нэвтрэн, түүнийхээ өрнөлтийн нилээд хэдэн байрлалыг дэс дараалан өнгөрдөг. Энэхүү өрнөлт нь “дорнод, өмнөд, өрнөт, хойд” гэсэн чиглэл буюу ухамсарын хэлбэрүүдийг дамжин өнгөрдөг. Ингэхдээ, бид тус тусдаа байгаа эдгээр бүх ухамсарын хэсгүүд, шинж чанаруудын нэгдэл, цаг хугацааны давхцалыг үгүйсгэдэггүй. Үндэс, иш, мөчир, нахиа, цэцэг, үр, жимс бүрэн бүтнээрээ үрэнд багтсан байдагтай адил, бидний хувьд эдгээр нь орон зай, цаг хугацааны дотор өрнөж, дэлгэрсэн үедээ л бодит зүйл болдог.

Олон талт Ухамсарын бодит байдлын тухай төсөөлөл өгөхийн тулд, ялгараагүй ухамсарын нандин хөх орон зайнаас Дхьяни бурхадын хөргөөс гэрэл цацруулсан байдал буй болдог “Дорно” гэгдэх зүгт, орон зайн хязгааргүй алс тэртээд байгаа адил хөх Акшобхья гарч ирнэ. Түүний зүрхнээс толь мэт Билэг билгүүний шинж чанараараа тусгаарлагдаагүй, өнгөгүй, цэвэр, цагаан / Вайрочанатай төсөөтэй / гэрэл цацарна. Толь адил билэг билгүүн чанарт “Нээгдэж танигдаагүй” үлдсэн, бүх юмсын дүрсүүд / рупа / салж тус тусдаа болсон байх бөгөөд үүгээр тэдгээр дүрсүүд нь толинд тодорхой, нарийн тусаж танигдсан байхыг харуулдаг. Толь нь бүдэг бадаг танигдсан зүйл байх ёсгүй гэдгийг ч харуулж байгаа юм. / Вайрочаны биеийн өнгө нь цагаан, гэрэл нь хөх, харин Акшобхьягын биеийн өнгө нь хөх, гэрэл нь цагаан байдаг ба энэ бол тэдгээр нь бие биенээ бүрдүүлж байдаг гэсэн төрх байдлыг зааж байгаа юм. /

Энэ бол цуцашгүй ажиглагч хүний байр суурь, цэвэр дотоод сэтгэлийн биелэл / Зэн Буддизм дэхь сатори-гийн дотоод сэтгэл биелэл / бөгөөд энд бидний жирийн сэтгэхүй нь бодит мэт байгаа зүйл нь арилдаг. Гэхдээ, үнэн чанартаа үйл явцын цаг хугацаа буюу

органик явдлын хэсгүүдээс шалтгаалсан чөлөөтэй тусгаарлалттай хамт арилдаг. Ийм шилждэг онцгой байдлууд, амьд хэлхээ холбооноос гарч ирэх бөгөөд юмс ба материалаг зүйлээр илэрч тодорхой болдог.

Гагцхүү толь мэт Билэг билгүүний хэмжээнд бол юмс өөрсдийн “материаллаг” байдлаасаа буюу тусгаарлагдмал байдлаас салдаг боловч өөрийн хэлбэрээ алддаггүй. Үүнд: юмс болон материаллаг байдлаасаа салсан ч эвдэрдэггүй юм гэж ойлгох хэрэгтэй. Учир нь, бүх хэлбэр дүрс, материаллаг байдлын үндэс болсон ухааны бүтээлч зарчим нь олон талт салангид авч үздэг ухамсарын идэвхтэй тал мэт ойлгогддог. Үүний өнгөн хэсэг дээр нь дүрсүүд үүсч, далайн усны гадаргуу дээрх давалгаа шиг алга болдог бөгөөд чимээ аниргүй болж, орон зайн цэвэр хоосон чанарыг / эмэгтэй хэсэг дэхь Вайрочаны Хоосон чанар / тэнгэрийн цэвэр гэрэлд тусгадаг.

Иймээс “Бардо тойдол” - д өгүүлэхдээ, “Бодит байдлыг хоёр дахь өдөртөө бодож бясалгахад “Ус” хэмээх язгуур махбодын цэвэр хэлбэр нь цагаан өнгөөр гэрэлтэж байдаг. Ингэхдээ аз жаргалын “дорно”-ын хөх талаас нь адист Важрасатва - Акшобхья гарч ирдэг. Түүний биеийн өнгө нь гүн хөх юм. Гартаа таван толгойт важра барьсан, зааны нуруунд түшсэн олбог дээр суусан бөгөөд Эх бурхан Лочана / Санжай жанма / дагиныг тэвэрсэн байдаг. Дүрсийн цэвэр зарчим нь яб - юмын хэсэгт Важрасатвын зүрхнээс гарч ирдэг толь мэт Билгүүн чанарын цагаан өнгийг цацруулдаг.”

“Өмнө” талын Дхьяни бурханыг нарны тусгал адил төсөөлдөг. Үүнд, нарны дулаан өнгөнд зохицсон өнгө бүхий Ратнасамбхавагын оюуны арвин хүч чадлаас гарч буй өглөгийн мутратайгаар / данамутра / дүрсэлдэг. Түүний зүрхнээс, амьд бүхний үндсэн тэгш байдлын Билэг билгүүн чанарыг харуулсан, алтан шаргал өнгөт гэрэл гарч байдаг. Түүний салшгүй хэсэг нь болох мэдрэмжийн цэвэр зарчмыг тэрээр, амьд бүхнийг тэтгэх хайр, харуусал, өөртэйгөө адилд үзэх сэтгэл болгон хувиргадаг.

Язгуур махбодын хувьд, Ратнасамбхава нь эх хүний цуцашгүй, элгэн халуун сэтгэлийг гаргаж, амьд бүхнийг тэжээн тэтгэгч, газар дэлхийтэй зүйрлэгдсэн байдаг. Түүний нүдэнд, түүний төрүүлсэн амьд бүхэн тэгш эрхтэй байна. “Шороо” хэмээх язгуур махбодын

уламжлалт билэгдлийн өнгө нь шар өнгө юм. Энэхүү өнгө нь өөрийн цэвэр хэлбэртээ алт юмуу, үнэт эрдэнэтэй төсөөтэй, тантрын ёсны алхимийн нэр томъёонд “прима матери” буюу “гүн ухааны чулуу” / зэндмэнэ эрдэнэ / - тай адилтгадаг.

Иймээс “Бардо тойдол”-д өгүүлэхдээ, “Шороо” хэмээх язгуур махбодын цэвэр хэлбэр нь, гурав дахь өдөртөө шар өнгөөр туяардаг. Ингэхдээ, өмнө зүгийн шар хэсгээс адистадат Ратнасамбхава гарч ирдэг. Түүний биеийн өнгө шар, тэрээр гартаа үнэт эдийг барьж, морьд тулсан сэнтийд заларч, Эх бурхан Мамакийг тэвэрсэн байдаг. Мэдрэмжийн цэвэр зарчим бол Эрх тэгш байдлын Билэг билгүүний шар гэрлийг цацруулна. / Морь бол нарны билэгдэл бөгөөд өмнө зүгтэй холбогдож, үд дундийн нартай холбоотой. /

Баруун зүгийн Амитабха, Дхьяни бурхан бол жаргаж байгаа нарны өнгө / улаан / - өөр илэрч, өдрийн бясалгалын цагтай холбоотойгоор түүний гар нь бясалгалын дохио / дхьяна мутра / - нд өвдөг дээрээ тавиастай байдаг. Дотоод ялгалтыг үзэгч, гүн улаан гэрэл нь түүний зүрхнээс гарч, бүтээлч бясалгалыг өрнүүлж, бүрэн дэлбээгээ нээсэн лянхуа / падма / цэцэг нь түүний мутарт байна. Билгүүн ухаанаар тунгаан ойлгож, мэдрэх чадвар нь Амитабхагын салшгүй бүрэлдхүүн хэсэг болох нь мэдрэмжийн цэвэр зарчмаас хөгждөг. Язгуур махбодын хувьд түүнийг галд хамааруулах бөгөөд ингэснээрээ эртний уламжлалт билэгдэл ёсоор нүд болон харааны үүргийг харуулдаг. / Иймээс Амитабхагын олбог суудал нь мэлмийгээр чимэглэгдсэн тогосны өдөөр түшсэн байдаг. /

Энэ тухайд “Бардо тойдол” - д өгүүлэхдээ, “Гал гэдэг язгуур махбодын цэвэр хэлбэр нь, дөрөв дэх өдрөө улаан гэрлээр цацарч байдаг. Энэ үедээ баруун зүгийн аз жаргалын улаан хэсгээс адистадат Амитабха гарч ирдэг. Түүний биеийн өнгө улаан, мутартаа лянхуа барьж, тогосоор түшүүлсэн сэнтий дээр заларч, “цагаан хувцастай” Эх бурхан Пандаравасиниг тэвэрсэн байдаг. Мэдрэмжийн цэвэр зарчим нь Тод ялган үзэгч, билэг билгүүн чанарын улаан гэрлээр цацарч байдаг...”

“Хойд зүгийн Амогхасиддхи, Дхьяны бурхан нь “шөнө дундын нар” хэмээн нэрлэж болох зүйл юм. Өөрөөр хэлбэл, үйл ажиллагаа нь мэдрэхүйгээс салгагдсан оюуны хүчний нууц идэвхжил бөгөөд нүдэнд үл үзэгдэж, мэдрэгдэхүйд үл хүртэгдэнэ. Түүний зорилго нь

Мэдлэг, Авралыг гүйцээж дуусах замд бие хүнийг / тодорхойлбол, амьд бүх юмсыг / замчилж удирдахад оршино.

Хүний нүдэнд үл үзэгдэх, шар өнгө / бодхи-гийн дотоод нарны / шөнийн гүн хөх тэнгэртэй холилдох бөгөөд түүнд нь, орчлон ертөнцийн төгсгөлгүй орон зай нээгдэж буй мэт болдог. Үүний үр дүнд Амогхасиддхийн ид шидийн ногоон өнгө гардаг. Зүрхнээс нь цацарч буй бүхнийг төгсгөгч идэвх билэг билгүүний чанарын ногоон өнгө нь Вайрочаны хөх өнгө болон Ратнасамбхавагын Тэгш билгүүн чанарын гэрлээр үүсгэгдсэн, сэтгэлийн халуун илчийн цогц нэгдэл болно.

Ийнхүү, амьд бүхэн дээд зэргээр эрх тэгш, нэгдэлтэй байх тухай мэдлэг нь олон талт оюуны идэвхжил болж хувирдаг. Энэ бүхнийг хамрагч хайр сэтгэл / майтри /, эс дуусах зовлон зүдгүүр / каруна /-гын хүчний нөлөөгөөр, амьд бүхэн хувиа хичээх сонирхлоосоо хагацдаг. Дээр өгүүлсэн билэг билгүүн чанарт байгаа энэхүү хоёр хүч нь Амогхасиддхийн эвдэршгүй Элдэв Очир / Вишва важра, төвдөөр: Дорже жадам / болох бөгөөд энэ талаар түүний Акшобхьягын важрийн идэвхжил гэж үзэж болно. Бурхадын мутрын барьцанд буй Элдэв Очир нь Бурханы ид шидийн оюун хүч / “сиддхи” буюу “шид” /-ийг билэгдэж байгаа бөгөөд энэхүү хүчинд өдөөгч зарчим нь аливаа би-д баримтлан хувиа бодсон сэтгэл тэмүүлээс ангижирсан байдаг. Язгуур махбодуудын төлөвийн хувьд энэхүү бүхнийг нэвтлэгч хүч нь хийн махбодод хамаарах бөгөөд хөдөлгөөн болон үргэлжлэх зарчим, амьдрал болон амьсгал / прана /-ын зарчимд тохирч байдаг.

Иймээс “Бардо тойдол” - д өгүүлэхдээ, “Тав дахь өдрөө “хий” хэмээгч язгуур махбодоос цэвэр хэлбэр нь ногоон өнгөөр цацарч, мөн энэ цаг мөчид төгсөж дуусгасан үйл ажлын “хойд” зүгийн ногоон хэсгээс адистадат Амогхасиддхи гарч ирнэ. Түүний бие ногоон өнгөтэй. гартаа Элдэв Очир барьж, Гарьд хэмээх хүн хэлбэрт шувуугаар түшүүлэн, олбог дээр заларч, тэнгэрийн уудам орон зайд халин нисэж байна. Үнэн сэтгэлт Дулмаа / Дамциг Дулмаа / хэмээх Эх бурханаар тэврүүлсэн байна. Авралын цэвэр зарчим / төвдөөр: ду - жед - жи пун по ней - судаг - па / нь Бүхнийг төгсгөгч Билэг билгүүний чанарын ногоон гэрлээр цацарна...”

9. Бүтээж харах талын удирдлага - зуурдын ертөнц буюу

“Бардо - тойдол” -ын ач холбогдол

“Бардо тойдол”-ын ёсоор бол бүтээж харах төрөл нь үхлийн дараах завсрын байдал / бардо /-д илэрдэг байна. Гэхдээ, энэ талаар ардын ямар ч аман зохиол болон бусад шашин судлалд байдаггүй ажээ. Энэхүү үзэгдэл нь ямар нэгэн ер бусын хүч, Бурхан, сүнс ч биш, гагцхүү бясалгалын үед үүсэх бүтээлч шатан дахь, оюун ухааны мэдрэмж, дотоод үйл явцын тусгал буюу харааны дүрсийн хуримтлал болно. Энэ бол бүх насаараа хийх дасгалын үр дүн бөгөөд тийм дасгалыг санаагаа төвлөрүүлэх, бүтээж харах зүйгээр эзэмшинэ.

Асч байгаа гэрэл мэт, эдгээр хэлбэр нь дадлага хийж буй хүний эргэн тойронд илбийн хүч, ид шидийн аргаар хийсэн мэт үүснэ. Тэрхүү үүссэн гэрлийн бүслүүр нь дадлага хийгчийг элдэв үхэл тахал, доройтол уналтаас хамгаалж, түүний гэрэл гэгээ, өөдрөг ариун юу байгаа бүхнийг тэтгэн дэмжинэ.

Оюун санааны тийм хүч, дотоод билэгдлийн уриа увидас нь “тойдол” буюу сонсгоод аврах / сонсгоод тонилох / илэрхийлэлд багтах гүний ач холбогдол болно. Зөвхөн чихээрээ сонсож чадагч тэрбээр, өөрөөр хэлбэл, авралын уриа дуудлагад өөрөө өөрийгөө амьдрал дээр хэр зэрэг бэлтгэж чадсан буюу дотоод сонсголын дасгалын тусалцаатайгаар хүлээн авч чаддаг болсон, тэр хүн л тухайн уриа дуудлагад хариу өгч, даган баясч чадна. Түүнчлэн, мэлмийн дотоод хараа нээгч тэрбээр, авралд хөтөлж буй үзэгдлийг / гэрлийг / харж чадна. Түүнээс биш, дотоод сонсголын буюу харааны дасгал хийж, биеэ бэлтгээгүй хэн ч атугай “Бардо тойдол”-ын утга агуулгыг хоосон сонсоод юу ч олж авч чадахгүй. Иймд сударт өгүүлэхдээ, “Хэн их боловсронгуй” / Цогчен, санскрит: Сампана крама / буюу нэгдэл / лайя крама / төгс байдлыг бясалгана, хэн их билэгдэл / пагжа ченпо, санскрит: Махамутра / нэгдэл ба бүрэн бүтэний их мутрын дохиог бясалгана, тэрээр тод гэрлийг харж, үхэх мөчид гэгээрлийг олж, номын ёсоор авралыг хэрэгжүүлэх учир, энэхүү “Бардо тойдол” -ыг тайлбарлуулаад байх шаардлагагүй.

Үүнтэй ижил утгын дүгнэлтийг өөр нэгэн газар хийсэн байдагт, хэрэв хэн нэгэн бээр, Бурханы номын бясалгал үйлдсэн бол, тэднийг бардо-д гарч ирэх үед олж харж, ойлгож таниад авралд хүрнэ гэжээ.

“Хэрвээ хэн нэгэн бээр сургаалыг / үүнтэй холбогдох / огоорвоос, “Бардо тойдол”-д сонсоод юу ч олж авч чадахгүй.”

Тийнхүү “Бардо тойдол” нь хүнийг зөвхөн үхлийн аймшигт бус, басхүү түүнийг биеэсээ салах мөчид нээгддэг, агуу их боломжийг ашиглах чадварыг нь бэлтгэж өгдөг, улмаар хамгийн дээд хойд нас, эцсийн авралд хөтөлдөг анхны ариун судар юм.

Бурханы шашны гүн ухаантан нэгэнд бол үхэх, төрөх хоёр нь хүний амьдралд нэг л удаа тохиолддог үзэгдэл төдийгүй, бидний дотоод ертөнцөд байнга явагдаж байдаг үзэгдэл гэдэг нь ойлгомжтой билээ. Бидний дотор талд ямар нэгэн юм шинээр төрж байдаг юм. Иймд, янз бүрийн төрх байдал л гэсэн үг юм. Тэрхүү төрх байдалд хамаарах зүйл нь: гэгээрсэн ухамсарын байдал, хүний ертөнцөд заяасан ердийн ухамсарын орших төлөв / жений бардо /, унтаж буй үеийн ухамсарын байдал / милам бардо / дхьяны үеийн буюу гүн бясалгалд шилжих үеийн ухамсарын байдал / самтан бардо / үхэх зовлон зүдгүүрийн шаналгаат байдал / чи кхей /, Бодит үнэнийг ухаарч буй байдал / шойнид бардо /, хойд насанд дахин төрөх ухамсарын байдал / сридба бардо / эдгээр болно.

Эд бүгд нь “Бардо”-ын язгуур мөрүүд / зургаан шад /-эд тодорхой бичигдсэн байдаг ба тэдгээр нь “Мон лам”-тай нийлээд “Бардо тойдол”-ын жинхэнэ анхны цөм болно. Тэр цөмийн эргэн тойронд үгээр илэрхийлэгдэх хэсэг нь тогтож, тайлбарын шинжийг хадгална. Энэ бол бид амьдралыг ямар байна, тэр байдлаар нь авч үздэгийн баталгаа бөгөөд зөвхөн үхэлтэй холбодог гэж тайлбарлах тийш хандах болсон “Бардо тойдол” сүүл үеийн оролдлого биш юм. “Мон лам” / ерөөл / гэдэг төвд үг нь санскрит хэлэнд “пранидхана” гэж орсон нь чухам залбирал гуйлтын мөргөл утгаар биш, харин манай эрхэм дээд үзэл санаа, ухааны дээдийг урьж ирүүлэх заллагын дуудлага юм. Энэ нь уг дуудлагыг хэрэгжүүлсэн Бурхан багшийг санагдуулж, түүний хатуу шийдвэр, ам

тангарагтай холбож, тэр жишээгээр мөрдлөг болгож, хүсэл эрмэлзлэлийнхээ үндэс суурь хийхийг зөвлөдөг юм.”

“Бардо тойдол” нь амьдралынхаа төгсгөлд ойртож буйг, эсвэл үхэл ойртсоныг зөн билгээрээ мэдэрсэн нэгэнд зориулагдсан төдий бус, басхүү амьдралынхаа оргилд хүрч, хүн болж төрсөнийхөө хэргийг бүрэн утгаар нь бүтээж байгаа хэн бүхэнд ч зориулагдаж байдаг. Бурхан багшийн сургаал ёсоор бол, хүн болж төрнө гэдэг нь ихээхэн хувь заяатай хэрэг бөгөөд учир нь хүн болж төрсөнөөр, тэр өөрийнхөө хүчээр аврагдах ховор боломжийг нээж, ухамсарын ариун оршихуйд хандах болно.

“Бардо” - гын язгуур мөрт дараах үсгээр эхэлдэг.

“За, зам, амьдралыг минь одоо Бардо гийгүүлж байна.

Залхуу хойргоос ангижирч цаг мөчийг эс алдая.

Номын мөрийг хөөж, бясалгал, мөргөл үйлдье.

Хий дэмий нэг ч агшиныг алдалгүй,

Хүн болсоныхоо хэргийг бүтээе”

Сонсох, санах, бясалгах гурав бол шавийн гурван эрдэм мөн. Төвд хэлний “сонсох” / той / гэдэг үгийг “тойдол” гэдэг илэрхийллийн нэгэн адил, зөвхөн бие махбодын сонсох үйл явцад хамааруулж болохгүй юм. Энэ нь санскрид “шравака” гэдэг нэр томъёо лугаа адил утга нэг “нянтой” гэдэг төвд нэр томъёо лугаа адил харагдаж байна. Юу гэвэл “нянтой” гэдэг нь шавьд хамаарах бөгөөд тэгэхдээ, бүр Бурхан багшийн гарын шавьд хамаарахаас бус, Бурханы сургаал сонссон тэр болгонд хамаардаггүй юм. “Сонсох” гэдэг бол сургаалыг бүхий л зүрх сэтгэлээрээ хүлээж аваад, түүнийгээ өөрийн явдал мөр болгохын нэр юм. Энэхүү утгаар бол “номын дуу сонсох” гэдэг нь сургаалыг үнэн сэтгэл зүрхээрээ / шрадха / сонсоно гэсэн үг болно. Энэ нь шавийн анхан шат болно. Хоёрдугаар шатандаа энэхүү учир шалтгааны ухаанаар гэхээсээ илүү шууд гэгээрэлд шилжих чиглэл нь оюун ухааны тусламжтайгаар ухаж хэрэгжүүлэх шатанд шилжинэ. Харин гуравдагч шатанд шавийн зөн совингын мэдрэмж, оюун ухааны ойлголтын аль аль нь шууд туршлагын тусламжтайгаар амьд үнэнд шилжинэ. Тийнхүү оюун ухааны үнэмшил

нь сэтгэл санааны итгэл төрүүлж, улмаар мэдэх, мэдлэг хоёрын зангидсан мэдлэгтэй хүн болно.

Энэ бол “Бардо тойдол”-ын сургаалыг хүлээж, авшиг авч сахил хүртэгсдийн сэтгэл санааны эрхэм дээд чанар юм. Түүний ачаар жинхэнэ номын шавь болж үхлийн байдлыг таньж мэдэх хэмжээнд хүрч, улмаар үхлийн мөн чанарын хуурамч болохыг ойлгож, түүнээс айх зовох юмгүй, шаналал зовлонгоос бүрэн чөлөөгдөнө. Учир нь үхлийн үйл явцад, бидний санаа сэтгэл, бясалгалын дээд шатны үеийн шаналгааных шиг тийм л үе шатуудыг дамждаг. “Үхэх мөчид бидний санаа сэтгэл, нөгөө агуу их тантрын ёсны бясалгалын ид шидийн хишиг хүртэгсэд лугаа адил шаналгаа амсана” гэж өгүүлжээ.

Энэхүү агуу их дад хүчнүүдийн нэгэнд зориулагдсан ном гэвэл “Бардо тойдол” юм. Сахил хүртэгсэд, эд материалын нууц үхлийн дүрээр нээгдэнэ. Тэрбээр дотоод чөлөөлөлтөндөө хүрэхийн тулд үхлийн зовлонг туулах ёстой. Тэрээр өнгөрсөн үе болон өөрийнхөө авралын төлөө түүнийг хийх ба үл гэгээрэгсдийн хүрээнд оруулахаас өрсөж зовлонгоос ангижрах ёстой. Амьдралын агшин бүрийг, бүр хамгийн сүүлийн агшинаа ч анхааралтай сэтгэж, үнэлж чадах тэр л хүн “Бардо тойдол”-ын дасгал үйлдэгчийн ариун удирдлагын лавлах бичиг, дотоод мэлмийн нээгч, зүйрлэшгүй зоригжуулагч болох ач холбогдлыг нь ойлгох боломжтой. Төвд хэлээр бичсэн, эртний ариун судруудын ач холбогдол үүнд оршино. Уг сударт удаа дараагийн бүх мандал буюу зөнч мэлмийтэй болох системийн буурь суурьтай зураглал агуулагдсан байдаг. Ийм учраас бид судалгааныхаа үндэс болгож “Бардо тойдол”-ыг авсан юм.

Дөрөвдүгээр бүлэг

“ХУМ”

“Эвлэн нэгдэх зам”

“Ум” ба “Хум” нь туршлагын нэмэлт үнэ цэнэ мэт

буюу метафизикийн билэгдэл мэт болох нь

Үй олон тодорхой зүйлүүдийн дунд төөрөхгүйн тулд бидний өгүүлж буй сэдвийн үндсэн онцлогыг байн байн эргэж харах хэрэгтэй. Бид тарнийн үгийн тухай үзэл санаа болон оюун ухааны аугаа хүч, язгуур, шууд туршлага бүхнийг өөртөө агуулсан, анхдагч авианы зарчмаас яриагаа эхэлсэн билээ. Эдгээр анхдагч авиануудын хамгийн эхний бөгөөд гол авиа нь “Ум” хэмээн үзэж, түүний гарал үүсэл, хэрэглэх байдлыг түүний оршин буй бүх түүхийн уртад судалсан билээ.

“Ум”-ыг бие сэтгэлээрээ туулах ахуйд, хүн өөрийгөө нээж, харанхуй үүрнээсээ гарч би хэмээх аминч үзлийн явцуу хүрээг эвдэн, өөрөө өөртөө буй болгосон хүрээ хязгаарыг тэлж, аврагдсан хамаг амьтан, сансар хорвоотой нэгдэн нийлдэг юм. Хэрэв хүн энэ байдалдаа хэвээр үлдсэн бол амьдарч, эргэцүүлэн бодож, жаргаж, зовж яваа хувь хүний хувьд оршихоо болих байсан. Тэрээр ухамсарын гадаад хувийн аминч бүтцийг бүрэн үгүй хийж, төгс тайвширан, хөдөлгөөн ба сэтгэлийн хөдлөлгүй болж, зөвхөн өөрийн дотоод сэтгэл төдийгүй, гаднаа, өөрөөр хэлбэл, зовж буй хамаг амьтаныг мэдэрч ойлгох боломжгүй болох байв.

Гэвч энэ үзэл санаа бидний өмнө, Буддагын өндөр дээд дүрээр зогсч байгаа бус уу? Тэгвэл чухам юу биднийг соронздох адил татна вэ? Бурхан багшийн амгалан дүр, түүний билгүүн ухаан, түүний оршин буй ахуйн нандин ертөнц үү? Энэ бүх чанар хамтдаа бидэнд нөлөөлж, тийм хүчирхэг, тийм их хүчээр өөртөө татаж байгаа бус уу? Гэвч эдгээр чанарын үнэ цэнэ хичнээн их байсан хэдий ч, Буддагын мөн чанарыг тайлбарлахад хангалтгүй юм. Тэдгээр нь Буддаг зөнч мэргэн юм уу, ариун гэгээн болгож чадах авч, төгс гэгээрсэн Бурхан багш болгож чадахгүй.

Түүнийг “төгс гэгээрсэн Бурхан”-ы зэрэгт чухам юу хүргэсэн бэ? гэвэл, түүний оршихуйн нийтлэг гэрэлтэй тал нь амьтан бүхний зүрхэнд тэдний зовлонг хуваалцах хязгааргүй их нигүүлсэхүйн чадвар нь түүнийг энэ зэрэгт хүргэсэн юм. Чухамхүү энэ л чадвар амьд бүхэнтэй дотоод холбоотой болоход тусалдаг юм. Тэрбээр бидний дотны мэргэн нөхөр, хайрт багш, хүн төрөлхтөний бүхий л алдааг биеэр туулан өнгөрүүлж,

улмаар сансарын эргүүлгэнд орж, улмаар түүнийг туулан гарсан учраас хэнд ч гэсэн төрсөн эх, эцгийн адил хандах болно.

Буддагын мөн чанар дахь энэхүү хүмүүнлэг тал нь түүний төгс боловсронгуйн хүршгүй өндрийг намсгаж, эгэл хүний амьдралаас асар их холдсон зайг товчилдог. Түүний хүрсэн түвшин нь угтаа түүний билгүүн ухаан адил өндөр бөгөөд түүний хүмүүнлэг дулаан сэтгэл, ухааных нь цар хүрээ бүхнийг хамран тэвэрсэн юм.

Бүхнийг хамран ариусгагч хүч “Ум”-аас тэр хүний хэмжигдхүүнт орчлонд эргэн ирж, ингэхдээ, төгс боловсронгуй ухамсар, хүн сансар хорвоогийн нэгдлийн тухай эрдмийг өгдөг юм. Тэр үед түүний зүрхэн тольтын бодьгалын анхдагч авиа сансар хорвоо болон хүний мөн чанар сүлжилдсэн авиа болж хувирдаг юм.

“Ум” нь ертөнцийн нийтлэгт тэмүүлэх бол, “Хум” нь энэ нийтлэг байдлаас хүний зүрхний гүн рүү буух тэмүүлэл юм. “Хум” нь “Ум” үгүйгээр байж болохгүй. “Хум” нь “Ум” -аас их юм. Энэ бол төгсгөлтөйд ч, төгсгөлгүйд ч уусч алга болдоггүй, аль нэг тийшээ туйлширдаггүй “Төв үзэл” юм.

Иймээс ч “зөвхөн ертөнцөд үйлчилдэг нь харанхуйд ирнэ. Тэр хоёрын аль алиныг нь хүлээн авч буй нь, харанхуйд илрэгчийг таньсанаараа, үхэлгүй мөнхийг олно.” / Иша упанишада /

“Ум” нь өөрийн тогтвортой чанараараа хувийн болон хэт хувийн ухамсарыг нэвт харж, аминч үзэл, “би” хэмээх хийсвэр хуурмаг үзэгдлээс ангид хоосон чанарын туйлын чанарт шилжинэ. Амьд бодис туйлын чанарт шилжих, орших нь хоосонд сэлэхийн адил бүтэшгүй зүйл бөгөөд учир нь ухамсарт амьдрал нь “Хум”- ыг ийнхүү туулах үед өөрчлөгдөн боловсордог. Энэ утгаар “Ум”-ыг нартай, “Хум”-ыг нарны туяа тусах газрын хөрстэй адилтган зүйрлэж болох юм.

“Ум” гэдэг нь “эс төгсөхүй”, “Хум” гэдэг нь “төгсөхүй доторх эс төгсөхүй юм. Тэдгээр нь цаг хугацааны мөнх нөхцөлд орших учраас, нөхцөлдөшгүй бүх хэлбэрийн үндсэн тодорхой хэлбэргүй орших учраас юмст байгаа хоосон чанарыг хоосонд байгаа юмсыг нээдэг юм.

“Юмсыг хэсэг бусаг, төгс бус элемент гэж үзэх нь хамгийн доод төвшиний аналитик мэдлэг юм. Туйлын чанар нь газар сайгүй байдаг. Түүнийг хаанаас ч олж харж болно. Төгсгөл бүхэн төгсгөлгүй бөгөөд өөрийн дотоод эс төгсөхүйд танигдаж мэдэгдэх ёстой. Гэвч, ертөнцийг ийм байдлаар ойлгож мэдэрч, бие сэтгэлээрээ туулахын тулд, зөвхөн оюун санааны ойлголттой байх нь хангалтгүй байна. Үүнд, зарим төрлийн үзмэрч чадвар, онцгой мэдрэмж, онгод хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, өөрийгөө ухамсарынхаа объектуудтай нэгтгэх хэрэгтэй.” / Sri. Aurobindo, 486 - р хуудас /

Ийм тэнгэрлэг чадвар нь, бидний дээд ухамсарын нийтлэг талыг бодьжуулсанаар л буй болно. Иймээс бид “Хум”-ын гүн ёроолд хүрч, түүнийг ойлгохын тулд “Хум” -ыг бие, сэтгэлээр туулах ёстой. Ийм ч учраас “Ум” эхэнд нь, “Хум” эцэст нь байдаг билээ. “ум” -д бид өөрийгөө нээж, “Хум” -д бид өөрийгөө өгдөг. “Ум” нь эрдмийн хаалга, “Хум” нь өргөлийн авиан дуу юм. Санскрит хэлний “Ху” гэдэг үг нь өргөл өгөх, өөрийгөө золиослох гэсэн утгатай үг юм. Бурхан багшийн сургаалд заасанаар, өөрөө өөрийгөө золиослох нь хамгийн ариун өглөг болдог.

Бярман минь тахилын шүтээн дээр чинь цуцлын мод тавихгүй би,

Галын цуцлыг гагцхүү өөрийнхөө дотроо асаана би,

Гал дүрэлзээд ирмэгц дээр нь өөрийнхөө “би” - г тавина.

Түүн дээрхи дөл - Энэ бол хөвөгч хүмүүний “би” буюу.

/ Самьютта Никайя /

“Хум” -ыг Бурхан багш энэ насандаа болон урд төрлүүддээ өөрийгөө үй олон удаа золиослосны гэрч болох газарт хүрэх дохио хэмээн билэгдсэн байдаг. Чухамхүү хамгийн дээд энэхүү өргөл муу муухайг ялж, түүний дагуул чөтгөр, шуламыг үлдэн хөөдөг.

“Хум” гэдэг авиаг айдас дуудлага занал зүхлийн илэрхийлэл гэж үзэх ёсгүй. Ийм өнгөц тайлбар өгөх нь мантрын практик уламжлалыг мэддэггүйн гай юм. Олон хийдийн номын сангуудаас мантрын үй олон томъёог олж болно. Өрнөдийн судлаачид тийм судруудыг үл хэрэгссэн нь харамсалтай. Хэрэв тэдгээрийг нарийвчлан судалсан бол “Хум” -ын хөгжил, бүтэц, дотоод хуулийнх нь тухай асар үнэтэй мэдээлэл олж болох байлаа.

Хэрэв “Хум” айлгаж заналхийлсэн чиглэлтэй байсан бол Дхьяны бурхан, Бодьсадва нарын “хилэнт” аймшигт дүр төрхийг илэрхийлсэн мантратай холбогдох байсан биз ээ. Гэтэл дээр дурьдсан, мантрын томьёонуудад үүнийг батлах ямар ч тохиолдол алга байна. Харин ч “Хум” нь амгалан тайван талын мантрануудтай холбоотой байна. Тухайлбал, “Ум ма ни бад мэ хум” бол үхлийн хорыг мөнхийн ус болгон хувиргахын тулд, ертөнцийн хамгийн доод ёроолд ч аймшиггүйгээр бууж ирэх цэцэн зүрхний эрхэм дээд илэрхийлэл юм.

Үнэн хэрэгтээ, Жанрайсаг нь эцэс төгсгөлгүй сүүлчийн сав ертөнц дэхь Эрлэг Номун хааны хэлбэрийг ч өөртөө агуулдаг бөгөөд Аугаа их амьдралын сүнснээс тасран гарах бидний үхлийн амьдралыг хайрын гэрлээрээ өөрчлөн хувиргаж, үхмэл хөшөнги “би” -г баримтлах байдлаас нь авран чөлөөлдөг билээ.

“Хум” гэдэг үгийн метафизик тал, түүнтэй холбоо бүхий хийсвэр зарчмуудыг авч үзэхийн өмнө, бид түүний дуудагдах билэг тэмдгийг сонирхон үзэх ёстой. Гэхдээ бид үг, ухагдхуунд шингээж байгаа бүхэн нь эцсийн цэг биш бөгөөд аажмаар ойртох үйл явц гэдгийг ойлгох ёстой.

“Хум” нь амьсгал гаргах “Х”, урт эгшиг “У”, хамрын “М” авиануудаас бүтнэ. “Х” авиа бол амьсгалын авиа, амьдралын жинхэнэ мөн чанарын, амьдралын нарийн хүчний авиа юм. Түүний анхдагч, хольцгүй цэвэр хэлбэр нь бүхнийг нэвтрэн урсгагч амьдралын хүч юм.

“У” авиа нь урагш тэмүүлэн сонсогдохгүй болтол дуурьсах, гүн чичиргээтэй эгшиг юм. “У” бол хүний дуу хоолойн хамгийн доод хязгаар нам гүний босго бөгөөд төвдөөр бол “Үл сонсогдохуйн үүд” юм.

“М” авиа нь дотогшоо чиглэсэн, дуурьсах авиа бөгөөд санскритээр “анусвара” гэдэг нэртэй эгшиг ч мөн, гийгүүлэгч ч мөн учраас энэ хоёрын салшгүй хослол болдог.

Ийм учраас тэр үсэг нь санскрит хэлэнд тэмдэглэгдгийн адил, төвд хэлэнд ч мөн адил дусал хэлбэрт ялгах тэмдгээр “цэг” эсвэл “таслал” -аар / санскрит: бинду, төвдөөр: тиг - ле / тэмдэглэгддэг ба өөрөөр хэлбэл, энэ нь нэгдэл нягтрал, бүрэн бүтэн байдал, туйлын

хоосон чанарыг үл зөрчих / акшара / -ийн билэгдлээр, эсвэл хоёрдмол чанарыг агуулагч дхармату мэтээр дүрслэгддэг. Тиймээс хэрвээ санскрит цагаан толгойн мантрын үсгийн мөн чанарыг тэмдэглэх хэрэгтэй болбол (Энэтхэгийн уламжлал ёсоор төвд судрын бичмэл адил Бурханы гарал үүсэл түүн дээр үндэслэсэн анусвара) түүн дээр бичигддэг. Жишээлбэл: зурган дээр, сэтгэхүйн төвүүд юмуу, эсвэл тус төв нь тодорхой ямар нэгэн “холбоо үе”- ээр илэрхийлэгдэх хүний биед агуулагдах хүрдүүд дүрслэгдсэн байх нь харагдана. Тэдгээр нь цэцгийн дэлбээ мэт Бадам цэцгийг тойрон хүрээлж байрлах ба түүний төвд гол чухал “холбоо үе” / тарнийн үсэг / нь илэрч тэр нь тодорхой нэг нэгжид, тэдний бүхий л байдалд, эсвэл билэгдлийн өнгөнд зохицон нийцсэн байдаг.

Индуйзм ба Буддизм дахь сэтгэхүйн

төвийн тухай сургаал

Сэтгэхүйн төвийн тухай сургаалын физиологийн үндэс нь Индуйст болон Буддист тантрад ижил байдаг боловч, Буддизмын системд энэхүү сургаалыг Индуйзмаас огт ондоогоор ашигладагыг мэдэх хэрэгтэй. Ийм учраас энэ хоёр системийг дур мэдэн хольж, Буддизмын практикийг Индуйзмын тантрын билэг тэмдэгтэй шууд адилтгаж болохгүй. Харамсалтай нь, энэ сэдвээр бичигдсэн бүх ном яг ингэж тайлбарласан байдаг билээ. Энэхүү үндсэн алдаанаас үүдэн, Буддизм өөрийн мөн чанарт огтхон ч таарахгүй зүйлийг авч, аажимдаа түүнийг өөрийн системд оруулсан мэт санагддаг юм.

Энэ хоёр системийн хоорондын гол ялгаа нь, үндсэн баримтыг өөр өөрөөр тайлбарладаг оршино. Өөр өөр зан авир, итгэл үнэмшилтэй хоёр аянчин явж өнгөрсөн нэг газрыг өөр өөрийнхөөрөө тайлбарлахдаа бодит баримтыг өөрчилж чаддаггүйн адилаар, Буддизмын болон Индуйзмын залгамжлагчид хүний оюун ухааны нэг л “баримт”- аас өөр өөр туршлага гаргадаг.

Индуйст систем, төвүүдийн тоон талыг голчилж, тэдгээрийг орчлонгийн үндсэн элемент болон хүчнүүдтэй адилтгадаг юм.

Буддист систем, төвүүдийн бодит тоон талыг төдийлөн анхааралгүй, харин тэдгээрээр дайран өнгөрөх урсгалуудад анхаарал төвлөрүүлдэг юм. Өөрөөр хэлбэл,

эдгээр урсгалын сансарын юмуу, байгалийн эрчим хүч нь оюун санааны чадавхи болон хувирахыг анхааралдаа авдаг. Үүний бүх арга нь Йога гэсэн ерөнхий нэрийн дор нэгдэнэ. “Йога” гэдэг бол ямагт нууц байдалд оршиж байсан үр дүнгүүдийн ердийн үүргээс урган гарсан, жам ёсны хөгжилд үндэслэсэн сэтгэцийн тусгай үйл явдлуудын систем юм. Анхдагч авиануудын мантрын билэг тэмдэг нь цагаан толгойн үсгийн дарааллаар байх учраас тодорхой төвтэй адилтгасан юмуу, түүнтэй бүрмөсөн нэгдсэн эрчим хүчний туйлширсан гүйдлээр төлөөлөгдсөн амьд урсгалд орсон юм.

Сэтгэхүйн ийм эрчим хүч хүний биед урсан орох сувгийг “нади” буюу төвдөөр, “рца” гэдэг юм. Тэдгээр нь мэдрэлийн системтэй адил биеийн үндсэн бүтцээр байрлах боловч, тэдгээрийг мэдрэлийн системтэй адилтгаж болохгүй. Гэвч, практикт яг ингэж адилтгах нь олонтаа гардаг. Үүнийг нотлох гэсэн бүх оролдлого нь “йогын” туршлагыг байгалийн ухаан, физиологи, анатоми болон туршилтын сэтгэлзүйн хэмжүүрээр хэмжиж болохгүй гэдгийг баталдаг юм.

Өрнөдийн үзэл баримтлалын дагуу, зөвхөн тархи л ухамсарыг агуулагч сав бөгөөд бидний тархины ухамсар нь зөвхөн ухамсарын боломжтой хэлбэрүүдийн нэг нь юмуу гэдгийг “йога”-ын туршлага нотолдог. Ухамсарын тэдгээр хэлбэр нь, үүрэг ба мөн чанараараа, биеийн янз бүрийн эрхтэнд байрлаж төвлөрсөн байдаг ба түүнийг эрчим хүчний төв буюу чакра гэдэг. Тэдгээрээс сэтгэхүйн эрчим хүчний хоёрдагч урсгал гарах бөгөөд тэднийг дугуйны хигээс юмуу, бадам цэцгийн дэлбээтэй адилтгаж болно.

Өөрөөр хэлбэл, чакра нь сэтгэхүйн үүрэг болон эрчим хүч хамтдаа байх юмуу, нэг нь нөгөөдөө нэвтэрч байдаг цэгүүд юм. Энэ бол сэтгэхүйн болон сансарын эрчим хүч, биеийн талстжих махбодын чанар, сэтгэхүйн хүч болон хувирдаг цэгүүд юм.

“Дотоод, гадаад хоёр ертөнц уулзах газарт санаа байрлана. Гадаад, дотоод хоёр ертөнц бие биедээ нэвтрэхэд, санаа тэдгээрийн шүргэх цэг бүхэнд оршино.” / Новалис /

Иймээс санааны нэвтрэхүйг хүлээн зөвшөөрч байгаа сэтгэхүйн аль ч төв нь адилхан санааны байрлах газар болж, эдгээр төвүүдийн идэвхийг сэргээснээр, бид бие махбодоо амилуулан өөрчилж байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор, Новалисын өөр нэг үгийг дурьдаж болно. “Эрхтэнүүдийг идэвхтэй ашиглах нь увидасын хүчээр ажиллагч санаа юм” гэсэн тойм утгаар ойлгож болохгүй. Энд ярьж байгаа сэтгэхүй бол бүтээлч үйл ажиллагааг хэлж байна. “Сэтгэхүй бол үйл юм” гэх нь увидасын болон мантрын ухааны үндсэн зарчим юм. Бүтээл, санаа, ойлголт, үзэл санаа нь хэмнэлтэйгээр давтсанаар, тэдгээрийн үйлчлэл хүчтэй болон тогтворждог.

“Бид илэрхийлэхдээ бүтээж чадах хэмжээгээр л мэдэж байна. Өөрөөр хэлбэл, бид ямар нэг юмыг хэдийчинээ боловсронгуй бүтээж чадна, тэр хэмжээгээр л мэдэж байна гэсэн үг. Хүн ямар ч үед, ямар ч аргаар хамаагүй бүтээж, бусдад түүнийгээ илэрхийлж чадаж байвал, тэр зүйлийг бүрэн төгс мэдэж байна гэсэн үг.”

Тантрын “йог”-ын агуу их нууц нь янз бүрийн төвшинд болон боломжтой бол бие сэтгэхүйн бүхий л төвд хэрэгждэгт оршино. Зөвхөн олон замын ухаарлын замаар бидний мэдлэг, тэрхүү гүнд буюу өргөн цар хүрээнд хүрэх бөгөөд урьд нь өнгөц, хуурамчхан ухамсарлаж байсан байж болох зүйлсийг дотоод сэтгэлдээ болон цаг тухайн чухал зүйлсэд өөрчлөн хувиргаж болох юм. Гурван хэмжүүрт алсаас дүрслэх дүрслэлд нэг газрын хоёр дүрслэлийг янз бүрийн зураасаар хөнгөхөн таталбарлах байдлаар холбож, бодит байдалд тун ойролцоо дүрслэл бий болгож болдогийн адил, оршин тогтнохуйн дээд хэмжүүр нь нэгдэл нягтралын замаар нэг зорилгод хүргэдэг бөгөөд тэдгээрийг ухамсарын янз бүрийн төвүүдээр болон түвшингээр амьдралд хэрэгжүүлдэг. Эндээс гурван хэмжүүрт ухамсарын түвшинд хийгддэг бясалгалын нилээд хэдэн суултыг тодорхойлон өгүүлэх аргагүй болдог бөгөөд учир нь сэтгэхүйн үйл явцад нэмэлт хязгаарлалт тавьж, аливааг илэрхийлэх боломжийг багасгадаг учир зүйн тогтолцооны хүрээнд явагдаж байгаа юм.

Бид сэтгэхүйдээ бүтээж буй ертөнц бол бидний алдаатай төсөөллийн ертөнцтэй адил хэмээн үзэх нь, ертөнцийн тухай бидний алдаатай төсөөллийн гол эх булаг юм. Бидний туршлагаасаа мэдэж буй ертөнц бол бидний сэтгэхүйн ертөнцийг багтааж байдаг. Учир нь бид янз бүрийн хэмжүүрт нэгэн зэрэг оршиж байгаа бөгөөд эдгээр хэмжүүрээс оюун ухаан, өөрөөр хэлбэл, логик сэтгэлгээний чадвар нь олон хэмжүүрээс зөвхөн нэгийг нь

төлөөлж байгаа юм. Хэрэв бид мөн чанараараа өөр хэмжүүрт хамаарах мэдрэмжийг оюун ухаанаараа бүтээхийг оролдвол, хоёр хэмжүүрт гадаргууд гурван хэмжүүрт объект юмуу, орон зайг дүрслэхийг оролдсон зураачтай адил болно. Тэр зураач илүү өндөр төвшний хэмжүүрт хамаарах тодорхой чанаруудыг үл хэрэгсэн тоотой хэдэн техник арга хэрэгслээр дүрслэхийг оролджээ.

Энэхүү дүрслэлийн хууль нь логикийн хуульд олон талаар нийцнэ. Тус хоёр хуулийн аль аль нь илүү өндөр түвшний хэмжүүрийг золиослон дур зоргоороо сонгосон харааны цэгээр хязгаарлагдаж байна. Учир нь тэдний харж буй объект зөвхөн нэг талаасаа тодорхой хугацаанд харагдах бөгөөд дүрслэл нь ажиглагчийн харьцангуй байрлалд зохицно. Тэгвэл зураач өөрийн сэтгэгдлийг нэг хэмжүүрээс нөгөөд ухамсартайгаар шилжүүлэхдээ жинхэнэ бодит байдлыг дуурайхыг ч оролдохгүй, зөвхөн түүнд хандах өөрийн хандлагыг л илрүүлдгийн адилаар философич хүн бодит байдлыг өөрийн санаагаар шүүрч авах гэсэн хий үзэгдлийн золиос болно.

Дүрслэх урлагт дүрслэлийг ашиглахын адилаар логик, сэтгэхүйг ашиглах нь маш чухал, зөв зүйтэй боловч аль нэг зүйлийг илэрхийлэх хэрэгсэл болохоос бус, бодит байдлын шалгуур биш ээ. Иймээс бид боломжийнхоо хэрээр логик тодорхойлолтыг ашиглах гэвэл, тэдгээрийг зөвхөн ухамсарын янз бүрийн хэмжүүрийг ойлгоход дөхөм болох хэрэгсэл гэж үзэх ёстой.

Огторгуй ба хөдөлгөөний зарчмууд

Эртний Энэтхэгийн уламжлалаар бол, орчлонт ертөнц нь хөдөлгөөн ба орон зай гэсэн, үндсэн хоёр чанараар өөрийгөө нээдэг. Хөдөлгөөний буй орон зайг акаша / төвдөөр: намхай, монголоор огторгуй / гэнэ. Түүний ачаар юмс нүдэнд харагдах үзэгдлийн хүрээнд ордог. Өөрөөр хэлбэл, юмс нь орон зайд үргэлжлэх, орших чанарыг олно. “Акаша” нь бүх юмсыг агуулагчийн хувьд, бидний мэдрэмжийн гурван хэмжүүрт орон зайд нийцэх бөгөөд энэ түвшинд “маха - акаша” буюу “их огторгуй” гэж нэрлэгдэнэ. Гэвч акашагын мөн чанар энэхүү гурван хэмжүүрээр шавхагдашгүй бөгөөд хөдөлгөөний бүх боломжийг агуулна.

Оюун санааны хүрээнд “акаша” нь “ухамсарын орон зай ба ухамсарын хэмжүүрт “читта - акаша” гэж нэрлэгдэнэ. Объект, субъектийн хоёрдмол чанар үгүй болдог, оюун санааны туршлагын дээд түвшинд “чида - акаша” гэж нэрлэгдэнэ.

“Акаша” гэдэг үг нь “каш” / гэрэл цацарсан / гэсэн үгнээс үүсэлтэй. Ийм учраас хөдөлгөөний зууч гэж ойлгогддог ба “эфир” / хий / гэсэн давхар утга бас илэрхийлнэ. Гэвч, хөдөлгөөний зарчим бол прана / төвдөөр: жуг /, амьдралын амьсгал бүхнээс хүчтэй, бүхнийг нэвтлэгч орчлонгийн хэмнэл юм. Ертөнц хорвоогийн бүтэх ба сөнөх нь, хүн амьсгал авах гарахын адилаар ар араасаа даган ээлжлэх бөгөөд нар, гаригсийн хөдөлгөөн, хүний бие дэхь цусны эргэлт, сэтгэхүйн эрчим хүчний уналт, бөхөлт адил үүрэг гүйцэтгэнэ. Орчлонгийн бүх хүчин хүний ухааны хүчний адилаар пранагын хувилсан дүр юм. Ийм ч учраас прана гэдэг үгийг амьсгалтай зүйрлэж болно. Гэхдээ “амьсгал” бол пранагын олон үүргийн зөвхөн нэг нь билээ.

Дээд агуулгаар нь акаша, прана хоёрыг зааглаж болох боловч, энэ хоёр нь бие биендээ дээд, доод, баруун, зүүн гэдгийн адилаар, учир шалтгааны холбоотой юм.

Орон зайд илрэлээ олсон бүх зүйл үргэлжлэтэй болж , акашагын мөн чанараар нээгддэг. Тийм ч учраас дөрвөн их элемент буюу хатуу / шороо / , шингэн / ус / , халуун / гал / , агаар / хий / нь акашагын хувилбар, огторгуй, хийн хувилбар юм.

Өөрчлөлт, эсвэл өөрчлөн байгуулалт зэрэг хөдөлгөөн шаардсан, бүх хөдөлгөөнт чанарууд нь бүгд пранагын мөн чанарыг нээн харуулдаг. Бүх материаллаг болон сэтгэхүйн үйл явдлууд, амьсгалын, цусны эргэлтийн, мэдрэлийн тогтолцооны нэгжүүдээс ухамсарын, сэтгэхүйн идэвхжилийн нэгжүүд хүртэлх бүх биеийн болон сэтгэл санааны эрчим хүчнүүд нь пранагын өөрчлөлт хувиралтууд юм.

“Акаша” нь хамгийн бүдүүлэг хэлбэрээрээ матери, хамгийн нарийн хэлбэрээрээ тогтвортой эрчим хүчний салбарт аажим шилждэг. Гал буюу шатах байдал нь хэдийчинээ эрчимтэй бол, төдийчинээ материаллаг байна. Нөгөө талаас, прана нь амьсгалах, хоол боловсруулах зэрэг биеийн болон сэтгэхүйн халууны / төвдөөр: тум - мо / материаллаг онцлогоор илэрдэг.

Тийм учраас, бие махбод, ухаан хоёр, матери, ухамсар хоёр, мэдрэх эрхтэн, мэдрэмжийн харилцан холбоо зэргийг ашигласны үндсэн дээр анхаарал төвлөрүүлэх бясалгалын техник үндэслэгддэг юм. “Энэтхэгчүүдийн үздэгчлэн, бие махбод бол хүний мөн чанар жинхэнэ хуулиудыг хэрэгжүүлэхэд зориулагдсан багаж бөгөөд бие махбодын амьдралыг өчүүхэн төдий ч үл хэрэгсвэл, биднийг Бурханаас зайлшгүй холдуулна. Иймээс бие махбодыг эс анхаарч, оюун ухааныг төгс боловсронгуй болгоход махбодын гүйцэтгэх үүргийг үл тоомсорлосон йогч хүн юу ч хийж чадахгүй.” / Sri. Aurobindo, 10 - р хуудас /

Хүний бие дэх сансарын төвүүд болон тэдгээрийн эрхтэнүүд нь, “акаша”-гын хувилбарууд юм. Өөрөөр хэлбэл, агуу их анхдагч элементүүд бөгөөд тэдгээрээр дайран өнгөрөгч, эрчмийн пранагын хувилбар юм.

Эрчмийн доод дөрвөн төв нь дороос дээш өгсөх дарааллаар байрласан элемент болох шороо, ус, гал, хий гэсэн акашагын талуудтай нийцнэ.

Энэхүү төвүүдээс хамгийн доор байрлах Шорооны нэгж (хүрд) нь асуух нурууны эцэст байрлах бөгөөд энэ нь өрнөдийн анагаах ухаанд томьёолсноор аарцагны мэдрэлийн сүлжээнд хамаарч амьдралын анхдагч эрчим хүчийг үл авах чанарыг агуулах ба биеийн нөхөн үйлдвэрлэл буюу шинэчлэлтийн үүргийг, оюун санааны чадварт гүйцэтгэдэг юм.

Эдгээр төвийн талд эрчим нь, нойрсож буй Кундалины дүрээр дүрслэгддэг. Тус эрчмийг эзэмшсэн Билгүүн ухаантан бээр, түүний тусламжаар оюун ухааны хамгийн дээд төгс чадлыг олох бөгөөд үүнийг мэдэхгүй хүмүүс түүний хөнөөлт үйлэнд өртөнө.

Өчүүхэн атомд агуулагдсан анхдагч эрчмийг, хүн төрөлхтөний сайн сайханд ч ашиглаж болох төдийгүй, хүн төрөлхтөнийг устгахад ч ашиглаж болохын адилаар, хүний бие дэх зүүрмэглэж буй өчүүхэн эрчмээр, өөрийгөө авран чөлөөлж ч болно, аюулт гав гинжээр хүлэн боолчилж ч болно. Гагцхүү тухайн эрчмийн мөн чанарыг нарийн тодорхой мэдэж, өөрөө өөрийгөө бүрэн хянаж чадсан йогч хүн, түүнийг ашиглан эзэмшиж чадна. Иймээс энэхүү эрчмийг сэргээх ба түүний зааврыг шашны ном сударт тэмдэглэхдээ, зөвхөн зохих ёсны их мэдлэгтэй багш л олон зуун жилийн бясалгалын туршлагыг

багтаасан судар ном, ёс горим журмын дагуу хэрэглэж чадна хэмээн тайлбарласан байдаг юм.

Зөвхөн цөөн тооны хүнд л ойлгомжтой хэл яриаг ашиглах талаар, хэд хэдэн нууц сургаалаар бүрхэгдсэн далдын халхавч нь, оюун ухааны суурьтай байж, тийм хүч чадал болон мэдлэг чадвартай хүмүүст саад болох бус, харин харанхуй бүдүүлэг хүмүүст тэдэнд заналхийлж буй аюулаас аврахад чиглэгдэнэ. Тантрын бясалгалын Буддист тогтолцоо нь уг аюулаас зугтаж, бясалгагч нь шактид өөрчлөн хувиргагч ухамсарын тэрхүү чанар руу болон сэтгэхүйн тэр төвүүд рүү төвлөрөхийг зөвлөдөг.

Бид Буддизмд шактигын оронд “Дагина”-ыг, эрчим хүчний зарчмын оронд билгүүний зарчмыг, байгалийн хүчний оронд нэгдэл нягтрал руу хөтлөгч урам зоригийн хүчийг тус тус тооцон үздэг билээ. / Бид энэхүү сэдвээр 13-р бүлэгт эргэж ярих болно. /

Кундалин йогийн сэтгэхүйн төвүүд,

түүний физиологийн талууд

“Язгуур төв” буюу “Муладхара-чакра” нь “Шороо”-н элементийг төлөөлдөг бол, түүний дээрх төв нь “Усан” элементийг төлөөлөх бөгөөд “Свадхистхана - чакра” гэж нэрлэгдэнэ.

Төвдийн анхаарал төвлөрүүлэх бясалгалын системд, энэхүү төвийг дурьддаггүй бөгөөд бие даасан төв гэж үздэггүй. Энэ төв “нандин газар” / төвдөөр: санг-гнас / хэмээх ерөнхий төвд Муладхара чакратай нийлнэ. Нандин газар нь бэлгийн хүчин түүний дагалдах чанарууд төвлөрсөн хэсгийг бүхэлд нь хянадаг. Хоол боловсруулах организмыг тэжээх системтэй холбоотой “Свадхистхана чакра” нь организмаас ялгарах ёстой зүйлийг ижилсүүлэх үүрэгтэй.

Энэ нь, дараачийн дээд төв болох “Нарны зангилаа” буюу “Манипура чакра”-тай холбогдоно. Тус чакра нь “Гал” махбодыг төлөөлөх бөгөөд махбодын болон сэтгэхүйн утгаар / хоол боловсруулах, ижилсэх, органик бус субстанцууд органик болон хувирах, органик субстанцууд сэтгэхүйн эрчим болж хувирах / өөрчлөлтийн хүчнүүдийг төлөөлнө.

Зүрхний төвийг “Анахата-чакра” гэх бөгөөд хий махбодыг төлөөлнө. Энэ төв нь хүний зүрхтэй заавал адил байх албагүй төдийгүй амьсгалын эрхтэнийг зүрхтэй холбогдох хэмжээгээр зохицуулан хянадаг. Уг төвийг бүх биеийн төв тэнхлэгт босоо байрласан хэмээн үздэг.

Дээд гурван төвд, хоолойн төв буюу “Вишуддха - чакра”, хөмсөгний төв буюу “Ажня - чакра”, магнайн төв буюу “Схасрара-чакра / мянган дэлбээт бадам цэцэг / орно.

Энэ гурван төв нь, бүдүүлэг элементүүдийн хүрээнээс хальсан, акашагын хэлбэрүүдтэй нийцэх бөгөөд орон зайн илүү дээд хэмжүүрийг төлөөлнө. Энэ орон зайн чанар гэрлийн чанартай адил болж, сансрын ухамсарын хүрээнд пранагын сэтгэхүйн эрчмийн байдалд уусна. Доод хоёр төв нэг болж нэгддэгийн адил, дээд хоёр төв нь Төвдийн йогын системд нэгэн бүхэл зүйл хэмээн үздэг. “Ажня - чакра” нь Төвдийн ном сударт, бараг дурьдагддаггүй ба мянган дэлбээт Бадам цэцгийн нэг хэсэг хэмээн үздэг. / Төвдөөр: даб - стонг /

Хүний биеийн энэ долоон төв нь, зарим утгаараа орчлонгийн хамгийн энгийн бүтцийг төлөөлдөг/ Өөрөөр хэлбэл, дээд зэргийн нягтармал, материалаг байдлаас, материалаг бус олон хэмжүүрт байдалд хүртэл, аугаа их анхдагч хүчийг агуулагч далд ухамсарын харанхуйгаас, гялалзан гэгээрсэн ухамсарын хүч хүртэл /. Бүх орчлон ертөнцийн хүч чадлын хэлбэрүүд нь энэхүү төвүүдэд нуугдаж байдаг бөгөөд тэдгээрт санскрит цагаан толгойн бүх авианууд, үет тарнийн хэлбэрээр өгөгдсөн байдаг.

Энэхүү сэтгэхүйн төвүүд нь тус тусдаа, бадам цэцгийн цоморлиг мэтээр дүрслэгдэх буюу тодорхой нэгэн чанар юмуу хүчийг илэрхийлэгч хөрөнгө үсгүүдэд / санскрит, биджа / цэцгийн дэлбээнүүд нь хамаарах бөгөөд харин төв нь тэрхүү нэгжийн билэгдлийг агуулдаг. Хөрөнгө үсгийн нэгж тус бүр яг түүний эзэмдэгч / санскрит, вахана / мэтээр амьтдын билэгдэлтэй холбоотой бөгөөд түүний тусламжаар тус нэгж нь тодорхойлогдоно.

“Язгуур төв” болох Муладхара чакраг Вам, Шам, Щам, Сам гэсэн үет тарниудтай, дөрвөн дэлбээт цэцгээр илэрхийлдэг. Түүний төвд “Лам” үет тарниутай, шар дөрвөлжин

байх бөгөөд нэгжийн билэгдэл нь “Шороо” юм. Түүний эзэгнэгч нь, / вахана / Индра Айраватын долоон хошуутай заан ажээ.

Дараачийн төв буюу Свадхистхана - чакраг Бам, Бхам, Мам, Йам, Рам, Лам гэсэн үет тарниудтай, зургаан дэлбээт бадам цэцгээр үзүүлсэн байдаг. Түүний төвд нь “Вам” гэсэн үндсэн үет тарнитай, хагас дугуй буюу “сар” байх бөгөөд нэгжийн билэгдэл нь “Ус” юм. Түүнийг эзэгнэгч нь “матар” / санск, макара / билээ.

Манипура - чакраг Дам, Дхам, Нгам, Там, Тхам, Дам, Дхам, Нам, Пам, Пхам гэсэн үет тарниудтай, арван дэлбээт бадам цэцгээр илэрхийлсэн байдаг. Түүний төвд нь “Рам” гэсэн үндсэн үет тарнитай, орой нь доош чиглэсэн улаан гурвалжин байх бөгөөд нэгжийн билэгдэл нь “Гал” юм.

“Зүрхний төв” буюу Анахата - чакраг, Кам, Кхам, Гам, Гхам, Нам, Чам, Чхам Жам, Жхам, Ньям, Там, Тхам гэсэн үет тарниудтай, арван хоёр дэлбээт бадам цэцгээр үзүүлдэг. Түүний төвд нь “Йам” гэсэн үет тарнитай, цэнхэр саарал өнгөтэй зургаан өнцөгт байх бөгөөд нэгжийн билэгдэл нь “Хий” юм. Түүний онцгой шинж чанар нь хөдөлгөөнт байдал, эзэгнэгч нь “марал гөрөөс” бөгөөд тэрээр хурдны билэгдэл юм.

Эдгээр дөрвөн төвүүд нь дөрвөн догшин ширүүн нэгжийг билэгдэх ба тэдгээрт санскрит цагаан толгойн бүх гийгүүлэгч агуулагддаг. Доороосоо дээшлэх тусам, төвүүдэд ялгавар улам улам ихээр нэмэгдэж, цэцгийн дэлбээний тоо нь өсөн үржиж байгааг бид ажигласан билээ. Өөрөөр хэлбэл, энэ нь ухамсарын харьцангуй өндөр хэм хэмжүүрт хамаарах доргилтын болон идэвхжилийн харьцангуй өндөр түвшин юм. Энд харьцангуй ялгаварт бус, далд ухамсарын байдлаас, бүхэлдээ дэлгэрсэн “мянган дэлбээт бадам цэцгээр” билэгдэгч ялгаварт ухамсар хүртэлх хөгжил дэвшил харагдаж байна.

“Хоолойн төв”, “Вишудхи” чакра нь ярианы чадвар болон тарнийг дуудах хүч буй болдог төв бөгөөд өөрийн арван зургаан дэлбээндээ санскрит цагаан толгойн бүх эгшгийг агуулдаг юм. Энэхүү төв нь орон зайн / огторгуйн / чанартай буюу “эфир” буюу “хий” гэгч нарийн нэгжтэй, авианы буюу доргиат тархацын зуучтай холбогддог байна. Түүний үндсэн үет тарни “Хам” нь гурвалжингийн оройд тулж байрласан цагаан өнгийн

хавтгай дугариг дээр дүрслэгдсэн байдаг. Түүнийг эзэмшигч нь зургаан соёотой цагаан заан юм.

“Ажня” чакра нь зөвхөн хоёр дэлбээтэй бөгөөд Хам, Кщам гэсэн үет тарниудтай. Түүний төвд үндсэн үет богино, эсвэл хагас “А” байдаг. Бид энэхүү үсэгний талаар дараа эргэж ярих болно.

“Магнайн төвд” гол үет тарни “Ум” байдаг. Түүний мянган дэлбээ нь төгсгөлгүйг билэгдэх бөгөөд өөртөө бүх авиаг болон бүх чакруудын үет тарниудыг агуулдаг учраас өмнөх зургаан төвийг бодвол харьцангуй дээд түвшинд хамаардаг юм. Ийм ч учраас “чакра” гэгч нэр томъёог явцуу утгаар нь зөвхөн түүнд л хэрэглэдэг. Эндээс Артур Аволоны орчуулсан санскрит эх бичиг “Шатча - кранирупана” / “Зургаан төвийг тодорхойлсон тэмдэглэл” / гэгч алдарт өгүүллэгийн нэр буй болсон юм. Чухамдаа энэхүү тэмдэглэл нь, тантрын Индуйст уламжлал дээр үндэслэгдсэн байсан билээ.

Сэтгэхүйн эрчим хүчний тухай сургаал

ба “таван бүрхэвч” / коша /

Үл үзэгдэх суваг буюу хүний биед эргэж байгаа эрчим хүчийг дамжуулагч нарийн судсуудыг “нади” / төвдөөр: рЦа / хэмээн нэрлэдэг.

Түүнийг орчуулбал, нерв, вена, артери / судас / болох учир буруу ойлгохгүйн тулд орчуулахгүй байх нь зөв юм. Йогийн нууцат анатоми, физиологи нь шинжлэх ухааны биет судалгаанд биш, субъектив - дотоод мэдрэмжийн судалгаанд үндэслэдэг. Өөрөөр хэлбэл, хүн амьтны организмын үүргийг гадна талаас нь судлах юмуу, үхдэлийн цогцсыг задалж судлахад бус, өөрийнхөө хүчин чадлыг ажиглаж, аливаа үйл явдлыг шууд бие, сэтгэлээр туулан, биеийн дотооддоо мэдрэх замаар судалдаг юм.

Мэдрэлийн системийг юмуу, цусны эргэлтийг нээх нь огт өөр эринд хамаарах ба “нади” гэдэг үгийг Энэтхэгийн анагаах ухаанд мэдрэлийн болон цусны судсуудыг тодорхойлоход хэрэглэдэг байсан, йогийн нэр томъёоны анхдагч утгыг тэдгээрийн физиологи ойлголтоор солихыг зөвтгөж байгаа юм.

Пранаямын / хий гүйлгэх / тухай бичсэн хүмүүс тухайн тэр эрчим байнга өөрчлөгдөж байх төдийгүй, урсгалаа зогсоохгүйгээр янз бүрийн дамжуулагч ашиглах чадвартайг олж хараагүй юм. Цахилгаан гүйдэл нь төмөр, ус, мөнгөөр гүйж чадах төдийгүй, хүчдэл хангалттай хэмжээнд өндөр байвал, эсвэл радио долгион хэлбэрээр тарахдаа ямар ч дамжуулагч шаарддаггүйн адилаар хэрэглэж болохоос гадна хангалттай дамжуулагчгүйгээр хязгааргүй орон зайд үйлчлүүлж болно. Ийм ч учраас пранаг амьсгалын тогтолцооны зуучийн хэмжээнд ашиглаж болох ба / мэдрэлийн ба цусны гүйдлийн / амьдралын эрчим хүчнээс илүү өргөн ойлголт юм. Тэр нь сэтгэлгээний чадвар, оюун ухааны юмуу, сэтгэл зоригийн хүчнээс илүү юм. Дээр дурьдсан зүйлүүд нь пранагын зөвхөн зарим хувилбарууд юм. Чакра бол акашагын / “огторгуй” махбодын / хувилбар гэж бид үзсэн билээ.

Нади нь мэдрэлийн болон цусны судлуудтай зарим үед адилхан боловч, тэдгээртэй яг адилгүй юм. Харин чакрууд өөртэйгөө холбоо бүхий эрхтэнүүдтэй харьцахын адилаар, мэдрэлийн болон цусны судлуудтай харьцдаг.

Өөрөөр хэлбэл, бид энд бие махбодын, сэтгэхүйн, оюун ухааны / бие, хэл, сэтгэл / үүргийг зэрэгцүүлэхтэй тулгарч байна. Энэхүү зэрэгцэл нь хүний ухамсарын таван бүрхэвчийн тухай сургаалд тодорхой байна. Уг таван бүрхэвч нь нягтарч бидний бие махбодын дотоод төвийн эргэн тойронд талст үүсгэдэг.

Буддизмын сэтгэлзүйд зааснаар, энэ төв нь бидний дотоод бүх эрчим хүчтэй нийцдэг харилцааны рациональ бус цэг юм. Гэхдээ өөрөө аливаа тодорхойлолтын гадна оршино. Хамгийн нягт бөгөөд гадна талын бүрхэвч нь, бие буюу “аннамайя - коша” юм. Дараачийн бүрхэвч нь, нарийн материд хамаарах, пранагаас бүрдсэн бүрхүүл бөгөөд хүний бүх биеийг нэвтрэн амьсгалаар тэжээгддэг. Үүнийг прана юм уу, эфирийн / хийн / бие “пранамайя - коша” гэж болно. Дараачийн илүү нарийн бүрхэвч нь, бидний санааны илрэл, идэвхтэй санаагаар үүссэн “бие хүн” юм. Дөрөв дэхь бүрхэвч нь, бидний санааны гадна орших потенциал “маномайя - коша” бөгөөд энэ нь ухамсарын бие юм. Уг бүрхэвч хүний оюун ухааны чадварыг бүхэлд нь хамардаг.

Сүүлчийн бөгөөд хамгийн нарийн бүрхэвч бол өмнөх бүрхэвчийг нэвтэлсэн, дээд ерөнхий ухамсарын биелэл бөгөөд эрхэм дээд баяраар тэжээгддэг. Энэ нь зөвхөн анхаарал төвлөрүүлэх бясалгалын үед л илэрдэг.

Эдгээр бүрхэвч нь хатуу цөмийн гадуур талстжсан давхаргын адил, бие биеэс “салахгүй”, харин ч харилцан нэвтрэн барилдагч эрчим хүч юм. Арай бүдүүн бүрхэвчийг, түүнээс арай нарийн бүрхэвч нь нэвтрэн дэмжиж байдаг.

Материалаг бие нь хоол тэжээлээр тэжээгдэж, пранагын амьдралын хүчээр тэтгэгддэг бол оюун санааны биелэлийн идэвхтэй ухамсар пранагын биеийг нэвтлэн биеийн илрэх хэлбэрүүдийг тодорхойлдог. Үүний зэрэгцээ амьсгалын бие нь өнгөрсөн туршлагын илүү гүнзгий ухамсараар нэвтрэн хөдөлгөөнд ордог юм. Түүнд бидний санаа ургуулан бодохуй биелэлээ олсон, төгсгөлгүй материал байдаг юм. Түүнийг “гүний ухамсар” хэмээн нэрлэнэ.

Анхаарал төвлөрөлтийн дээд төвшинд, эдгээр ухамсарын болон гүн ухамсарын нарийн материалаг амьдралын болон биеийн үүргүүд урам орон сэргэж, оюун санааны баярын дөлөнд автаж, түүнд далд ухамсарын ерөнхий чанар илэрдэг. Энэ бол “дотоод галын йога” / төвдөөр: тум - мо / орших үндэс юм.

Ийм урам зоригоос төрсөн, таван бүрхэвчийг нэвтлэн, бүх эрхтэн чадварыг нэгэн бүхэл болгосон оюуны ганцхан бие оршдог.

Нэгдэн нийлэх, үүсэн бүрдэх, төгс боловсрох энэхүү үйл явцад мөнхрөхийн нууц оршин, энэхүү төгс сайнд / нэгдмэл чанар - ариусалд / хүрээгүй цагтаа бид өөрсдийгөө бага үнэт зүйлстэй, эсвэл зарим хэсгийг үзэх төлөвтэй адилтгадаг бөгөөд материйн болон үхэгсдийн ертөнцийн хуулийн хараат байдалд оршдог билээ.

Гэвч бие нь, өөрийн мөн чанараараа хамгийн явцуу буюу биет юмс руу нэвтэрч чадахгүй ч, тэр нь бусад бодис юмсаар өөрийгөө бүхэлд нь хүрээлүүлэн, сэтгэл санааны бүх зорилго болон үйлсэд зүй ёсны гишгүүр болж байдаг учраас бие бялдрын ач холбогдол “стхула - шарира” буюу үнэ цэнийг алдаатай үнэлэхгүй байх байсан биз. Бие - энэ бол “Сэтгэц сансар” - ын жүжгийг шуналтайяа тоглосоор байдаг Тэнгэр ба Газрын хоорондох

тайз билээ. Санваартнуудын хувьд бие нь хэмжээлшгүй гүн гүнзгий шашны жүжгийн оршин байх ариун газар нь болдог. Иймээс мэдлэг, тодруулбал, энэхүү биеийн ухамсарт туршлага нь йогич хүний хувьд болон бясалгалын замд эхлэн орж буй хэний ч хувьд тийм агуу их чухал үүргийг гүйцэтгэдэг байна. Мөн бие нь пранагын урам зоригийг төгөлдөр болгоход хамгийн хялбар хэлбэрт тооцогдох амьсгалын дасгал хийх явдал ухамсарт зэмсэг нь болдог юм.

б. Пранагын биеийн болон сэтгэхүйн үүрэг

ба хөдөлгөөний зарчим / Вайю /

Амьсгалыг ажиглах нь анхаарал төвлөрөлтийн үндсийг бүрдүүлдэг тухай, эртний пали суаруудад өгүүлсэн байдаг. “Мажхима - никайя” судрын 118 -р ярианд, Буддагын хэлсэнээр бол, энэ нь амьсгал авах, гаргахыг ухамсартайгаар ажиглахад оршино. Амьсгал нь анхаарал төвлөрүүлэх дөрвөн үндэс / сати - паттхана / , гэгээрлийн долоон хүчин зүйл / самбохжанга / эцэстээ төгс эрдэм - аврагдах эрх чөлөөг нээдэг юм.

Энэхүү өгүүлэлд бясалгаж буй хүнийг эзгүй хээр аглаг газарт анхаарал төвлөрүүлэх уламжлалт байрлалуудаар суулгах ба ухамсартайгаар амьсгал авч байна гэж ухамсарлуулна.

“Амьсгалаа уртаар гаргахдаа, “би амьсгалаа уртаар гаргаж байна” гэж ухамсарлана. Амьсгалаа богиноор гаргахдаа, “би амьсгалаа богиноор гаргаж байна” хэмээн ухамсарлана.”

Энэ бол эхний шат бөгөөд амьсгалын процессыг ердийн маягаар тухайлбал аль нэг зүйлийн тухай юу ч бодохгүйгээр амьсгалын ердийн үүргийг зөрчихгүйгээр ажиглаж байгаа хэрэг юм. Ингэснээр амьсгал ухамсартай үйлдэл болж, амьсгалын эрхтэнүүдийг бүхэлд нь ухамсарлана.

Хэрэв бидний зорилго амьсгалын процессыг шинэчлэхэд оршиж байгаа бол, энэ шатанд уг дасгал дуусч байгаа хэрэг тэр юм. Гэвч, энэхүү дасгалын зорилго бол огт өөр бөгөөд биеийнхээ нэгдмэл бүтэн байдлыг мэдрэх явдал юм.

“Би амьсгал авахдаа бүх биеэ / сабба - кайя / мэдэрч байна”, “Амьсгал гаргахдаа бүх биеэ мэдэрч байна” гэж бясалгаж буй хүн өөрөө өөртөө итгүүлнэ. Бүх бие гэдэг томьёо “амьсгалын биед” / пранамайя - коша / хамаарч байна уу, бүхэл биед хамаарч байна уу гэдэг чухал биш юм. Учир нь энэ хоёр бие биедээ нэвтэрч, зөвхөн амьсгалын эрхтэнээр хязгаарлагдахгүй болно.

Дараачийн шат нь, амьсгалын ухамсарт хэмнэл тогтоох замаар, биеийн бүх хэсгийг тайвшруулахад оршино. Сэтгэхүй махбодын тэнцвэр бүрдсэн байдлаас дотоод зохицол үүсч бүх биеийг дээд зэргийн тайван, хангалуун жаргалтай мэдрэмжээр дүүргэнэ.

“Тайвширлыг мэдрэн би амьсгал авч байна”, “Тайвширлыг мэдрэн би амьсгаагаа гаргаж байна”, “Сэтгэл хангалууныг мэдрэн би амьсгаа авч байна”, “Сэтгэл хангалууныг мэдрэн би амьсгаагаа гаргаж байна” гэж өөртөө итгүүлнэ.

Ийнхүү амьсгал нь бие, ухаан хоёрын хооронд зуучилж, оюун ухааны мэдрэмжийн тээгч болгоно. Энэ бол биеийг их, бага ямар нэг хэмжээгээр идэвхгүй байдлаас төгс гэгээрсэн ухааны түвшин хүртэл хөгжүүлэх зэвсэг болж байгаа бөгөөд Буддагын бие бол түүний тод жишээ юм.

Дараагийн шат нь, оюун санааны амьдралын процесст нэвтрүүлэхэд зориулагдана. “Ухааны идэвхийг мэдрэн ухамсарлан, ухаанд баясан, ухааныг төвлөрүүлэн, ухааныг чөлөөлөн, би амьсгал авч, амьсгалаа гаргаж байна” хэмээн өөртөө итгүүлнэ. Өөрөөр хэлбэл, анхаарал ухааныг хөдөлгөгч хүчийг амьсгалын үүрэгтэй холбож, түүнд тусгалаа олж, түүгээр дамжуулж “амьсгалын бие” болж нэгдэнэ. Энэхүү үйл явцыг тайлбарлах хэцүү, харин үүнийг зөвхөн бие, сэтгэлээрээ мэдэрч, бас ойлгож болно.

Энэтхэгийн уламжлалыг мэддэг хэн ч гэсэн, эдгээр томьёолуудыг Энэтхэгийн гүн ухааны мэдлэгт хэрэгтэйгээр барахгүй, түүнтэй уялдаа холбоо бүхий шашны зан үйлд тогтворжсон байдаг гэдгийг ойлговол зохино. Эдгээр томьёолууд нь хэдийгээр хураангуй товч байдаг ч гэсэн, тогтсон зарим утга агуулгыг, тухайн уламжлалыг мэддэг хэнд ч болов тодорхой дамжуулж өгч чаддаг билээ. Дээрх уламжлал хэлбэршин тогтоогүй байсан бусад орнуудад Буддизм дэлгэрсэн зөвхөн тэр л цагт, бясалгалын дадлага туршлага

доройтож, зохиомол үсгийн эрдэм, ухаан боллоо хувирсан гэдэг нь хожуу үеийн Тхеравадчуудын / Бага хөлгөний / тайлбараас харагдаж байна. Гэвч гайхамшигтай нь, Өрнөдийн Буддизмын ойрын чиг хандлага бол энэхүү эртний амьсгалд хийх дадлагыг сэргээн ил гаргахад чиглэгдэж байгаа явдал юм.

“Анапанасати”- гийн туршлагын нэн чухал үр дүн буюу амьсгал дээр анхаарлаа төвлөрүүлэх гэдэг нь - амьсгалын дасгалын явцад, өөртөө ухамсартай ба ухамсартай бус нэгжүүдийг хооронд нь холбож буй хэсгийг төсөөлөгч, бясалгагч хүний ухаарал гэж үздэг бөгөөд ийм ч учраас энэ нь бүхий л амьдралын нилээд төгс илэрхийлэл болдог юм.

Анхаарал төвлөрөлтийн гүнзгий байдалд хөтлөх эдгээр дасгал нь амьсгалыг ажиглах, зохицуулах явцыг ажихаас эхэлж, ингэснээр дурын бус аяндаа урсах явцаас ухамсарт үйл явц болон хувирч эцсийн дүнд оюуны хүчнүүдийн зууч болдог.

Энэтхэгээс гаралтай язгуур уламжлалаас хэзээ ч холбоо тасраагүйгээр уламжилж ирсэн, Төвдийн уламжлалд анхаарал төвлөрүүлэлтийг ажиглах техник одоо болтол амьд хэрэглэгдэж байна. Энэхүү томьёоны өргөн бөгөөд гүн агуулгыг ойлгохын тулд, пранаг ердийн амьсгалтай хольж хутгахгүй байх хэрэгтэй.

Пранаяма / хий гүйлгэх / нь амьсгалын ердийн үйлдлээс эхлэх бөгөөд түүнийг өөрийн практикийн үндэс болгож, амьсгалыг ажиглах ердийн техникээс асар өргөн хүрээтэй болгосон юм. Энэ нь амьдралын сэтгэхүйн эрчмийг түүний илэрч буй бүх хэлбэрт хянах хэрэгсэл болсон байна. Үүнээс амьсгалын үйлдэл илүү тодорхой харагдана. Пранагын бүх идэвхи, үйлдлийн дотроос хамгийн ойлгомжтой бөгөөд нөлөөлөхөд хялбар нь амьсгал учраас анхаарал төвлөрүүлэх хамгийн зохистой эхлэл болдог. Амьсгал бол бие, ухаан хоёрын амьдралын нууцад нэвтрэх түлхүүр юм. Гүн нойронд, эсвэл ухаан алдаж унахад амьсгал зогсдоггүй. Харин ийм тохиолдолд мэдрэхүй, тэр ч байтугай ухамсар хүртэл зогссон байдаг билээ. Амьсгал байгаа цагт амьдрал байна. Хүн тухайн мэдрэмжийн бүх ухамсарт үйлгүйгээр харьцангуй удаан хугацаанд амьдарч чадах бол амьсгалгүйгээр чадахгүй. Иймээс амьсгал бол амьдралын бүх хүчний билэгдэл бөгөөд пранагын биеийн үүргийг тэргүүнд тавигддаг юм.

“Сөрөг буюу бүдүүлэг материалын талыг төлөөлсөн эдгээр үйлдэл нь “Вайю” гэдэг ерөнхий томьёоны дор нэгдэнэ. Энэхүү томьёо нь Төвдийн анхаарал төвлөрүүлэх система Каржудпа / Гаржудба / сургуульд онцгой үүрэг гүйцэтгэдэг. Ийм ч учраас Буддын йогийн практик талыг судлахын өмнө, энэ талаар зарим зүйлийг мэдэх шаардлагатай.

“Вайю” буюу төвдөөр лүн гэдэг нь хий гэсэн утгатай бөгөөд европын ихэнх хэлэнд орчуулагдсан байдаг юм. Вайю гэдэг үг хоёрдмол утгатай.

Тэр нь анхдагч элементэд хүний организмын амьдралыг тогтвортой хүчинд хамаарна. Түүний мөн чанар нь хоёр тохиолдолд хөдөлгөөний мөн чанартай адил бөгөөд иймээс прана гэдэг томьёотой нилээд өргөн нийтлэг агуулгаар төрөл юм.

1. “Срог - зин” нь амьдралыг тэтгэгч, амьсгалыг хэрэгжүүлэгч / санскрит: прана /

2. “Ен - гью” нь дээш тэмүүлж буй амьсгалын / амьсгал гаргахаар / шалтгаан болж буй зүйл, үг ярианы чадвар / санскрит: “Удаяна - вайю /

3. “Тхур - сэл” нь доош дарж буй зүйл, янз бүрийн ялгаварлалын үндсэн шалтгаан / санскрит: апана - вайю /

4. “Мэ - ньян” нь бүхнийг тэгшитгэгч гал, ижилсэх хоол боловсруулах, амьсгалах чадвар / санскрит: самана-вайю /

5. “Кхье - жед” нь биеийг нэвтэлж буй зүйл, өөрөөр хэлбэл, булчингийн хөдөлгөөн, цусны эргэлтийн шалтгаан / санскрит: вьяна - вайю /

Дээрх таван үүргийг санскрит уламжлалаар нь даган баясагч Рене - Гуно нь “Вайю” - г амьсгал авах, өөрөөр хэлбэл, амьсгалын анхан шат / прана гэдэг үгийг нягт утгаар / -ны үйлдэл буюу сансар эргэн тойрны бие махбоджоогүй, бие махбодын ухамсарт ороогүй эхний байдал гэж тодорхойлсон байна.

Рене - Гуно нь “Апана - вайю” - г төвд уламжлалаар нь янз бүрийн дотоод булчирхайн үйл ажиллагааний шалтгаан гэж тодорхойлоод амьсгал авах нь амьсгалын дараах шатанд орж, хувь хүнд нэвтэрч байгаа элементүүд гэж тайлбарлажээ.

Тэрээр “Вьяна - вайю” бол дээрх хоёр шатны завсарын мөч буюу өөрөөр хэлбэл, хувь хүн, орчин тойрны элементтэйгээ холбогдсоны үр дүн, амьд биетийн цусны эргэлтийн хөдөлгөөн хоёрын завсарын шинж хэмээн үзжээ.

“Удана - вайю” бол Рене - Гуногын тайлбарлаж байгаагаар, амьсгалыг захирч, бие махбоджоогүй байдлаас нь хувь хүнд нэвтрүүлж өгдөг үүрэгтэй юм.

Эцэст нь авч үзэхэд, “Самана - вайю” бол хоол боловсруулах буюу гэдэс ходоодонд оруулсан хоол тэжээлийн зүйлсийг шингээж боловсруудаг үүрэгтэй ажээ. Ийм учраас эдгээр үүргүүдийн тус бүрийн онцлог төдийгүй, тэдгээрийн өөр хоорондын харилцан хамаарал буюу нөлөөлөл, материаллаг болоод оюун санааны тусгалын нийтлэг ба онцлог шинжийг ойлгох нь чухал болно. Тэдгээрийн харилцан барилдлага, шүтэлцэлийг бат бөх, үнэн зөв ойлгож тогтоосон цагт л “чакра” ба “нади”-гийн олон талт мөн чанарыг ойлгож, улмаар тэдгээр бүдүүлэг материаллаг биет / стхула шарира / -ийн шинж төрх буюу эрхтэн бус, харин нарийн материалт буюу хий биетэд / линга шарира / хамаарна гэдгийг сая л ухаж мэднэ. Тийм л биет нь хүний нүдэнд тусах болно.

“Линга - шарира” гэдэг нь вижняна - майя, мано - майя болон прана –майя - кошагын хослол ба өөрөөр хэлбэл, гүний ухамсар / далд ухамсар /, мэдрэл оюуны / сүнсний / ухамсар, материаллаг бус буюу прана биеийн ухамсаруудын хослол, нийцэл болно.

Тэдгээрийн хоорондох органик хэлхээ холбоо, физиологи, мэдрэлийн систем буюу чакрууд хоорондын ба тэдгээрийн зохих мэдрэлийн төвүүдийн хооронд хоёрдогч шинж чанар байх бөгөөд практик бясалгал, йогийн дасгалыг ойлгоход чухал ач холбогдол бүхий үндсэн нади - нуудыг нэг бүрчлэн суддалж мэдэх нь гарцаагүй шаардлагатай болно.

7. Хүний бие дэхь гурван гүйдэл ба тэдгээрийн суваг

“Акаша” нь материаллаг бус орон зай болон материаллаг бодьгалын туйлуудын хооронд харьцдагын адилаар, “прана” нь соронзон болон цахилгаан орны эерэг, сөрөг цэнэгийн адилаар, бие биеэ нөхцөлдүүлэн тэнцвэржүүлж байдаг тогтвортой хоёр хандлагын хэлбэрээр нээгдэнэ. Хүний бие бол, орчлонгийн хуулбар буюу багасгасан

орчлон, бичил сансар гэдэг үзлийн үүднээс бол, биеийг нэвтлэн уусч буй эрчмийн туйлын гүйдлүүд нь нар, сарны эрчим хүч болно.

Нарны эрчим бол ухамсар, бодит мэдлэгт хүргэх төвөөс зугатах хүч юм. Сарны эрчим нь дээд ухааны харанхуйд ажиллагч шөнийн хүчнүүдийг билэгдэнэ. Тэдгээр нь төв рүү тэмүүлэгч хүч юм.

Энэ хоёр хүч нь сэтгэхүйн эрчмийн адил хоёр гол сувгаар / сарны лалана - нади, нарны расана - нади / урсана. Энэ хоёроос үй олон хоёрдогч суваг эх авдаг.

Авандуди нь ариун уул Сүмбэр буюу ертөнцийн тэнхлэгт зүйрлэгддэг бөгөөд долоон төвийн хооронд шууд холбоо тогтоогч төв суваг юм. Энэ нь нар, сарны гүйдлийг нийлүүлээд зогсохгүй, дээд доод төвүүдийн хүчийг нэгтгэнэ.

Өөрөөр хэлбэл, энд нэг талаас баруун зүүн, нөгөө талаас дээд, доод гэсэн хоёр туйл нийлж байна. Энэ үйл явц хэд хэдэн үеийг дамжин, ийнхүү нийлэх үйл явцын дээд байдал нь харьцангуй чанаруудыг арилгахад биш, тэдгээрийг бие биед нь бүрэн нэвтрүүлэн зохицуулахад оршино.

Төвдийн бясалгалын судар буюу йогийн практикт лалана, расана хоёрыг ердөө баруун, зүүн гэж нэрлэдэг. Энд энэ хоёр нади авандудыг тойрон давших хөдөлгөөнөөр эргэдэг тухай дурьдаагүй байна.

Авандуди доод төгсгөлдөө хаалттай байх бөгөөд нойрсож буй, сэтгэхүйн далд хүчнүүд сэрсэний дараа сул чөлөөтэй болсон авандуди дээд төв рүү чиглэнэ. Ийнхүү эрчим бүрэн нээгдэж дээд төвд бодитойгоор илрэх хүртлээ шилжилтийн байдалд оршино. Энэ нь чакруудыг сэрээж ухамсартай бодит илрэлийн төв болгох бүх дасгалын болон йогийн зорилго юм. Йогч хүн гэдэг бол, өөрийн оршихуйн төвийг олж авандудийг нээж, дотоод хүчиндээ хүрэх шууд замыг олсон бөгөөд гүнийг өндөртэй нэгтгэж, өөрийн мөн чанарын туйлуудын хооронд шууд харилцаа тогтоосон хүн юм.

Хэрэв бид “агуу их ухаан”-ыг үзэл бодол, баримт сэлт, эд юмс, мэдрэмжийн тоо баримт, хэлхээ холбооны хүчний дотоод харилцааны шууд ойлголцлыг тогтоох чадвар гэж тодорхойлбол, түүнийг жирийн хүмүүн гагцхүү нөр их цаг, хөдөлмөр гаргаж байж сая

ойлгож болох бөгөөд харин бясалгалын практик нь хүнд “агуу их ухаан” “билэг билгүүн” хайрладаг гэж хэлж болно. Тэгвэл дотоод хүч / авандууд / -ээ нээж, оршин буй учир шалтгааныхаа гол ерөнхий чигийг барьж, дотоод хүчиндээ шууд хүрч чадсан хүнийг йогч гэдэг билээ. Йогч хүн л хамгийн гүнийг хамгийн өндөртэй нь холбож, бие махбодынхоо зах хязгаар, туйлуудын хооронд шууд холбоо барьж чаддаг юм.

Авандууд бол хүн болгонд зүүрмэглэж байх бөгөөд йогоор хэрэгждэг бүх боломжийн билэг тэмдэг юм. Хүн болгон адилхан эрхтэнтэй төрдөг боловч түүнийгээ бүгд ижилхэн ашиглаж чаддаггүй билээ.

Төвдийн “Шой - друг дуй - би син - бри” сударт өгүүлсэнээр, бясалгал үйлдэж буй хүн авандууд / Бу-ма-р Ца / - г хүйснээс дөрвөн хуруу доор орших цэгээс босоо шугамаар дээшилж, толгойн орой буюу зулайд хүрч байгааг төсөөлөн харах ёстой. Бас авандугигээс баруун, зүүн талд орших баруун зүүн суваг буюу нади - ийг ажиглаж болно.

Харин уг сударт, спираль буюу эргэлдэх хэлбэрээр дээшлэх сувгийн хөдөлгөөн, мөн нурууны нугасны гадна болон дотор нь орших сувгийн талаар дурьдсан зүйлгүй. Гагцхүү бясалгагчийн биед суваг байна гэж санаандаа баттай хандаж, тэр нь хамраас тархи хүртэл өгсөөд дараа нь доошилж төмсгөнд хүрч байна гэж бодож итгэх хэрэгтэй. Үүний зэрэгцээ тэдгээр нади буюу сувгийг санскрит цагаан толгойн бүх эгшгээр, баруун талынхыг нь бүх гийгүүлэгчээр дүүргэж байна гэж төсөөлөх ёстой ажээ.

Энэ бол ертөнцөд үйлчилж хөдөлж байгаа юмс хоёр хуваагдах ба зүүн талынх нь сарны, баруун талынх нь нарны шинж чанартай амьд урсгал болон харагдана гэсэн үг юм. Зохих язгуур үеүд нь гадагш, дотогш амьсгалахад алмазын улаан өнгөөр гэрэлтэж үзэгдэнэ.

Түүнийг агаартай хамт орж ирээд, агаартай хамт амьсгал гаргахад гараад явчихдаг зүйл гэж үзэж болохгүй. Харин тэдгээр нь / хий / орохдоо амьсгал авах үед бэлэг эрхтэнийг нээж, амьсгал гаргах үед биеийг орших ба харин дээшлэх урсгал бүхий зүг чиглэлээ өөрчилдөггүй билээ. / Тэд хэрвээ амьсгалын үед гадагшлах, дотогшлох хийн хөдөлгөөний аясыг дагана гэвэл, цэвэр тохиолдол болно. / Хоёр янзын хөдөлгөөнийг

нэгэн зэрэг төвлөрүүлэх боломжгүй тул, хамрын баруун, зүүн нүхээр ээлжлэн амьсгалж, баруун зүүн гүйдлийг дэс дараалан мэдэрч болно.

Ийм дасгалын зорилго нь юу вэ ? Сударт Буддист йогийн ерөнхий байдлыг тодорхойлсон тайлбар өгөхдөө, түүнийг саяхан Индуйст тантрагай ижилсгэн жишиж, өрөөсгөл дүгнэлт хийсэн тал бий. “Шатчакранипурана” сударт бичсэнээр бол, Буддист анхны тантраас Индуйст тантра нь даруй мянган жилээр дүү болж байгаа юм. Юу гэвэл, Индуйст тантра нь зөвхөн XV - XVI зуунд л бичигдсэн байна. Бурхан багш өөрөө йогийн олон тооны дасгал бичсэнээс үзвэл, тэрээр йогийн дасгалуудыг сайн мэддэг байсан төдийгүй, сувгийн йогийн дасгал хийж байсан нь тодорхой. Энэ нь Нади Чхандогья 8, 6, 6: Катха 6, 16: Йогашикха 4, 7 болон бас судрын нотолгоогоор батлагддаг юм.

“Маджхима-никая”-гын 36-д, Бурхан багш сургахдаа, тэрээр амьсгалаа захирч, тухайлбал, пали хэл дээрх судруудад дурьдсанчлан амьсгалаа ам, хамар, чихээ хааж барих замаар, агаарын хүчтэй урсгал, түүний хөдөлгөөн / вата - вайю / толгой болон дотор биенд нэвтэрч ходоод гэдэсний орчимд дүрэлзэх галыг мэдэрч болно гэжээ. Энэхүү дотор биен дэхь хий нь амьдралын хүчин буюу “нади” - гийн урсгал болох учир Бурхан багш амьсгалаа барих ердийн үйл явцын талаар ярьсан нь мэдээжийн хэрэг юм. Энэ баримт нь тухайн дасгалыг Бурхан багш өөрөө удаан хугацаагаар үйлдэж, амьсгалаа захирч чаддаг байсныг нэгэн адил харуулж байна.

Тус сударт өгүүлэхдээ, уг дасгалыг ус дуслах тоолонгоор сувагт ордогтой зүйрлэж болно гэжээ. Нэг үгээр хэлбэл, дээрхи дасгалууд нь сэтгэлзүйн энергийг зориуд урсгаж, чиглүүлж захирч болох нөхцөлийг бүрлүүлэх зорилготой болно. Буддист тантра нь физиологи, статистика мэт “нади” -гийн тодорхойлолтуудыг ухаан бодолд, эрчимт сэтгэл зүйн тодорхойлолтоор сольдог байна. Буддист тантрыг баримтлагчид гурван гол нади хаана байна, нурууны голын гадна талд уу, дотор талд уу, эсвэл хүрдүүд / чакра / биеийн ямар эрхтэнүүдтэй давхцан оршдог талаар ярихгүй, тэрчлэн тэд “лянхуа” цэцэг тус бүр хэдэн “дэлбээтэй” байна вэ ? Дэлбээ бүр нь ямар чанартай холбоотой юм бэ ? эсвэл чакруудыг ямар бурхан дааж хариуцдаг вэ ? гэх мэтийн талаар ярьдаггүй. Буддист тантрыг

баримтлагчид нь ямар нэгэн тогтоосон баримт сэлт тэдгээрийн үйлчлэлтэй зууралдах биш, харин өөрөө буй болгож байгаа юмс, бидний үйлийн үр, хувь тавилангийн төвшин, хөгжлийн талаар тойрч үл болох нийтлэг жам хуулийн хүрээнд өөрөө өөрийгөө бүтээх явдал, энэ л ганц тустай зүйл гэдгийг сайн мэддэг.

Ийм учраас Төвд багш нар, шавь нартаа заавал баримтлах бодит баримт сэлт, баталгаа нотолгоо тулгадаггүй байна. Тэд “нади энд байг, тэнд ч байг” харин, “амьдралын хүчний гүйдэл чухам хаанаас хаашаа урсаж байгаагын амьд үзэгдэл хэлбэрийг дотоод ертөнцдөө буй болго” гэдэг байна. Тэд ийм л замаар бясалгал үйлдэгчдийнхээ ухамсар ба бүтээлч төсөөллийг аль нэгэн үүрэг, жишээ нь амьсгалын, эсвэл шууд буюу тойруу замаар үйлчилж болох тэр эрхтэн рүү залж чиглүүлдэг байна. Тэгсэнээрээ, ухамсарын хүчний үйл ажиллагааны сэтгэлзүй болон бие махбодын нөхцөлийг бүрдүүлж өгнө. Өөрөөр хэлбэл, дадлага хийж буй хүн гэгээрэх бөгөөд “нарийн материал” биед мэдрэмжит мэдрэлийн системийг үүсгэгч сувгийг өөрөө / санскрит: сукшма, линга - шарира / бүтээнэ. Авандуди хаана байрлаж байгаа нь чухал бишээ. Сэтгэлзүйн хүчний гүйдлийг бид хааш нь чиглүүлнэ, тэр тэнд л байгаа. Улмаар уг туйлын цахилгааныг ухамсартай болгоно. Авандуди үсний ширхэгээс ч нарийхан байж болох, бас бүх бие цорын ганц хүчний цахилгаан, бүх ертөнцийг дүүргэхээс нааш өсөлт нь үл хязгаарлагдах тийм өргөн ч байж болно.

8. Төвдийн бясалгалын систем дэхь дотоод

галын йога / Тапас ба Тум-мо /

Өмнөх бүлэгт өгүүлсэний тодорхой жишээ болгож харуулах үүднээс нийтлэг бясалгал дахь “дотоод гал” -ын бүтээл үйлдэх, бясалгал хийх ёсыг тунгаах үндсэн сэдэв оршвой.

Садхакийн / бясалгагчийн / ухаан санаа урьдчилсан дасгалын хүчинд ариусч, дотоод сэтгэлээ эзэмдэн амьсгалаа тохируулж, улмаар хүйсний хонхорт анхаарлаа хандуулж төвлөрүүлнэ. Лянхуад тэр нь “Рам”, түүний дээд талд “Ма” үсгээр тодрох ба цаашдаа Дорж Налжирмаа / санскрит: Ваджра - йогини, дагина, төвдөөр: Хандмаа / болж харагдана. Энэ бол тантрын Буддизмд байдаг Бурханы ид шид бөгөөд ухамсарын хүчийг

бадрагч болно. Вадра йогини нь эргэн тойронд дөл бадарсан улаан өнгийн алмаз эрдэнэ байна.

Бясалгагч бээр Хандмаагын биеийг олж, өөрийгөө Дорж Налжирмаа гэдгээ ухаарахтай зэрэг анхны “А” үеийг хамгийн доод талд нь, “Хам” үеийг хамгийн дээд талд нь тус тус байрлуулна.

Дараа нь тэр гүн бодолт, амьсгал, ухаан санааны хүчтэй төвлөрлөөр “А” үеийг халааж, нүглээ наманчилах байдалд орно. Ээлжит амьсгаа бүрийн дараагаар тэр нүглээ наманчилж, аажмаар галт сувдан сондроос шатаж байгаа дөлийн хэлбэрт орох ба дунд сувгаар нь Авандуди нади гарч, сүүл сүүлдээ дээд талын төвд хүрч очмогц, “Хам” язгуур үеэс амьдралыг тэтгэгч мөнхийн рашаан цагаан дусал гарна. Энэхүү цагаан рашааны дусал нь доош уруудаж, бүх биеийг нэвчин хөлөргөнө.

Энэ дасгалыг 10 -н үе шаттайгаар хийнэ.

1. Дөл дүрэлзүүлсэн авандуди нь үсний ширхэгийн хэмжээний зузаан байна.

2. Дараа нь чигчий хурууны чинээ бүдүүрнэ.

3. Гарын дайтай болно.

4. Өргөн нь бүх биетэй тэнцэнэ. Өөрөөр хэлбэл, авандуди нь бидний биеийн хэмжээнд хүрч, бидний бие нь “гал агуулагч сав” болно гэсэн үг юм.

5. Энэ шатанд нүдэнд үзэгдсэн зүйлс / санскрит: утпаннамкрама, төвдөөр: жидрэм, монголоор: эхлэлийн зэрэг / дээд цэгтээ тулж бясалгагчид өөрт нь үл мэдэгдэнэ. Хорвоо ертөнц бүхэлдээ дөл дүрэлзсэн авандуди, хязгааргүй буцалж шуугисан галан далай мэт болно.

6. Зургаа дахь шатнаас эхлэн буцах үйл явц эхэлж, шуурга намдан, галын далай бүх биед тархана. / энэ нь санскрит: сампанна крама, төвдөөр: зогрим, монголоор: төгсгөлийн зэрэг /

7. Авандуди бүдүүнээрээ гарын дайтай болно.

8. Бүдүүнээрээ чигчийн чинээ болно.

9. Бүдүүнээрээ үсний ширхэг шиг болно.

10. Улмаар тэр нь нэг мөсөн алга болж, хоосон чанарт уусна.

Их хоосонд мэдлэгийн хоёр тал шилжигдэн байрлаж, оюун санааны бүхэл бүтэн их холбоосыг буй болгоно.

Оюун санааны нэгдлийн гал нь биеийн бүх гадаргуугаар дүрэлзэж, хувь хүний биед харилцан нэг нэгнийгээ үгүйсгэх элементүүд үүсгэх ба чухам үүнийг л төвдөөр “Тум - мо” буюу “Дотоод гал” гэдэг ба энэ нь бясалгалын хамгийн гол зүйлийн нэг болдог. Уг дотоод галын илч дулааныг энэтхэгээр “Тапас” гэдэг.

“Тапас” нь Тум - мо / Дү-мэ , монголоор “бүлээний гал” гэдэг / лугаа нэгэн адил, хүнийг хорвоогийн жаргал эдлэх гүн нойрноос сэрээж, газар дэлхийн амьдралаас ангижруулна. Оюун санааны энэхүү илч дулааны хүчээр хүн зориг эрмэлзлэлээ тэтгэн бадруулна. Тийм хэмжээнд хүрч гэгээрсэн хэнд ч атугай, хорвоогийн явдал нь тоглоом төдий, хөрөнгө баялаг нь ядуу дорой, таашаал жаргал нь хоосон зүйл болох нь ухаарагдана.

Бурхан багш нь жинхэнэ ёсоор төгс гэгээрлийн байдалд амьдарч байсан болохоор, ямар нэгэн юмнаас татгалзаж зайлсан зүйлгүй. Түүнд “энэ миний юм” гэж итгэж үнэмших зүйл энэхүү дэлхийд угаасаа байсангүй. Иймээс түүнд татгалзаж орхих юм гэж байгаагүй ажээ. Харин “Тапас” гэдэг нь ердийн үгүйсгэх даяанч үзлээс хавьгүй давуу хандлага юм.

Учир нь “Тапас” нь үүсгэн бүтээх, зохион байгуулах, эмх цэгцэнд оруулах зарчим болно. “Тапасны дөлнөөс юмсын эмх цэгц, жинхэнэ үнэн төрсөн билээ” / Ригведа, 10, 190 / Оюун санааны хувьд бол, зөвхөн бие эрхтэнээр мэдрэх төдий бус, сэтгэн бодох дээд хэмжээнд хүргэх хүч мөн. Энэхүү “Тапас” -ны хүчээр хувийн өчүүхэн бодлын явцуу хүрээнээс гарч, хатуужиж “хөрсөн” юм болгоныг цэнэглэн, хайлуулах увидас бий болно.

Дэлхий ертөнц нь “дотоод галын хүч” -ээр галнаас төрж, мөнхүү галын хүчээр эвдэрч сүйднэ. Энэ талаар “Ригведа”-д дурьдсан нь буй. Энэ утгаараа тапас нь үүсгэн бүтээх, авран чөлөөлөх зарчим болохоор “кама чанд” / мэдрэхүйн мөр, дурлал тачаал /, “дхарма чанд” / үнэний мөр, дарма-г бишрэх / аль алины үндэс болж өгнө. Эс бөгөөс, үүнийг арай нийтлэг хэллэгээр тодорхойлж болно. Үүнд, тапас нь доод хэлбэртээ галд автсан сүрэл мэт

нүдгүй сохор, улаан галзуу түймэр мэт сэтгэлийн хөдлөл бөгөөд, гэхдээ, дээд хэлбэртээ орохуй дор оюун санааны нүдээр үнэнийг олж харах дотоод сэтгэлийг бадраагч гэгээн дөл болно.

Аль алины мөн чанар галд буй. Түүнчлэн, галд автсан сүрэл мэт, дүрэлзэн унтрах доод хэлбэр нь зохих илч дулаанаа авч, эв ая нь таарвал дээд хэлбэртээ урган орж, ямар ч хатуу ганг хайлуулж болох тул, сэтгэлийн хөдөлгөөний чадлыг дутуу үнэлж болохгүй юм. Сэтгэлийн хөдөлгөөний гал нь эцсийн эцэст, биднийг зөв замаар залж байдаг хүчин зүйл учир түүнээс салангид үзэж үл болно гэдгийг ойлгох хэрэгтэй. Үүнийг шашны номонд экстаз / онгод, сэтгэлийн хөөрөл, догдлол /, транс / сэтгэл алдрах, ухаан балартах, ховслогдох / даяан гэх мэтээр нэрлэдэг юм.

Сэтгэлийн хөдөлгөөний галыг сэрүүнтэй харшилдууж үзэх нь, үнэнийг олж харахад зайлшгүй чухал зүйл болно. Сэтгэлийн хөдөлгөөний галын эсрэг тавигдсан үзэл бодлын ойлголтын сэрүүн нь, бодит үнэний ялагдашгүй хүчинд баригдах ажээ. Оюун ухааны ойлголт гэдэг нь санааны харьцааны тогтоц болох бөгөөд түүнд мэдрэгдэж буй тусгагдхуун / объект / нь санаа буюу субъектийн гадна үлдэнэ. Тэгвэл сэтгэлийн хөдөлгөөн нь субьекттэй хамт, түүнтэй нийлэх хүртлээ нэгэн зүг чигт хөдөлж байгаа хүчин зүйл, байр байдал юм. Энэхүү хөдөлгөөн нь сэтгэл санааны мэдрэмж бөгөөд бидний гэгээрч боловсрох эд эстэй нэгдэж, улмаар хүний оюун санаа, ухаан бодол, сэтгэл хөдлөлийн болон бие махбодын бүхий л чанарыг задлан шинжлэх дотоод их хүч болно. Энэ нь нэг бүхэл, бүтэн цогц үйл явц юм. Уг үйл явц дунд сэтгэлийн хөдөлгөөний гал нь урам зоригийн төвшинд хүрч хувирна.

Урам зоригийн дотоод ертөнц буюу дүр төрхийг Ницше шиг, тод томруун бичсэн хүн үгүй билээ. Тэрээр бичихдээ: “XIX зууны сүүлчээр яруу найрагчдыг эрин зуунаас давсан хүчирхэг “урам зориг” гэж нэрлэж байсан биш үү ? Хэрэв тийм биш бол, би нэг тодорхойлох гээд үзье.

Мухар сүсэг тун багатай ч гэсэн аливаа хүн хувилгаан дүр, зарч, тунхагч, хүний ер бусын хүчин чадлын зуучлалын үзэл бодлыг ойшоохгүй байж чадахсан болов уу ? Далдыг

мэдрэх, мэлмийг нээх үзэл санаа гэдэг нь гэв гэнэт цаглашгүй их хүчээр ил тодорхой, хурц шулуун үзэгдэх, сонсогдох болж биднийг сандаргаж, ахуй амьдралын гүнд гарцаагүй нөлөөлдөг бөгөөд энэ бол зөвхөн баримт сэлтийн тодруулга юм. Лавлах, сураглах, мэдрэхүйгээр сонсох, эсвэл хэн хайрлаж гийгүүлж байгааг нь эс таньж мэдэх, тэнгэрийн цахилгаан ухаан санааг хямруулах адил, гарцаагүй зайлшгүй юманд эргэлзэх хэрэггүй бөгөөд түүний хэлбэрүүдийн талаар ч гэсэн надад ямар ч сонголт байгаагүй ээ. Баярлахын дээд хэмжээ нь, дусал нулимсыг ихээхэн хүчээр цэнэглэж гаргах бөгөөд энэ хөдөлгөөн нь заримдаа хүчтэй салхи шуурга мэт, заримдаа намжуу тайван явагдана. Ахуйн нөгөө талын байдал, гэхдээ хөлийн хуруунуудын үзүүрт тулж очсон хязгааргүй олон тооны долгион, хэлбэрт үелзэл үүсдэгийг зайлшгүй, үнэн зөвөөр нь ойлговол зохино. Аз жаргал гэхэд л, түүнд зовлон гамшиг, бүрхэг харанхуй бүх юм үйлчилж байх хэдий ч, элдэв янзын зөрчил маягаар биш, харин зайлшгүй орших нөхцөл шалтгаан болдог ажгуу. Энэ бол ертөнцийн жам ёс, түүний өнгө аяс, уриа дуудлага юм. Жам ёсондоо татагдах ааш араншин, түүний бүхий л хэлбэрийн үйлдэл, гүн нарийн хэмжээ эдгээр нь ямар ч саад бэрхшээлийг таягдан хаях урам зориг буюу сэтгэлийн хатыг тодорхойлох барагцаа бүхий шалгуурууд мөн. Энэ бүхэн нь юунаас ч үл хамааран, эрх чөлөө, Бурханы ид шид ..., дотоод ертөнцийн үл болзохуй буюу үл нөхцөлдөхүйн хүчит шуурга мэт үүсч явагдана. Ойролцоо утгаар бол, энэ нь хамгийн гайхамшигтай хэсэг юм. Учир нь хэлбэр дүрсийн талаар ямархан ч ойлголт байхгүй атлаа, бүх юм өөрсдийгөө хамгийн ойр дөтөөр, хамгийн энгийн илэрхийлэл болгон харуулдаг болно. / “Kroners, Taschenbuchaus – gabe”, боть 77, хуудас - 275 /

Миний доогуур нь зурсан үгнүүд бол, Бурхан багшийн номонд “өөрчлөлт, шилжилт” буюу гүн гүнзгий бясалгалд автагдах / дхъяна / ёсыг дүрслэн бичихэд ашигласан илэрхийлүүдтэй агаар нэгэн болохыг, мэргэн уншигчид юун эс андах билээ. Тухайлбал:

Дотоод туршлагыг үзэгддэг болгох. Тийнхүү үзэгддэг болгосон хэлбэр юм уу, билэг тэмдгийн гоц бие болон зайлшгүй шаардлага

Баяр бахдал, жаргал цэнгэлийн мэдрэмж, тухайлбал, “хурууны үзүүр” хүрсэн тийм мэдрэмж / үүнийг пали хэлний сударт: питисукха, төвдөөр: дэ /. Ийм мэдрэмж байх

учраас Миларайба багш, түүнийг “жаргал цэнгэл нь хурууныхаа үзүүрт тулсан тэр бээр” гэх мэтээр зураглан бичсэн байдаг. Тэрчлэн “Дигха никайя”- д Бурхан багш өөрөө айлдсан нь: “Дхъяна” буюу гүн бясалгалын байдалд амьдарч ахуй цагт, бүх биенд амар жаргал нэвчин дүүрч, түүн үгүй биеийн өчүүхэн хэсэг ч үлдсэнгүй гэжээ.

Дээд мөрийн зэргийг гүн мөрийн зэрэгтэй нэгтгэн, бүх чанар ба төвүүдийн хувирал, нэгдэл нягтралын замаар эсрэг тэсрэгийн шинжилгээ хийдэг ажээ.

Ухааны ариусгалыг өсгөн нэмэгдүүлж, улмаар биеийг хувиргана.

Сэтгэлийн дарамт хүлээсийг тайлж, хувь хүний өдөр тутмын ядаргааг шунал тачаалын хорлолоос ангижруулна.

“Тэнгэрийн” хүчийг / сиддхи / сэргээж, сэтгэлзүйн төвүүдийн үүдийг нээж, жинхэнэ чадвар үүсгэж, түүний дээд биелэлт болох төгс гэгээрэлд хүрнэ.

Бурхан багш бясалгалын туршлагадаа бодол санаагаа төвлөрүүлдэг лугаа адил, оюун санааны хөгжлийн явцад биеэ залгаж өгөх үйлдэл нь зөвхөн амьсгалын үйл явцыг ухаж ойлгох төдийгүй, бие сэтгэл хоёрын ялгааг арилгах ёс, хүний бие, мэдрэл, сэтгэлзүй, оюун ухааны ялгаа нь гагцхүү тэдгээрийн зэрэг зиндаа болсоноос биш, мөн чанар нь бус болой. Ухаан санааны гэгээрлийн үед, бие махбодь нь тэрхүү гэрэлт, туяат орчинд орно. Бүх ариун гэгээнтэний биеэс гэрэл цацарч байдгын учир шалтгаан нь гагцхүү үүнд л оршино. Энэхүү гэрэлт цацраг / тайджаса, теджас / нь зөвхөн билгийн мэлмийд үзэгдэх бөгөөд “тапас”- ын шууд тусгал буюу шашны ариун номын дөл, байгалын үр өгөөж, түүнд хуралдсан мэдлэг ба билгүүний гэрэл, сэтгэлийн хөдөлгөөний дулаан болой. Ийм ч учраас Бурхан багш энэ тухай өгүүлсэн нь:

Дива тапати аддиччо, раттим абхати чандима

Саннаддхо кхаттийо тапати, жхайи тапати брахmano

Аттха саббамахораттим Буддхо тапати теджас.

(Дхаммапада, 387)

Нар өдөр гийгүүлж, сар шөнө гэрэлтэнэ.

Дайчин хуяг дуулганд, бярман бясалгалд өнгө орно.

Наран өдөр шөнө байнга гэрэл цацруулж, гэгээнтэнийг гийгүүлнэ.

Энэ бол яруу найргийн зүйрлэл огтхон ч биш, харин ямар ч хэлбэрийн шашин үүсээгүй, эрт балар үеэс уламжлалтай илэрхийлэл юм.

“Нар”, “сар” нь өдөр, шөнийн хүчтэй дүйцэх агаад нэг нь “дайчин эр” -ийн гадна тийш чиглэсэн үйл ажиллагаа, нөгөө нь “тайлгач бярман”-ы дотор тийш чиглэсэн үйл ажиллагаа болно. Гэгээнтэн хүн, бодит үнэний хоёр талыг холбож үздэг. Тэрээр өөрийнхөө дотор өдрийн гэрэл, шөнийн харанхуй хоёрыг нэгтгэнэ. / Үүнийг сүүл үеийн тантрын хэллэгээр, наран адил расан, саран адил лаланы үйлдэл гэнэ. Эхнийх нь, үхэлт амьдралын мөнхийн рашаан, удаах нь, үхэлгүй амьдралын мөнхийн рашааныг тус тус агуулна. / Өөрөөр хэлбэл, бүх орон зайг эзэлсэн түнэр харанхуй, од ертөнц, нарны гэрэл, амьдралын үхэлгүй бүтээлч хүч хийгээд мэдлэгийн бүхнийг чадагч хүчин болно.

Эдгээр зарчмууд хуваагдмал байдлаар юм уу, арай тодруулбал, бие биенээсээ хөндий тусгаар, өрөөсгөлөөр хөгжих аваас, ямар ч үр ашиг өгөхгүй, өөрөөр хэлбэл, өөрийн дотоод ертөнцийг болон ач тустай учир холбогдлыг нээх чадваргүй болох бөгөөд яагаад гэвэл, тэдгээр нь нэгэн амьд бүтэн зүйлийн хоёр тал болно.

Амьдралын үхэлгүй бүтээлч хүч нь, эрдэм мэдлэгийн хүчгүй ухамсарт мэдээлэлгүй бол сохор бөгөөд үхэл, сэргэн мандалт / сансара буюу амьдрал / хоёрын мөнхийн мөчлөг дотор, шунал тачаалын эцэс төгсгөлгүй тоглоом болж хувирна. Түүнчлэн, эрдэм мэдлэг буюу билгүүний хүч нь хэрэв амьдралын дархан хүч чадалтай холбоогүй бол, оюун санааны үхмэл хар амьдралыг хөнөөхөд зориулагдсан чөтгөр шулмын зарчим болж хувирна.

Хоёр хүч нэгдэж, харилцан нэг нэгнээ нөхөж тэтгэх тийм газар, тэдгээр нь гэгээрсэн ухааны ариун дөл / бодхичитта / болж, илч дулаан болоод гэрэл гэгээ цацруулж, түүний ач үрээр бясалгагч бээр өөрөө амьд билгүүнд урган орж, харин оршихуйн шуналын сохор дон, галзуу зэрлэг тачаал нь хорвоогийн хайр дурлалын хүчин болж хувирна.

Ийм учраас “дотоод галын йога” нь бодис махбодын дулааныг үүсгэхэд зориулагдаагүй хэдий ч, бусад эрхэм чанарууд лугаа нэгэн адил, хажуугийн нөлөө үзүүлж

болох юм. Өнөө цагийн өрнөдийхний дунд нэг ташаа ойлголт байдаг нь, йогийн дасгал үйлдэгч бээр, Төвдийн мөсөн ууланд тэсч, амьдрахад чиглэгдсэн практик гэдэг ойлголт юм. Ийм онолыг баримтлагчид, йога нь хүйтэнтэй тэмцэх ямар ч шаардлагагүй халуун орон болох Энэтхэгийн тэгш нам дор газраас, өндөр уулийн Төвдөд орж ирж өргөн дэлгэрсэн гэдгийг мартаж буй бололтой. Тийнхүү йогийн зорилго бол, манай ахуй орчны гэрэл гэгээт хүч чадал, чанар чансаа нь хуримтлагдаж, галт шилэнд туссан нарны туяа шиг уялдаа холбоо бүхий, дотоодын бүрэн гүйцэд нэгдмэл, бүтэн төрх байдлыг буй болгоход чиглэгдсэн, цэвэр оюун ухааны үйл ажиллагаа юм.

Бүрэн нэгдэж нягтрах энэхүү үйл явцыг бадран дүрэлзэж байгаа цэг буюу галын дөлөөр билэгдэн төлөөлүүлсэн байдгыг / санскрит: бинду, төвдөөр: тиг - ле / гэж томъёолох бөгөөд “Хум” гэдэг үеэр тэмдэглэнэ. “Хум” -ын учрыг дараагийн бүлэгт үзэх болно. Дахин цохон тэмдэглэхэд, дөлийн хэлбэр нь зөвхөн уран зүйрлэл төдий бус, харин энэ утганд галын шинж чанар болох энгийн / тежас / болон эгэл бус нарийн / тайджаса / байдлаар илэрдэг психофизикийн үйл явцын бодит туршлагын бүхий л илрэл оршин байдаг. Эдгээрийн шинж чанар болох дулаан, халуун улайдмал хийгээд ариусган цэвэрлэх, хайлуулах, дөл үүсгэн бадраах, гэрэлтүүлэх зэрэг нь бясалгагчийн гэгээрэх үйл явцад асар их ач тустай болох нь бүрэн мэдэгдэнэ.

9. Дотоод галын йога дахь

бие, сэтгэцийн үйл явц

“Тум мо”- гийн дотоод галаар дүүрэн амьдралыг туулсан тод томруун жишээ бол Төвдийн агуу их яруу найрагч, ариун гэгээн Миларайба багштан / 1052 - 1135 / бөгөөд тэрээр, Каржудпа дэг ёсны сургуулийн дөрөв дэхь лам буюу багш болой. / Эхний гурав нь Тилопа, Наропа, Марпа лозава нар болно. / Түүний намтар нь агуу их дээдсийн дурсгалд зохиогдсон үлэмж төгс утгатай нэгэн сор болсон бүтээл төдийгүй, дотоод гал буюу уламжлалт орчуулгаар бүлээний галын йогийн үйл явцын талаар, та бид ухаж мэдэж, ойлгож болохуйц гайхамшигт түүхэн баримт мөн.

Бясалгалын дэг ёс, оюун ухааны дасгалын талаар, энд дүрслэн бичигдсэн зүйлүүдийг судалж байгаа уншигч та бүхэн доорх зүйлийг унших явцдаа зарим үед энэ ер нь юу л бол доо, нэг бол овжин заль мэх үү, эсвэл үнэхээр үнэн туршлагын бодит баримт уу ? гэж эргэлзэж болох юм. Тэгээд хүсч хүлээсэн үр дүндээ хүрсэн тодорхой баримт өөр хаана байна вэ ? гэж өөрөөсөө асууж болно. Тэгвэл Миларайбын амьдрал нь оюун ухаан дахь “тум-мо” дасгалын ач тус, практик үнэ цэнийг баталсан, үнэхээрийн итгэл үнэмшилтэй, агуу их амьд бодит нотолгоо гэж хэлэх нь байна. Тийм дасгал хийгээгүйсэн бол, Мила багштан тэр их хүнд нөхцөлд өөрийн туйлаас өндөр зорилгыг биелүүлж, өнөө хүртэл өгөөмөр баян, үр шимээ хүртээсээр байгаа, оюун ухааны өв хөрөнгө, ариун гэрээслэлээ үлдээх боломжтой байсан гэж үү.

Чухамдаа Мила багштаны дасгал үйлдэж, нямба хийж байсан тэрхүү газар орон болох Төвдөд хүрэлцэн очиж, он жилээр даяанчлан, алс бөглүү уулын хяр, хадны агуйд ганц биеэр бясалгал хийж байсныг газар дээр нь ухаарсан тэр азтай хүн, түүнийг бурхан тэнгэрийн онгодоор олж харсан, оюун ухааны гэгээрлийн мөрийн талаар ямар нэг хэмжээний ойлголт авч, хэрэв тэр бүхнийг биеэр туршиж үзвээс, хүнийг оюун ухаан болон бие махбодын хувьд ч өөрчилж чадах увидас бүхий, бясалгалын энэхүү аргын асар их ач холбогдлын талаар, арай нарийн ойлголттой байхсан билээ. Түүний сургаал нь одоо ч гэсэн, амьдралд хэрэгжсээр бодит байдлаар амьдарсаар байна.

Миларайбын намтраас үзэхэд, тэрээр өөрийн багш Марва / Наропын шавь / -гаас эзотерик сургаалыг уламжлан авч, Дэмчогын тантрын практикийг Наропын зургаан сургаалын хамт хүлээж авчээ. Дэмчогын тантрын практикийн / санскритээр: Шри Чакрасамбара Махасукха, төвдөөр: Пал Хор - ло Домба Дэмчог ба Дээдийн жаргалын мандал гэх ба / болон “Наропын зургаан сургаал” - ыг төвдөөр: Чой друк гэнэ. Тэдгээр нь:

Бүлээний галын сургаал / Тум - мо /

Хий үзэгдэх биетийн сургаал / Гью - лус /

Нойрны замын тухай сургаал / Ми - лам /

Гэгээн гэрлийн тухай сургаал / Од - сал /

Зуурдын байдлын тухай сургаал / Бар - до /

Сүнс тонилох сургаал / Пхо - ва /

Эдгээр сургаалын үндэс нь их, бага ямар нэгэн хэмжээгээр төстэй “Бардо тойдол” сургаал болох нь / “Бардо тойдол” - ын гарчигнаас / харагдана. Тэр нь оюун ухааны практикийн гол үндэс болох “Бүлээний галын йога” юм. Мила багштаны хэлсэнээр, “Тум-мо” сургаалын эх судрыг, шашны мяндагийн билэг тэмдэг болох Наропын жанчны хамт хүлээлгэн өгчээ. Ийнхүү шашнаа залгамжлуулсан Марва гэгээнтэн Миларайбын йогийн эрдэм маш арвин болохыг биширч итгэж байсны илрэл юм.

/ W.Y Evans - Wentz, 1928, 144 -146 хуудас /

Энэ нь түүхийн үндэстэй болохыг Миларайбын шавь, намтарч Речунгын хэлсэн үг нотолдог байна. Тэр хэлэхдээ, Миларайбын бүх бие нь аз жаргалаар бялхаж / төвдөөр: гаваа / тэрхүү баяр баясгалан нь хөлийн хурууны үзүүрээс эхлээд зулай / пьи - цугту / хүртэл нь шингэсэн байдаг ажээ. Тэгээд зулай дээр нь гол сувгуудын зангилаа задарч, сэтгэлзүйн дөрвөн төвүүдийг үүсгэдэг ажээ. “Бүлээний галын йога” - ын судруудаа, дээд талын дөрвөн төв гэж газар сайгүй гардаг учир, энэ системийг Кундалин йогийн системтэй андуурч болохгүйг анхааруулдаг юм. Энд, кундалин, тум – мо хоёр нь огт өөр төрлийн практик болох нь тодорхой байдаг. Хөндлөнгийн хүмүүст иймэрхүү ялгаа нь, онцын чухал зүйл биш мэт үзэгдэж болох хэдий ч, тэрхүү ялгаа нь жинхэнэ номын ёсоор дасгал хийж буй хүнд, гол үндэс суурийн үүрэг гүйцэтгэх ач холбогдолтой. Түүний бясалгаж буй хүрдний аль нь ч мөн чанараараа дундын нади, эсвэл авандуди ч болохгүй.

Зангилаа тайлах гэдэг бол, маш эртний бөгөөд гүн гүнзгий адилтгал юм. “Шурангаме сутра” - д, өгүүлсэнээр бол уг адилтгалыг Бурхан багш манай өөрсдийн ахуйн зангилааг тайлахад ашигласан байдаг.

Энэ зорилгоор, Бурхан багш торгон алчуур авч зангидаад, “энэ юу вэ ?” гэж Анандагаас асуухад: “Татхагата / “Туулсан бурхан багшаа” гэсэн хүндэтгэлийн үг / “энэ бол зангидсан торгон алчуур” гэж тэрбээр хариулжээ. Бурхан багш алчуурыг авч хоёр

дахь, гурав дахь, цаашлаад нийт зургаан удаагаа зангиджээ. Зангидах бүрдээ Бурхан багш Анандагаас “энэ юу вэ ?” хэмээн давтан асуухад, Ананда мөн л анх хэлсэн хариултаа давтаж байжээ.

Үүний дараа Бурхан багш хэлсэн нь, “Би анх зангилаа хийхэд чи түүнийг зангилаа гэж хэлсэн. Хоёр, гурав дахь зангилааг хийхэд, чи өмнөх саналаа давтсаар байсан. Чухам юу гэж хэлүүлэх гэснийг нь эс ухаж мэдсэн, Ананда учирласан нь : “Татхагата, ганц зангидсан ч, зуу зангидсан ч зангилаа хэвээр үлдэнэ. Харин алчуур янз бүрийн өнгийн утсыг нэхэж, нэг болгосон хэвээр байна” гэжээ.

Бурхан багш үүнийг зөвшөөрсөн хэдий ч, нэг онцлогийг сануулсан нь: алчуур бол нэг хэсэгхэн торго, нэг болон бүх зангилаа нь цөм зангилаа мөн боловч, яг үнэндээ зангидсан арга, дэс дараа нь ялгаатай юм гэжээ.

Бурхан багш энэхүү нарийн, чухал ялгааг онцлон тайлбарлаад үүнийг яаж тайлах вэ ? гэж асуухдаа, зангилааг нь улам чивчрүүлэн чангалжээ. Тэгэхэд нь Ананда: “Би эхлээд яаж зангидсаныг нь хармаар байна” гэв.

“Ананда, чи зөв хэллээ. Хэрэв чи зангилааг тайлахыг хүсвэл, эхлээд яаж зангидсаныг нь мэдэх ёстой. Үүнтэй адил, аливаа юмны гарал үүслийг мэдсэн хүн түүнтэй хэрхэн харьцахаа мэднэ. Бас нэг асуулт тавья. Бүх зангилааг нэгэн зэрэг тайлж болох уу ? гэв.

“Болохгүй, Бхагават. Зангилаануудыг нэгэнт тусгай аргаар нэг нэгээр нь дэс дараалан зангидсан болохоор, бид тэдгээрийг нэг нэгээр нь буцааж тайлахаас өөрөөр зангилааг задлаж чадахгүй” гэж хариулжээ.

Дараа нь, Бурхан багш зургаан зангилаа нь мэдрэхүйн зургаан эрхтэн лүгээ тохирох бөгөөд тэдгээрийн хүчээр бид хорвоо ертөнцтэйгээ холбогдож байдаг юм. Хэрвээ бид мэдрэхүйн бүх эрхтэний гарцаагүй нөхцөл нь болсон зургаан төвийн хэлхээ холбооний учир холбогдлыг бүрэн зөв таньж мэдвэл, Бурханы шашны йогийн үндсэн хуулийг ойлгохын зэрэгцээ, доод төвүүдийг хянаж үзэлгүй, шууд дээд биений төвүүд рүү анхаарлаа төвлөрүүлж болохгүйн учир шалтгааныг ч ойлгох болно. / Гэтэл орчин үеийн зарим гэнэн “нууц тарнийн ёсны” үзэлтнүүд, байгалийн хуулийг болон йогийн номыг

бүтээгчдийг аргалж болно хэмээн эндүүрч байдаг агаад гэтэл тэрбээр, йогоос зөвхөн хүрдний тухай анхны мэдлэгийг л авсан байдаг юм./

Оюун санааг материалд буцааж оруулах буюу тодруулж хэлбэл, ухамсарыг материаллаг байдалд төвлөрүүлж, улмаар зангилааг буцаах журмаар тайлж болно. “Эдгээр зангилаа нь манай оюун санааны мөн чанарын нэгдлээр зангилагдсан байдаг юм” гэж Бурхан багш Анандатай хийсэн сонирхолтой ярилцлагынхаа төгсгөлд дурдсан байдаг.

Бурхан багшийн үед, хүрднүүд болон йогийн сувгууд тодорхой мэдэгдэж байсан гэдэг нь тэдгээрийн талаар Упанишадад гардгаар нотлогддог юм. “Катха” болон “Мундака” упанишад судруудад “зангилаа” / грантхи - грантх гэдэг үгнээс гаралтай зангидах, эргэн тойрон ороох гэсэн утгатай / гэдэг үг энэ л утгаараа орсон байна.

“Зүрхний хүрдний бүх зангилаа тайлагдсан цагт, энд ч атугай, өөрөөр хэлбэл, хүний төрөлд үхэл нь үхэл үл болох ёсон буй. Ариун номын сургаалын увидас ийм байдаг ажгуу. / “Катха упанишада” 11, 3, 15 /

Дараагийн хэсэгт нь “Зүрхний төв”- ийн 101 нади - гаас цорын ганц “сушумна” - гын талаар цухас дурьдсан байх бөгөөд “сушумна” нь толгойн зулайд өөрөөр хэлбэл, Сахасрара Бадма буюу “Мянган дэлбээт Бадам лянхуа”- н хүрдэнд хүрнэ.

“Мундака Упанишада” судраас бид дараах зүйлийг уншиж болно. “Зүрхний зангилаа тайлагдаж, бүх эргэлзээ арилахтай зэрэг хүн сая гэгээрч дээр доор гэгчийн ялгаа болон бүхий л юмсыг мөн чанарынх нь үүднээс хардаг болно.”

Энэ бүхэн нь оюун санааны хууль, амьдрал практик хоёр нь бодит үнэн байдлаар зохицолдож байдгыг харуулж байна. Бурхан багш эртний Энэтхэгийн ведийн номонд / Ригведа, Аюур веда, Атхарва веда / байдаг шиг олон ургальч биш, тарнийн номынх шиг өрөөсгөл биш, голч нямбай байр суурийнхаа үүднээс дээр дурьдсан оюун санааны хууль, дадал заншил / практик амьдрал / - д шинэ тайлбар хийсэн юм. Веда болон тантрын ёсны аль аль нь тоо бүртгэлийн чанартай үзэл баримтлал байсан бол, Бурхан багшийн байр суурь нь гэгээрлээ өөрийн хүчээр олох увидас бүхий, оюун санааны зам мөр бөгөөд Бурхан багш түүнийгээ Бенарасын номлол “Дарма - чакра -паравартана” хэмээн, анхныхаа

айлтгалд энэ бол сургаалын маань гол зорилт гэж тунхагласан нь, улмаар нирвааныг өрөөсгөлөөр тодорхойлох явдлыг болгоомжлуулсан хэрэг билээ.

Иймд асуудлын гол нь, хүн ер бусын хүчийг олж хүртэх, эсвэл хүлээж авахад бус, гагцхүү бидний сэтгэлзүйн алдагдсан тэнцвэрийг нөхөн сэргээж, өөрсдийнхөө дотоод хүлээснээс ангижрах, оюуны болон ухаан санааны хомсдолоос өөрөө өөрсдийгөө авран чөлөөлөхөд оршино. Үүнийг зөвхөн бие, сэтгэлийн уужим тайван, ухаалаг аргаар олж авахаас биш, нас биеэ золиослох, даяанчилж хатуужил хийх болон сэтгэлээ тэвчих зохиомол өрөөсгөл аргаар олж авч чадахгүй билээ.

Миларайбын намтрын нилээд хэсгийг бүрдүүлдэг “Буман дуулал” - д дурьдсан нь: “Түүний бүх бие” бүлээний гал асахтай зэрэг аз жаргалаар бялхаж эхэлдэг байна. Нарны хүч / ро - ма /, сарны хүч / шан - ма / - ний гүйдэл хий / лүн / дундад суваг / бу - ма / буюу авандуди - д ороход Миларайбын бие галаар бүрхэгдэнэ. Түүний биеийн дээд талын хүрдүүд нь гэгээрэх ухамсарын урсгал уруудах цагт, бас амар жаргалыг эдэлнэ. Бас биеийн доод талын хүрдүүдэд бүтээлч илч нэвчсэний ачаар амар тайвныг олно. Тэрбээр нар, сарны хувирсан илчний улаан урсгал нийлэх үед, хөнгөн шаналгаа авдаг боловч, зүрхэндээ амар жаргалтай хэвээр байна. Мила багштан нь түүний бие бүхэлдээ хир толбогүй, амар амгалангаар бялхаж нэвчсэн тохиолдолд зовлонгоос ангижирч амирлана. Энэ бол Йогийн зургаан зүйл, дээдийн жаргал гэх эдгээр буюу” гэжээ. / Н. А. Jaschke, 1949, 231 - р хуудас /

“Наропын зургаан сургаалын судар” -ын учир утгыг ойлгохын тулд, дахин дахин гүнзгий унших хэрэгтэй юм. Түүнд өгүүлэхдээ, бясалгал үйлдэгч бээр, санаа бодлоо бүрэн төвлөрүүлж, дотоод биеийн адислал хүртэхдээ, Важрайогини биеэрээ боллоо хэмээн өөрийгөө үзэж, энэ нь түүний бясалгалын билэгдэл, дүр төрх гэдэгт итгэх болно гэжээ. Тийнхүү дасгал үйлдэгч нь, өөрийнхөө биеийг хүн биетээс салгаж, түүнийг “шуньята” буюу “хоосон” -д үзэж, мөн чанарыг ойлгоно. Энэ нь нэг үгээр хэлэхэд, хүн өөрийгөө бодит махбодоор оршин буй бус, харин өөрийнхөө оюун ухааны цэвэр бүтээл болохыг мэдрэнэ гэсэн үг болно. Тэр одоо энэхүү ямар ч хольцоогүй тунгалаг биендээ, дөрвөн гол

хүрдийг төсөөлж эхэлнэ. Толгойн, хоолойн, зүрхний, хүйсний дөрвөн хүрд буюу тэдгээрийг тэрэгний дугуйтай жишиж болно. Тэдгээр хүрдний голоор буюу тэнхлэгээр авандуди явна. Авандудийн доод талаар нь / язгуур төвд / язгуур үеийн бага “а” үсэг харагдана. Тэнд “лалана”, “расана” дайралдаж авандудид холбогдоно.

Тарнийн “А” үсэг нь аль ч хэл ярианы гол үсэг учраас, ямар ч хэлэнд, бүр гийгүүлэгчид ч орох тул прима матери адил бүх дуу авианы “сав” буюу эх болно. Мантрын энэхүү үсэг нь улаан хүрэн өнгийн үсгээр харагдах буюу төсөөлөгдөх бөгөөд нарийнаараа үсний ширхэг мэт, өндрөөрөө ямхын чинээ болно. Тэрхүү үсгийг хэлэхэд салхиний цохилт мэт улайссан нарийн утас мэт үргэлжлэх дуу чимээ гарна.

Мантрын билэгдэл нь, бидний мэдрэмжийн чадлын дээд түвшинд хамгийн амьд үнэн байдлаар харагдах ёстой. Бидний санаа бодол, мэдрэмжинд тэгж л үзэгдэж, дуу чимээ нь хүртэл анзаарагдах ёстой. Тэр нь ямар нэгэн амьгүй дүрс үсэг биш, харин биет амьдралаар бялхсан агуу их бодит хүчтэй амьд оршихуй хэмээн ойлгох ёстой.

Бясалгагч бээр тэрхүү язгуур үе болох “Хам”- ыг авандудийн оройд / бясалгагчийн толгойны зулай хүрдэнд байрлана / буй цагаан өнгөтэй , (саран адил), дотроо мөнхийн рашаан агуулсан бумба мэт зүйл гэж төсөөлбөл зохино. Харин улаан өнгийн “А” нь билгийн шинжтэй / сөрөг туйл / болохыг мэдвэл зохино. “Хам” нь аргын талыг агуулах / эерэг туйл / бөгөөд амьд эсэд маш чухал үүрэг гүйцэтгэх амьсгал болон амьсгалын дуу чимээ юм. Тэд бүгд нийлээд санскритээр “би”- г төлөөлөхөөс биш, ямар нэгэн битүү бүхэл биш юм. Үүнийг унадаг дугуйн дээр байнгын хөдөлгөөний тусламжтайгаар, тэнцвэрээ олоод явах хүнтэй зүйрлэж болно. Түүнчлэн, энэ мэт хөдөлгөөний хамаарлаар атом - молекул юм уу, гариг ертөнцийн систем тэнцвэрээ харьцангуй тогтвортой барьж оршин тогтноулж байдаг билээ. Хэрэв агшин зуур ч атугай, тэнцвэр нь алдагдвал бүх бүтээл тэр аяараа нурна. Энэ бол олон талын ач холбогдолтой чухал баримт мөн. Ийм ч учраас бид энэхүү нэгдлийн туршлагыг зогсоох, тогтоох, хязгаарлах юм уу, шахаж нягтруулах гэж оролдвол, тэр бээр зөрчилд орж, дотоод шүтэлцээ нь эвдрээд мөхөлд учруулах хор болох аюултай. Нөгөөтэйгүүр, хэрэв бид түүнийг жинхэнэ мэдлэгийн гэрэл

гэгээнд чөлөөтэй шумбуулж, эрхэм дээд ухамсарын галд хайлуулж саадгүй урсгах юм бол бүгдийг нэгд нэгэнгүй авран тэтгэгч гээрлийн аврага хүчин зүйл болно.

Энэхүү гайхамшигт чанар нь “А” болон “Хам” хоёр нэгдэж “А - Хам” хэмээх билэгдлийн үг болоод харилцан уусч, болор цагаан өнгөт мөнхийн рашаан болж, доош дуслах тэрхэн мөчид сая илт харагддаг байна. Учир нь бадран дүрэлзэх “А - Хам” зулын гол хайлж, гэгээрлийн рашаан болж доош урсдаг байна. / Энэхүү рашааныг санскрит: бодхичитта, төвдөөр: жан чив сэм бэ гэнэ. / Доош урссан уг рашаан нь хүний биеийн сэтгэлзүйн бүх цэгүүдийг бүхэлд нь том, жижиггүй ариусгадаг юм. Тантрын хэлээр “А - Хам” - ыг тарнийн ёсны томьёо болох “Эвам” - аар тодорхойлж болно. Дараах ишлэлийг “Субхашитасамграха” - Девэндрапариприччхатантра”- гаас авлаа. / Н. Guenther, 1952, хуудас - 76 / Энэхүү орчуулга нь үлгэр жишээ байж магадгүй:

Э - карас ту бхавен мата

ВА - карас ту пита смритах

Биндус татра бхавед йогах са йогах парамакшарах

Э - карас ту бхавед пражня

ВА - карас суратадхипах

Биндус анахатам таттвам таж - жатани акшарани ча”

Э - энэ бол эх

Ва - бол эцэг

Бинду / М / - энэ тэдний холбоо, хатуу бие шингэрэхгүйгээр хайлах

чимээ

ВА - энэ бол дурлалт нөхөр

Бинду - энэ бол билгийн мөн чанар, тэдгээрээс бусад дуу чимээ бүгд

төрнө.

Үүнээс улбаалж, “Ахам” -ыг бид дараах мэтээр тодорхойлов. Үүнд: “А” - энэ бол билгийн / төвдөөр: юм, монголоор: эх / талын язгуур үе буюу хөрөнгө үсэг, билгүүн ухаан, зөн билэг юм. “Ха” - энэ бол аргын / төвдөөр: яб, монголоор: эцэг / талын язгуур

үе гэгээн дурлал, гашуун зовлон аль алиныг нь тэсвэрлэгч эрхэм зарчим, “М” - энэ нь / санскритаар “Ха” үсгийн дээд талд байдаг цэг буюу бинду төвдөөр: тигле (холбоо, нэгдэл нягтралын) билэгдэл юм. Тухайн нөхцөлд бол билгүүн, арга туршлага хоёр буюу арга, билгийн холбоо нэгдэл бөгөөд түүнийг хэрэгжүүлэх зүйл нь / пражнопайя / буюу билгүүн ухаан, хайр дурлал хоёрын нэгдэл юм. Яагаад гэвэл дурлал, зовлонгийн үр тогтоох хүчгүй бол билгүүн үр жимсгүй болж хоосон хоцорно.

Бидэнд нуугдаж байдаг язгуур үе “А” чанарыг асаан ноцоож, улайсган бадруулж байдаг чухам тэр зүйл бол, гагцхүү бидний урам зоригийн ундрага мөн. Харин урам зоригийг ундруулан тэтгэгч охин тэнгэр бол, Важрайогиний хувилгаан дүр, эрхэм дээд дагина мөн. Тэрээр бидний далд ухамсар дахь, мөнхийн туршлагын эрдэнэсийг сэргээж, бидний оюун ухааныг дээд ухамсарын түвшинд хүртэл өргөнө.

Ийнхүү бид мантрын язгуур үе, тэдгээрийн үүргийг нэгэнт мэдсэний эцэст, энэхүү йогоор дасгал хийж, гол онцлогуудыг үргэлжлүүлэн мэдэх болно.

Амьсгалаа санаатайгаар авах үед, амьдралын хүчний сэтгэлзүйн эрчим / прана, төвдөөр: лүн / зүүн, баруун надигаар дамжин, дунд авандуудыг орж, үс хэлбэрт богино “А” - тай шүргэлдэх бөгөөд өөрөө түүний “А” хэлбэрт шингэн шингэтэл орооцолдож голыг нь дүүргэнэ.

Төвлөрөл, хараа мэлмий нь улам нэмэгдсэн язгуур үе “А” амьсгалаа санаатайгаар байн байн дотогш, гадагш авсанаар, улайдсан хурц улаан байдалд орж, галынхаа дөлийг өөрөөсөө хөндийрч, өөрөө цагираг үүсгэн дээшлэхийг хүлээнэ. Амьсгалаа авах, гаргах бүрийд галын дөл нь хагас ямхын дайтай дээшилнэ. Найман мөчлөг амьсгалын дараа дөл доош уруудаж, биеийн доод хэсгийг галаар төөнөнө. Дараагийн арван удаагийн амьсгалаар дөл нь дахин тасралтгүй өгссөөр зүрхний хавьд, хоолойн төвөнхөд, бүр сүүдээ зулайн хүрдэнд хүртэл өгсөнө. Түүний дараах арван амьсгалын үед язгуур үе “Хам” толгойн оройн төвд байснаа гэнэт хайлж, Гэгээрсэн ухамсарын мөнхийн рашаан / төвдөөр: жан чүв сем бэ / болох ба оройн төвийн бүх хэсгийг дүүрэн дүүртэл байна.

Дараа нь толгойн оройн буюу зулайгаас доошилж, доод биеийг чиглэнэ. Дараах арван мөчлөг амьсгалуудаараа, тэр нь хоолойн төвөнх, зүрхний хавьд, хүйсний хавьд болон хөлийн хуруу хүртэлх бие, доод биеийг дүүргэнэ. Нийт 108 мөчлөг, амьсгал авах, гаргах нь нэг мөчлөг болно. Яг энэ ёсоор Буддист, Индуйст шашны эрхиний тоо аль аль нь нэг зуун найман ширхэгтэй байдаг билээ.

10. Дотоод галын йога дахь сэтгэхүйн

хүчний төвүүд

Дээр дурьдсан зураглал бол, бясалгалын үйл явцыг дээд зэргээр хялбарчилсан учир түүний зөвхөн араг яс төдийд л илэрхийлсэн зүйл бөгөөд яг үнэндээ тийм ч амар зүйл биш болохыг ярихын ч хэрэггүй юм. Ийм болохоор энд зөвхөн хүснэгтэн бүдүүвч маягаар ойлговол зохистой. / 352 - р хуудсанд буй зурагнаас харах / Зураг дээр хүрд болон тэдгээрийн үүргийн талаар Буддист системийг тойм төдий тусгасан болно.

Үүнээс үзэхэд, Буддист систем нь хүний биед мэдрэгдэж, ойлгогдох гол үндсэн таван хүрдээр хязгаарлагддаг ба Төвд уламжлалаар бол, тэдгээр нь гурван бүсэд хуваагдана. Дээд бүсэд толгойн болон хоолойн төв цэгүүд, дунд бүсэд зүрхний төв, доод бүсэд хүйсний төв буюу асуух нурууны төв тус тус байрлана. Эдгээр гурван бүс нь тус бүрдээ лалана, расана, авандуди - гээс ижил зайнд оршино. Лалана, расана хоёр нь бүтээгч ба хөнөөгчийн журмаар бие биеийн эсрэг хандсан чигтэй буюу арга, билгийн байдлаар бие биеийн эсрэг дээш, доош хандсан байдалтай байна. Гэтэл авандуди нь хоёр сувгийн хооронд байрлах учир лалана, расана хоёрын дотоод холбоог олж тогтоож, эцсийн эцэст хоёуланг нь нэгтгэн өөртөө шингээнэ.

Зүрхний төв нь дээд, доод төвүүдийн хооронд орших болохоор уусгах, эзэмших чадвартай ажээ. Энэхүү гурван бүс нь, гүн утгаараа дараах түвшинтэй байна. Үүнд:

1. Газрын түвшин: Байгалийн ердийн хүч, газрын материаллаг чанар буюу дэлхий ертөнцийн мөн чанрын түвшин.

2. Сансрын буюу мөнхийн түгээмэл хуулийн түвшин. Тухайлбал, дотоод цаг хугацаа ба зөн совингын мэдлэг, түүний мөнхийн жам хуулиудын ердийн ба ердийн бус төвшин:

Хязгааргүй орон зай дахь Агуу их хоосон чанартай (Шуньята) холбогдох төвшин, түүний дүрстэй ба дүрсгүйн түвшин хамаарна.

3. Хорвоо ертөнц, дээд тэнгэрийн хүч нь хүн төрөлхтөнд нөлөөлөх төвшин: Тэдгээрийн шүтэлцээ зохилдолгоо, харилцан холбогдол, тэдгээр нь хүний сэтгэл санаанд нэвт шингэж, үүрд орших чанар болно.

Эртний Хятадын ном зохиолд байгалийн хууль / инь - ян - цзяо / - ийн гүн ухаан / И Цинь / нь тэнгэр, газар гурван мөнх журам, дотоод холбоон дээр үндэслэгдсэн байдгыг тэмдэглэхэд сонин. Тэнгэр, газрыг хүн өөртөө нэгтгээд, ихэд зохицон оршиж, машид боловсронгуй болно. “Мундака упанишада” сударт ч гэсэн бас газар, тэнгэр хоёр хүн дотор дайралдсан тухай дурьдахдаа: “Хүн бол түүний биенд тэнгэр, газар, тэдгээрийн завсарыг бүхий л ухаан, амьдралыг тэтгэгч бүхий л цахилгаан гүйдлүүдтэй хооронд нь нэгтгэсэн үед л нэгдмэл нэг “би” байна гэж өөрийгөө таньдаг юм. Олон юм бүү хэлэгтүн, энэхүү гүүрээр яваад л үхэлгүй мөнхөр” / 2, 2, 5 / гэжээ.

Сэтгэлзүйн хүрднүүдийн мантра буюу тарнийн шинж чанарыг шинжилж судлахаас өмнө, тэдний байгалийн дүр төрхийг товч ч гэсэн мэдэх нь зүйтэй. Урьд дурьдсанаар, Буддын тантра йога нь тогтсон хэмжигдхүүн юм уу, тоо бүртгэлийн үзэл баримтлал хэрэглэдэггүй, гагцхүү сэтгэлзүйн хүрдүүд ба тэдний үүрэг ач холбогдлоор илэрхийлэгдэнэ. Нэг үгээр хэлбэл, тантра йога гэдэг нь бидний дотоод хөгжлийн зүт чигийг тодорхойлогч сэтгэл оюуны түвшин гэсэн үг юм.

Дээд хүрдүүд гэхэд л сансар огторгуй юм уу, түүний хязгаарын чанад дахь ухамсарын байр биш, зүрхний хүрд гэхэд л тэр нь оюун ухаан, зөн билгийн ухамсарын байр бус, түүний нэгэн адил, язгуур хүрд нь сэтгэлзүйн ухамсар буюу бие махбодын ашигт хүчин чадвар аль аль нь үгүй билээ. Гагцхүү, тэдгээр хүрдүүдийн үүргийг зориуд дамжуулан шилжүүлэх, өөрөөр хэлбэл, мал адгууст байдаг шиг, дадал зуршлыг оюун ухаанд нэвтрүүлж байж, сэтгэлзүйн хүрдүүдийн тухай бүрийн үүргийг бодит зүйл болгож хэрэгжүүлнэ. Мал адгуус дээр бол материаллаг биетэй харьцах харилцаа байдаг бол, хүний хувьд материас салсан байх ёстой билээ.

“Расана”-гын нарны төвөөс зугатах хүч нь хувийн мэдлэг, задлан шинжилгээний зарчмыг үхлийн хорын хамтаар агуулдагын нэгэн адил, лалана буюу сарны төвд тэмүүлэх хүч нь “мөнхийн рашаан”-ыг төлөөлөхийн зэрэгцээ оршихуйд сохроор тэмцэж, эцэс төгсгөлгүй дахин төрөх / сансара / тойрог үүсгэнэ. Тэргүүн дэхь хүрдүүд эс шингэрэх хайлмаг хэлбэрээр биднийг амьдралын язгуур эх булаг болон бүх хүн амьтны дотоод нэгдлээс улам холтгон хөндийрүүлэх, оюун ухааны ертөнцийн идэвхи буюу увидасыг төлөөлнө.

Гадна тийш хандсан оюун ухаан нь та биднийг шинээр үүсэн тогтох үйл явц, тухайлбал, “юмс”-ын ертөнцийн материаллаг хэлбэр хийгээд бидний өөрсдийн саланги тусгаар мэт хуурамч тал, цаашилбал, ертөнцийн мөнх бус тийш улам хүчтэй татна. Оюун ухаан нь дотор тийшээ хандсан цагтаа, мөн л бодол эргэцүүлэлд хийсвэр сэтгэлгээний ёроолгүй ангал хийгээд ухаан мэдрэлийн зогсонги үхэлд өөрийгөө алдана.

Гэхдээ, хэрэв оюун ухаан нь үнэнхүү шинж чанарын зүй тогтлын бус, тохиолдлын гогцоог шүүрч авбал, түүний цар хүрээ нь явцуурсаа, сүүлдээ эвдрэл сүйрэл, эх захгүй байдлаар дуусах болно. Сэтгэл санааны хувьд бодит үнэний төрөлх ухаан нь боловсорч бэлтгэгдээгүй хүнд эгэл үнэн болж, үл итгэм аймшигт муухай хэлбэрээр дүрслэгдэнэ.

Ийм учраас дээд мэдлэг буюу бодит үнэний ухамсар нь тасалдсан хүнд зовлон гансрал нь Хэрука - “Цус уугч бурхан” гэгч аймшигт дүрээр дүрслэгдэнэ. Түүний мандал нь “толгойн оройн хүрд” болох бөгөөд тайван амгалангийн билэгдэл Дхьяна бурхадын мандал нь “Зүрхний хүрд” лянхуа цэцгийн голд үзэгдэнэ. “Хилэнт бурхадын уух цус” нь билгүүн ухааны рашаан, нүгэл буяныг ялгагч бодь модны үр юм.

Билгүүн ухаан бүрэлдээгүй хүний “толгойн хүрд” нь үхлийн үр хөврөлийг агуулдаг бол, “язгуур хүрд”-ийн авандудийн нөгөө талд амь насны цөм, дахин дахин төрөх, сансарын мөчлөгийн учир шалтгаан агуулагдана. Гэгээрлийг олоогүй хүний “толгойн хүрд”-ний ухамсар нь амьдралын хүч, түүнийг тэтгэгч чанарыг ялган таних чадвартай боловч, тэдгээрийг нэгтгэж бүрэн гүйцэд ухамсарлах чадваргүй байдаг юм. Харин сэтгэлзүйн мэдрэмжийн “язгуур хүрд”-үүд нь нэгтгэх аргын эх булаг боловч, өөрийнхөө

оршихуйн төлөө чадлаа барагч, амь насны сохор хүчийг шүтэгч юм. Тэр нь уг сохор хүчинд эрдэм ухаан болон чиглэл өгсөн ч танин мэдрэхүйн ялгаатай ойлголт өгч чадахгүй.

Ийм ч учраас танин мэдэх буюу ялган таних нарны зарчмын ухамсар нь сэргэжээрсэн байдалдаа, манай дур зоргын санааны ертөнц / субъект / болж, учир утга бүхий амьсгалаар хүч орж, амьдралын эх булаг руу уруудан бууж, түүний нөхөн үйлдвэрлэх хүчийг эр, эмийн явдлаас сэтгэлзүй, оюун санааны явдал болгон өөрчлөх ёстой билээ.

Иймд үет тарни “А” нь дээр дурьдсан бясалгалын практикт мэдлэгийн зарчим нь болох ба тэр нь хамгийн доод талын хүйсний төвд авандудийн амсарт буйгаар төсөөлөгдөх ёстой байхад / энд “язгуур” хүрдийг хайхрах шаардлагагүй /, амь насны мөнхийн рашааныг төлөөлдөг үет тарни “Хам” нь дээд талын хүрэнд үзэгдэнэ. Ийнхүү үзэж мэдэрч чадвал дөл бадруулагч “А” нь бясалгалын үед “Хам” - д хүрч, улмаар түүнийг / Хам - ыг / идэвхжилд оруулж буйн тэмдэг болно. Тарнийн үе “А” - гаас дөл бадарч буй нь, зовлон шаналалын үнэ цэнэ хийгээд сэтгэл төвлөрөлтийн шалгуур болно. Одоо дөл гаргагч “А” - гын халуун илчлэг нь “Хам” - д нэвтэрч буй учир “Хам” нь хайлан урсч Гэгээрэх ухамсар буюу Бодь сэтгэлийн нөхөн үйлдвэрлэх хүчин чадлыг идэвхжилд оруулсанаараа, “толгойн оройн хүрд” - ийг дүүргээд, тэндээсээ бусад хүрдүүд рүү цутгана.

Энэхүү уруудалт нь сэтгэлзүйн мэдрэмжийн хүрднүүдийн шилжилтийг илтгэн харуулж буй хэрэг юм. Үүнд: нэгдүгээр шилжилт нь сэтгэл оюуны танин мэдэх зарчим, дотоод болон шууд мэдлэгийг хөхүүлэн тэтгэгч дөл, төгс төвлөрөлтийн галд улайссан байдал юм. Хоёр дахь буюу хамгийн ноцтой төвлөрөлт нь тэдгээр хүрдүүд нь энэ тохиолдолд гэгээрч буй ухамсарын зэвсэг болон хувирч, улмаар мэдлэг, мэдрэмж, хайр дурлал, гэрлийн хурц туяа, амьдралын илч дулаан бүгд нийлж байж нэг бүтэн хайлш болдогт оршино. Ийм нэгдэл нягтралын билэг тэмдэг нь тарнийн үе “Хум” болно.

Уг хоёр янзын шилжилт, өөрчлөлт нь сэтгэлзүйн төвүүдийг нойрноос сэрээж, шинэ урам зориг, чадал тэнхээ өгдөг байна. Энэ нь тус хүрдүүдийг хооронд нь холбож, ухамсарын цахилгаан гүйдлийг нь дээшлүүлэх, доошлуулах зэрэг байнгын хөдөлгөөнд оруулсаны үр дүн болно. Ийм хөдөлгөөнд орсон гал / дээшлэх / буюу усны / доошлох /

мөн чанарууд нь нэг нэгэндээ нөлөөлж, нэг нэгэндээ нэвтэрдэг байна. Тэдгээрийн хамтран оршиж нэгэн зэрэг үйлчилдэг үндсэн зарчмуудыг энгийн хэлээр товч өгүүллээ. “Милиндагын асуултууд” хэмээх судрын Бурхан багшийн давхар ид шидийн тухай өгүүлсэн бүлэгт дурьдсанаар, оюун санааны төвлөрөлтийн ачаар, Бурхан багшийн биенээс солонгон гэрлэн бие / аура /, дөлөн буюу усан хүрээ нэгэн зэрэг цацардаг ажээ.

11. Буддын хүрдний систем дэхь Дхьяны бурхад,

тарни ба язгуур махбодууд

Буддын йогийн хүрдний системд хүрд ба тарни, язгуур махбодууд (махабхуты буюу язгуур махбод) нь хоорондоо харилцан шүтэлцээтэй байдаг. Уг тогтолцооны таван төв буюу хүрд нь, таван махбодын нэгэн адил, харилцан хамааралтай байдаг.

“Гал” махбод гэхэд л, зөвхөн халуун дулааны билэгдэл төдийгүй, нарны хүч болон гэрэл гэгээний билэгдэл болдог билээ. Гэрэл гэгээний билэгдэл утгаараа үзэж харахуйн билэгдэл, түүнчлэн сэтгэлзүй, урам зориг, омог бардам, бадрангуй байдал, сэтгэл хөдлөл, золбоо хийморь, хүсэл мөрөөдөл, эрмэлзлэл тэмүүлэл энэ бүгдийн билэгдэл юм.

Тэгвэл “Ус” махбод бол үл тасрах урсгал, шингэн бүтцийн байдал төдийгүй тэгш тэнцүү чанар, шингэлэх уусгах увидас ба амь насны мөнхийн рашаан, сарны хүч, сав шим, үржил шим, өнгөгүй буюу билгийн зарчим, толь мэт тусгах чадал, далд ухамсар гэх мэт олон зүйлийн билэгдэл болно.

Тийнхүү махбод нь цаг хугацаа, орчин тойрны хүчин зүйлс, хөдөлгөөний үе шат, эсэргүүцэл зэрэг олон төрлийн зүйлсээс шалтгаалсан, өсөлт хөгжилтэй байна.

Нөгөө талаас, Буддист йога нь хорвоо ертөнц, Дхьяны бурхан тэргүүтэний холбогдлоосоо илүү сэтгэлзүйн холбогдолтой болно. Иймээс сэтгэлзүйн хүрд буюу чакрууд нь язгуур махбодуудын шинж чанараар бус, харин тэдгээртэй ямар ч харьцуулшгүй сэтгэлзүйн үүрэг, ажиллагаагаар тодорхойлогдоно.

Оюун ухааны хүрд нь ухамсарын эрхтэн болох ба түүнд орон зайн махбод буюу хий махбодтой дүйнэ.

Зүрхний хүрд нь ухаан, мэдрэмжийн эрхтэн мөн учир бясалгалын үйл явцын гол эрхтэн болно. Тухайн / зүрхний / төвийн үүрэг ажиллагааг “гал” махбодоор төлөөлүүлдэг заншилтай. Гэхдээ энд жинхэнэ гал махбод бус, харин шашны сургаалд гардаг сэтгэлзүйн галын тухай яригдаж байгааг мартаж үл болно.

Хүйсний хүрдийг “ус” махбодтой холбож үздэг билээ. Энэ нь түүнийг сэтгэлзүйн дулааны төв болж чадахгүй гэсэн үг бус, харин жишээ нь бүлээний галын йогад ч гэсэн гал нь бүх хүрдүүдийг дамждаг байна. Ер нь тантрын Буддист лам нар: “Энэ юу вэ? ” гэж асуудаггүй, харин “Үүний тулд яах вэ? хэмээн асуудаг билээ.

Үүнээс улбаалан бодвоос, Дхьяни бурхад, тэдгээрийн үет тарни ба язгуур махбодь нь тус бүрийнхээ зохих хүрдүүдтэй холбоотой гэж үздэг билээ. Гэвч энэ нь тийм бус, учир нь энд дурьдсан махбодууд нь тэдний үзэл бодлын үүднээс авч хэлэлцэгдсэн бөгөөд тийм ч учраас билэгдлийн янз бүрийн зэрэглэлд байна. Жишээлбэл: Амитабха, “гал” махбодь хоёр харилцан холбоотой, тэгэхдээ дулааны шинж чанарыг илэрхийлэх талаараа бус, харин гэрэл гэгээ татуулж, юмс үзэгдлийг мэлмий дор харагдуулдаг гэдэг утгаараа болон “улаан” өнгөтэй чанараараа холбогдоно.

Эдгээр бүх билэгдлийн зэрэглэлүүд / категорууд / зөвхөн ганц утга илэрхийлэх, ганц тогтмол хэмжээг авах нь буруу юм. Жишээ нь: цорын ганц дүн гардаг томьёо буюу “А - Х” ба “В - Х” гэдэг тэгшитгэл манай бодлогод таарахгүй. Дээрх томьёог цааш үргэлжлүүлбэл, “А - В” болно. Гэтэл энэхүү тохиолдолд бид оюун ухааны үзэл санаатай харьцаж буйгаас тэгшитгэлтэй харьцсан нь үгүй. Гэвч эдгээр цуглуулга болон зэрэглэл нь санаан зоргын хэрэг хараахан биш ба харин өөрийн өвөрмөц жам ёсны дагуу зохиогдсон зүйл билээ. Энэ утгаар нь, бид тэдний хөдөлгөөнийг урьдаас тааж эс болох мөртлөө, бас ч зарим хуулиас шалтгаалдаг амьд бодистой зүйрлэж болох талтай билээ.

Хөгжлийг олсон билэгдэл бүрт нэг гол сэдэв зонхилох ёстой бөгөөд систем нь хэдий чинээ хөгжинө, түүний гол бүтцийн ач холбогдол төдий чинээ хязгаарлагдмал болно.

Бясалгалын үйл явцын билэгдэлд тэргүүлэх зарчим нь онолын сэдэв бус, харин практик туршлага, түүнээс үүдэлтэй сэтгэлийн хөөрөл, гаслан зовлон юм. Ийм болохоор

бясалгалын тогтсон таалал болгон, түүнчлэн тантрын хувийн бүлэг бүр уламжлалаа барьсан, багшаас шавьд өвлөгдөх хувь хувийн тогтолцоотой байдаг билээ.

Тийнхүү Дхьяни бурхан, тэдгээрийн сэтгэлзүй, бие махбодын төвүүдийн байршил нь цорын ганц, тогтоосон тогтолцоо байж таарахгүй. Тэр нь бясалгал үйлдэгч, түүний сонгож авсан билэгдэл, тэдгээрийн байршилт гэх мэт олон зүйлээс хамаарна. Бясалгалын үед бие нь өөрөө мандал болох ба түүний дотор хүрд бүр дээр зохих бага мандлууд оршино.

“Чакра” гэдэг нэр томъёо “мандал”-ын ижил утгын үг болж хэрэглэгдэх явдал олонтоо тохиолдоно. Тэр ч байтугай, биеийг тойрон буй гадаад ертөнц, усны дөлгөөн мандал дээр шидсэн чулуунаас үүссэн хүрээ улам өргөжин өргөжсөөр хязгааргүй төгсгөлдөө хүрэхээс нааш зогсдоггүйн нэгэн адил, бүгдийг хамарсан мандал үүсгэдэг билээ.

Тийм ч учраас Дэмчогын Тантрад өөрийгөө болон үзэгдэж харагдаж буй бүх юмсыг Бурханы мандал мэт, тэрчлэн сонсогдож буй авиа бүрийг “мантра” хэмээн үзвээс зохистой бөгөөд ухаанд орж буй утга санаа бүрийг Аугаа их билгүүн ид шидийн гайхамшиг гэж үзэлтэй.

Өөрөөр хэлбэл, бясалгал үйлдэгч бээр өөрийгөө мандлын төвд Пражнягын бүтээсэн Бурханы дүрээр төсөөлөх бөгөөд тэгвэл дасгал үйлдэгчийн зорилго биелэх нь тэр болно. Ингэснээр бүхий л дур зоргын үйлдэл алга болно. Ямар нэгэн илүү юм уу, хийсвэр / субъектив / дүгнэлт сэлтэнд байр үлдэхгүй: хорвоогийн юм бүхэн өөрөө ариун хүрээ, тойрог болон өөрчлөгдөж, тэнд йогчийн бие, орд харш болж хувирна. Ухамсарын ердийн баримт төсөөлөгдөшгүй нотолгоо болно. Харагдаж байгаа нь гүн үнэний билэг тэмдэг, сонсогдож байгаа нь мантра, харин биеийн сэтгэлзүйн хүрдүүд нь ариун дуганын таван давхар болно. Тэдгээр давхар тус бүр нь Дхьянын бурхадын титэм болон мандалтай байна.

Хамгийн доод буюу нэгдүгээр давхар - “язгуур хүрд”, түүнийг “шороо” махбодтой зохих шар өнгийн дөрвөлжин ба гурвалжинаар төлөөлүүлэх бөгөөд түүний харанхуй

саванд бүх үйл явдлын үр хөврөл боловсорно. Энэ бол нүгэл нүдээр гарах гэдэгтэй агаар нэгэн ойлголт юм. Түүний шинж чанарыг газрын эрчит ба эрчит бус махбодын шинж төрхтэй жишиж болно. Ийм учраас давхарын энэ хэсгийн эзэн буюу өөрчлөгчөөр нүглээ наманчилж арилгасан, өөртөө билгүүн ухааныг шингээсэн, бүхнийг бүтээж чадах үйлстэн Амогхасиддхийг сонгожээ. Түүний үет тарни нь “А” болой.

Чакрын эзэн нь ямар нэгэн бурхан сахиус бус, гагцхүү тухайн хүрдийг дүүргэх буюу идэвхжүүлэхэд чиглэгдсэн хүчний билэгдэл болой. Энэхүү билэгдлийн сонголт нь уг хүрдний үүрэгт аль зэрэг тохирохоос шалтгаалах ёстой. Билэгдэл нь чакрын зарим нэгэн шинж чанартай тохирч байх ёстой хэдий ч, зарим нэгтэй тохирохгүй өвөрмөц онцлогтой байж болно.

Хоёрдугаар давхар / “хүйсний төв”/ - ийг цагаан өнгийн зээрэнцэг буюу дугуй / дусал маягтай / - гаар дүрслэх бөгөөд “усан” махбодтой дүйцүүлж агуу их тэгшитгэгч Дхьяны бурхан Ратнасамбхавагын чанарт зэрэгцүүлнэ. Түүний тэгшитгэлийн ухаан нь бүх юмсын үндсэн нэгдлийн тухай ухаан мөн. Түүний тарнийн үе нь “Дам” болно.

Бүдүүлэг махбод “хүйсний хүрдэнд” ороод амьдралын буюу сэтгэлзүйн сайжралыг олно гэж Дэмчогын тантрад дурьджээ. Цаашилбал, энэхүү хүрдэнд дөрвөн дэлбээт лянхуа, түүний дэлбээнүүд нь цагийн зүүний дагуу баруун тийш нар зөв эргэлдэх ба дараах чанартай гэж үздэг.

Праны мөн чанар буюу “Шороон” махбодын амьдралын зарчим

“Усан” махбодын амьдралын зарчим

“Гал” махбодын амьдралын зарчим

“Хий” махбодын амьдралын зарчим

Эдгээр махбодын дагуу тарнийн үеийг харж болно.

Шар Лам

Цагаан Бам

Улаан Рам

Ногоон Ям

Лянхуан дотор “хий” буюу “акаша” хэмээх амьд орон зайн буюу огторгуй махбод / төвдөөр: намхай / нь цэнхэр цэгийн байдлаар оршино гэж төсөөлөх нь зүй ёсны юм. Мөнхүү судрын өөр нэг хэсэгт дөрвөн их махбодын амьдралын зарчмыг ариун сүм, биеийн “дөрвөн хаалга” гэж нэрлэжээ.

Гуравдугаар давхар нь зүрхний төвд хамаарах бөгөөд улаан гурвалжин / конус буюу пирамид / - аар төсөөлөгдөнө. Тэрээр сүмийн төв буюу дундах давхарыг үүсгэнэ. Тэнд гал бадарсан ариун тахилын ширээ байх ба галын дөл нь манай хувь хүмүүсийн муут уусган хайлуулж цэвэрлээд, анхдагч махбодыг нь сэргээнэ. Энэхүү ариун дөлийн тарнийн үе нь “Хум” бөгөөд дүрс нь Важрасаттва - Акшобхъя болно. “Хум “ нь оюун ухааны нягтралын билэгдэл, Важрасатвагын онцгой үүрэг сэлтийн талаар дараагийн бүлэгт тодорхой гарна.

“Хоолойн хүрд” - д хамаарах дөрөвдүгээр давхар нь “хийн” махбодид зоиулагдах бөгөөд нумны хагас цагираг буюу ногоон өнгийн хагас дугуй биеэр билэгдэл болгоно. Бид Лүн гэдэг төвд үгийн янз бүрийн агуулгатай тааралдаж байсан бөгөөд тэр үгийн санскрит утга нь “прана” буюу “вайю” юм. Хөвчилж татсан нум бол, энэхүү махбодын хүчирхэг шинжийг илтгэнэ. “Хоолойн хүрд” - ийн хувьд, тэрээр / лүн буюу хий / нь амь оруулагч амьсгал төдийгүй, үг яриа, бүх төрлийн дуу авиа, бүх нарийн чичэрхийллийн эх үүсвэр бөгөөд тэдгээрээс бүх юмны олон янз хэлбэр буюу мантра, мэлмийн харааны үндэс үүснэ. Ийм учраас дотоод үзэхүйн танин мэдэх үндсийг эзэмшигч Амитабха / түүний амьдралын хязгааргүйг төлөөлүүлэн харуулдаг Амитаюс буюу Аюуш бурхан идэвхтэй дүрсэлдэг шиг / нь уг хүрдийн эзэнд тооцогдоно. Түүний тарнийн үе нь “Хри” болно.

Үүнд: “Х” - нь амьсгалын авиа, бүх амьдралын билэгдэл

“Р” - нь галын авиа, / Рам /

“И” - нь оюун ухааны дээд идэвхи, ялгаралыг төлөөлдөг чичэрхийлэлтийн хамгийн гүнзгийрүүлэгч эгшиг юм.

Тавдугаар буюу хамгийн дээд давхар нь тэргүүн буюу толгойн оройн хүрдэнд хамаарна. Тэрээр орон зайн махбод буюу “огторгуй” / акаша, төвд: намхай / - гаар буюу

билэгдлийн гал дөл болсон цэнхэр дусал / бинду / - аар төсөөлөгдөнө. Түүний эзэн савдаг нь жам хууль буюу Дхарма - дхатугын гайхамшигт бадруулагч Вайрочана юм. Тэрээр Огторгуй махбодын эхэд тэврүүлэн сууна. Түүний тарнийн үе нь “Ум” болно. Сэтгэлзүйн мэдрэмжийн хүрдүүд, махбодиос тарнийн үсэг, Дхьяны бурхадын хоорондын харилцаа нь “бие” / кайя, төвд: Ски /, “хэл” / вак, төвд: гСунг /, сэтгэл / читта, төвд Тхугс / гэсэн гурван зарчимтай дүйцэх бөгөөд сэтгэлзүйн бүх чанарууд болон бясалгал үйлдэгчийн хүч чадлыг нэгэн аяст оруулж жигдрүүлсэний дараа доор дурдсан гурван зарчимд шилжинэ.

1.Тэргүүн буюу толгойн хүрдэнд орших бүхнийг хамрагч, иж бүрэн биеийн зарчим / Ум /

2. Хоолойн хүрдэнд бүрэлдэж бүхнийг хамрагч, мантрагын хэлний зарчим / гСунг /
Зүрхний хүрдэнд боловсорч бүхнийг хамрагч, гэгээн энэрэн нигүүлсэл буюу бодь сэтгэл / бодхичитта /, бүх бурхад / Хум /, эдгээр болно.

Бүдүүвч зургийн баруун тал дахь цэглэлтээр үзүүлсэн шугамууд нь өнгөний зохицол дээр суурилсан билэгдлийн категори дахь элементүүд болон Дхьяни бурхадын хоорондын уялдаа холбоог үзүүлж байгаа юм.

Энэхүү бүдүүвч зураг нь дээр үзүүлсэн таван махбодын билэгдлүүдийн шинж байдлыг харуулах буюу Төвдийн “Чортена” / чходтен / буюу сувраганы бүтцийг харуулна. Энэ нь урьд өмнө Бурхан багш болон түүний шавь нараас үлдэж хоцорсон зүйлүүдийг ариун нандин шүтээн болгон хэрэглэж байсан Энэтхэгийн сувраганаас / чайтъя, дагоба / үүсч хөгжсөн шашны архитектурын байгууламж юм. Сувраганы хөгжил билэгдлийн талаар “Сувраганы билэгдлийн зарим асуудлууд” / Лондон, 1940 / нэг сэдэвт зохиол, тэрчлэн “Сувраганы уран барилга, түүний хийцийн хөгжилд Нарны болон Сарны билэгдэл” гэсэн шүүмжлэл / Бомбей, 1950 / зэрэг миний бүтээлүүд болон түүнээс гадна Жүзеппе Туччийн “Энэтхэг, Төвд болон баруун этгээдийн суврага ба сац” бүтээлийг үзнэ үү. / Рим, 1932 /

Гэхдээ, Төвдөд эдгээр байгууламжууд нь цэвэр билэгдлийн шинжтэй бөгөөд оворт урлагийн аргаар хийгдсэн мандлууд юм.

Ийм мандлуудын нилээд үзэсгэлэнтэй, тод жишээ бол сүүдрэвчтэй, давхарласан дуган хэлбэртэй Гъянцзе дахь “Буман бурхадын суврага” юм. Энэхүү суврага бол бараг 100 шахам жижиг бурхантай, тус бүр нь жижиг мандалтай, тэдгээрт олон мянган зураг, баримал дүрсүүд хоршдог. Мандал тус бүр нь найман мянга гаруй дүрсүүдийг агуулдаг.

Доод давхарын шоо хэлбэртэй хэсэг нь “усан” махбод, алтадсан гурвалжин хэсэг нь “гал” махбод, түүний дээрх шүхэр хэлбэрт хэсэг бол “хий” махбод юм. “Огторгуй” хэмээх язгуур махбодын цацарсан дусал нь амьдруулагч рашаан / амрита - калаша, төвдөөр: аюкалаша, төвдөөр: цхе - бум / нь бумбатайгаа байна.

Дөрвөн их элементүүдийн билэгдлүүд Миларайбын намтарт онцгой үүрэгтэй. Түүний багш Марба нь, түүний оюуны хөгжилд саад болж буй өнгөрсөний хилэнцэт үйлдэл болон бусармаг хувь тавилангаас түүнийг хэлтрүүлэхийн тулд, дөрвөн байшин барьж, дөрөвдүгээрхээс бусдыг нь нураахыг түүнд тушаажээ. Төлөвлөхдөө, эхний байшин нь дугуй, хоёр дахь нь хагас дугуй, гурав дахь нь гурвалжин, дөрөв дэхь нь дөрвөлжин байжээ. Өөрөөр хэлбэл, Марба багш түүнийг ус, хий, гал, шороо гэсэн дөрвөн махбодод сэтгэлээ төвлөрүүлдэг болгосон ба эдгээр нь амирлангуй / шива /, дэлгэрүүлэх / ргъяс - па /, өөртөө зохицуулах буюу засаглалыг эрхэмлэгч эрх / ван / болон эвдэн бусниулах догшин / драг - па / гэсэн дөрвөн төрлийн үйлдэлд тохирч байдаг. Тэр иймэрхүү байдлаар өөрийн урьд өмнө үйлдсэн бүх үйлийг устгах ёстой бөгөөд эхлээд тэдгээрийг сэргээн босгоод, дараа нь “шороон” язгуур махбод бүхий суурь төвийг нь хүртэл, дэс дараалан нураах юм. Зөвхөн энэ үед л, түүний оюуны шинэ амьдрал болох сүүлчийн байшинг барьж эхлэхийг түүнд зөвшөөрдөг билээ.

12. Тарнийн үсэг Хум нь таван билгүүний нэгдэл болох нь

“Дотоод гал”-ын йогийн үйл явцыг үзэж байхдаа, янз бүрийн үе шат дамжлагыг бид нэгэнт мэдсэн билээ. Эхний үе нь газарт шахагдан буй доод хэсгийн, биеийн болон язгуур махбодын бүх бөөгнөрсөн хүчнүүд задарч хий болон ууршиж, биеийн доод хэсгийг бүлээний дотоод галын дулаанаар дүүргэж эзэмшсэнээр тодорхойлогдоно. Иймээс “хүйсний хүрд” -ийг сэтгэцийн дулааны гол эрхтэн буюу эсвэл, чухал үндсэн цэг гэж

нэрлэдэг. Ийм байдлаар доод хүрдүүдийн саадыг арилгаснаар, бясалгал нь найдвартай суурь дэвсгэртэй болж, тэгсэнээр оюун санааны нэгдэлд хүрэх гол зорилгод шилжиж байгаа юм.

Энэ нь бясалгалын хоёрдугаар үе шатанд, өөрөөр хэлбэл, өөрийгөө хязгаарлахуй, “би” болон “би бус” гэсэн хоёрдмол байдлыг давсан түгээмэл ухамсарын ололт амжилтын үед явагдана.

Гурав дахь үе шат нь, оюун санааны бүх ололт амжилтыг амьдрал, амьдралын үйл ажиллагаанд барагдан дуусах хүмүүний түвшинд буцаана. Энэхүү бясалгалын үйл явцын эзлэх байр нь “Очир биет” буюу Важрасатва / Доржсэмбэ / биеллээ олж, хүний зүрх бөгөөд “Хум” тарнийн үсэгт тусгасан, газар сайгүй бий болох хүч юм. Тэр бол Акшобхъя бурханы идэвхтэй тусгал бөгөөд ертөнцийг өөрчлөгч түүний төлөв юм.

Важрасатвад Дхармын хүрээний дээд бодит чанар тусгагдсан бөгөөд тэр нь бодгалын төвшин дээрх ухаарал болно. Важрасатва нь Толь мэт агуу их билгүүний идэвхт туяа бөгөөд хоосон чанар ба үзэгдэл дэхь “Хоосон чанар”, “Хоосон чанар дахь үзэгдэл” аль алиных нь толь болно. Тэрбээр иж бүрэн бүтэн үндсийн мэдлэг, үзэгдэл тус бүрийн бүрэн бүтэний дотоод ертөнцийг мэдрэх мэдлэг, эс төгсөхүйгээс төгсөхүйд, цаг хугацаанаас ангид шилжих үзэгдлийн мэдлэг юм. Тэр бол зүрхний “Важра” буюу “Очир” юм.

Хэрэв “Ум” нь иж бүрэний өгсөлт бол, “Хум” нь иж бүрдлийг зүрхний гүн тийш уруудуулагч бөгөөд “Хум” нь “Ум”-ын санааширлыг агуулж, бүх таван Билгүүний нэгдэл болно. Энэ бол үгээр тодорхойлогдох мэдлэг бус, ухааны эсрэг объект буюу оюун санааны төлөв байдал болно. “Йога нь гадаад тусгалыг дотоод тусгал” болгосныг хэлнэ. Йогийн мэдлэг туршлага бол мөн чанартаа, амьдралыг өөртөө бясалгах, дагах гэсэн үг юм. Ертөнцийн амьд, бүхэл бүтэн юм бүхэн нь, ямар нэг байдлаар гадны юм багтаасан бол, тэр нь мэдрэмжинд тусгагдах ухамсарт тогтоно. Энэхүү ертөнцийн дотор нь оршиж буй, ямар нэгэн бодит байдал мэтээр түүнийг төсөөлж болно. Түүний хүчнүүдийн хоорондох хэлхээ холбоонуудыг судалж, тэдгээрийг зүй тогтол хэмээн ойлгож болно. Шинжлэх ухаан бол ийм л замаар замнадаг юм. Өөрийгөө ертөнцөөс салангид зүйл хэмээн ертөнцөд

сөргүүлэн бодохгүй байвал, юмсын хэлбэр дүрсийн талаар ертөнцийн зүй тогтол гэж, юмсыг салгаж үздэг ойлголт ч үгүй болно. Тэгээд ч бүхэл бүтэн ертөнцийг дотор нь ялган салгаж, нэр оноох нь зөвхөн мэдрэмжийн асуудал бөгөөд өөрийн гэсэн ахуйтай юм. Үүнээс үүдэн гарсан “бодитой” ба “бодитой бус” / Н. Zimmer, 111 - р хуудас / гэсэн ухагдхууны хувьд, тэр нь зөвхөн адилтгах үзлийн үүднээс л үздэг жам ёсны зүйл гэж хэлж болно.

Ийм учраас “Дэмчог тантра” -д өгүүлсэнээр, “Хум” нь бүхий л утгын агуулга буюу үзэл баримтлалаас чөлөөтэй ухаан юм. / Зин данг брал - пай семс / “Хум” ба түүний үзэгдэх хэлбэрийн / Энэтхэг болон төвд сударт тэмдэглэсэнээр / таван хэсэг нь таван Дхьяни бурхан болон тэдгээрийн Билгүүнд тус тус тохирдог. “Хум” гэдэг үеийн доод хэсэг болох “у” эгшиг нь уг эх бичгийн ёсоор Амогхасиддхийн Билгүүнд тохирдог бөгөөд энэ нь бүхий л үйлсийг төгс төгөлдөр болгодог / бъя - ва груб - пай йе - шес / - д дүйцнэ. “Х”- ийн толгой / бүх үсэгт нийтлэг байдаг бөгөөд бурханы сэнтий буюу мантрын дуу авиа бүрт амилан байдаг бүтээлч хүч болох хөндлөн зураас / нь, адилтгалын байдалд буюу Ратнасамбхавын тэнцэл / мням - па ньид кьи йе - шес / - д дүйцнэ. Хагас саран хэлбэрт тэмдэг нь Акшобхьягын толь мэт Билгүүн / ме - лонг лтабуй йе - шес / -д дүйцэх ба дөлт цэг / галын дөлний билэгдэл / буюу дусал нь / тигле / Вайрочаны Дхарма - дхату Билгүүн / чхос - кьи дбьгсгьи йе - шес / - д тус тус дүйцнэ.

Эдгээр таван хэсэг нь тус бүртээ таван Дхьяни бурханы нэгэнд нь тохирдог өнгөтэй байна. “У” эгшиг нь ногоон өнгөтэй, “Х” үсгийн бие нь улаан өнгөтэй, “Толгой” нь шар өнгөтэй, хагас сар нь цагаан, “Цэг” буюу тигле нь цэнхэр буюу хөх өнгөтэй байна.

Энэ бол мантрагын амьд билэгдлийн жишээ бөгөөд түүнийг сонсож, дуудаж болох дотоод, гадаад дуу авиа болох төдийгүй, тэр нь бас өөрийн дотоод хэлбэртэй байх ба эцсийн эцэст бясалгал үйлдэгчид орон зайн объектив байдлаар төсөөлөгдөх бурханы үзэгдэл юм.

Дээр өгүүлсэнээр, тарнийн үсэг “Хум” нь цэнхэр, ногоон, улаан, шар өнгийн гэрэлт туяа цацруулдаг бөгөөд энэ цацрагуудыг эрхэм дээд таашаалын биелэл болох

Чакрасамбара буюу Махасукха, / төвдөөр: Дэмчог/ хэмээх гол бурханы дөрвөн нүүрнээс гарч буй цацраг гэж хэлж болно. Эцсийн дүнд бүх хорвоо ертөнц нь энэ цацрагаар дүүрдэг. Цагаан өнгө нь энд заагдаагүйг тэмдэглэх хэрэгтэй. Үүний шалтгаан нь цагаан өнгө бол Махасукхийн дотоод мөн чанар бөгөөд тэрээр өөрт байгаа бүхнийг нэвтрэгч, нугарашгүй “хоосон чанар” Важрасатвагын дүрээр нээгдэнэ.

Бясалгагчийн дотоод ой ухаанд мантрагын билэгдэл нь үүсгэлийн зэргийн үе шатандаа боловсрон хөгжиж, бясалгал үйлдэж буй юмтайгаа өөрийн бие сэтгэлийг адилтгах замаар урт удаан хугацааны дасгал сургууль хийсний үр дүнд, ухаарч ойлгосоны дараа л бясалгагч нь ийм байдалд хүрч очих ёстой. Энэхүү үл дийлдэгч “хоосон чанар”-ыг хэрэгжүүлэхийн тулд, бясалгагч нь бясалгалын явцыг төгсгөлийн зэргийн шат руу хандуулах ёстой бөгөөд “Хум”-ыг дороос нь “У” эгшгээс эхлэн эргүүлнэ. Тэгэхдээ “У” эгшгийг “Х”-ийн биед орохоор, “Х”-г түүний “толгой” -д, “толгой”-г тал саран тэмдэгтэд, тал саран тэмдгийг дүрэлзэж байгаа дөлт цэг / тигле / -г тус тус орохоор эргүүлнэ. Цэг нь хоосон орон зайд шингэх хүртэл буюу цэг нь цэвэр тантрын дуу авиа шиг чичэрхийлэх хүртэл буюу цэг нь анир чимээгүй байдалд уусч алга болох хүртэл энэ үйлдлийг хийж гүйцэтгэнэ.

Энд үгээр илэрхийлж болох зах хязгаарт бид хүрэх юм. Тиймээс ч тантрын билэгдлийн хэлний түвшинд үлдэх нь бидэнд илүү бөгөөд түүний адил төстэй талууд, үгийн хэмжээ хязгаараас хальсан нууцад нэвтрэн ороход тус дөхөм болох юм.

13. Бясалгалын үйл явц дахь Дагинийн

үүрэг ба “Хум” тарнийн үсэг

Бид Важраянын мантрагын бясалгалын практик дахь “Хум” хэмээх тарнийн үсгийн гүн гүнзгий агуулгыг бүрэн төгс ойлгохыг үнэхээр хүсвэл, энэхүү өрнөдийн сэтгэлгээ, мэдрэмж огт ороогүй уг системийн үзэх төлөвийг судлахад өөрсдийгөө зориулах ёстой юм. Мөн чанараараа “Хум” -тай сүлжилдэх, хөндлөнгийн гаж зүйл мэт санагддаг, амьд билэгдлийн тухай бид дээр өгүүлсэн билээ. Тэдгээр нь сайтар журамлагдсан бидний

сэтгэлгээний ертөнцөд оруулах боломжгүй учраас л ер бусын, аймшигтай аюултай мэт санагддаг юм.

Энэ бол “Хум”-ын үгээр илэрхийлэн тодорхойлж болшгүй чанарт шингэсэн билгүүний тал бөгөөд бид сэтгэлгээний туйлын чанарт хоромхон зуур гарч чадвал түүнийг мэдрэх болно. Тиймээс оршихуйн хязгаарыг нэвтлэн үл мэдэгдэхүйд үсрэн орох хүсэл төрүүлэгч, юмсын жинхэнэ мөн чанарт төрөлх мэдрэмжээрээ хоромхон зуур нэвтэрдэг онгод л түүнийг мэдрүүлдэг юм.

Важрасатвын ер бусын чанар нь нэгэн чиглэлд, бүхэл ба хэсгүүдийн, цаг хугацаат ба хугацаагүйн, нийтлэг ба хувийн, оршихуйн ба эс оршихуйн, хоосон ба биетийн харилцан үйлчлэлд оршдоогоороо онцлог юм. Энэхүү ер бусын, чанарын биелэлтийн зам нь эсрэг тэсрэг хоёр туйлын хоорондох ёроолгүй ангальн дээгүүр харайхад хүргэнэ.

Ийнхүү харайх зориг зүрхийг олохын тулд, сэтгэхүйн ер бусын хүчирхэг түлхэлт авах хэрэгтэй. Ийм түлхэц нь тантрын нууц сургаалд Дагинын дүрээр оршдог бөгөөд Дагина нь хүмүүн ба хүмүүн бусын хэлбэрээр илэрч, шидтэнгүүдийн / сиддхи / чухал үүрэг гүйцэтгэдэг эрдэм ба ид шидийн хүчнүүд эмэгтэйн дүрд цогцолсон байдаг.

Энэтхэгийн шидтэнгүүдийн утга зохиолын онцлог болох цэвэр билэгдлийн хэлээр бичигдсэн “Бадмасамбхавагын намтар”-г, нэгэн Дагина Буддын йогын нууцыг тайлсан тухай өгүүлсэн байдаг. / W. Y. Evans - Wentz, 1954, 131 -р хуудас /

Дагинын тухай сударт өгүүлэхдээ, тэр үхэгсдийг тавьдаг газрын дунд буй зандан модон шугуйд, хүний гавлаар барьсан өргөөнд суудаг бөгөөд Бадмасамбхаваг очиход, үүд хаалга нь цоожтой, шивэгчин нь ус зөөж явах нь харагдана. Тэгэхэд нь Бадмасамбхава анхаарал төвлөрүүлэх аргаар биеэ захиран, түүнийг ховсдож барьдаг.

/ Иймэрхүү баримтыг “Лалитавистара” судраас олж болох ба залуу Сиддхартха Бодь модны дор суугаад гүн бясалгалд орчихсон байсан яг тэр агшинд, түүний дээгүүр рид хувилгааны хүч төгөлдөр таван шидтэн түүнийг хорлохоор эргэлдэн ниссэн боловч, Сиддхартха тэднийг бясалгалын хүчээр болиулж чаджээ. /

Шивэгчин эм болороор хийсэн хутгаар цээжээ ярахад, биеийнх нь дээд хэсэгт дөчин хоёр амгалан дүрт бурхан, доод хэсэгт тавин найман догшин дүрт бурхан харагдахуйд шивэгчин эм Бадмасамбхавад хандаж, “Чи ид шидтэй, их гайхалтай ламтан байна. Гэхдээ, над руу хар. Чи надад итгэж байна уу, үгүй юу?” гэхэд нь Бадмасамбхава түүнд сөгдөн мөргөж, “Эрж яваа эрдмийг минь зааж соёрхоно уу” гэжээ. Шивэгчин эм: “Би ердөө л зарц эм, та дотогшоо ор” гэж хариулжээ.

Ордонд ортол, нар саран суудал дээр завилан сууж, гартаа дамар, гавал, аяга барьсан Дагиныг гучин хоёр дагина нөхөр сэлт нь хүрээлэн байхыг харав. Тэрхэн мөчид Бадмасамбхавагын толгой дээгүүр дөчин хоёр амгалан дүрт, тавин найман догшин дүрт бурхад хүрээлэв. “Энэ бурхадыг харж байна уу? Авшиг хүрт” гэжээ.

Бадмасамбхава: “Мөнх ертөнцөд бурхан бүр багш байсан. Намайг ч гэсэн шавь оруулна уу” хэмээн гуйв. Бурхад Дагинын биед шингэж, Дагина бээр Бадмасамбхаваг “Хум” болгон хувиргахад, Бадмасамбхава Дагинын уруул дээр тогтохуйяа, Амитабха ходоодонд ороод, Авалокитешварагын нууц сургаалыг мэдээд “Язгуур хүрд”- ийн төвшинд хүртэл доошлоход, Дагина түүнд бие, хэл, сэтгэлийн их хүчийг юүлжээ.

Намтрын энэ хэсэгт, олон чухал мэдээлэл буй боловч түүний утгыг ухаж ойлгохын тулд, Төвдийн бясалгалын ухаанд Дагина ямар үүрэгтэйг мэдэх хэрэгтэй. Санскрит хэлний сонгодог бүтээлүүдэд Дагиныг хүүрийн газар зэрэг айдас төрүүлэм, бөглүүд газарт оршдог, хүмүүст аюултай шулам мэтээр дүрсэлсэн байдаг.

Гэвч, усан нүдтэн, цусан зүрхтэнийг айлгадаг ийм газар бол ганцаар бясалгал хийж, махбодыг захирах хамгийн тохиромжтой газар гэж йогууд үздэг байна.

Эгэл ертөнцийн айдас хүйдэс, итгэл найдвар нэвтэрч орохооргүй, тийм газарт Дагина бясалгалын ид шид, оюуны хязгааргүй хүчийг олжээ. Тэдгээр нь ухааны болон сэтгэлийн гүнд нойрсогч чанаруудыг өдөөн, сэргээгч хүч байв.

Энэхүү Дагинын тухай төсөөллийн өөрчлөлтийг бясалгалын Буддист сургаалын нөлөөгөөр / ялангуяа МЭ VI - VII зууны үеийн төвд орчуулганд тусгасан байдаг. Үүнд, Дагиныг төвдөөр: Хандмаа / мКха - Грома / гэж орчуулдагын “Ха” / мКха / нь “акаша”,

“эфир” гэсэн утгаар бол “огторгуй” гэсэн үг бөгөөд энэ нь Буддизмын сургаалаар, тав дахь язгуур махбод болдог ажээ. Өөрөөр хэлбэл, энэ нь хөдөлгөөнт үйлдэл буюу / билэгдэл нь “хий” буюу төвдөөр: рЛунг /, үзэгдэх / төвдөөр: сНанг-ва / хэлбэрүүдэд уриалах боломжтой боловч, өөрөө энэхүү нөхцөлд хөдөлгөөнд ордоггүй, үзэгдэж харагддаггүй зүйл гэж ойлгож болно. Түүний тоон билэгдэл нь - тэг, түүний гүн ухааны болон метафизикийн тэнцэл нь - хоосон чанар, харин түүний сэтгэхүйн тэнцэл нь - оюун санааны өндөр ухамсар буюу ухаан / сем - нид / юм.

“Тро-до” буюу “ндо” нь “явагч” буюу “одогч” гэсэн утга агуулна. Хандмаа ба Дагина нь Буддизмын тав дахь язгуур махбод болсон “акаша” буюу “огторгуйд” хөдөлж, түүний мөн чанарыг нэвт шингээсэн эм хүйсийн тэнгэр юм. Дагина нь эрхэм дээд эрдмийг төгс эзэмшсэн бөгөөд хүн, бурхан, шулмас ямар ч дүртэй байсан, эрдмийн болон гээрлийн зам мөрийг дагасан хүнд, ялангуяа йогуудад газарчлан замчлагч юм.

Бясалгалын ухагдхуун болон йогийн хэлээр бол, Дагинас нь биет бус бөгөөд хүний далд ухамсарын гүнд нойрч байсан оюун санааны сэрэл, хүчнүүдийн нэгдэл юм. Ухамсарын энэхүү үйл явцыг өдөөсөн түлхэлт нь түүний хөгжилтэй шууд хамаарлаар өсөх ба билгүүний далд гэгээ, түүний нууцыг нээх хүртэл өдөөн түлхэгч хэвээр байна. Энэхүү билгүүн нь ертөнц дэхь юмсын боол болсон хүмүүст аймшигтай авч, “үнэн”- тэй атгаг санаагүй нүүр тулж чадах хүнийг л авардаг юм.

Иймээс билэгдлийн хуулиар, эрхэм дээд журмын Дагинас нь нүцгэн байх ёстой бөгөөд тэд бол нүцгэн бодит байдлын мэдлэгийн цогц, нүцгэн үнэнийг байгаагаар нь харахад зайлшгүй хэрэгтэй, аймшиггүйг илэрхийлэгч юм.

Энэ бол байгалийн сохор хүчин бус, харин түүнийг удирдан залах билгүүний чадвар бөгөөд харин суу билгийн бүтээлч ухамсараар байгалийн хүчийг өөрчлөхөд зоригжуулж байдаг хурц гэрлүүд юм.

Тийнхүү Буддын йогад хүчний тал буюу Шактид дулдуйддаггүй, харин билгүүн буюу Пражня -д түшиглэсэн байдаг билээ. Буддын системд Шакти буюу Кундалиний тухай дурдсан зүйл байхгүй төдийгүй, тэрээр бясалгалын объект ч болдоггүй аж. Ийм ч учраас

бясалгалын Буддист системийг тантрын Индуизмын Кундалинд хамаатуулах нь, түүнийг Кундалин йога гэж нэрлэхтэй адил учир дутагдаалтай зүйл болно. “Наропын зургаан сургаал” йогад Кундалиныг харааны дасгалд оруулаагүй бөгөөд йогчинд, “Тус бүр шүхрийн савх болон дугуйтай төсөөтэй дөрвөн чакра дээр бясалгал хийгтүн” гэж зөвлөжээ. Чакрын тухай сонгодог тодорхойлолтыг “Мундака упанишада” судраас ч олж болох бөгөөд түүнд: “Ара ива ратханабхау самхата йатра надъях” / “Надинууд нь дугуйнд бэхлэгдсэн савх мэт” 2, 2, 6 / гэжээ.

Зүрхний чакрад, хоёрдугаар зэргийн хэдэн зуун нади бөөгнөрсөн байх ба чакрын авандуди босоо шугамаар хурдалж байдаг. Дугуй хэлбэрт дөрвөн чакра нь бүгд нийлээд галт хүрд болно. / Энэ нь хүрдэн дор Илия ба Ёнохогын бошиг үзүүлэгчид тэнгэрт заларч байдаг галт хүрднүүдийн нэгийг санагдуулна. / Тэдгээр дөрөв буюу оройн болон хоолойн хүрд нь өмнөх, хүйсний болон зүрхний хүрд нь арынх тус тус болно.

Бясалгалын төвд, Дагина орших ба түүнийг Ваджра йогини буюу Доржналжормаа хэмээнэ. Энэ бол Буддын тантризм, оройн Кундалин йогийн бодит хүчийг үгүйсгэж, ач холбогдлыг нь бууруулж байгаа хэрэг огт биш, харин тэдгээрийн арга нь өөр, нөлөөлөх хэрэгсэл нь ч өөр гэдгийг харуулж байна.

Усны энерги нь хүрхрээнийхээ цутгалан шиг ширүүн, догшин, омголон хэлбэртэй байдаг атугай ч, түүнийг номхотгож, залж, хуваарилж янз бүрээр ашиглаж болно. Түүн лугаа адилаар, Буддын тантра - йогад анхаарлыг Кундалин / язгуур хүрдэн / дээр бус, харин түр зуурын цөөрөм, шанд дээр буюу дээд талд нь угсарсан энерги хураагч мэтээр, гүйдлийн хүч нь тохируулагдаж байдаг суваг дээр төвлөрдөг юм.

Кундалин хэмээх байгалийн хүчний оронд, ухамсарын зарчим буюу билгүүн / пражня / -ийг тэтгэн зоригжуулагч, Дагинын хэлбэр түүний мантрын тэнцүү чанараар илэрхийлэгдэнэ. Тэрээр / Кундалин / замын саадыг арилгаж, авандудийн үүдийг нээж, чөлөөлөгдсөн хүчнүүдийг зөв чиглүүлнэ.

Дагина нь Видьяагын бүх эмэгтэй хувилгааны нэгэн адил, эсвэл анхаарлын төвлөрөл, хүчний чангаралт, нэгдэн нийлэлтийн шинж чанарыг агуулагч гэгээрэлд хүргэгч,

зоригжуулагч бамбарын дөл нь шатаж бөхөөгүй цагт, хадгалагдсаар байдаг билгүүн мэт аж.

Иймд дотоод үзэхүй буюу бясалгалын үйл явцад зориуд тусгасан, хэлбэр үүсгэгч Дагина нь дүрэлзсэн дөл маягаар төсөөлөгдөж, “Хум” хэмээх үет тарниар болон нэгдэж нийлэхийн мантрын билэгдлээр дуудагддаг. Тэдгээр нь Дотоод галын биелэл буюу Миларайбын намтарт нэрлэснээр “Дагинын бүлээн амьсгал” юм. Тэрээр бүлээн амьсгал / хий / нь гэгээнтнийг “зөөлөн шинэ жанч” адил бүрхэн хамгаалж байдгийг В. Эванс - Вентсийн яруу найргийн хэлээр орчуулбал:

“Чамайг ариутган, Дагинын дулаан амьсгал нь

Цэвэр бөгөөд зөөлөн жанч адил илбэнэ”

хэмээжээ.

Билгүүн нь олон хэлбэр, зэрэглэлтэй байдгын адил, Дагина бол Кама -дхату төвшингийн Лока - Дагина / Жигтэн Хандмаа / - аас эхлээд “Пражня”-гын хэлбэрээр эцэг, эх хэмээх хос нэгдэлд холбогддог Дхьянын бурхадын эмэгтэй талын хэлбэрүүд хүртэл олон янзын дүр төрхтэй болдог.

Бясалгалын явцад анхаарал төвлөрүүлэх дасгалуудын эхний шатанд, / пали хэлний гол сударт, үүнийг “сатипаттхана” гэдэг / Дагинууд нь биеийг ухааран ойлгож байх мэт, бодол ухааралд тохирдог. Иймээс Дэмчог тантрад өгүүлэхдээ, биеийн хувьд дагиныг анхаарал хэмээн үзэх хэрэгтэй. Хандмаа / мКха - гро - ма ни лус – рЖес - су, дран - по / бурханы дүрээр илрэн гарсан хэлбэрүүдийг бясалгалын зам засагч туршлага хэмээн ойлгох хэрэгтэй / лха - рНамс лам - гьи нго - бор дран - пар бъяо / гэжээ. / Avalon, 1919 /

Дагинын бодит байдал нь “Эм шулам” болон “Сахиулсан тэнгэр”-үүдийн бодит биелэл адил дүр төрхтэй, тийм л туршлага практик дээр оршин байх бөгөөд аливаа гадны баримтат зүйл дээр оршин байдаггүй юм. Энэхүү бодит биелэл нь бурханы үзэл бодлын үүднээс авч үзвэл, гаднын юмсын бодит байдлаас хавьгүй хурц, тод юм. Учир нь энэхүү бодит биелэл нь өнгөц мэдрэмж, мэдрэх ойлгоц, ухаарлаас шууд гардаг юм.

Дагинын эрхэм дээд, өөрөөр хэлбэл, хамгийн төгөлдөр хэлбэр нь Ваджра - дагинын, ялангуяа Ваджра - йогини / Доржналжормаа / - ийн янз бүрийн хэсгүүдтэй адил, нугарашгүй хоосон чанарын хүрэн дэхь бурхадын Билгүүныг өөртөө шингээсэн хэлбэр юм. Үүнийг бясалгалын үе дэхь туршлага ажиллагаа нь дээд цэгтээ хүрдэг хэмээн үзэх байм Дагина бол Бадмасамбхавад авшигыг бий болгож өгдөг.

14. Бадмасамбхавагын авшиг хүртэлт

Бадмасамбхавагын Дагинаас авшиг хүртсэний нууц сургаалын утга санаа юунд орших вэ?

Оршуулгын газрын дунд, зандан модон шугуй буюу цэцэрлэг байх нь сансарын ертөнц бөгөөд гаднаас нь харахад сэтгэл булаам үзэсгэлэнтэй үхэл нурангиар сансарын ертөнц хүрээлэгдсэн байна. Дагина нь хүний гавлаар бүтээгдсэн ордонд амьдрах бөгөөд олон сая амь насны өвөөс бүтээгдэж хийгдсэн, өнгөрсөн үеийн материаллаг хүний бие, хэл, сэтгэлийн үйлийн үр / карма / юм.

Бадмасамбхаваг ирэхэд, ордны хаалга цоожтой байх бөгөөд тэрээр юмс үзэгдлийн утгыг тайлах түлхүүрийг олоогүй байгаа хэрэг тэр ажээ. Тус биеийн үнэн шинж чанар, түүнд мэдэгдээгүй байгаа юм.

Дараа нь ордонд ус зөөж яваа шивэгчин нь гарч ирнэ. Энд ус бол амьдралын хүч болох пранаг зааж байгаа хэрэг ажээ. Бадмасамбхава өөрийн бясалгалын захирамжаар, энэхүү хүчийг зогсооно. Өөрөөр хэлбэл, пранаямагын / хий гүйлгэх / тусламжтайгаар, тэрхүү хүчийг хяналтанд авна. Иймээс ч ус зөөгч бүсгүйг ид шидийн хүчээр зогсоодог.

Дараа нь шивэгчин бүсгүй болор хутгаар / хурц тодорхой чанар, учир зүйг задлан шинжилж мэдэхээр, дотогшоо нэвтэрч байгаа юм / түүнд цээжээ нээж өгдөг. Өөрөөр хэлбэл, материаллаг чанарын нууц далд шинж төрхийг нээж, ил гаргаж байгаа хэрэг бөгөөд Бадмасамбхава бол догшин Дхъянын бурхадын мандалыг харна. Уг бие нь хоромхон зуурын шинжтэй ч гэсэн, эрхэм дээд, хүч төгөлдөр байдлын сүм гэдгийг тэрээр ойлгож эхэлдэг.

Тэрээр шивэгчин эмийн өмнө сөгдөх бөгөөд Дагина мэт өөрийгөө нээж харуулсан тэр бүсгүйгээс сургаал айлдахыг хүсдэг. Бүсгүй түүнийг ордонд орохыг зөвшөөрч байгаа нь эвлэрэнгүй байдал, юмсыг байгаа байдлаар нь үзэхэд, бэлэн байгааг харуулж буй хэрэг агаад үүнээс өмнө цоожтой байсан хаалгыг нээдэг. Нууц хүч нь тайлагдаж ойлгогдоогүй байсан өөрийнх нь биед нэвтрэх хаалга юм.

Одоо тэрээр нар, сараар чимэглэгдсэн сэнтийд заларсан Ваджра йогинь дүр бүхий Дагиныг өөрийн нүдээр харна. Нар, сар бол расана, лаланад туйлшруулсан, сэтгэц - сансрын эрчим хүч буюу энерги юм. Энэхүү хүч нь Дагинын хяналтанд байна. Дхармын гаднах дуу авианы мөнхийн хэмнэлийн билэгдэл бөгөөд Бурхан багш соён гэгээрсэний дараа, “үхэшгүй мөнхийн Дхарма” - гын тухай, өөрийнхөө анхны номлолд дурьдаж байсан юм. Тэрээр ертөнц даяар өөрийн үхэлгүй мөнхийн дамрын дууг (атама - дундубхин) сонсохыг хүсэж байв.

Дагина нь зүүн мутартаа цус дүүргэсэн гавал аяга барьж байх бөгөөд энэ бол зөвхөн амиа золиослох үнээр олж авч чадах билгүүн ухааны билэгдэл болно. Тэрээр гучин хоёр Дагинасаар хүрээлүүлсэн байх бөгөөд эдгээр нь гэгээрсэн бурханы биед байдаг гучин хоёр төгөлдөр шинжийг харуулж байна.

Бадмасамбхава, түүнээс сургаалаа айлдахыг хүсэхэд, Дагинын шивэгчин бүсгүйн нээж өгсөн Дхьянын бурхадын хоёр мандал нь орон зайд тусгайлан хийж бүтээсэн юм шиг, жинхэнэ бодит байдлын хүрээнд дахин харагдана. Авшиг авалтын үед, тэдгээр бурхад нь Дагинад орох бөгөөд Дагина нь бүх бурхадын хувилал болсон учраас “Сарва Буддха Дагина” гэж нэрлэгдэх болсон юм.

Улмаар Бадмасамбхава “Хум” хэмээх үет тарни болон хувирч, өөрийнхөө бясалгалынхаа хурц талаар өөрийгөө мантратай бүрэн адилсгаж, бүх бурхадыг зоригжуулагч хүч / соён гэгээрэхэд сэргээн өдөөгч / - тэй нэгдмэл болж, Бодхигийн жаргал цэнгэлийн ухамсарыг өөрийн бүх хүрдүүдэд илгээж, биеэ Гэгээрлийн сав болгож хувиргасан юм. Үүнд: дараахь хүрдүүд хамаарна.

1. Амитабха биеллээ олсон тэр зүйл / “Хум” нь түүний уруул дээр байх үед /, өөрөөр хэлбэл, мантрын дуу авиа үүсч гардаг “хоолойн хүрд”

2. Авалокитешвара биеллээ олдог тэр зүйл / “Мани”-гын эрдэнээр билэгдсэн / буюу “хүйсний хүрд”

Язгуур хүрд болох гурван нади -гийн уулзвар газар / гурамсан холболт, төвдөөр: гСум - мДо / гэж байна. Энд нь биеийн бүтээлч хүчнүүд бие, хэл, сэтгэлийг үнэхээр сэргээж, оюуны боломж болж хувирдаг. Энэ бол Дагина өөрийн ид шидийн хүчээр, Бадмасамбхавагын гурван төвийг тэтгэсэн авшиг юм.

Эрхэм дээд Дагинын гурвалсан далд хүч буюу Бурханы бүх билгүүнийг хамарсан түүний шинж төрх бол, Ваджра йогинь эртний мантрын томъёонд тусгагддаг бөгөөд Буддын нууц тарнийг санскрит хэлбэрээр бичвэл, “УМ УМ Ум Сарва Буддха дакинийе Ваджра варнани Ваджра Вайрочанийе ХУМ ХУМ ХУМ ПАД ПАД ПАД СУУХАА” болно. / Sadhanamala, 453 - р хуудас /

“УМ, ХУМ, ПАД” гэсэн гурвал бол бясалгалын гурван өөр түвшинд, ахуйн гурван өөр хэм хэмжээний үр дүн буюу Ваджра йогинь гол гурван хэлбэрт тохирч нэгдэж байдаг. Тэрбээр Сарва Буддха Дагина болгож, бүх бурхадын өдөөгч хүчийг өөртөө шингээдэг бөгөөд өдөөгч хүч, амьд юмсыг Бурханлиг чанарын онцлог шинжтэй болгох, Төгс төгөлдөр Гэгээрэл рүү дагуулдаг юм.

Ваджра Вайрочана -гын байдлаар, тэр нь цацраг гэрлээ болон Дхармадхатугын нугарашгүй, идэвхтэй ухамсарын гадагш чиглүүлсэн Ваджрагын идэвхжил болно.

“ХУМ” бол Ваджра йогинь үзэгдлийн бүх хэлбэрүүд болон Яб - юм / эцэг - эх / -ын хооронд нэгдэж орсон Херука адил, түүний аргын талын төвшинд нийтлэг юм. Херука гэдэг бол бурханы онцлог чанарын “эрэгтэй” талын шинж чанарын биелэл, Гэгээрэхүйн эрчимтэй төлөв нь юм.

“ХУМ” нь Очирын мөн чанар бөгөөд түүний амгалан зөөлөн / шива / болон догшин / бхайрава, төвдөөр: драгпо / дүрийн илрэл болдог. “Хум” хэмээх үе дээр “пад” хэмээх үе

залгагдвал, энэ нь / дайсагнасан / хорт муу үйлсээс хамгаалах ба дотоод сэтгэлийг ариусгах, эсвэл бясалгалын төвлөрөлд хүч нэмэгдүүлэх үүрэг гүйцэтгэнэ.

“СУУХАА” нь буянт үйлийн болон энэрэн нигүүлсэхүйн илэрхийлэл бөгөөд аль нэг талаараа “аминь” -тай төсөөтэй ариун үйлс, аз жаргал, амжилтын биелэлтэнд чиглэгдсэн байдаг юм. Энэхүү үг хэллэг нь ариусгахад буюу шашны зан үйлийг гүйцэтгэхэд дээрхийн нэгэн адил хэрэглэгдэнэ.

“ПАД СУУХАА” нь харанхуй хар хүчнээс хамгаалахын зэрэгцээгээр, гай барцадаас зайлуулан аврагч хүчнүүдийг нэгэн зэрэг бий болгодог. Хэрэв Бадмасамбхава нь авшиг хүртсэнийхээ эцэст, өөрийнхөө тухай “бие, хэл, сэтгэлээрээ авшиг хүртсэн” хэмээн өгүүлсэн байх ба энд бие нь бүх бурхадын лагшин, хэл нь бүх Туулан гэтлэгсдийн ариун зарлиг, сэтгэл нь бүх Бурхадыг гэгээрүүлэгч бодь сэтгэл гэсэн утгатай юм. Үүнийг зөвшөөрч Дэмчог сударт өгүүлэхдээ, “Кайя” хэмээн хэлвээс бид бүх Бурхадын бие болоод хувилгаан дүрийн тухай, “вак” хэмээн хэлвээс бүх Бурхадын айлдварын тухай, “читга” хэмээн хэлвээс бүх Бурхадын оюун билгийн тухай тус тус хэлж байгаа хэрэг бөгөөд эдгээрийн нэг нь нөгөөгөөсөө салшгүй хамааралтай юм нэгэн цогц зүйл юм” гэжээ.

15. Видьядхарын мандал ба бясалгалын

дээд түвшинд орох нь

Дагина бол ухамсарыг өдөөн зоригжуулагч хүч болдогын адил, Хэрука / арга талын шинж тэмдэг буюу чанар бүхий Бурханы мөн чанарын хувьсан бүтэх ёс / бол Каруны идэвхтэй төлөв бөгөөд / хувиа хичээх гэдэг явцуу хүрээнээс гарах эрхэм дээд илрэл болсон / аминч хязгаарлагдмал чанарыг дамжин, Мөн чанарын / Важрасатва / түгээмэл хуулинд нэвтрэн ордог хязгааргүй зовлонгийн идэвхтэй хэсэг нь юм. Энд саад, тотгор бүгд арилна. Үүнд өөрийн “би” гэдэг хуурамч чанар ч, өөрийн тусгаар зүйл гэсэн чанар ч бүгд арилна. Өөрөөр хэлбэл, бидний үздэгчилэн бүх ухаалаг бодол, эргэцүүлэл арилна. Зөн билгийн мэдлэг, дотоод мэдрэмж хоёр нь энд Юганадха дахь Дагина, Хэрука хоёрын холбоо адил / эцэг, эх / салгаж болшгүй нэгдэлд орно. Энэ нь ухаан бодол тодрох үйл явц

бүрд, Бурханы чанарын билэгдэл бүрд, аргын байдлаар илэрч байлаа ч гэсэн, нүд үл гүйцэж харах тэр зүйл тод томруун харагдах болдогыг онцлон тэмдэглэж байгаа хэрэг юм.

Дхъяни Бурханы тайван ба амгалан байх, нэгдэлтэй байх үе хэмээн тайлбарладаг Бурханлиг чанарын эрхэм дээд туйлын хүсэл болно. Өөрөөр хэлбэл, Хэрука бол Очир хөлгөний / Важраяна / ид эрч хүчээ хангасан бусад дүрийн адил, “цус уугч” / төвдөөр: Кхраг тхунг, санскритээр: Хэрука / “хилэнт” кродха, / төвдөөр: кхрова / буюу “аймшигт”, “догшин” / бхайрава, төвдөөр: драг - по / бурхан мэтээр тайлбарладаг. Энэ нь Марагын / шуламын / дайчидтай Бурхан багш тэмцдэгийг билэгддэгийн адил, дээд Гэгээрлийн үйл явц дахь идэвхтэй шинж чанар, Бурханы бүрэлдэж буй болох үйл явц, гэгээрэн гэрэлтэхийн ололт амжилтыг онцлон өгүүлж буй хэрэг юм.

Баатарлаг догшин Бурханын ид шидэт дүрүүд бол “Санаанд үл багтах зүйлд” / ачингъя /, оюун ухааны хувьд “Танин мэдэх боломжгүй зүйлд” / анопалабдха / йогчийн нэвтрэн орох тэрхүү агшинг илэрхийлж байгаа юм. “Пражня парамита судар” - т бичихдээ: “Дээд Гэгээрэл / ануттарасамъяк самбодхи / - ийг тайлбарлан бичиж болох уу, эсвэл нэгэн цагт Бурхан иймэрхүү зүйлийг сургаж айлтгаж байсан бил үү”, хэмээн Будда Субхутигаас асуухад Субхути хариулахдаа: “Миний ойлгож байгаагаар бол Төгс гэгээрсэн Бурханы сургаалд “анутгара - самъяк – самбодхи” мэтийн зүйл байхгүй, Татхагата / туулсан бурхан / ямар нэгэн тодорхойлогдох Дхармаг / сургаалыг / сургаж байгаагүй юм. Яагаад гэвэл, Татхагатын сургаж байсан зүйлс нь мөн чанартаа тайлан таних боломжгүй, тэдгээрийг сургаж айлдаж болохгүй. Тэгээд ч тэр нь байдаг ч юм биш, тэдгээр нь онцгой юм ч биш, танигдахгүй зүйл ч биш. Энэ юу гэсэн үг вэ ? гэвэл Бурхан, Бодсадва нар тодорхой сургаалаар гэгээрлийг олж авсан бус, харин бясалгал, зөн билэг, зүй тогтолын замаар түүнийг олж авсан юм” гэжээ. / Buddhist bible, 1938, 102 - р хуудас /

Пражня - парамитагын шууд биелэл, уламжлалын үргэлжлэл нь Очир хөлгөний ид шидийн дүрүүдэд харилцан илэрсэн бөгөөд энэхүү дүрүүд нь Важрасатвын тантрын ёсны замд / Акшобхъягын идэвхтэй тусгал /, хувьсах ба дахин нийлэх замд тааралддаг байна.

Энэ замд тааралдаж буй, ялангуяа тантрын замд Дагина, Вира / баву / болон Хэрукагын адил далдлагдаагүй, бодит байдлын даянч маягийн нүцгэн иарэл болох Бурхадын дүрийн олон талт хэлбэрүүд нь йогийн үзлийн үүднээс чухал юм. Учир нь тэдгээр хэлбэрүүд нь, бясалгалын ажиллагаа биеллээ олж буй, агуулгыг үзэгдэхүйц болгож байгаа юм.

Иймээс тантрын Бурхадын чуулганы тоо үлэмж олширч байдаг нь, “доройтсон” Бурханы шашны олон бурхадын үзэл эрчимжиж буй хандлагаар тайлбарлагдах бус, Бурханы шашин болон шашин суртал газар авч байхад бишрэн дээдлэх шинэ зүйлийг эрж хайж, хүний бодол сэтгэмжийг Бурханы хэмжээнд хүртэл өргөж байсан хэрэг огтхон ч биш, үүний эсрэг шашны бодол сэтгэмжийг дээдлэх гэсэн хандлагыг амьдралын практик туршлагаар сольж байгаа хэрэг юм. Эрдэм ухааны аливаа шинэ нээлт бүр нь мэдээ баримт, мэдлэгийн хүрээг өргөжүүлж байх төдийгүй, цаашид нээлт хийсэн, урьдын таньж мэдсэн зүйлээ дахин үнэлж цэгнэхэд хүргэдгийн адилаар, бясалгалын үйл явц бүр нь практикт болон бодит амьдралд шинэ шинэ арга ухааныг буй болгодог байна. Хүний ухаан бол эрдэм мэдлэгт хүрэх замын аль нэг хэсэгт нь очоод зогсчихдоггүй. Хэрвээ зогсчихлоо гэх юм бол энэ нь үхэл, хөдөлгөөнгүй болох, эвдрэл сүйрэл болох гэсэн үг юм. Энэ бол аливаа амьдрал, аливаа ухамсарын хууль мөн бөгөөд бас сүнсний ч хууль мөн билээ. Математик сэтгэлгээнд байдаг шиг өөрчлөлт хувиралт бүр нь дээд зэрэглэлд хамаарах өөр нэг өөрчлөлт хувиралтыг буй болгож байдгын адил, бид эцэс төгсгөлгүй, цуврал өөрчлөлт гарч байх ёстой гэсэн ойлголттой болох хүртэл бидний оюуны хүрээ тэлж, бидэнд ухамсарын шинэ өөрчлөлт буй болдог юм.

Аливаа сэтгэлийн бодлогошрол бүр нь, тухайн хүний өөрийнх нь мэдлэгийн хязгаарыг л зааж байгаа хэрэг бөгөөд энэ нь ямар нэгэн үл тайлагдах, түүнд оюун ухаан нэвтэрч үл болох хязгаартай зүйл биш, тэдгээр нь үнэндээ сэтгэлийн бусад бодлогошролуудтай холбоотой байдаг юм. Энэхүү үнэний баримт бол хоосон чанар буюу бүх тодорхойлолтын харьцангуй чанар, төгсгөлгүй чанар болох “шуньята” хэмээх нэр томъёонд тусгагджээ. Төгсгөлгүй чанар бол ямар нэгэн юмыг тусад нь салгаад үнэмлэхүй

болгож болохгүй, хязгааргүй зүйлээс болон практик туршлагаас юмсын гүн шүтэлцээ холбоог салган авч болохгүй билээ. Энэ “харьцангуй дээд чанар, бол амьд ертөнцийг нэгтгэж байдаг язгуур махбодыг ч мөн агуулж байдаг. Учир нь төгсгөлгүй холбоо бол бүхнийг хамарсан метафизикийн хэмжээ бөгөөд энэхүү хэмжээг “байгаа зүйл” ч, “байхгүй зүйл” ч гэж, бас “хөдөлгөөн” ч, “хөдөлгөөн биш” ч гэж тодорхойлж болохгүй.

Энд бид бодож тунгааж, мэдэрч болох бус, юмсын төгсгөл, санаа бодлын хязгаарыг олж мэдлээ. Туйлын тайван буюу хөдөлгөөнгүй байдал хэмээн ялгаж салгаж болдоггүй, дээд хязгаартаа байгаа хөдөлгөөн гэдгийн адил, дээд зэргийн шүтэлцээ холбоо, харьцааны чанарыг “туйлын” байдлаас нь ялгах боломжгүй юм. “Мөнх байх чанар” гэдэг нь зөвхөн хөдөлгөөнд л байдаг. “Мөнхийн өөрчлөгддөг зүйл” гэвэл, тогтмол оршин байдаг, бүхэл бүтэнээрээ байдаг, эдүгээ цаг үед ч байдаг юмыг хэлнэ.” / Новалис /

Иймээс “хоосон чанар” буюу “шуньята, татхата” хоёр нь чанар байдлаараа ижил юм. “Хоосон чанар” бол бодит юмс үзэгдлийн “хоосон” сөрөг талыг, татхата бол тэрхүү юмс үзэгдлийн тодорхой, эерэг талыг тус тус илэрхийлж байдаг. Хоосон чанарын бодитой илрэл нь агшин зуурын бодлогошролоос буюу бүх юмны хувирч өөрчлөгдөх чанараас, түр зуурын орон зайн харьцангуй чанараас, туйлын чанараас эхэлдэг. Зөвхөн Өрнийг Дорнотой холбохын тулд буюу сэтгэлгээний логик - гүн ухааны аргыг, зөн билгийн метафизикийн аргатай нарийн холбож үзэхийн тулд л эдгээр үг хэллэгийг бид хэрэглэж байгаа юм.

“Харьцангуй чанарын тухай орчин үеийн үзэл бодлыг, хоосон чанарын үзэл бодолтой цэвэр логик үндсэн дээр харьцуулж үзэх гэсэн оролдлого бол оюуны хомсдол юм” гэж Д.Т. Судзукийн хэлдэг нь зөв юм. “Хоосон чанар” гэдэг бол зөн билгийн үр дүн болохоос ухааных биш. Хоосон чанарын тухай төсөөлөл бол практик туршлагаас үүсдэг бөгөөд түүний логик үндсийг олох гэвэл, харьцангуй чанарт урьдчилсан нөхцөлийг нь эрж хайх хэрэгтэй юм. Харьцангуй чанарыг бид заавал дайрч гарахаас бус, тойрч гарах аргагүй юм. Тэгээд ч бидний ой ухаанд харьцангуй чанар байна гэвэл, бид явцуу тойрог дотор байгаа хэрэг.

Тойрог дотор байгаагаа ойлгож байгаа бол түүнээсээ / тойргоосоо / бид гарах ёстой. Учир нь тэр тойргоос гарлаа гэсэн бүхэл бүтэн ойлголттой болох ёстой. / D. T. Suzuki, 1953 /

Бидний оюуны өнгөц ухамсар болон хувь хүний онцгой чанарын зөн билгийн гүн ухамсар хоёрын дунд байгаа, ёроолгүй ангал дээгүүр ийнхүү харайн гарч чадсан явдал нь Дагиныг тэвэрсэн цус уугч бурхадын онгодын бүжгээр илэрхийлэгдэж байгаа юм. Явцуу тойрог, явцуу бодлоосоо гарч бодит чанар, бүхэл бүтэн юм гэсэн чанарыг ойлгоогүй байх үед, хуурмаг чанар, дадаж дассан төсөөлөл ихээхэн таатай боловч явцуу хүрээнээс хальж гарахад, Дагина бол зоригжуулагч хүч тэнхээг өгч байгаа юм. Ийм явцуу хүрээнээс гарч чадсанаар бүх хэлхээ холбоо, гав гинж бутран унаж, хуурмаг үзэгдэл арилж, тогтсон бүх үзэл бодол үндсээрээ өөрчлөгдөж, бүх хүсэл тэмүүлэл, дасал болсон зүйл алга болж, өнгөрсөн ирээдүй гэх юмгүй, үндсээрээ эргэж Аугаа их хоосон чанар нь мөнх оршин тогтнох эрхэм дээд Бодит чанар, Байгаа төрхөө хадгалах чанар / татхата / - ын адил бодол санаанд буух болно. Энэхүү хязгаар хүрээнээс халин гарсан хүчийг хүний хирээс давсан, лус савдагийн шидтэй, олон гартай олон тэргүүнтэй дүрсээр, олон талт, бүхнийг нэвт мэддэг, “гурван цаг үеийг” / нүүрэндээ гурван мэлмийтэй болгон билэгдсэн / аль ч цаг үед үл хамааруулах эдүгээ болгон хувилж чаддаг дүрээр илэрхийлжээ.

Газар дэлхийн хэмжээнд тунгааж үзвэл, иймэрхүү дүртэй амьтан “аймшигтай” юм. Учир нь энэ амьтны биеийн хэсгүүд нь дайн тулааныг билэгдсэн байх бөгөөд энэ нь дотоод тэмцлийг харуулж буй хэрэг билээ. Харин жирийн хүний нүдэнд энэ нь “Аврагч зэмсэг” бус, хүн амьтан оршин амьдарч байгаа газар дэлхийнх нь бүх юмыг эвдэж сүйтгэх зэвсэг болон харагддаг.

Ид шидэт буюу “Цус уугч” бүх бурхад / эдгээр нь гавлаар хийсэн аяганд цус дүүргэж гартаа барьсан болохоор, ийнхүү нэрлэсэн ажээ / -ын хувьд, тэдний баримтлах гол зүйл нь Билгүүн ухааны зарчим болж байх юм. Учир нь “Цус” бол юмыг ухаж ойлгох боломжийг бүрдүүлдэг, улаан нарны хүчийг билэгддэг. Улаан нарны илч бол хувийн явцуу бодол, сэтгэлгээнээсээ гарч чаддаггүй хүмүүсийг хорлох үхлийн хор болон хувирдаг. Харин “би”

хэмээх өөрийн хуурмаг хоосон бодлоосоо салахыг хүссэн хэнд ч бол, тэрхүү улаан нарны илч нь авран чөлөөлөгч билгүүн ухаан болон хувирдаг байна.

“Цус уугч” бурхад бол эцэг, эх / яб, юм / - ийн төрхөөр, өөрөөр хэлбэл, өөрсдийн пражнянуудтай хамт гарч ирдэг.

Тэдгээрийн эх авах газар нь уураг тархины төвд байдаг танин мэдэх ухамсар, нарны зарчим юм.

Эдгээр бурхадын эрхэм дээд, арай илүү аймшигт дүрүүд бол уураг тархины төвд хамаатай бөгөөд “Бардо тойдол” -д таван Хэрука болон пражнянуудтай орон зай, өнгөний уламжлалт чиглэлд дүрсэлжээ. Гэтэл Дхъяни бурханы амгалан дүрт хэлбэрүүд нь зүрхний хүрдэнд харьяалагддаг, харин бурхадын “Тогтоон баригч мэдлэг” / видъядхара, төвдөөр: риг - зин / нь, дээрх хоёрын уулзварын дунд нь байрлаж, мантрын авианы төв болох хоолойн хүрдэнд хамаарагдана.

Видъядхарууд бол онгодын бүжиг бүжиж, цусаар дүүргэсэн гавлын ясан аягыг дээш өргөж, өөрсдийг нь тэвэрсэн дагинуудын хамт, баатарлаг дүртэй хүний хэлбэрээр дүрслэгдсэн байдаг. Тэдгээр Хэрука нарын амгалан байдлыг / Цус сорогч бурхадын / нэгтгэн харуулж, гадна талдаа хувь хүний буюу хүнд байж болох билгүүнийн тусгал мэт байх бөгөөд энэхүү Билгүүн гэгээнтэн, суут йогууд, урам орсон сэтгэгчид болон тэдэнтэй дүйцэх бусад хувилсан баатрууд (вира, төвдөөр: Па–бо, мон: баатар) эзэмшсэн байдаг. Энэ бол явцуу хүрээнээс гарч, олон талт бясалгалд орохын сүүлчийн шат буюу тэрхүү бясалгалаас буцаж жирийн хүний танин мэдэж болох товшинд буцаж орох эхний шат юм.

“Бардо тойдол” - д өгүүлсэнээр, Дхъяни бурхадын амгалан дүр тодрон гарснаас хойш завсрын байдлын / Бардо / долоо дахь өдөр нь Видъядхарын бурхад гарч ирдэг. Тэдгээр нь зах хязгааргүй мандалын хэлбэртэй гарч ирэх бөгөөд түүний гол дунд нь бүхий л үйл явдлаас / мин випака / үүдэн гарах үр дүн буюу үр шимийг ухаж ойлгосон Бясалгалд боловсорсоны идрэл болох Эрхэм дээд Видъядхара / намбар минбай ригзин / гэрэл цацруулан байрлана. Түүнийг тойрон таван өнгийн солонго тодрох бөгөөд “Бүжиг эзэгнэгч” гэж нэрлэнэ. Өөрөөр хэлбэл, хөдөлж байгаа болон хөдөлдөг юм болгоныг

эзэгнэгч юм. Учир нь түүний удирдан чиглүүлж байдаг сэтгэхүйн хурд гэдэг нь хөдөлгөөний махбод / хий / бөгөөд “агаар”, “салхи” “амьсгал”-ын шинж чанарыг агуулдаг амь, бүтээгч авиа, ариун үг мэдлэгийг эзэгнэгч, оюуныг идэвхжүүлэгч, нээгдүүлэгч хэмээн үздэг.

Бүх үйл явдлын үр дүнг тунгааж, “хэрэг явдлыг төгс байдалд нь хүргэдэг” номч билгүүн “огторгуй” хэмээх махбодь нь Амогхасиддхийн салшгүй нэг чанар юм. Гэхдээ, түүнтэй холбогдсон Дагина бол, улаан өнгөтэй, “бүжгийг эзэгнэгч” хэмээх түүний нэрийг “Бадма” / падма гаргьи ванг - пхьуг / гэдэг үгээр орлуулж болдог. Ийм хоёр нөхцөл байдал нь тэдгээр хоёр Бурханы хөрөг Амиабхагын төвшинд Бадматай холбоотой ба түүнд Амогхасиддхи, Амиабха хоёр нэгдсэн байгааг зааж буй хэрэг юм.

Амиабха бол нүдээр үзэж, ялгаж болох билгийн мантрын дуу авианы хэсгүүд болох амьсгалын ба билгүүн ухааны амин сүнстэй салшгүй холбоотой юм. Өөрөөр хэлбэл, Амиабха бол ялгаж нягталдаг “Дотоод мэлхийн билгүүн чанарын илрэл бөгөөд түүний идэвхтэй дүр болох / Амиаюс / нь түүний амьдралын цаг хугацаагүй чанарыг илтгэн харуулдаг. Яагаад Амиабха / Амиаюс буюу Аюуш / нь хоолойн хүртэй холбоотой байдгын, учир шалтгаан үүнд оршиж байж болох юм.

Мандлын дэлгэсэн дөрвөн дэлбээ нь, өөрийн гадаргуу дээрээ дараах зүйлийг агуулдаг болно. Үүнд: Дорно зүг нь Цагаан дагина тэвэрсэн, газарт орших Цагаан Видьядхара, өмнө зүгт Шар Дагина тэвэрсэн, амь насны хугацааг мэдэгч ”Шар Видьядхара, баруун зүгт Улаан Дагина тэвэрсэн “суут их билгийн ”Улаан Видьядхара, хойд зүгт Ногоон Дагина тэвэрсэн “Дотоод сэтгэлийн ”Ногоон Видьядхара” тус тус оршино.

Энэ бол холимог мандал байгаа юм. Өөрөөр хэлбэл, билэгдлүүдийн хоёр зэрэг буюу хоёр цуглуулбар нэгтгэгдсэн бөгөөд нэг нь мандлын бүтцэд нэг байрлалд очсоноор, өөр цуглуулбартай нэг бүрдэл болж, нийлж байгааг харуулсан бүхэл бүтэн тогтолцоо болно. Энэ бол Төвдийн бясалгалын практикт байх онцгой тохиолдол биш, түүний олон мандалд нь байх энд тайлбарлахад амаргүй, тодорхой логик дараалал зорилготой юм. Тэгээд ч үүний тулд, энэ аргыг нилээд урт удаан хугацаагаар гүнзгий судлах шижим гаргаж,

дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай болно. Ийм ч учраас энд дараах зүйлийг нэмж өгүүлээд төгсгөө. Үүнд: Амитабха ийм байр суурьтай байдгын учир бол, тэрээр энэхүү уламжлалыг үндэслэгч тэнгэрлэг эцэг Бадмасамбхава / Ловон Бадамжунай / болох ба Амитабхагын ертөнцийн тусгал буюу хувилгаан бие / Нирманакайя / мөн гэж Бардо тойдолын уламжлалд өгүүлсэнийг иш татав. Бардо тойдолын эхлэл шүлгээс энэ нь ойлгогддог юм. Тэгээд ч энэхүү мандлыг тэрхүү Амитабхагын үзлийн үүднээс авч үздэг юм. Тус мандлын төв нь Амитабха Амогхасиддхи хоёрын нийлбэр цогц юм. Дөрвөн дэлбээний зүүн зүгийнх нь Ратнасамбхава / шороон махбод / Важрасатва / цагаан өнгө, Цагаан Дагинатай / хоёрын зарчмуудыг нэгтгэж байгаа болно. Өмнө зүгийнх нь Амитабха / амьдралыг эзэгнэгч Аюушын дүртэй / болон Ратнасамбхава / шар өнгө, Шар Дагинатай / хоёрын зарчмуудыг нэгтгэж буй, баруун зүгийнх нь Вайрочана / эвлэн нэгтгэхийн их билэгдэл / болон Амитабха / улаан өнгө, Улаан Дагинатай / хоёрын зарчмуудыг нэгтгэж буй, хойд зүгийнх нь Акшобхья / дотоод сэтгэлийн биелэл / болон Амогхасиддхи / ногоон өнгө, Ногоон Дагинатай / хоёрын зарчмуудыг нэгтгэж буй хэрэг болно.

Ийм баримжаа нь, Бардо тойдолын онцгой нөхцөл, үзэл баримтлалд нийцдэг байв. Иймэрхүү байдлаар Төвдийн Бурханы шашны урсгал, чиглэл бүр нь өөрийн оюуны уламжлалд бүрэн нийцүүлэн, уламжлалт мандлуудад зарим өөрчлөлт оруулдаг юм. Үүнийг ойлгохын тулд, эхлээд үндсэн ерөнхий төлөвтэй нь танилцах хэрэгтэй. Бид зүрхний, хоолойн, толгойн хүрдүүдийн гурван мандлыг төлөөлөн бодох үедээ, энэхүү ерөнхий төлөвийг баримтлах ёстой. Тус хүрдүүд нь дээрээ байрлаж байгаа, бурхадын хөргийн шулуун зэрэгцээ байдал, дотоод ижил төстэй байдлыг илэрхийлж буй хэрэг болно.

16. Бие, хэл, сэтгэлийн үйл ба Хум дахь

Важрасатвагын дотоод зам

Бурхадын эдгээр бүх хувилал болон тэдгээрийн бий болгосон мандлууд бол, байх ёстой жирийн шинж чанарууд биш, бясалгалын биелэл, түүний үр дүнгийн билэгдлүүд юм. Үүний үрээр, эдгээр хүрдүүд нь өөрсдөө эрхэм дээд ухамсарын эх үүсвэрүүд болж

хувирдаг, мөн үүний үрээр орчлон ертөнц бүхэлдээ нэгэн цогц болдог. Мантрын авианы ертөнцийн мэдлэг, ертөнцийн хайр, элгэмсэг сэтгэл, / амьд бүхэнтэй өөрийгөө адилтгаж, тэдний тоонд өөрийгөө оролцуулах замаар / болж, сэтгэл оюун бүх гүн ухааралд нэвт шингэсэн байдаг.

Гэгээрэлд хүргэх замын дээд гурван төвд үүсдэг бие, хэл, сэтгэлийн үйл нь, зөвхөн дээд буяны үйлсэд нь сайн санаат, түмний тусын тулд өөрийн биеэ огоорогчдын замнах зам төдийгүй, “Бардо тойдол” -д нэрлэсэнээр “аймшигт ёроол / Төвд: Чин пай пхранг /” -д очих зам болдог. Энэ нь бид өөрсдөө оршин байгаа болон бидний хүсэл тэмүүлэл, зовлон зүдгүүрийн ёроолгүй ангалтай / зуурдын хавцгай / нүүр тулан учирч байгаа зам мөн. Энэ бол эрэлхэгээр тэмцэж, ид шидийн чөлөөт байдалд хүрэх зам мөн. Ийм байдалд орсоноор, амгалан дүрт бурхан ч, цус уугч хилэнт догшин бурхад ч, аль аль нь бидний анд нөхөд маань болдог юм. Хэрэв бид эдгээр бурхадад зүрхнийхээ цусыг эс өгвөөс, энэ урт удаан замыг хэзээ ч туулж барахгүй бөгөөд бие, хэл, сэтгэлийн нууц увидасыг хэрэгжүүлж ч үл чадна. Ердийн хүний сэтгэцийн хүрдүүд нь бие болон газар дэлхийн ухамсарын махбодын хүч тэнхээгээрээ дүүрэн байдаг оюун ухааны хувьд, сайтар хөгжсөн, өөрөөр хэлбэл, тухайн хүний бодол тэмүүлэл өөрт нь ч гэсэн хомс дутмаг санагддаг. Хүнд эдгээр хүрдний хүч нь Дхьяни бурхадын тасралтгүй хөгжин дэвших байдалд шилждэг бөгөөд Дхьяни бурхадын билэгдлүүд, энэхүү хүрдүүдэд амгалан оршдог. Гэвч оюун ухааны төгс төгөлдөр байдал, харилцан уялдаа л тэдгээрийг бүрэн хуваарилтанд хүргэж чадна. Иймээс Төвдөд ариун гэгээнтэний хөрөг дээр зөвхөн Бодьсадвын дүр дээр нь, ар талд нь уг бурханы хөргийн дээд гурван төвд орших тус тус газар нь бие, хэл, сэтгэлийг үе үеэр нь товчилж нэрлэсэн “Ум аа хум” тарнийг бичдэг юм. Тиймээс ч энэхүү гурван үет тарнийн үгийн утга бол Вайрочана, Амогхасиддхи эсвэл Акшобхья мэтийн ганцаарчилсан хөргүүдээс давуу байдаг. Өөрөөр хэлбэл, тэдгээр үе үеэр нэрлэсэн үгнүүд нь / Ум аа хум /, билгүүн ухааны нэн дээд түвшинд хамаарагдах бөгөөд энэхүү мэдлэг оюунд Дхьяни бурхадын тус хэсгүүд нь бүгд нийлж нэгдчихсэн байдаг. Тэгээд ч тэр дээд гурван төв нь үлдсэн бусад хүрдүүдийнхээ үүргийг өөрөө хүлээдэг юм. Иймээс ч, Амогхасиддхийн үүрэг

нь хоолойн хүрдэнд Амиабхагын үүрэгтэй нийлсэн байх бөгөөд энд “Хри” үсгийн байранд байгаа “А” хэмээх үсгийн Видьядхара гэгч мандалын билэг тэмдэг болдог юм. “Хум” бол Ратнасамбхава бурханыг хүйсийн хүрдтэй холбоотой, амьд биеийн бүх нэгдлийг хамруулсан билгүүн чанар болон бүх үзэгдлийн хэлбэр ба хоосон чанарыг тусгасан Акшобхьягын агуу их толины билгүүн чанараас эхлээд Важрасатва / Очир мэт бодит байдал / -д илэрхийлсэн, бүх Дхьяны бурханы бүхнийг хамрагч билгүүн чанар хүртэлх бүх бүрдэд багтаах болсон юм. Ийнхүү мантрын нэг авиа бол хэд хэдэн утга илэрхийлэх болно. Үүнд уялдаа бүхий шүтэн барилдлагаас шалтгаалах бус, тус авиа хэрэглээний ухамсарын тэрхүү төвшинөөс шалтгаалах юм. Энд бид нэг л зарчмын эрчимжилтийн их, бага хэмжээний тухай буюу янз бүрийн боломжийн тухай ярьж байгаа билээ. Ганц авиаг / Хум / давтан өгүүлэх нь түүний эрчимжилтийн их багыг илэрхийлж байгаа төдийгүй, нэг билэгдэл хөрөгийн олон хэсгүүдтэй тэрээр холбоо шүтэлцээтэй байгааг болон бодит байдлын хоёр өөр төвшин дэхь бясалгалыг төлөөлөн өгүүлж буй хэрэг юм.

Иймээс Акшобхьяд байх “Хум” болон төгс утгаараа байх “Хум” хоёрыг ялгах хэрэгтэй болж байна. “Хум” төгс утгаараа бүх Дхьяны бурхадын хоршсон билэгдэл болж байх бөгөөд тэрээр Важрасатвын идэвхтэй хэлбэрээр ч, эсвэл Самантабхадра / Бурханы дээд хэлбэр буюу улааны шашин ба цогчин урсгалын чиглэл дэхь Ади бурхан / - ийн хэлбэрээр ч, эсвэл Важрадхара / Каржүмба урсгалын Ади бурхан / - ийн хэлбэрээр ч байж болно. Энэ гурвын сүүлчийн хоёр нь Важрасатватай адил, бүх Дхьяны бурхадын мөн чанарыг бүрэн илэрхийлж байгаа боловч, дан Татхатын буюу “ байгаа байдлын” амарлингуй дүрийг илэрхийлдэг. Иймээс ч Ади бурхан / анхдагч бурхан / хэмээн нэрлэдэг. Тэдгээр нь Важрасатва шиг Дхармакайягийн (Номын биеийн) илэрхийлэл болдог буюу амьд бүхэнд байдаг бурханы шинж чанарын чадавхи боломжийг билэгдэж байгаа болохоос, зарим хүмүүсийн хэлдэгээр орчлон ертөнцийг бүтээгч бурхан ба хүнийг билэгдэж байгаа биш юм. Бурханы бүхий л шинж байдал буюу ухаарлын чадварыг ойлгоход дөхөм болгох үүднээс, бид олон талт шилэнд солонгын өнгө хувирч харагддаг шиг, тэдгээрийн бүрдэл

хэсгүүдийг ялгаж, үзэгдэж харагдахуйц болгох ёстой. Ойлгож мэдсэн энэхүү байдлыг задалж, шинжилж үзээд дүгнэх хэрэгтэй. Энэ нь Амитабхагын үзэхүйн замаас эхэлж, дээд зэргээр хорших зам болох Акшобхья Ваджрасатвын замд бүрэн биеллээ олдог. Иймээс Ваджрасатвын зам мөр бол нэгдсэн билгүүн чанаруудыг нийлүүлсэн явдал юм гэж “Бардо тойдол”-ын сургаалд өгүүлдэг. Дотоод нэгдлийн энэхүү оюун билгүүн нь Дхьяны бурханыг нэг дүр болгож нэгтгэх гэсэн бясалгалын бүх урсгал чиглэлүүдийн хүсэх эрмэлзлэлийг илэрхийлж байгаа юм. Тус нэгдсэн дүр нь Ади бурхан ба энэ дүрд тохирох Херука / жишээлбэл: Махасукха, төвдөөр: Дэмчиг / болох бөгөөд түүнд төгс байдалд нэвтрэн орох байдал буюу дээд туйлд хүрэх үеийг илэрхийлнэ. Хүний ухаан явцуу хүрээнээс гарч, олон талт ертөнцийн нэгдэлд орж ирсэний дараа ухамсар бол хүний төвшинд эргэж ирж, зүрхний хүрдний “Хум” хэмээх үйлдэл болж хувирна. Ингэж “Хум” нь нэгэн биеийн цохилох зүрхнээ амьдарч, түүндээ хоёрдмол чанараас сайжирсан байдаг. Энэ бол амьд бүхэнд байдаг дотоод бодит байдлын оюун билгийн эрхэм дээд зарчим, эрхэм дээд хэлбэр мөн. Ийм ч учраас мөнхөд ариун, оршин байх бие, хэл, сэтгэлийн хязгаарт үл автан байх гурван цагийн бүх бурханын “Ум” нь таван билгүүн чанарын эвдэрч нуршгүй хоосон, илчит бие болж, “Хум” хэлбэрээр, түүний бүх бүрдэл хэсгүүд болох үйлчлэн тархах хүрээнд тов тодорхой төгс байдлаар үүсч буй болдог. Таван хор нь дотоод галын йогад / 3 / бясалгалын эхлэлийн зэрэг ба төгсгөлийн зэрэгт мөнхөд гэрэлтэгч билгүүн чанар болон хувирна. Дөрвөн бие / 4 /, Таван билгүүн чанарыг төгс танин мэдсэн Зүрхний Ваджра нь энэ амьдралд ч биеллээ олж болно. / W.Y. Evans - Wentz, 1935, зураг - 8 /

Дээр өгүүлсэн зүйлд дараах жижиг тайлбаруудыг хийе.

1. Гурван цаг гэдэг нь өнгөрсөн, одоо, ирээдүй цаг юм. Гурван цаг, гурван ертөнцийг Бурхан багш хэрхэн болгоодогыг илэрхийлбэл: Хүслийн ертөнц, Дүрстийн ертөнц, Дүрсгүйн ертөнц / Кама лока, Дхату, Арупа дхату / - ийг дөрвөн нүүр тус бүрдээ гурав гурван мэлмийтэй Херука төлөөлж байгаа юм.

2. Төвдийн бясалгалын тогтолцоонд, бүх хэлбэрээр маш тодорхой ухааж ойлгохыг шаарддаг юм. Энд будлиантай юм уу, тодорхой бус зүйл гардаггүй, санамсаргүй гэх зүйл байдаггүй. Авиа, өнгө, дүрс болгоныг тов тодорхой, амьдлаг байдалд нь авч үздэг. Төвдийн үл танигдах нууц зүйл гэдэг бол “үл танигдах харанхуй”, хүн сүнс хоёрын дундах нэгэн зүйл амьтны тухай төсөөлөл огт биш, Төвдийн сүнсний тухай ойлголт бол, оюуны мэдлэг ухаанд үндэслэсэн бөгөөд энэ нь сэтгэл хөдлөлийн санаанаасаа ургуулан бодсон, эсвэл мятрашгүй нэгэн төсөөлөл зэргийг таалдаггүй юм. Йога нь ухамсарын хувирамтгай байдлыг зогсоох зам, эрчимтэй урсгалыг зогсоох, огт өөрчлөгддөггүй ухамсарыг, толь шиг мөлгөр байдаг зүйлийг арилгах зам мөн. Энэ бол тусгал дүрсийг толиноос нь ялгадаг, толины өнгөн дээр байгаа зүйлийг өөр ямар нэгэн гаж буруу тусгалаас ялгаж, үнэхээр дотоод үзэгдэл мөн болохыг нягтлах чадварыг эзэмшсэн зам болно. / Н. Zimmer, 115 - р хуудас /

3. “Зунг жуг “ / төвд сударт / гэдэг хэллэгийг энд бүлээний галын йогад хамааруулж, нэр томьёо болгон хэрэглэсэн бөгөөд тэрхүү бүлээний галын йога нь расана болон лалана - гын сэтгэхүйн эрчим хүчний урсгалыг нади -авандуди хэмээх дунд сувагт нэгтгэхийг эрмэлздэг.

4. “Дөрвөн бие” гэдэг нь дараах зүйлүүд болно. Үүнд:

а. Дхармакайя нь “Номын бие” буюу “Жинхэнэ бие”

б. Самбхогакайя нь “Төгс бие” буюу “Хэлбэр дүрсээр ариун бие”

в. Нирманакайя нь “Хувилгаан бие” буюу “ертөнцөд заларсан бие”

г. Важракайя нь “Очирын бие” болно.

Ийнхүү үй түмэн дүрс хэлбэрийг мэдрэх шатнаас, дотоод сэтгэл оюунаа тунгааж, цэгцлэх шатанд бүх Бурхадыг нэгтгэх Бодь сэтгэлийг өөрсдөө, яг одоо энд бодитой болгож буй шатанд эргүүлэн, авчирч байгаа хэрэг юм.

Тавдугаар Бүлэг

“УМ МА НИ БАД МЭ ХУМ”

Агуу их мантрын зам

Гурван биеийн онол ба бодит

байдлын гурван түвшин

Бид “Ум” хэмээх ариун үгэнд агуулагдсан түгээмэл чанар, “Мани”- д агуулагдсан эрдэнэ мэт үхэлгүй мөнхийн ухааны гэрэл гэгээ, “Бадма” хэмээх ухамсарын дэлбээнд билгүүн болон бадран дэлгэрч, “Хум” гэгч ариун үгэнд нийлэн амилах тухай үзлээ.

“Ум” -ыг амилуулах зам бол, түгээмэл замд хүрэх буюу Их хөлгөн - Махаянад хүрэх зам юм. “Ум” -аас “Хум” хүрэх зам бол, түгээмэл чанарыг хувийн чанар болгох зам юм. Энэ бол манай нүгэлт “материаллаг” ертөнцийг машид гүн нүднээ үл үзэгдэх, ухамсарыг төрүүлэгч ухааны гадна оршигч бодит байдал болгон хувиргах бөлгөө.

Важрасаттва нь Акшобхъягын идэвхтэй хүч болдогын адилаар, Авалокитешвара нь хүмүүний туршлага, үйл ажиллагааны түвшин дэхь Амитабхагын тогтвортой талыг тусгана.

Будда нь бодит байдлын гурван түвшинд аль алинд нь байх учраас түүнд гурван бие, тэдгээрийн гурван зарчим байна.

1. Номын бие буюу “дхармакайя”. Бурхан багш өөрийн биеэр байна. Энэ бол Дхармагын төгс, түгээмэл, гүн хувийн бөгөөд цаг хугацаанаас ангид бүх юмсын шалтгаан болох бие юм. Түүнээс махбод, ёс суртахууны болон метафизикийн дэг жаяг үүсгэнэ.

2. Төгс жаргалангийн бие буюу “самбхогакайя”. Буддагын оюун санааны мөн чанарыг тусгасан бие. Энэ бол бүтээлч дотоод үзэхүйд ажиглагдах гэрэлт ертөнц - жинхэнэ урам зоригийг төрүүлэгч, оюун санааны цэнгэл эдлэгч бие болно.

3. Хувилгаан бие буюу “Нирманакайя”. Энэхүү урам зоригийн хүчээр хувилан үйлдэл хийх, үзэгдэхүй хэлбэрийг олсон хувилгаан бие нь Будда бурхан хүний төрлийг олсон бие мөн билээ.

Бүх орчлонгийн ухамсарын зарчим болсон Дхармакайяд бүх юмс үзэгдлийг хамарсан хязгааргүй орон зайн адилаар, бүх үүсэн бүрдэхүй, оршихуй агуулагдана. Дхармакайя бол оршин буй бүхний зайлшгүй хууль мөн. Гэхдээ, орон зай, юмстай ав адилхан хэмээж болохгүй. Орон зай, юмсаас ялгаатай ч гэж болохгүй. Хүмүүн бид орон зайг түүний эсрэг тал болох дүрсгүйгээр ухаарч чадахгүй учир, Дхармакайя нүдэнд үзэгдэх дүрсийг олж байгаа нь тэр юм. Энэ нь оюун ухааны хараанд өртөх гэрэл цацарсан цэвэр хэлбэрээр юм уу, үйлдлийн болон хувийн чанарын дүрстэй ертөнцөд хувилж ирнэ.

Түүгээр дамжин Самбхогакайя амилах бөгөөд түүнээс урлагийн мөнхийн бүтээлүүд, гүн цэцэн ухаан, бүх тулгуур үнэн үүснэ. Энэ нь хоёр төрөл байх бөгөөд урлагийн агуу их бүтээл туурвисан хүн, эхэлсэн үйлээ дууссаныг хараад сэтгэл хөдлөлийн туйлд хүрч, бүтээлч үйлийг дахин эхэлдэгийн адил юм.

Эхнийх нь Будда болон Бодьсадва нар “Самадхи” -гийн байдалтай байхдаа эдэлдэг сэтгэлийн цэнгэл ба хоёр дахь нь эхний замд автаж, түүгээр замнан эрхэм дээд оршихуй, оюун санааны ялалтыг ухамсарлах үе юм.

“Туйлын төгсөхүй” буюу барамид хэмээх зургаан зүйлийн үе шатуудын тухай өгүүлье. Эдгээр нь:

1. Өөрийгөө хүртэл золиослоод амьтанд өглөг болгон өгөх үйлдэлд илэрдэг өглөг барамид буюу өөрийгөө бусдад бүрэн зориулах үйл / дана /
2. Арван хар нүглийг тэвчээд аливаа буян бүхнийг хураах амьтныг хайрлах энэрэлд ихэвчлэн илэрдэг шагшаавад барамид буюу төгс суртахуун / шила /
3. Бүхнийг өршөөх, атгаг муу санааг арилгах, хүлээцтэй тэвчээртэй байхад илэрдэг хүлцэнгүй барамид буюу төгс тэвчээр / кшанти /
4. Төгс гэгээрэлд хүрэхийн тулд тохиолдох бүх саад бэрхшээлийг давж гарахын тулд урам зориг дүүрэн байхад илэрдэг хичээнгүй барамид буюу төгс чармайлт / вирья буюу төвдөөр зундуй /
5. Бодит байдлыг зөв ухаарч, ухаанаа жинхэнэ ёсоор нээхэд илэрдэг дияан барамид буюу төгс бясалгал / Дхьяна буюу Самадхи /

Төгс гэгээрэлд хүрэхэд бүрддэг хоосон чанарыг оносон билэг барамид буюу төгс билгүүн / Праджня / эдгээр болно.

Дундад зууны эртний ариун судар “Буддхавамса, Чарьяпитака”- д Махаяна ёсонд өглөг, шагшаабад, хүлцэнгүй, хичээнгүй, диаян, билэг, үнэнч шударга байдал, эр зориг, нигүүсэл, чигч шулуун сэтгэл гэсэн арван зүйлийг оруулсан байдаг.

Иймээс Самбхогакайягийн хоёр төрөл байдаг бөгөөд нэг нь “сва – самбхогакайя”, нөгөө нь “пара - самбхогакайя ажээ. Эхнийх нь, цэвэр ариун, мөнхийн нийтлэг, хязгааргүй дүрст бие / Рупакайя / бөгөөд хоёр дахь нь шүтэн бишрэх урам зоригийг бусдад зориулдаг бие юм. Дхармакайян онол хүний ухаанд хувилах зам ийм бөлгөө.

Тийм ч учраас оюун ухаан хүний биеийг бүтээдэг агаад ухаан хэдий чинээ Дхармакайяг тусгаж, түүгээр баяжин дүүрч байна, төдий чинээ биед нөлөөлөн, түүнийг өөрчилдөг хэмээн үздэг болой. Ийнхүү шилжилт буюу өөрчлөлт, гэгээрсэн биетэд бүрэн биеллээ олдог. Бурхан багшийн бие нь төгс гэгээрлийн гучин хоёр шинжийг агуулсан гэдэг нь ийм учиртай ажгуу.

Төвдөөр “Тулку” (хувилгаан) гэдэг Нирманакайя гол төлөв хий буюу тунгалаг бие гэсэн утгатай “майядеха” гэгч үгээр орлуулсан байдаг. Энэхүү ойлголтыг Майягын сургаалын адилаар, буруу тайлбарласан нь олонтоо тохиолдоно. Энэтхэгийн гүн ухааны сэтгэгчид, энэ ертөнцийг “Майя” гэж тодорхойлсон нь, ертөнцөд бодит юм гэж юу ч байхгүй гэсэн үг биш, харин түүний бодит байдал харьцангуй бөгөөд ертөнцөд бидний нүдэнд харагдаж байгаагаасаа огт өөр гэсэн утгатай үг юм. Ертөнцийн харьцангуй бодит байдал нь, гагцхүү төгс гэгээрсэн билгүүн ухаанд л мэдэгдэх ба жинхэнэ дээд бодит байдлын дэргэд юу ч биш, уул мэт сүндэрлэсэн үүлэн дотор хормын төдийд л гялсхийх цахилгаан мэт өчүүхэн билээ.

Гэхдээ, ертөнцийн үзэгдлүүд нь хий үзэгдэл биш, өөрөөр хэлбэл, дур зоригийн, утгагүй зүйл биш бөгөөд бодитой болох нь яах аргагүй, тодорхой дотоод хуулийн илрэл юм. Бидний төсөөлж байгаа энэхүү ертөнц нь оюун ухааны бүтээл байлаа ч гэсэн бодитой гэсэн үг биш, харин энэ ертөнц өөрийг нь бүтээсэн ухааны адил бодитой юм. Миний бие,

миний ухааны бүтээл гэж ухамсарласан цагт, бие хэзээ ч устаж үгүй болохгүй. Бидний ухааны бүтээл үзэгдэх хэлбэрийг олмогц материйн, бидний оршин буй ертөнцийн хуульд захирагдана. Махбодын материаллаг чанар, үүргийг ямар ч хувилгаан гэгээнтэн өөрчилж үл чадмой. Тэрбээр, зөвхөн алхам алхмаар өөрчилж чадах боловч, гагцхүү биежих эхний шатанд нь нөлөөлж чадна. Материаллаг юманд зөвхөн үүсэн бүрдэхийн шатанд нь нөлөөлж, залах боломжтой юм.

Тиймээс Буддагын хувилсан биеийн тухай төсөөлөл нь бодит байдалтай зөрчилдөхгүй, нэн эртний болон хожуу үеийн Тхеравадинуудын түүхэн бие хүнд итгэх итгэл болон Буддагын хүмүүн бусын төгс хүчинд бишрэх бишрэлтэй зөрчилдөхгүй. Буддагхоша “Бурхан багш аугаа их хүний наян бага шинж, гучин хоёр их шинжийг агуулж, үйлдэл бүрдээ цэвэршсэн, гэгээрсэн, зүйрлэшгүй аугаа их хүчийг олж, бүрэн гэгээрсэн” тухай бичсэн байдаг. / N. Dutt, 1930, 101- р хуудас /

Тэрээр “Аттхасалини”-гийн удиртгалд Буддагын биеэс олон өнгийн солонго цацарч байгаа тухай бичсэн нь буй. “Гүн цэнхэр, алтан шаргал, час улаан, цасан цагаан, ногоон, хүрэн нүд гялбам хурц зургаан өнгийн гэрэл, Бурхан багш хүнийг тольдогч мэлмийгээрээ дхармын гүнээс харж байхад биеэс нь гэрэл цацарч байв. Түүний үс, нүднээс нь гүн цэнхэр гэрэл цацарч байлаа. Энэхүү гэрлийн туяанд тэнгэрийн гадаргуу гялалзан, цэнхэр өнгийн нунтаг цацчихсан ч юм шиг, Бадам цэцгийн дэлбээгээр хуччихсан ч юм шиг байлаа. Арьснаас нь алтан шаргал гэрэл цацарч байв. Түүний туяанд гэрлийн цацрагууд алтан тоосоор бүрхсэн мэт гялалзаж бие, цус, нүднээс улаан гэрэл цацарч, яс, шүд, нүднээс нь цагаан гэрэл цацарч байв. Гэрлийн цацрагууд энэхүү туяанд мөнгөн аяганаас ундрах сүүн урсгалаар угаагдсан мэт байлаа. Тэгээд Бурханы цус тунгалаг, түүний ухаан санаа болон дүр нарийн агаад гүн дхармыг харж байхад нь бас л ариун тунгалаг боллоо.” / Expositor, 1920, 17 - р хуудас /

Пали хэл дээрх сударт, Бурханы гэгээрлийг тэмдэглэн бичээд зогсолгүй, түүний бүтээсэн өөрийнх нь тусгал болох Ниммита бурхан нь / бурхан Шакъямунийн дүрт

Дагина, Бурханы нэг төрөл / дэлхий ертөнцөд түүнийг эзгүй байх үеэр нь Түшитийн орноос өөрийн эхэд Абхидхармагын номыг номлож байсан гэжээ.

Энэ бүхэн бол пали хэл дээр бичигдсэн Бурханы сургаалд “Гурван биеийн номлол” нь бүрэлдэж чадаагүйг харуулж байна. Тэр тусмаа, эдгээр биесийн шинж чанар болон оюун санааны чанарууд, түүнд үндэслэж Бурханы түүхэн буюу хувь хүний онцлог шинжийг онцлон дурьдсан хэн боловч буруугаа хүлээж улайсан билээ. Тэдний хувьд хүн төрөлхтөний мөн чанар, зөвхөн бие сэтгэлийн бодит байдалтай төдийгүй, өөртөө оюун санааны хязгааргүй боломжийг агуулж байдаг. Мөн орчлон ертөнц нь хязгааргүй юм гэдгийг ойлгох болжээ. Эндээс үзэхэд Хинаяна Буддист “реализм” болон Махаяна “идеализм” - ын хооронд, энэхүү харилцаан дээр ямар ч зөрчил байдаггүй юм.

Майя бол ухамсарын хэмжүүр,

бүтээгч зарчим

Дээр хэлсэнээс үзэхэд, бид учир шалтгааны оюуны дүгнэлтэд үндэслэсэн субъектив идеализмын тухай ярьж байгаа биш, харин ухааны бодит чанар, түүний гүнзгий туршлагад үндэслэсэн үзэл онолын тухай ярьж байгаа нь тодорхой болж байна.

Хэрэв “эрхэм дээд” буюу туйлын бодит байдалтай харьцуулах юм бол энэхүү бодит байдлыг бидэнд хуурамч мэтээр харагдуулж байгаа бүх дүрс нь өөрөө хуурамч юм. Гагцхүү бид, туйлын хэмээн нэрлэж чадах тэрхүү бодит байдал л, бүхнийг бүрэн дүүрэн хамаарч чадна.

Цаг маягийн ухамсарт, төгсгөлгүй үргэлжлэх шугам ухагдашгүй. Ийм ухамсарт хүртэхүйг хормын төдийд шүргэн өнгөрөх цэгүүдийн төгсгөлгүй эхлэл л баригдана.

Харин шугаман ухамсарт / нэг хэмжүүрт /, төгсгөлгүй хавтгайг хүртэх боломжгүй, учир нь ийм шугам зөвхөн нэг л чиглэлд хөдлөх бөгөөд зөвхөн дараалсан цэгүүдийн шугаман холбоог л төсөөлнө.

Хоёр хэмжүүрт ухамсарын хувьд, төгсгөлгүй хавтгай ойлгомжтой, өөрөөр хэлбэл, цэгүүд болон шулуун шугам, муруй шугам, зургууд ойлгомжтой, гэхдээ хавтгайн орон зайн холбоог, жишээ нь хавтгайнууд шоо гадаргууг үүсгэхийг хүртэж чадахгүй.

Гурван хэмжүүрт орон зайд орших ухамсар, янз бүрийн хавтгай болон цэгүүд, шулуун шугам, нэгэн зэрэг орших биеийн төсөөллийг үүсгэхийн тулд, янз бүрийн төлөв байдлын холбоог төсөөлж чадна.

Ийнхүү дээд хэмжүүрт ухамсар нь илүү өргөн, илүү олон талт нэгдэлд орших хөдөлгөөнүүдийн чиглэл, хэлхээ холбооны янз бүрийн системүүдэд нэгэн зэрэг хүртэхэд оршино. Гэхдээ, энэхүү түвшинд татагдан орсон доод хэмжүүрүүдийн хувийн онцлогийг орхидоггүй. Ингэхлээр доод түвшиний бодит байдлыг дээд түвшинд түлхэж зайлуулахгүй. Хэрэв бид хавтгай өөрийнх нь хэмжүүр байхгүй чиглэлд хөдөлж буй хавтгайн хөдөлгөөний янз бүрийн түвшинг хүртэж мэдэрвэл, биеийн хүртэхүй гэсэн үг. Хэрвээ бид нэгэн чиглэлд хөдөлж байгаа цэгүүдийн хөдөлгөөний янз бүрийн түвшинг хүртэж мэдэрвэл, шулуун шугамын хүртэхүй гэсэн үг. Хэрэв бид паралель биш чиглэлд хөдөлж буй шулуун хөдөлгөөний янз бүрийн түвшинг хүртэж мэдэрвээс, хавтгайн тухай ойлголт юм. Хэрэв бид биеийн хөдөлгөөний янз бүрийн түвшинг хүртвээс, түүний мөн чанарыг буюу өөрөөр хэлбэл, дотоод хууль, орших аргыг ойлголоо гэсэн үг юм. Хэрэв бид ухамсарт биеийн дотоод хөдөлгөөнийг хүртэж мэдэрвээс, түүний хувийн чанар, физик шинжийг ойлгоно.

Хэрэв бид хувийн чанар дамжин гарах ёстой оршихуйн олон талын хэлбэрийг ойлговол, янз бүрийн нөхцөл, үй олон хүчин зүйлүүдээс хамааралтай дүрсүүд хэрхэн үүсч байгааг харж, хүртэхүйн оргилд гарч, үйлдэл ба сөрөг үйлдлүүдийн хуулиуд буюу Кармын хуулийг ойлгоно.

Хэрэв бид Кармын гинжин хэлхээг Кармын бусад эгнээтэй холбоотойгоор ажиглах юм бол, арьсны өнгө, үндэстэн ястнууд, соёл иргэншил, хүн төрөлхтөн, од гаригууд, нарны аймаг, эцэст нь хорвоог бүхэлд нь хамарсан Карма буюу үйлийн үрийн нийтлэг холбоог ойлгох болно.

Дхармакайян хэмжүүрээр салангид бүх хэлбэрүүд нь Майя юм. Гэвч, гүн утгандаа Майя бол бүтээгч талаараа бодит байдал бөгөөд нөгөө талаараа бодит байдлын бүтээгч тал нь болно. Тийнхүү Майя нь хий үзэгдлийн шалтгаан болох авч, өөрөө хий үзэгдэл биш

юм. Майя нь төгсгөлгүйн хувьд, бүтээх үүрэгтэйн хувьд, нэгэн бүхэл цогц, орчлонгийн хэлхээ холбоо, өөрчлөлтийн төгсгөлгүй хүч юм.

Гэвч бид түүнийг аль нэг бүтээлээр нь хязгаарлаж, түүнийг “байгаа байдлаар” төсөөлбөл, хий үзэгдлийн замаар орж, үр дагаврыг шалтгаан гэж сэтгэж, сүүдрийг бодит бие болгож, тохиолдлын юмыг дээд бодит байдал хэмээн эндүүрэх болно.

Майягын энэхүү хүч нь өөрөө хий үзэгдэл биш мөртлөө, ертөнцийн амьдралын хоосон хэлбэрүүдийг бий болгодог. Уг хүчийг эзэмшсэн хүн йогийн шидэт хүч, бүтээх хувилах, нэгдэх хүчийг зэвсгээ болгох ёстой.

“Бидний дотоод үзэхүйн хүч нь йогад хэлбэр ба ертөнцүүдийг бүтээх бөгөөд тэдгээр нь бидний ухамсарыг огцом ер бусын аугаа бодит байдлын мэдрэмжээр дүүргэнэ. Түүнтэй харьцуулахад манай өдөр тутмын бодит байдал бүдгэрч алга болно. Бидний ухаан санаанд сэтгэгдэшгүйг тэнд мэдрэх боловч, бодит байдал олон үе шаттай. Тэнгэрлэг энэхүү замд төгс хэлбэрийг олох хүртлээ олон шаттай. Йога гэдэг бол тус шатаар өгсч уруудах арга юм. / Н. Zimmer, 151 - р хуудас /

Дүрс чухал биш гэж боддог хүн, түүний амин сүнсийг алддаг бол дүрсийг шүтэгч юу ч үгүй хоцорно. Дүрс, хөдөлгөөн хоёр бол амьдралын нууц, үхэшгүй мөнхийн түлхүүр мөн. Юмс үзэгдлийн зөвхөн шилжих чанарыг голлож, ертөнцийг үүсгэгч хүн, үзэгдэл юмсын зөвхөн гаднах өөрчлөлтийг харж, өөрчлөлтийн мөн чанар, түүний арга нь бүхий л хэлбэр, бүх бодит байдлыг түлхэгч сүнсийг нээх явдал гэдгийг ойлгодоггүй юм. Гагцхүү сүнс л бүх үзэгдлийг дүрстэй болгодог ажээ. Бидний махан нүд, юмс үзэгдлийн өөрчлөгдөх чанарыг л хардаг. Харин бидний билгүүн ухааны нүд л орон зайн байдлыг харж мэдэрч чадна.

Өөрчлөлт гэдэг бол дотор нь сүнс / ухаан / хөдөлж байдаг дүрс юм. Материалаг хэлбэрүүд сүнсний араас даган хөдөлж чадахгүй бол задарна. Үхэл гэдэг бол дүрс юм уу, мэдрэмжийн талууд юм. Сүнсний араас даган өөрчлөгдөж чадахгүй бол, сүнс түүнийг эсэргүүцэж байгаа хэрэг билээ. Энэ бол хөшингө сэтгэлгээний эсрэг хөдөлгөөн гэж хэлж болно. “Пражня -парамита судар”- т өгүүлсэнээр, бүх юмс үзэгдэл нь хоосон чанараар нөхцөлдсөн мэт тооцогдох бөгөөд хоосон чанар нь тэдгээрийн бодит чанарыг хүлээн

зөвшөөрч, хэлбэр дүрс, мэдрэхүй, ухаж ойлгохуй буюу ухамсараас үл ялгарах учраас юугаараа ч юм “Майя”-тай адил төстэй байдаг. Хоосон чанар нь зөвхөн өөрийн мөн чанараараа хязгаарлагдмал, бүх тодорхойлолтонд хоосон мэт боловч, бодит байдлын дээд илэрхийлэл болдогын нэгэн адил, “Майя” бол зөвхөн сөрөг хуурамч, үзэгдэлт хэлбэр төдий бус, харин үзэгдэл юмсын бүх хэлбэрийг буй болгогч хөдөлгөөний зарчим бөгөөд тэр өөрийгөө цорын ганц эцсийн эд юмсад бус, харин ч үүсч буй болохын үйл явцад, мөнхийн урсгалд, хязгааргүй хөдөлгөөн дунд өөрийгөө нээдэг юм.

Дүрс болон үзэл онолд хүлэгдэж, хөдөлгөөнгүй болсон Майя бол хоосон юм. Учир нь түүнийг амьд шүтэлцээнээс нь салгаж цаг хугацаа, орон зайд хязгаарлажээ. Өөрийнхөө хоосон “би” - г дэмжин хадгалахыг оролдож буй харанхуй хүний хувийн бодгаль чанар нь нэг ёсондоо сөрөг агуулгатай Майя юм. Төгс гэгээрсэн хүний бие ч гэсэн Майя мөн боловч бүх хуурмаг үзэгдлээс чөлөөлөгдсөн ухааны ухамсарт бүтээгдхүүн учраас эерэг агуулгатай билээ.

Худал хуурмаг, үзэгдэх дүрс төдийд хутгалдсан, эгэл ертөнцийн харанхуй хүнд л Буддагын үзэгдэх дүр нь Майя болно. Ийм ч учраас “Махаяна шраддхотпада” -д өгүүлэхдээ, “Татхагатын идэвхтэй чанар, төсөөлшгүй их үйлсэд зөвшөөрөгдсөнөөр, үгийн утганд хоёр янзын төрөл байдаг. Эхнийх нь Нирманакайя мэт мэдээжийн, ердийн хүмүүсийн ухаанаар хүлээн авч болох төрөл, хоёр дахь нь Дхармакайя мэт, оюун санааны болон зарчмын ойлголт буюу Самбхогакайя / агуу их хэмжээлшгүй боломжуудыг эзэмшигч / мэт ариуссан хүмүүсийн ухаанаар хүлээж авдаг төрөл юм.

Ердийн хүмүүсийн ухаанд бууж буй бодит байдал Дхармакайя бол, жинхэнэ бодит байдлын зөвхөн сүүдэр төдий юм. Тэр нь оршихуйн зургаан салбарт хэрхэн төсөөлөгдсөнөөсөө шалтгаалж, янз бүрийн дүрээр бууна. Тэдний баримжаалсан ойлголт нь түүний боломжуудыг өөрсдийн аз жаргалын тулд ашиглахыг тэдэнд зөвшөөрдөггүй бөгөөд ийм ч учраас тэд түүний тусгалыг Нирманакайяд хардаг юм. Гэвч Бодьсадва нар нь гэгээрлийн зам руу үе шаттайгаар урагшлан давшихад, тэдний оюун ухаан цэвэршин ариусаж, тэдний Дхармакайягын талаарх ойлголт нь улам гүнзгий болж, тэдний ариун үйл

хэрэг нь улам зах хязгааргүй тэлэх бөгөөд өндөр үе шатанд хүрсэн цагтаа, тэд Пражнягын тусалцаатайгаар, түүний жинхэнэ бодит байдлыг зөн билгээрээ мэдэж авдаг байна. Эцсийн эцэст, тэдний амиа бодох үзлийн бүх ул мөр нь устаж үгүй болж, зөвхөн Бодь сэтгэлийн хувиршгүй ганц байдал л үлддэг ажээ.” / Buddhist bible, 1938, 383 - р хуудас /

Нирманакайя нь Боджилтын дээд

хэлбэр болох нь

Ердийн хүний бие ч “Майя” мөн бөгөөд Төгс гэгээрсэний бие ч Майя мөн билээ. Гэвч, энэ бол ердийн хүний биеийг Нирманакайя гэж нэрлэж болно гэсэн үг хараахан биш юм. Үүний ялгаа нь юунд орших вэ? гэвэл, Төгс гэгээрэгсдийн бие нь, түүний ухамсарт бүтээлч хөдөлмөрийн үр дүн байдаг бол ердийн хүний бие нь түүний өнгөрсөн амьдралын хүсэл эрмэлзлэлийн үр дагавар байдаг. Энэ хоёр хоёулаа “Майя” мөн боловч нэг нь ухамсартай, нөгөө нь ухамсаргүй, нэг нь эзэн Майя бол, нөгөө нь боол Майя, үүний ялгаа нь билгүүнд / праджня / оршино. Дхармакайя ч гэсэн энэ нь үнэн бөгөөд харьцангуй байдаг. Тэр нь бүхнийг хамарсан учраас бид түүнийг ухамсарлаж байгаа эсэхээс үл хамааран хаана ч байдаг юм. Гэхдээ гагцхүү бид Дхармакайяг далд ухамсарын потенциал байдлаас бүрэн ухамсарлагдсан байдалд шилжүүлж, нүдээ гэрэл рүү нээсэн цагт л, түүний мөн чанар нь бидний хувьд идэвхтэй хүч болж, биднийг үхэл тээсэн харанхуй нүхнээс гаргана.

Энэ нь бие болон ухааны шилжилт бөгөөд өөрөөр хэлбэл, бие хүнийг Нирманакайяд шилжүүлэхтэй холбоотой юм. Зөвхөн Нирманакайя л бид Дхармакайяг жинхэнэ ёсоор нь ухамсарлаж, бие хүний бүх элемент цэвэрлэгдэн сэргэсэн бүрэн дүүрэн мэдрэмжинд түүнийг ухаарал болгон олж авна. Бие болоод ухааны шилжилтэнд Аугаа их Гэгээнтэнүүд л хүрч чадсан билээ. Тиймээс Нирманакайя бол Бодьжилтын дээд хэлбэр, эгэл ертөнцийн балар хүний нүдийг нээгч цорын ганцхан зүйл юм. Бурхан багш асар удаан хугацаанд, урдах үй олон төрөлдөө, бүх хүчээ дайчилж байж хүрсэн Төгс гэгээрлийн үр шим нь энэ бөлгөө. Бурхан багш “Махапаринирвана судар” - т хэн нэг хүн надаас гуйсан бол, туулсан бүх замаа дахин туулах байсан юм гэсэн байдаг.

Хөндлөнгөөс харах буюу өөрөөр хэлбэл, үзэл баримтлалын сэтгэлгээний үүднээс харвал, Самбхогакайя, Нирманакайя хоёр нь Дхармакайягийн үр дүн бөгөөд орчлонгийн дээд зарчим түүнд агуулагдана.

Дотроос нь буюу туршлагын үүднээс харах юм бол, Самбхогакайя Нирманакайя хоёр нь Нирманакайяд агуулагдана. Зөвхөн Нирманакайяд л бусад хоёр “бие” бодьжих билээ.

Эхний үзэл баримтлал нь Махаяны философи, хоёр дахь хандлага нь Йогачарын практикт, ялангуяа Важраянад илэрдэг.

Иймээс Нирманакайя нь гурван бие гурвуул оршиж, нэгэн зэрэг хүртэгдэж байгаа тухай туршлагын талаас нь “Важракайя” буюу “Дөрөв дэх бие” хэмээн нэрлэх нь бий. Жаахан засч хэлбэл, “Дөрөв дэх хэмжүүрийн бие” юм. Гэвч, энэхүү хэмжүүрийг математик биш утгаар, харин сэтгэхүйн утгаар нь ойлговол зохино.

Нийтлэг болон хувийн оюун санааны энэхүү хэмжүүрийг мэдрэх тухай “Гандавьюха”-д бичсэн байдаг. Гэгээн мөргөлчин Судхана бодьсадва нь Майдарын суваргыг үзсэн тухай гардаг уг зохиол нь, дээд түвшиний хэмжүүрт өмнөх хэмжүүрүүдийн шинж чанар байдаг бөгөөд тэдгээр шинж чанарыг илүү дээд нэгдэл болгодог гэсэн томъёоллыг нотолж байна. Үүнд:

“Бүх зүйл тус тусдаа биш нийлүүлээд хайлчихсан мэт нэгдмэл байтал, юм бүхэн хувийн чанараасаа юуг ч алдаагүй байв. Учир нь ариуссан Майдарын дүр юм бүхэнд шингэсэн байлаа.” Уран яруу хэлээр бичсэн тус зохиолын төгсгөлд, “Залуу мөргөлч Судханы бие болоод ухаан бүрэн хайлж, бүх бодол санаа нь ухамсараас гарч, ухаанд нь байсан таагүй зүйлс алга болохыг мэдэрлээ” гэсэн байдаг. / D. T. Suzuki, 1953, 138 - р хуудас /

Дүрсүүд, юмс үзэгдэл, үйл явдлууд бие биедээ бүрэн нэвтэрч, тэр бүхний хувийн чанар хадгалагдан ялгаа болон нэгдэл нэгэн зэрэг орших нь, Будда болон Нагаржунайн агуу их нээлт юм. Энэ нь “оршихуй”, “эс оршихуй” - н хоорондын бодит байдлын мөн чанарыг илэрхийлсэн “Дундаж замын төв үзлийн философи” юм.

Энэ зам нь юмс бие биеэсээ үл хамааран тус тусдаа үүсч, алга болж эсрэг тэсрэгийг үүсгэдэг хэмээн төсөөлөгч, царцанги үзэл баримтлалаас чөлөөлөгдсөн сэтгэлгээний шинэ чиг баримтлалд үндэслэдэг. Хөдөлгөөнд байгаа юм бүрийг харах юм бол, ийм ойлголт бодит байдалд нийцэж буй харагдахгүй. Энд рупа, шунъята хоёр нь бие биеэ үгүйсгэсэн эсрэг, тэсрэг хоёр тал биш, харин тасралтгүй харилцан үйлчлэлд оршин байгаа нэг бодит байдлын хоёр тал гэж ойлгогдоно.

Хэрэв ийм байгаагүйсэн бол бүрэн төгссөн, ив ижилхэн хоосон байдлаас хэлбэр, ялгаа, хөдөлгөөн хэрхэн үүсэх вэ? гэсэн асуулт гарч ирнэ. Гэвч, бид энд илүү “эртний” юм уу “өмнөх” доод түвшиний бодит байдлуудыг биш, нэг л Бодит байдлын хоёр талыг төсөөлж байна. Дүрс буюу орон зай нь хоорондоо нөхцөлддөг бөгөөд ийм ч учраас дүрсгүйдэл нь Бодит байдлын дээд, харин дүрс нь Бодит байдлын доод байдал юм гэж нотолж болохгүй. Тэгж зөвшөөрч болдог юм аа гэхэд, эхлэл төгсгөлгүй хөдөлгөөний ухамсарт үйлийн илэрхийлэл мэт бус, харин ямар нэг зүйл өөрөө өөртөө хатуу чанга хадгалж байгаа мэтээр дүрсийг бид нар хөдөлбөргүй утгаар нь хүлээн авч болно.

Гагцхүү хэлбэржсэн дүрсгүйг мэдэрч чадах, хэлбэргүй дэхь дүрсийг мэдэрч чадах хүн буюу “хоосон”, “дүрс” хоёр нэгэн зэрэг оршин байгааг мэдэрч чадах хүн л дээд бодит байдлыг ухамсарлаж чадах болой.

Энэ тухай “Зүрхэн судар” -т дүрс бол “хоосон” бөгөөд хоосон ч “дүрс” -ээс ялгаагүй, гэвч “хоосон” бол дүрс юм. Учир нь юмс бүгд “хоосон” - ны мөн чанартай, тэдэнд эхлэл ч үгүй, төгсгөл ч үгүй, тэд төгс ч биш, төгс бус ч бас биш” хэмээсэн нь буй.

Иймээс Дхармакайя нь ялгалгүй “Хоосон”-ы туршилт төдий бус, харин бүх дүрсүүдийн “оршин тогтнохуй” юм. Учир нь бүх дүрст байдаг тэрхүү чанар нь илүү сайн үггүйгээр байхын тулд “хоосон чанар”- тай төстэй, “хоосон” субстанц бус чанар, ухамсарын эзлэх орон зай, хөдөлгөөний төгсгөлгүй боломжит байдал, бүх дүрсүүдийн харилцан шүтэлцэлийн хязгааргүй байдал, хувьсамтгай болон хөдөлгөөнт чанар гэх мэтийн үгээр илэрхийлэгддэг буюу тэмдэглэгддэг байна.

Дхармакайягийн танигдашгүй чанарын талаар, эртний Махаянад үзэгдэл болон туршлагын барим тавим дүрсүүд нь Дхармакайягийн “хоосон”- той хэрхэн харьцах вэ? гэсэн асуулт тавьсан байдаг. “Махаяна Шрада - хотпада шаштир” – т, энэ асуудлыг томъёолоходоо: “Дхармакайя Будда дүрсийн ямар ч хүртэхүй, төсөөллөөс чөлөөт бол барим тавим дүрсүүдийг хэрхэн үзэгдэх вэ?” гэжээ.

Үүний хариулт нь, “Дхармакайя бол үзэгдэж буй дүрсэжсэн бүхний мөн чанар бөгөөд тиймээс ч хэлбэржсэн зүйлд үзэгдэнэ гэжээ. Гэвч, ухаан, хараа хоёр эхнээсээ нэг л нэгдлийг хүртэж ирсэн болохоор, харааны болон дүрсийн мөн чанар нь ухаан байж таарна. Учир нь харааны мөн чанар нь биежсэн дүрсгүй болохоор Дхармакайятай адил дүрсгүй атлаа, орчлонгийн хаана ч нэвтэрдэг билээ.” / Buddhist Bible, 1938, 385 - р хуудас /

Дхармакайя ба биеийн нууц

Дээр хэлсэнээс үзэхэд, Дхармакайя бол хийсвэр зарчим төдийгүй, туршлагын янз бүрийн түвшинд, янз бүрийн хэлбэрээр илэрдэг, амьд бодит байдал гэдэг нь тодорхой байна. Энд “кайя” буюу “бие” гэдэг үгийг оюун санааны болон ухамсарлагдсан бодит байдлын идэвхийн хүрээ гэсэн утгаар хэрэглэж, нэгэн бүхлийг үүсгэн, физик биетэй жишиж байна.

Оюун санааны хувьд хөгжөөгүй бие хүн, материаллаг хүрээ, түүний дүрсүүд болон физик биеэр хязгаарлагдана. Оюун санаа нь хөгжсөн бие хүн, түүний дүрсийн материаллаг хүрээ төдийгүй, оюун ухааны хүрээг хамрах ба түүний ухамсарт бие нь физик биеийн хүрээнээс хол давж гарна.

Хувийн сонирхол, мэдрэмжийн хүрээнээс хальж, эрхэм дээд үзэл санаагаар амьдардаг хүний “ухамсарт” бие нь орчлонгийн үнэний хэмжээнд, гоо сайхан, ёс зүйн таашаалд тэлнэ.

Тиймээс орчлонг бүхэлд нь ухамсарлан, төгс гэгээрсэн хүний хувьд, бие бол юу ч биш, гэхдээ түүний физик бие Орчлонгийн ухааны илрэл болохоос гадна, түүний дотоод

үзэхүй нь аугаа их бодит байдлын илрэл болж, үг хэл нь мөнхийн үнэн, мантрын хүчний илрэл болно.

Энд бие, хэл, сэтгэлийн нууц хамгийн дээд илрэлээ олж, бүх үйл явдал болох оршихуйн гурван хэмжээнд жинхэнэ мөн чанараараа нээгдэнэ.

Биеийн нууц нь - материалаг чанар, физик биежилтийн нууц биш, хязгааргүй, бүхнийг багтаасан нийтлэг биеийн нууц болдог.

Хэлний нууц нь - ердийн нууцлаг үг яриа, ойлголтоос хамаагүй өргөн хүрээтэй бөгөөд утгыг нь агуулсан сонсогдох, үзэгдэх, бодогдох, билэг тэмдгийн хэлбэрээр илэрсэн оюун санааны бүхий л зүйлийн зарчим юм.

Сэтгэлийн нууц нь - сэтгэлгээ болон үзэл санаагаар ойлгож ухамсарлах зүйлээс илүү өргөн хүрээтэй зүйл бөгөөд энэ бол оюун санааг матери болгох, төгсгөлгүйг төгсгөх, ерөнхий зүйлийг өв тэгш зүйл болгох зарчим, махан биеийг Нирманакайяд оруулах явц юм.

Ийнхүү бие, сэтгэл хоёрын хоёрдмол байдал, ялгаа арилж байна. Төгс гэгээрсэний бие нь үзэгдэх төдийд, итгэл төрүүлэм урам зориг оруулж, үг бүхэн нь буюу дохио зангаа бүр нь Дхармын гайхамшигт бодит байдлыг илтгэж байдаг. Энэ бол хүмүүс хоорондоо харилцаж, дотоод оршихуйдаа өөрчлөгдөж байдаг “сонсогдохуй” үгс юм. Энэ нь ердийн үгний хязгаараас хальж, ариун бурханаас цагарч байдаг сонсогдошгүй мантрын авиа юм. Тиймээс төгс гэгээрсэнийг “Муни” буюу “Дуугүй” гэдэг. Түүний зүрхнээс цагарсан оюуны цацраг “дотоод авиа”, “дотоод үзэхүй” нь эцэсгүй орчлонг нэвтэлж байдаг билээ.

Тус харилцааны талаар “Махаяна Шраддхотпада шашдир” – т, дурьдахдаа: “Дотоод мөн чанарын гүн гүнзгий утгыг гаргах гол онцлог нь аливаа хэмжээ хязгаарлалт болон тодорхойлолтоос / үзлээс / чөлөөлөгдөх хэрэг юм. Нөхцөл боломж нь тодорхой бол, тэр нь өөрөө илрэн гарахад, зөвхөн оюун ухаанаас шалтгаалж, орчлон ертөнцийн аль ч цэг дээр илэрч гарч болно. Ийнхүү Бодьсадва болон Самбхогакайягийн гайхамшигт чанар нь ойлгогдож танигддаг бөгөөд эдгээр нь нэг нэгнээсээ ялгарч, хязгаарлалт буюу аливаа хүрээн дэхь үзэл бодлоос чөлөөтэй байдаг ажээ. Иймээс Татхагатууд / туулсан бурхад /

бол биет дүрсээр илрэх чадвартай. Тэгэхдээ, тэнд нь орчин юмсыг огт хөдөлгөөнгүйгээр бусад Татхагатууд ч илэрч болно. Энэхүү гайхалтай харилцан нэвтрэлт нь, мэдрэхүй ухаанаас шалтгаалдаг аливаа ухамсарын хувьд үл ойлгогдох зүйл юм. Гэхдээ оюун ухааны Мөн чанарын үл мэдрэгдэх дотоод идэвхжилийн үүднээс бол, энэ нь тодорхой зүйл юм. / Buddhist bible, 385 - р хуудас /

Төвдийн зарим бурхан зурагт сэтгэл санаагаа гүнээ төвлөрүүлсэн юм уу, Дхарма номлож буй Буддаг үй олон Дхъяни бурхадаар хүрээлүүлэн зурсан байдаг нь Их гэгээрлийн идэвхтэй хүч нь субъектив процесс төдийгүй, оюуны асар их цацраг гэдгийг харуулсан хэрэг юм.

Хүний өвөрмөц чанарын халхавчийг нэвтрэн, мэдэгдэж буй хүний хирээс ахадсан амьдрал, туршлагын бодит ертөнцийн эдгээр хүчтэй зорилтууд нь ганцаарчлан илэрдэг. / “Персона” гэдэг бол Эртний Грекийн жүжигт тухайн жүжигчний зан чанарыг илтгэсэн баг байсан бөгөөд жүжгийн дуу хоолой нь энэ багыг нэвт дуулддаг. “Сонара” - энэ бол дуугарах, дуулдах гэсэн үг юм. /

“Хүний өвөрмөц чанар” гэдэг бол анхдагч утгаараа, “Хувь хүний чанараас” илүү юм. Тэгээд ч “Хүний өвөрмөц чанар”- т тусад нь салгаж авч үзсэн аливаа хуурмаг, хуваагдашгүй байдал болон нэгдэлтэй байдал байдаггүй юм. Гэвч, үүний эсрэг байж болно. Тэгээд ч бидний илэрч гарах түр зуурын дүрсүүд нь, арай дээд бодит байдлын дуу хоолой нэвтэрч чаддаг, түр зуур хэрэглэх багтай адил төстэй байдаг. “Хүний өвөрмөц чанар”, “хувь хүний чанар” бол ялгаатай болохыг бүр Рене - Гуно хэлж байсан бөгөөд энэ тухай Д.Т. Сузуки бол “Хүний өвөрмөц чанар”- ын элементүүдийг Дхармакайяд олж хараад, мөн иймэрхүү байр суурийг баримталдаг.

“Үзэл санааг бие хүнээр төсөөлөх үзэл баримтлал илүү ойлгомжтой юм. Эрхэм дээд бодит байдалд нь хийсвэр ойлголт төдийгүй мэдрэмжтэй, ухамсартай, ухаантай, тэр ч бүү хэл, хүний сул дорой муу муухайг арилгах, ариухан хайр сэтгэлтэй амьд үйл мөн” гэж Сузуки тэмдэглэн бичсэн байдаг. / D. T. Suzuki, 1947, 41- р хуудас /

Өөрөөр хэлбэл, энэ нь хувь хүнд илэрч, бие хүний хэлбэрийг олсон амьд хүч юм. Гэвч тэр нь хувийн ухамсарын хязгаараас хальдаг, учир нь түүний эх булаг нь оюун санааны нийтлэг хүрээ Дхармакайяд оршдог. Тиймээс, хүний ухаанаар төлөөлсөн бие хүний шинжтэй болно. Хэрэв энэ нь хийсвэр үзэл төдий байсан бол, оюун ухаанд нөлөөлж чадахгүй байлаа.

Тиймээс ч Дхьяни Бурхад / жишээлбэл, Амитабха / ухамсарт амьд хүчний хувьд, зөвхөн биежсэн хийсвэр төдий бусын хувьд, бие хүний бүх шинж чанарыг агуулдаг. Амитабхагын энэ “хүн” шинж нь дур зоргоор нэмсэн хольц биш, хүний туршлагын хэлбэрт оруулсан нийтлэг бодит байдал юм.

Цахилгааныг хэвийн байдлаар хэрэглэхийн тулд, өндөр хүчдэлийг арай нам болгон хувьсгах гүйдэл болгон шинж байдлыг алдуулахгүйгээр хэрэглэх хэрэгтэй байдгын адил, олон талт үнэт чанарууд хүний амьдралд хэрэгтэй болсон бол, тэдгээрийн мөн чанарыг алдагдуулахгүйгээр хүний үнэт чанар болгон хувиргах ёстой болно.

Энэ зарчим бол бүх Дхьяни бурхад болон шашин, йогийн таньж мэдсэн мэдлэгийн төсөөтэй хэлбэрүүдэд хавсаргаж болох зүйл юм. Тэдгээр нь хүний оюун ухааны цаг хугацааны дээр байгаа хэлбэрүүд / “архетипүүд” буюу “эртний хэлбэрүүд” гэж К.Г. Юнг хэлэх байсан байх / болно. Иймээс ч тэдгээр нь хэрэгжүүлэх үйл явцад болон оюун ухааны бодож олоогүй хийсвэрлэлээс буюу оюун санааны зорилго, үнэт зүйлсийг оюун ухаанаар мэдрэхээс үр дүнтэй хамгаалахад чухал юм.

Сиддхи буюу Зэнгийн увьдист чадвартнуудаас олдсон “Гантрын” буюу “Зэн буддын” содон гайхалтай зүйлүүдийг өнгөц байдлаар хүлээн авч дуурайхад аюултай байдаг нь үүнд л оршино. Тэрхүү содон гайхалтай зүйлийг зөвхөн Гэгээрлийн мөрийн төгсгөлд, уламжлалт шашны бүх хэлбэрүүд болон логик тодорхойлолтуудаас салж, чөлөөтэй болох чадвартай болсон үед хэрэглэж болно.

Хийсвэр үзэл санаа нь, өөрийнхөө хүнчилсэн буюу биежсэн дүрсээс хэзээ ч “дээш гардаггүй”. Дүрсгүй байдал нь дүрстэйгээсээ заавал үнэ цэнэтэй юм уу, үнэн байх албагүй. Тухайн хүн дүрсийг нэвт харж, байгаа дүрс болон түүний байхгүйг мэдрэх нь харьцангуй

гэдгийг ухамсарлаж чадахаас бүх зүйл хамаарна. Энэ хоёр туйлшрлийн аль аль нь аюултай. Бид дүрсийг хязгаар хэмээн эндүүрч болох ба нөгөө нь дүрсээр илэрсэн бодит байдлын нөгөө талыг харахгүй байж мэднэ. Үнэхээр ч бид бодит байдлын нэг түвшинд байгаа болохоор, энэхүү аюулаас зайлахад бэрх юм. Эндээс л тэднийг нэгтгэж, Важраянад нэгэн зэрэг ухаарах шаардлага урган гарч ирж байна.

5. Их Мантрын олон хэмжүүрт тал

Мантрын ач холбогдол, үр өгөөж нь түүний олон хэмжүүрт тал, бодит байдлын бүх төвшинд шинэ агуулгыг нээх чадварт оршдог. Хүмүүн бид туршлагын янз бүрийн үе шатыг нэг бус удаа туулж байж, мантрын туршлагыг бүрэн ойлгох болно.

Иймээс ч, Бурхан багш мандлын билэг тэмдэгтэй танилцаагүй хүнд Их мантрын “Ум ма ни бад мэ хум” хэмээх зургаан ариун үг заахаас татгалзаж байжээ. Бид ч гэсэн ийм шалтгаанаар, мандал болон чакрын мөн чанартай дэлгэрэнгүй танилцах болно.

Бурхан багш Маанийн зургаан үсгийн далд утгыг тайлахаас татгалзсан шалтгаан нь, мантра өөрөө авианы бүтээгдхүүн болохын хувьд, дотоод үзэхүйн талууд, билгүүн ухааны гадаад талуудтай холбож үзэхгүй бол төгс бус, үр ашиггүй зүйл юм. Мантрын энэхүү томъёолол нь юмсыг гэгээрлийн байдалд хүргэж чадаж байгаа бол, түүний мөн чанарыг Авалокитешварагын гайхамшигт төгс мөн чанар хэмээн үзэх ёстой. Уг мөн чанар бодит байдлын бүх хүрээ, төгс гэгээрсэн үг хэл, санаа бодол, билгүүн чанар болон суудлыг мэдэх ёстой. Мантра нь мандлын нэгэн адилаар, өөрөө үйлдэж чадахгүй бөгөөд үйлдэхийн тулд “дотоод зүрхний” олон талын илрэлийг ч ойлгогдохуйц болгодог. Гэвч, энэ хүрээнд ч мантра зөвхөн үзэгдэх илрэл төдий байх нь үгүй.

Энэхүү “Бурханлиг зүйл” нь өөрийгөө умартан, гүн гүнзгий бясалгалын байдалд орсон “садхак”-ийн оюун ухаанаас өөр юу ч биш юм. Өөрийгөө хий үзэгдэл, би-г баримтлах аминч хувийн ухамсараас чөлөөлөх явцад, түүний бие махбод Авалокитешварагын үзэгдэх илрэлийг тээгч болох ба түүний мөн чанар нь “Ум ма ни бад мэ хум”-аар илэрнэ.

Тус мантрын утгыг түүний бүрдэл хэсгүүдийн тодорхой зарим агуулгаар хязгаарлаж болохгүйн учир нь, амьд бүхэн болон бүтээлч идэвхийн бүх хүрээнд бүхэл нь түүний хэсгүүдийн нийлбэрээс их байдагт оршино. Бүрдэл хэсгийн утга нь, бүхэлийн утгыг ойлгоход бидэнд тусалдаг билээ. Бүхэл ба хэсгүүдийн амьд уялдаа нь туйлын чухал учраас аль нэг тодорхой хэсгүүдийг нарийвчлан судлаад, дараа нь тэдгээрийг нэгтгэн дүгнэх боломж байхгүй. Бид бүхэлийг дотоод туршлагын бүх чиглэлд нь шууд олж харах ёстой. Мандалын билэг тэмдэг йогын ухамсарын бүх түвшинд биеллээ олох замаар үүнд хүрнэ.

Энэ тохиолдолд Амитабха нь Дхармакайяд “Ум”-аар төлөөлөгдөх ба сэтгэцийн дээд хүрдэнд нийцсэн мандалын төвд Вайрочаны байрыг эзэлдэг.

“Мани”-д бол, Амитабха нь Дхармакайягийн өмсгөлтэй Аюуш бурханы дүрээр байдаг. Иймээс төгсгөлгүй амьдралыг бэлэглэгчийн хувьд, өөрийн мөн чанарын идэвхтэй талыг төлөөлнө. Энд Амитабхагын гэрэл нь амин хувийн явцуу хүрээнд баригдаагүй, эцэс хязгааргүй жинхэнэ амьдралын эх булаг болно. Энэхүү амьдралд тус тусдаа амьдралын олонлог нь, амьд бодис бүхний нэгдэлд биеллээ олдог.

“Бадма”-д, Амитабха нь эцэс төгсгөлгүй идэвхтэй хэлбэрүүдийг нээх замаар Нирманакайя болох бөгөөд түүнийг мянган мутарт Авалокитешварагаар билэгдэнэ.

“Хум”-д, Авалокитешвара нь “Очир эрдэнийн бие” буюу Ваджракайя болно. Тийнхүү бясалгагч нь Амитабхагын амилсан дүр болно. Үүнийг Амитабхагын ариун үг “Хри” -гээр тэмдэглэн, улмаар мантрын бүрэн хэлбэр нь “Ум ма ни бад мэ хум хри” болно.

Оюун ухаанаа хүчтэй төвлөрүүлж, бясалгалын үед Амитабха бурханы үзэгдэх дүрс нь өөр өөр бөгөөд йогач хүний зохих хүрдүүдэд тэр нь илэрдэг юм. Жишээ нь: Амитабхагын төлөв Дхармакайя нь толгойн хүрдэнд, Аюуш бурхан нь хоолойн хүрдэнд, Авалокитешвара бурхан / эсвэл түүнд хамаарах Очирын хэлбэр / нь зүрхний хүрдэнд тус тус байгаа мэтээр дүрслэгддэг. Харин түүний өөрийнх нь хувилгаан дүр, амьдралын төгс төгөлдөр, нэгдмэл чанарыг билэгдэж, йогач хүний бүх биеийг эзэмдэж байдаг билээ. Гурван нууцын үүднээс / бие, хэл, сэтгэл / мантрын томьёо нь дараах утгатай болно.
Үүнд:

“Ум” – д, бид Дхармакайя болон орчлонгийн биеийг мэдэрнэ.

“Мани”- д, Самбхогакайя болон сэрсэн ухамсар, дотоод үзэхүй, урам зориг болсон мантрын авианы нууцыг мэдэрнэ.

“Бадма”- д, Нирманакайягийн туршлага, бүхнийг өөрчлөгч билгүүний нууцыг мэдэрнэ.

“Хум”- д, гурван нууцын нэгдэл болсон Ваджракайяг мэдэрнэ.

“Хри”- д, хувирсан бүх биеэ Амитабха-д бүрэн зориулна. Энэ бол Авалокитешварагийн дүрээр билэгдсэн Бодьсатвагийн үзэл санааны биелэл юм.

“Хри” бол Амитабхагийн тамга төдийгүй, Бодьсатвын замд хүрэхэд ач холбогдолтой юм. “Хри” нь дотоод дуун, бидний дотоод дахь ёс зүйн хууль, хүний мөн чанарын дуурьсал, дотоод эрдмийн гэрэл юм. Энэ бол нүгэлтэн, буянтан хоёрыг алагчлалгүй гийгүүлэгч, алтан нарны адилаар, бүхнийг гэгээрэлд дуудагч Бодьсатвын онцгой билэг, хөдөлгөгч хүч, хөтлөгч зарчим юм. “Хри” гэдэг үг “ичиж улайх” гэсэн утгатай байдаг нь, бид дээд эрдэм, нинжин сэтгэлд хүрсэн цагт л ичих мэдрэмжтэй болдогтой холбоотой. Улаан өнгө бол Амитабхагийн өнгө билээ. Мантрын утга агуулга нь, үгчилсэн утгын хүрээнээс асар хол хальдаг. “Хри” бол гэрэл цацруулагч нарны зарчим, дээшлэн мандагч авиа билээ.

Түгээмэл хүрээн дэхь энэ бүх гэрлийн болон галын холбоо нь Цаглашгүй гэрэлт буюу Амитабха бурхантай зохицон орших ба тэдгээрийн билэгдэл нь “Гал” буюу шингэж буй нар мэт “улаан өнгө” бөгөөд шашны сургаал нь Авалокитешвара бурханыг, харин сэтгэл хөдлөлийн холбоо нь хүн төрөлхтөнийг заадаг.

“Нүдээр үзэгч Нигүүлсэхүйн бурхан” Авалокитешвара нь хамаг амьд амьтаныг ариун хайраараа энэрэн хайрлагч Бурхан бөгөөд хувийн сонирхлоосоо ангижирч, зовлон хайрыг тэсвэрлэгчдэд хэмжээлшгүй энэрэн нигүүлсэхүйг үзүүлэгч хувилгаан билээ. Аливаа үйлийн байр суурь болон сэтгэлийн илрэл хаана илэрч байна, тэнд Авалокитешвара бурхан өөрийн хязгааргүй, тоо томшгүй олон хэлбэрээрээ, амьдралын аливаа хүрээнд тодрон гарч ирдэг юм.

“Билгүүн” буюу “оюун ухаан” Важрасатвад болон бүх ухамсарын дийлдэшгүй мөн чанарт зонхилж байдагчлан, Бодхичиттагын сэтгэл хөдлөлийн зарчим буюу энэхүү энэрэн нигүүлсэл нь Авалокитешварад давамгайлж байдаг юм. Тэдгээрийн нэгдэл нь гэгээрэхүйн төгс төгөлдөр зам болдог. Ийм ч учраас Авалокитешварагын мантрын томьёо нь Важрасатвын сүүлчийн тэмдэг “Хум”- аар төгсдөг билээ.

“Бид хязгаарлагдмал мэдлэгийн хүрээнд байхад ертөнц тийм ч бодитой санагдахгүй. Учир нь түүний оршихуй хий үзэгдэл мэт тогтворгүй, харин бид Бодьсатвад хүрэхэд маш багтай, бодитой юм барьж авсан мэт болно. Зөвхөн энд л амьдрал жинхэнэ утгаа олно.”

Бид мэдлэгийг эзэмших замаар өгсөн дээшилж, гучин гурван тэнгэрийн оргилд хүрэх мэт болох ба тайван суугаад доод ертөнцийг ажиглана. Доод ертөнцийн амьдралыг хөл доогуур нүүх үүл мэт гэвэл, хуйларсан бөөн юм харагдах атал, дээд ертөнц нь цэлмэг тэнгэр мэт амгалан харагдана. Гэвч, Бодьсатва энэ бүхнийг амгалан дүрээр харж, мөнхөд харж суудаггүй, учир нь түүний зүрх энэхүү эгэл ертөнцийн зовлонгоор дүүрэн учир оршихуйн бужигнасан урсгал руу доошлон орно.”

/ D. T. Suzuki, 1953, 149 - 150 хуудас /

Нэгэн домогт өгүүлсэнээр, Авалокитешвара нь бүхнийг нэвт үзэгч мэлмийгээр доод ертөнцийн энэхүү зовлонг бужигнааныг хараад бусдын зовлонг нимгэлэх нинжин сэтгэл нь дээд зэргээр бадрахад толгой нь олон хэсэг болон задарчээ. Түүний биеэс тусламжийн мянган мутар тал тал тийшээ цацран гарсан гэнэ. Мутар бүхний алган дээр мэлмий байгаа нь Бодьсатвагын энэрэл нь сохор сэтгэл хөдлөл биш, билгүүн ухаан, хайр энэрэлийн нэгдэл юм. Энэ бол юм бүхний дотоод нэгдлийн мэдлэгээс үүдэн гарсан, бусдад туслах сэтгэлийн оргилуун эрмэлзлэл болно.

Зовлон болоод энэрэхүй нь ёс суртахуун, оюун ухааны давуу талд тулгуурладаггүй. Харин “өөрийгөө бусадтай адил болгох” мөн чанар юм. Өөрөөр хэлбэл, бусдаас өөрийгөө ухамсарлах нь жинхэнэ ёс зүй буюу бие биеэ ойлгохын түлхүүр болно. “Ёс суртахууны агуу их нууц бол хайр сэтгэл буюу бидний уг чанараас гарах гарц, бусад бие хүний бодол, үйлдэлд байдаг гоо сайхантай өөрийгөө адилтгах явдал мөн. Сайн санаат хүн өөрийгөө

хүчтэй, ойлгох чадвар сайн гэж төсөөлөх ёстой бөгөөд өөрийгөө бусдын байр суурин дээр тавьж сурах хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, тухайн хүний ойр дотнын хүмүүсийн зовлон зүдгүүр болон баяр баясгалан нь тэр хүнийх болох ёстой” гэсэн үг юм. / П. Б. Шелли /

Энэрэн нигүүлсэхүйн сэтгэлийн үүднээс зовж зүдэрсэн бусад бүхий л амьтадын байр сууринд өөрийгөө тавьсанаар, түүний мөн чанар хичнээн гүн гүнзгий болохыг ойлгох бөгөөд ингэснээр, тухайн нөхцөлд зовлон эдлэгчийн зан байдалд тохирсон тусыг түүнд санал болгодог юм. Иймээс ч Бодьсадвагын тус нь дотроосоо урсан гарч, тусламж хүртэж буй хүнд дарамт болох биш, амьд бүхний дотоод мөн чанарт нуугдан байгаад гэгээрсэн хүч бөгөөд ямар ч нөхцөлд аймшиггүй байх боломжийг өгч, жинхэнэ үнэ цэнэ, чөлөөлөгдөх хэрэгсэл бологч юм. Энэхүү хүчийг “аймшиггүй” хэмээн тодорхойлоход хэтрүүлэг болохгүй.

Аймшиггүйн энэ хүч нь үйлийн үрийг ч няцааж болно. “Цаазлагдах ялтан Амитабхагын нэрийг зүрх сэтгэлээсээ дуудаж чадваас, алуурчны илд бяц үсэрнэ” гэж сударт байдаг нь, алуурчин бол цаазлагдах үйлтэний үйлийн үр бөгөөд өөрийн үйлийн хариуцлагыг ухамсарлаж, гэмээ хүлээвэл, харанхуй сохрын золиос болсон, өөрийнхөө алдар хүндийг эргүүлж олно гэсэн үг юм. Тэрбээр, өөртөө Авалокитешварагын өгөөмөр сэтгэл байгааг мэдрээд гэгээрэлд хүрсэн бүхэнтэй оюун санааны нэгдэлтэй байгаагаа мэдэж, зүрхэндээ гэрэл гэгээг дуудмуй. Дотоод сэтгэлийн өөрчлөлтийн энэхүү гайхамшиг нь цаазын илдийг ч хугалж, аугаа их Авалокитешвараг нээмүй.

Тиймээс ч, мянган мутарт Авалокитешварагын арван нэгэн толгойн дунд Амитабхагын нигүүлсэнгүйн дүрийн дор Эрлэгийн эзний аймшигт тэргүүн байдаг билээ. Авалокитешварагын дүр нь их мантрын олон хэмжүүрт талын илрэл болохын хувьд, зөвхөн Нирманакайян илрэл төдийгүй, Дхармакайя буюу Самбхогакайяг нэгэн зэрэг агуулдаг.

Цян Лун хааны 13-р онд Жанжаа хутагтын зарлигаар хэвлэсэн сударт: Авалокитешварагын мянган мутрын, найм нь Дхармакайя, дөч нь Самбхогакайя, 952 нь

Нирманакайяда хамаарна гэсэн байдаг. Дхармакайяг тодруулагч мутрууд нь биеийг хүрээлсэн дотоод хүрээг үүсгэх ба Самбхогакайягын үл үзэгдэх мутрууд нь дараачийн хүрээг үүсгэж, яг энэ мөчид Нирманакайягын мутрууд / тусламж үзүүлэх гэж сунгасан, түүний эсрэг чиглэлд байрласан, ямар ч тодотгох зүйл бариагүй / нь биенээс хөндий тэгш хэмтэй буй болж, улмаар тэдгээр нь улам олширсоор, дээд таван хүрээг бүрдүүлдэг юм. Бодьсадвагын нигүүлсэлийн хүч ертөнцийн гүн рүү нэвтрэх тусам, тэдгээр мутрууд нь улам нэмэгддэг бөгөөд тэдгээр нь илрэх байдлаараа улам ялгарч, улам олон янз болдогыг үзүүлбэл:

Доод хүрээ: 8 мутар ----- Дхармакайя

Хоёр дахь хүрээ: 40 мутар ----- Самбхогакайя

Гурав дахь хүрээ: 142 мутар -----

Дөрөв дэхь хүрээ: 166 мутар -----

Тав дахь хүрээ: 190 мутар ----- Нирманакайя

Зургаа дахь хүрээ: 214 мутар -----

Долоо дахь хүрээ: 240 мутар -----

Энэ бүгд нийлээд 1000 мутар болдог.

б. Авалокитешвара ертөнцийн зургаан

оронд бууж ирсэн нь

Бодьсадва нарын хүмүүн болон амьтнаа туслахын тулд, авралын мутраа өгөөмрөөр сунгасан энэхүү ертөнцийн мөн чанар нь чухам юу байв ? Буддизмд тодорхойлсоноор, бидний бүх насаа өнгөрөөдөг ертөнц хэмээн нэрлэж байгаа зүйл нь бидний үйлдэл, бодол, бүтээлийн үр дүн юм. Энэхүү үйлдэл, сэтгэмж, мэдрэмж нь амин хувийн явцуу хий үзэгдлээр нөхцөлдөж байгаа цагт бид хязгаарлагдмал, өрөөсгөл орчинд байх болно. Тиймээс ертөнц бидэнд тогтворгүй, найдваргүй, аймшигтай санагдах ба юм бүхнийг бусад юмс хийгээд аугаа их амьдралаас тусгаарлан хана мэт хаасан байдаг. Өөрийн аймшиггүй зориг, хязгааргүй үнэнч итгэлээр энэхүү аймшигаас юмсыг чөлөөлөгч

Бодьсадва нь үл мэдэхийн хана хэрмийг нураан, хүмүүний мэлмийг нээж, чөлөө учралын энгүй уудам руу хандуулдаг юм.

Үүний ачаар нигүүлсэл, хайр энэрэл, өрөвч сайхан сэтгэл, эдгээр нь тэнгэрийн хишиг биш, чөлөөт ухамсарын зүй ёсны шинж чанар гэж ойлгог - доно. “Үнэн буянтан буян хийснээ өөрөө ч мэддэггүй. Ач тус багатай хүн л, ач тус хүргэх гэж хөөцөлддөг. Иймээс жинхэнэ ач тус хүргэж чаддаггүй. Жинхэнэ ачтан угаасаа ачтан байх тавилантай болохоор, ачтан болох гэж огтхон ч санадаггүй. Төгс мэргэн ухаант ачтан улиглах бус, нигүүлсэн өрөвдөх сэтгэлээр дүүрэн, гэгээрсэн ухаантай нэгдсэн байдаг юм. Харин ядруухан ачтан нөхцөл ба хүслийн шалтгаанаар, зориудын үйлдлээр л ач тус үйлддэг ажээ.” / Дао - дэ цзин, 38 - р бүлэг / гэсэн байна.

“Шурангама судар”-т Авалокитешвара дээд чөлөө учрал, аймшиггүйн чанад хязгаарт хүрээд хамаг амьтныг зовлонгийн хүлээснээс аврах тангараг өргөсөн бол, бид энэ тангарагийг нийт оршихуйн мөн чанар, нэгдлийн улмаас чин зүрхний угаас аяндаа ундрэн гарсан эрмэлзлэлийн илэрхийлэл мөн хэмээн авч үзэж болох юм. “Би” хэмээх хуурмаг үзэл арилж, тэр тусмаа ангид тусдаа “Би” гэж байхгүй гэдгийг ухамсарлах болсон цагт, зөвхөн өөрийгөө чөлөөлөх тухай бодол байна гэж үү ? Бид ойр дотныхоо хүмүүсийн зовлонг мэдэж, өөрийн зовлон мэтээр шаналж байвал, өөрийгөө чөлөөлөх нь бусдыг ч чөлөөлөх үйлс болно. Энэ бол цаг хугацааны асуудал биш бөгөөд харин чөлөөлөх үйлдэлд бүх юмс багтана гэсэн үг ээ. Энэ нь орон зай, цаг хугацааны талаар Дхарма-дхатугын хүрээнд, өөрөөр хэлбэл, орон зай, цаг хугацааны эсрэг тэсрэг байдал арилж, гагцхүү ийм хэмжүүрт тохирсон эвдэршгүй бүрэн бүтэн чанар мэдрэгддэг тэр л хүрээнд болдог ажиллагаа юм. Христ нь хүн төрөлхтөн болон тухайн мөчид хараахан төрөөгүй байгаа ирээдүйн хүний төлөө өөрийгөө золиосолсон гэж ярьдагчлан Бурхан багш гэгээрсэн нь / бусад аливаа ухамсарт амьтан лугаа адил / хамаг амьтаныг авралдаа багтаах гэсэн хэрэг мөн бөгөөд тэдний төлөө цаг хугацааны эцэст иртэл үйлчлэх юм.

Оюун ухаанаар үүнийг ойлгох аргагүй, яагаад гэвэл ухааны хэмжүү - рээс давдаг юм. Бид хүн төрөлхтөний аугаа их мэргэдийн нууц шидэт туршлагаас энэхүү нууцын гүн рүү

хандсан битүүлэг санааг гохдон авч болно. Энэ бол орон зай, цаг хугацааны гадна оршиж, “Амогхасиддхийн бүхнийг төгсгөгч мэргэн ухаан”- д нээгдэгч гэгээрсэн ухааны нууц хүч юм. Үүнийг орон зай, цаг хугацаа хоёрын хэмжүүр, “Дөрөв дэхь хэмжүүрийн” дээд бодит байдалд нэгдсэн Вишваважрад / Элдэв очир / билэгджээ. Энэ бол гэгээр - сэний хүч үйлчилж, бүх Бодьсадва өөрийн оршихуйтай байдаг ухамсарын онцгой хэмжүүр юм. Гагцхүү энд л, Авалокитешвара идэвхтэй үйлчлэгч Бодхичиттагын хувьд үй олон хэлбэрээр илэрдэг.

Гэвч, энэ хүчинд оролцохын тулд, чин сэтгэлийн хүчин чармайлт буюу оюуны зохих бэлтгэлтэй байх ёстой. Цэцгийн дэлбээ нарны гэрлийн өөдөөс нээгддэг шиг, бид энэхүү хүчийг ашиглахыг зорьж л байгаа юм бол, түүний өөдөөс өөрийгөө нээх ёстой. Дэлбээ нь хумигдсан цэцэг рүү нарны гэрэл орж чадахгүй шиг, бид эгэл ертөнцийн аар саархан шальдир буддир зүйлд сэтгэл автсан бол энэ хүч бидэнд нөлөөлөхгүй.

Энэ асуудлыг “Махаяна шраддхотпада шаштир”-т нэгэнтээ тайлбарласан байдаг билээ. Хэрэв бүх Бурхад эхлэл үгүй (тэргүүлшгүй) цаг үеэс авахуулаад билгүүн, энэрэлийн ийм хүчтэй, мэдрэгч, хамаг амьтныг сайн сайханд хүргэх тоо томшгүй олон хэрэгсэлтэй байсансан бол, эдгээр амьтад яагаад энэхүү сайхан хүсэл, идэвхийг үнэлэхгүй, үнэнийг гэгээрэн, төгөлдөржигч практикийн эхлэлээр тэдний ачийг хариулахгүй, Гэгээрэлд болон Бурхадын мөн чанарт хүрч чаддаггүй юм бэ? Дхармакайятай адил болсон бурхад хамаг амьтныг ариун мөн чанартай нь хамт өөртөө багтааж, бүх орчлон ертөнцийг бүрэн дүүргэдэг мөнхийн төрөл бөгөөд мөнөөх “би” гэгч мөн чанарыг агуулсанаараа, бидний хүсэл эрмэлзлэлийн илрэлийг хүлээж, мэдрэмжинд хариуг өгч байдаг нь Дхармакайя буюу Номын биеийн төгс нэгдэл, цэвэр ариуны зайлшгүй нөхцөл болдог. / Buddhist Bible, 1938, 396 - р хуудас /

Өөрөөр хэлбэл, гэгээрэгсдийн дүрүүд нь оршихуйн бүх орон зайд, тухайлбал, ёроолгүй гүнд, өндөр тэнгэрт, хүмүүний болон амьтдын ертөнцөд ч илэрдэг.

Төвдийн сүм дуган бүрт, Сансарын хүрдний зургаан зүйлийн амьтаны тивийг дүрсэлсэн зураг байгааг харж болно. Эцэс төгсгөлгүй дахин төрж байдаг, энэхүү

ертөнцийн мөн чанартай уялдуулан, хорвоо ертөнцийг зургаан зүйлд багтаасан хүрдээр төлөөлүүлэн зурсан байдаг. Энд буй зургаан хэсэг нь эгэл ертөнцийн оршихуй буюу өөрөөр хэлбэл, гэгээрээгүй оршихуйн зургаан гол төрөлд тохирч байдаг. Оршихуйн эдгээр хэлбэр нь элдэв эд юмсаар хангалуун байдалд шунаж, хүсэлдээ харш бүхнийг үзэн ядагч “би” гэсэн ангид буруу үзлээр нөхцөлдсөн байдаг юм.

Гэгээрээгүй харанхуй оршихуйн эдгээр гурван төрлийн сэдлэг буюу үндсэн шалтгаан / хету / нь дахин төрөхийн хүрдний бул болох бөгөөд шунал тачаал, уур хилэн, мунхаг харанхуйг билэгдсэн гурван амьтны дүр - сээр зурагджээ. Үүнд, улаан азарган тахиагаар шунал тачаалын хүлээсэнд баригдсаныг, ногоон буюу бараан могойгоор үзэн ядахуй, атаа хорсол, уур хилэн, бидний амьдралыг хороор хордуулагчдын биелэлийг, хар гахайгаар харанхуй мунхагийг төлөөлж “би”-гийн хуурамч үзэл, төрөх үхэхийн эцэс төгсгөлгүй орчилд бүх амьтаныг тойруулан хөөгч, сохор зүтгүүрийн билэг тэмдэг болгон дүрсэлжээ.

Гурван амьтан бие биеийнхээ сүүлнээс хазаж нийлээд зураг дээр тойрог үүсгэдэг. Энэ нь шунал тачаал, уур хилэн, мунхаг харанхуй нь бие биеийг нөхцөлдүүлж, салшгүй холбоотой байдгыг үзүүлж байгаа хэрэг юм. Тэдгээр нь, юмсын үнэн, мөн чанарын тухайд үл мэдэхийн үндсэн үр, үүний улмаас үүдэлтэй тогтворгүй юмсыг жинхэнэ бодитой, хүслэнт юмс болгосны эндүүрэл юм. Ухаан санаа нь хөгжөөгүй, мухар сохор шунал, дотоод ухам - сарын хүсэлдээ хөтлөгдсөн амьтдад ертөнцийг танин мэдэхүйн ийм дутагдал буй нь будлиан, хий төөрөгдөл, хуурамч үзэл, Төвд илэрхийллээр явцуу байдал буюу хүлээсэнд баригддаг бөгөөд эдгээр нь биднийг мунхагийн харанхуй дахь түр зуурын жаргалын хойноос хөөцөлдөж, бодит үнэнээс зугтаахад улам бүр татан оруулж, олдсон бага сага юмаа алдахын айдаст хүргэж, хуурмаг мөнх байдлын төлөө гэх мэт, янз бүрийн амьдралын эргүүлгэнд оролцуулах гэж биднийг өөрийн эрхгүй татаж байдаг билээ. Сансар бол мөнхийн хэрүүл тэмцэл, эвлэршгүй ялгарал, хоёрдмол байдал, тэнцвэртэй хийгээд дундаж төв замаа алддаг ертөнц мөн бөгөөд үүнээс болоод амьтад нэг хязгаараас нөгөө хязгаарт унаж байдаг билээ.

Тэнгэр нарын баяр баясгалант байдал бол тамын зовлонт амьдралын шууд эсрэг тал юм. Асура нарын ширүүн тэмцэл, эрх мэдэлд шунах явдал нь амьтаны айдас, мөрдлөгийн эсрэг байдаг бол бүтээлч идэвхи, бүтээл туурвилын бахархлаар дүүрэн хүмүүний аймаг, бирдийн аймшигт амьдрал | үүнд, ханашгүй тачаал, гүйцэлдэшгүй хий үзэгдэл маягтай аж төрдөг | -тай эсрэгцдэг.

Төвд хэлний “Сансарын хүрд” буюу “Амьдралын тойрог”-ийн дээд хэсэгт, Тэнгэрийн орныг харуулдаг. Энэ хүрээн дэхь, амирлангуй амьдрал буюу хөгжим, бүжиг зурсан нь элбэг хангалуун байдалд цаг нөхцөөдөгт анхаарлаа хандуулдаг явдал юм. Тэнгэрүүд оршихуйгаа ийнхүү өрөөсгөлөөр хүртдэгийн улмаас, амьдралын жинхэнэ мөн чанарыг үл ухамсарлах ба тэдний оршихуйн хязгаарлагдмал тал нь бусад амьтаны зовлон болон, өөрсдөө мөнх бус болохоо умартадаг. Тэд түр зуурын ая таатай зохицонгуй байдалд аж төрж буйгаа мартдаг. Тэднийг ийм жаргалтай байдалд хүргэсэн / Бурханы шашны номлолоор тэд ёс суртахууны үр шим, гавьяа / шалтгаан барагдмагц, тэрхүү ая таатай байдал нь дуусгавар болдог. Тэд гоё сайхан амьдарч, урт насалж, зовлонгоос ангижирсан хэдий боловч, шийдэх асуудал байхгүй, амгалан аж төрдөг нь бодит байдлыг болон бүтээлч идэвхийг ухаарах, дээд эрхэм мэдлэг өөд эрмэлзэхэд нь саад болдог. Ингээд цаг хугацаа нь болохоор тэд доод амьдралын эргүүлэгт эргээд живдэг. Иймээс тэнгэрийн оронд хувилж төрөх явдлыг, тэмцэн зорих зам, хүсч мөрөөдөх зорилго биш гэж Бурханы шашинтнууд үздэг. Энэ бол оршихуйн асуудлыг шийдвэрлэдэггүй түр зуурын буудал төдий зүйл мөн бөгөөд уг түр зуурын буудал нь Сансарын ертөнц дэхь зөвхөн “би”-гийн гүнзгий хуурмаг үзэл, улам их ээдрээтэй байдал өөд хөтөлдөг.

Иймээс бид “Сансарын хүрд”-ний доод тал болох тамын зовлонт амьдралыг олж харна. Янз бүрийн тамлалыг ямар ч хүний ой ухаанаас гарахын аргагүйгээр дүрсэлсэн тамын энэхүү зовлон бол хүч төгс Дээд тэнгэр болон Бүтээгч эзэнээс төөрөлдсөн амьтдад оноосон шийтгэл бус, харин өөрсдийнх нь хийсэн үйлийн үр зайлшгүй мөн. Эрлэг Номун хаан бол ялагч бус, зөвхөн амьтан бүр өөртөө оногдох зэмлэлийг сонсгож байдаг нинжин сэтгэлийн талыг л баримтлагч юм. Эрлэг Номун хааны амнаас гарч байна уу даа, гэж

санагдмаар уг зэмлэл нь толины голд туссан “Хри” хэмээх эхний үеэр илэрхийлэгдсэн, мөнөөх дотоод дуу хоолой мөн. Ийм ч учраас Эрлэг Номун хаан / Яма, Шүүгч, Хуулийн хаан / бол Авалокитешварагын хэлбэрээр Амитабхагын хугацаа дуусч буй явдал гэлцдэг. Авалокитешвара тамын гүнд орж, бүхнийг мэдэгч толь мэт билгүүний хүчээр зовлонг ариутгагч болон хувирдаг бөгөөд үүний улмаас амьтад зовлонгоос ангижран, амьдралын сайн сайхан, дээд хэлбэр өөд ахицгаадаг.

Авалокитешвара энэхүү аймшигт орчлонд байгаа баримтыг дурайтал илэрхийлэх зорилгоор, түүнийг Эрлэг Номун хааны өөрийнх нь догшин дүрийн гадна талаар, Бурхан багшийн хэлбэрээр бас дахин дүрсэлсэн байна. Авалокитешварагын мутраас ариусагч дөл гарч, тусгай зориулалтын билэг тэмдгийг мутартаа барин, оршихуйн бусад оронд ч очдог.

Тэнгэрийн оронд Авалокитешвара нь хөгжмийн аялгуун дахь тэдний жаргалант амьдрал, дээд бодит чанарын гаднах зохицонгуйд ханасан шилжилтийн хангалуун байдлын хуурмаг үзлээс ангижрахын тулд “пипа” хөгжимтэй ирдэг. Пипа хөгжмийн эгшиг бол дотоод сонсголыг сэргээдэг Дхармагын эгшиг дуун мөн.

Тэмцэлдэгч Асура нарын орныг баруун талд дүрсэлсэн байх бөгөөд тус оронд Авалокитешвара улайсгасан мэстэй очдог. Яагаад гэвэл, эндхийн амьтад зөвхөн хүч үзэх, тэмцэлдэхийн хэлийг л ойлгодог ажээ. Бодьсадва нь тэнгэр ба асура нарын орны хооронд ургадаг хүслийг хангагч модны жимсний төлөө тэмцэлдэхийн оронд, танин мэдэхүйн ба шуналгүйн жимсний төлөө тэмцэх, илүү ариун шударга тэмцлийг тэдэнд санал болгодог. Улайсгасан мэс бол идэвхтэй “ялгагч мэдлэг”-ийн билэг тэмдэг мөн ба үүгээр үл мэдэхийн харанхуйг зүсэж, эргэлзээ тээнэгэлзлийн зангилааг тас огтолдог.

Эрх мэдэлдээ ташуурсан асура нарын хүрээний эсрэг тал нь зүүн доод хэсэгт байрлах айдасын орон юм. Энэ бол амьтаны аймаг, жам ёсны зайлшгүйг болон хяналтгүй зөн совингийн сохор хувь заяаг даган мөрдөх хүрээ мөн. Амьтаны аймагт / энэ нь сэтгэлзүйн хүрээ гэдгийг санацгаая / тэдний дотоод ухамсарын тэмүүлэл, ядуу дорой, мулгуу мохоо байдал, хөгжөөгүй ухааны харанхуй будангаас ангижруулж болох ялагдах яриа, тодорхой бодол санаа байхгүй учраас Авалокитешвара мутартаа ном барьсаар заларч очдог.

Бурханы орны эсрэг талд хүний ертөнц байна. Энэ бол тодорхой зорилготой, идэвхи зүтгэл, дээд зэргийн урам зориг төгөлдөр орон бөгөөд энд сонголтын эрх чөлөө гол чухал үүрэг гүйцэтгэдэг. Учир нь энд оршихуйн бүх орны чанар, хүрч болох хүрээний үнэн бодит чанарыг танин ойлгох замаар төрөх, үхэхийн орчлонгоос дээд зэргээр ангижрах боломж байдагт оршино. Иймээс Авалокитешвара нь чухам энд л “нүд нь үл мэдэхүйн тоосонд яльгүй дарагдсан” хүмүүст ангижрах зам мөрийг зааж өгөхийн тулд, даяанчийн хувцас өмсөж, энэрэлийн бадар аяга барьсан, Бурхан Шакиа- мунг болон заларч ирдэг. Гэтэл зөвхөн зарим хэсэг нь л, төгс ангижрах энэхүү зам мөрд ороход бэлэн байдаг. Олонхи нь энэ хорвоогийн идэвхи зүтгэл, мэдрэхүйн сэтгэл ханамж, эрх мэдэл, нэр алдар хөөцөлдөхийн урхинд орсон байдаг.

Бид ханаж цадашгүй шунал тачаал, ухаалаг бус хэнээрхэлийг идэвхи зориг гаргаж байж, өөрийгөө бататгадаг байдлыг уг ертөнцөөс олж мэднэ. Үүнийг, амьдралын хүрдний баруун доод хэсэгт дүрсэлсэн байх бөгөөд хүслээ хангах боломжгүй зүйлдээ хөдлөшгүй хүлэгдсэн, “бирд”- ийн шунал тачаалыг бид эндээс олж харна. Бирд хэмээн нэрлэгддэг энэ орны амьтад бол, биелэшгүй шунал тачаалаар дүүрэн бөгөөд сэтгэлдээ дүрслэн бодож шунасан ертөнцдөө зүүд зэрэглээ мэт, амьдарч буй амгалан бус сүнс юм. Энэ бол дотоод тэнцвэрээ алдсан амьтад бөгөөд хэр хэмжээнээс хэтэрсэн шунал нь амьдралын зохилдоогүй хэлбэрийг буй болгодог. Эд бол сүнс харуулсан тоглолтын үед, итгэмтгий хүмүүсийг төөрөгдүүлж болох, ард түмний бишрэлээр биелээгүй шуналаа хангахын тулд урьд төрөлдөө байсан газар руу байнга ирж байдаг амьтад, ухамсарын мөн чанар буюу хүч юм. Бирдийг хэнгэрэг мэт гэдэстэй, өлсөж цангаж, түүндээ ханадаггүй зовлонг сүнсний хэлбэртэй дүрсэлсэн байдаг. Тэдний дөрвөн мөч нь чөргөр хатин - гар, хоолой нь маш нарийхан учир яльгүй бага юм залгихдаа ч тэсэхийн аргагүй зовно. Идсэн хоол нь шингэхгүй, зөвхөн ходоодыг нь цочроох төдий болно. Тэдний уусан юм нь гал болж хувирна. Энэ бол амар заяа үзүүл - дэггүй зовлонг үүсгэдэг шуналын мөн чанарыг сэтгэлд хоногштол харуулсан зураглал юм. Шуналаа орхихгүй байх нь, гал дээр тос нэмсэн мэт, түүнийг улам гааруулна. Өөрөөр хэлбэл, шунал бол зовлонгийн уг сурвалж юм. Гагцхүү

бид шохоорхсон хэрэггүй зүйлсээ хэрэгтэй зүйлсээр / өөрөөр хэл - бэл, мэдрэгдэх шуналын кама - чхандаг, дхарма - чханда, үнэний буюу мэдлэгийн шунал болгон хувиргах / сольсон цагт л, тийм шуналт хүслээс сая нэг ангижирч болно. Иймээс бирдийн оронд Авалокитешварагын дүрээр ирсэн Бурхан багш хоёр мутартаа огторгуйн туяаны дүр бүхий жинхэнэ үнэт зүйлтэй юм уу, / эсвэл идээд шингэсэн үед гал юм уу, хор болдоггүй / оюун санааны хүнстэй сав барьж явдаг. Огторгуйн энэхүү туяаны дэвсгэр дээр хорвоогийн хүсэл юу ч биш, хэрэггүй зүйл болж, зовлон дагуулдаг ханашгүй шунал буюу шохоорхол алга болдог.

7. Прамитья – самутпада буюу шүтэн

барилдахын нэгдэл

Зургаан зүйл хамаг орон нь Амьдралын хүрдний төвөөс ялгаран гарах суурь хөдлөх хүчний нөлөөний доорхи сансар хорвоогийн хамаг амьтны ялгарлыг харуулдаг бол, түүний гадаад хүрээ нь хувь хүний амьдралын учир шалтгааныг нээж харуулдаг.

1. Замаар тэмтэрч яваа сохор эмэгтэйгээр “мунхаг”-ын харанхуй бүдүүлгийг төлөөлүүлнэ. / Авидья ма ригпа - эм төрөл / Ийнхүү оюун санааны сохроос болж, хүн өөрийнхөө болон ертөнцийн талаар хоосон дүрслэл зохиож, насан туршдаа харанхуйн дунд бэдэрнэ.

2. Гэгээрээгүй хүний үйлдэх үйл ажиллагааг, зураг дээр ваарчнаар дүрсэлсэн байна. Гэгээрээгүй ухамсарыг санскара буюу төвдөөр: ду–бьед гэнэ, монголоор “хуран үйлдэх” гэнэ. Ваарчин хүн ваар савныхаа хэлбэрийг цутгахын адил, бид хувь заяа болон зан үйлээ хэлбэршүүлнэ. Ийм явц дундаас шинэ ухамсар төрнө. Зан үйл болон ул мөр үүсгэнэ. Ийм үйл ба эсрэг үйлийг бид номын ёсоор “карма” буюу “үйлийн үр” хэмээн нэрлэдэг.

Амьдралд үргэлж давтагдах тийм үйл явц бүр хялбаршиж, аажмаар хүн төрөлхтөний дадал болно. Шаварчин хүн зөөлөн шавраар ваар сав хийхийн нэгэн адил, бид хүний амьдралын тодорхой бус материалаас оюун ухаан, бодол санаа, үг хэлнийхээ тусламжтайгаар ирээдүйн ухамсарын сав суулга бэлтгэж, түүнийг тодорхой хэлбэр дүрс зориулалттай болгоно.

3. Бидний ухамсар нь үл устах цөмтэй бөгөөд тэр нь биднийг нэг амьдралаас нөгөө амьдралд шилжихэд хадгалагдан үлдэж, дахин төрөхийн үр хөврөл нь болдог юм. Ийм ухамсарыг Виджняна / төвдөөр: рНамшес, монголоор, “тийн мэдэхүй” / гэнэ. Шинэ амьдралын эхэнд зогсох тийм ухамсарыг, гуравдугаар зураг дээр мөчрөөс дүүжлэгдсэн сармагчингаар дүрсэлжээ. Сармагчин нэг мөчрөөс нөгөөд дүүлэн мацах мэт, бидний ухамсар нь нэг зүйлээс нөгөө зүйлд шилжиж, нэг амьдралаас нөгөө амьдралд тэмүүлнэ.

4. Ухамсар дангаараа тогтох боломжгүй, заавал материалаг биетэй хосолж тогтоно. Ийм учраас ухамсарыг ухаан, бие (нэр, дүрс) хоёрын нэгдэл хэмээн үздэг. Үүнийг завинд сууж яваа хоёр хүнтэй зүйрлэж болно.

5. Тийм үйл ажиллагаа нь мэдрэх зургаан эрхтэний үүргийг тодор - хойлж өгнө. Шадаятана / төвдөөр: скье - м Чхед,мон: “төрөн түгэхүй” / нь сэтгэх, харах, сонсох, үнэрлэх, амтлах, ойлгох эдгээр болно. Ийм чадварыг бид орчин тойрноо харж болдог, байшингийн цонхтой зүйрлэж болох юм. Тийм ч учраас тэд - гэерийг зургаан цонхтой байшингаар харуулсан байна.

6. Эр, эмийн харьцааг билэгдсэн байна. Энэхүү Спарша / төвдөөр: регпа,мон: “хурьцахуй” / - г сэтгэлтэй болсон эр, эм хоёроор харуулсан байна.

7. Дээрхээс үүдэн гарсан зовлонгийн мэдрэмжийг Ведана / төвдөөр: цхор ва / нүдэндээ сум зоосон хүнээр дүрсэлжээ. Үүнийг “хүртэхүй” гэнэ.

8. Эмэгтэй хүнээр асруулсан архичинг дүрсэлжээ. Эдгээр нь амьдралын шунал тачаалыг билэгдсэн шинж чанар агуулна. Нүдэндээ сум оруулсан хүний эмзэглэлийг бус, харин түүний цаашдын хүчтэй нөлөөнөөс болж, гунигт үр дагаварт хүрсэнийг харуулжээ. Үүнийг “сэрэхүй” гэнэ.

9. Амьдралын аливаа хүсэл мөрөөдлийг / Упадана ба төвд: ленпа / модноос жимс тасалж, сагсандаа хийж буй хүнээр төлөөлүүлсэн байна.

10. Хүсэл мөрөөдлөөс хайр дурлал үүсэхийг эр, эм хоёроор төлөөлүүлсэн байна.(Заримдаа боловсорсон жимсээр төлөөлүүлнэ) Хайр дурлал нь цаашдаа шинэ амьдрал, дахин төрөлтийг бий болгоно.

11. Ийм ч учраас хүүхэд төрүүлж буй эмэгтэйг дараачийн зурагт дүрсэлжээ. (жати, төвдөөр: скье-ва,монголоор: төрөхүй)

Төвдүүд амьдралын жам ёсыг хамгийн ойлгомжтой бодит байдлаар харуулахыг хичээдэг юм.

Иймээс Төвдүүд хурьцлын ажил болон төрөлтийг хоёрдмол утгагүй, зураг тайлбаргүй дүрслэхээс зайлсхийдэггүй. Энэ нь Гүн ухааны хийсвэрлэлийг бодвол, амьдралд тун ойрхон байхыг онцолдог. Гэлээ ч гэсэн тэдний билэгдэлд / үгээр болон үзэгдэх дүрсээр илэрхийлсэн аль алинд нь / оюун санааны бодлогоширлыг нэн тодорхой, тод томруун мэдлэг туршлагын нарийн өнгө аясыг онцлон илэрхийлсэн байдаг. Тэдний гүн ухаан бол зөвхөн ухагдхуун, нэр томъёо төдийгүй оюуны практик туршлагын илэрхийлэл мөн. Тиймээс, шашин ба гүн ухааны үзэл бодлыг иймэрхүү үзэгдэж харагдах хэлбэрт, адил төсөөтэй байдалд оруулах нь тэдний гол зорилго болдог бөгөөд энэ нь хэнд ч ойлгомжтой, боловсрол муутай хүнд ч ойлгомжтой болгохыг зорьдог. Үл ойлгогдох байдлаас зайлсхийхийн тулд, дээр дурьдсан зураг бүр нь “сармагчин гэдэг нь “мэдэхүй” буюу “ухамсар”, “хараагүй сохор эмэгтэй гэдэг нь бүдүүлэг харанхуйн билэгдэл” гэх мэтээр бичсэн давхар тайлбартай байдаг. Дээр дурьдсан зураг бүрийг ухаж ойлгоход хялбар дөхөмийг бодож, “сармагчин - ухамсар”, “хараагүй эмэгтэй - харанхуй бүдүүлэг” гэх мэтээр товч тайлбар хийсэн нь байдаг.

12. Нас барсан хүнээ оршуулахаар авч яваа хүнийг харуулсан нь төрсөн болгон өтөлж хөгшрөх бөгөөд эцэст нь үхэж, мөхөх тавилантайг харуулжээ.

Эртний Бурханы шашны уламжлал ёсоор ийм томъёолол зонхилж байсан нь Төвдөд хамгийн их нөлөө үзүүлжээ. Ажанта / МЭӨ II – VII зуун г /- ын агуйн сүмд ч Сансарын хүрдний зураг байдаг юм. Мөн үүнийг судлаачдын дунд 12 хуваагддаг тэнгэрийн ордуудтай адилтгах явдал ч гарч байв. Эдгээрээс хамгийн эртнийх нь, Данжуурт орсон Нагаржунайн зохиолд бий. Түүнийг заримдаа учир шалтгааны “Арван хоёр шүтэн барилдлага” гэж нэрлэх нь ч бий.

Түүнийг “Арван хоёр шүтэн барилдлага” хэмээн нэрлэж, иймэрхүү эндүү ташаа төсөөллөөс болж, олон эрдэмтэд энэхүү учир шалтгаант чанарыг логикийн хуулийн тусламжтайгаар хэрхэн тайлбарлаж болох, эсвэл энэхүү томъёоллыг баттай болгож байгаа журмын дагуу, жирийн байдлаар хэрхэн тайлбарлаж болох талаар толгойгоо гашилгаж байв. “Авидья” буюу мунхаг бол ямар нэг танигдашгүй зүйл бус, оршин тогтнохын метафизик шалтгаан буюу ертөнцийн тайлалын шалтгаан ч биш, харин бидний жинхэнэ амьдрал өрнөж байдаг нөхцөл буюу бидний ухамсарын жинхэнэ байдлыг хариуцдаг нөхцөл байдал юм.

Бурхан багш харилцан нөхцөлдсөн буюу шүтэн барилдсан холбооны талаар ярьсан болохоос биш, учир шалтгааны жам хуулийг яриагүй юм. Тэрээр “Өтлөх, үхэх нь юунаас болдог вэ?” гэсэн асуултаар сургаалаа эхэлнэ. Хариулт нь “Төрсөнөөс бид өтөлж, үхэж мөхнө” гэжээ. Цаашид иймэрхүү байдлаар төрөх явдал нь үүсч буй болох явцаас шалтгаалдаг гэдгийг үгүйсгэж байсан, харин амьдралд тэмүүлэх хүсэл байхгүй, амьдралын зохих хэлбэрүүдэд дасахгүй байсан бол, энэхүү үйл явц нь мэдрэмж / шунал тачаал, мэдрэгдэх зүйлд маш их дассан, сонирхсон сэрлийг ялгаж салгахаас /-ээс шалтгаална. Нөгөө талаас мэдрэмж нь мэдрэх эрхтэнүүдэд гадны юмс тусгагдаж, мэдрэгдэх үед л боломжтой юм. Мэдрэх эрхтэнүүд нь сэтгэхүй бүхий амьд зүйл дээр үндэслэгддэг. Амьд зүйл гэдэг нь ухамсар байдаг амьтанд л үүсдэг. Гэхдээ ухамсар нь бидний хувийн хязгаарлагдмал хэлбэрт, хувийн буюу цэвэр өөрийгөө бодсон идэвхжилтэй холбоотой / оршин тогтнохын тоо томшгүй өмнөх бүх хэлбэрийн туршид / бөгөөд энэхүү идэвхжил нь бидний “би” гэдэг хуурмаг хоосон зүйлийг салгаж үзсэнээс болдог. “Арван хоёр шүтэн барилдахуйн” томъёолол нь тийнхүү эхлэл, төгсгөлгүй дугуй хэлбэрээр илэрхийлэгджээ. Салаа буюу нүд тус бүр нь, бусад салаа буюу нидана нь өнгөрсөн амьдрал, сүүлчийн хоёр нь / төрөлт, үхэл / ирээдүй, бусад нь / 3 - 10 / нь одоогийн амьдралын тусгал болно. Энэ нь авидья, санскара хоёр нь 8 үе шаттай, нэг үйл явц гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, нэгэн ижил үйл явцыг дээд мэдлэгийн үзэл бодлоор / 1-2 / зураглан бичих, мөн уг үйл явцыг сэтгэлзүйн задлан шинжилгээний үүднээс / 3-10 / зураглан бичих, дараагийн хэсэгт мөн

физиологийн буюу бие, үзэгдлийн үүднээс авч үзэхийг хэлж байна. Үүнийг ойлгохын тулд Бурхан багшийн сургаалыг санах хэрэгтэй. Үүний тулд өтлөлт, үхэлтэй холбогдсон асуудлаас эхлэн аажмаар улам гүнзгийрүүлж, сэтгэлзүйн орчинд хүрэх бөгөөд эцэстээ, оюун ухааны хүрээнд орно. Ингэхлээр “эго” буюу би-гийн аминч үзлийн тухай баримтлал, түүнчлэн харанхуй бүдүүлгийн мөн чанар, түүний үр дагавар нь цөм санааны зүйл гэдэг нь мэдэгдэнэ.

Үнэн хэрэг дээрээ Абхидхармын “төрөх үхэхийн үйл явц нь бидний амьдралын агшин бүрд тохиолдох учраас бид дээрхи томъёололыг дэс дараалан гурван орчилд хуваах, эсвэл гурван агшин болгон үзэх, эсвэл тухайн нэг амьдралын доторхи үе шат болгох, алин ч гэсэн онцгой ач холбогдолтой биш юм.” / Энэ талаар “Эхэн үеийн Буддизмын сэтгэл зүй” номын 2 - р хэсгээс үзэж болно. /

Иймд дээрх томъёолол бол хийсвэр учир зүйд ч холбогдолгүй, цэвэр шалтгаан ч биш, харин харилцан нөлөөлсөн амьд шүтэлцээтэй, цаг бусаар эсвэл нэгэн зэрэг тайлбарлаж болох үйл явц буюу үзэгдэл юм.

Шүтэн барилдахуйн ийм бүх үе шат нь, тухайн хий үзэгдэл буюу аминч үзлийн хийсвэр дүр төрх юм. Гагцхүү хий үзэгдлийн хүрээг гэтлэн давах гэдэг бол зөвхөн өөртөө оршиж, өөрийн төлөө тогтож байдаг юмс огт үгүй, харин амьдралын бүх хэлбэр байгаль дэлхийгээр орших орчиноо хийсэн байдаг ба түүнийг бүхэл бүтэнтэй нь холбоотой авч үзэхээс, өөр ямар ч арга байдаггүй.

Хувь хүн энэхүү түгээмэл, нийтлэг жам ёсыг ухаж ойлгосон тэрхүү цагт л өөрийгөө түр зуурын гэж үзэх үзлээс ангижирч, амьдралд гүнээ бишрэх бөгөөд ингэснээр өнгөрсөн, одоо, ирээдүйн хоорондох ялгааг арилгаж чадна. Энэ талаарх мэдрэмжийг Миларайба богд шүлэглэн дуулахдаа, “Одоо ба ирээдүйн амьдралын нэг болохыг ойлгож мэдсэнээс хойш, би үхэх төрөхийн зовлонг мартан амарлаа” гэжээ. / W.Y.Evans - Wents, 1928, 246 - р хуудас /

Ийнхүү айх юмгүй амар тайван байх нь Бодьсатвагын нэгэн нийтлэг шинж бөгөөд төрөх, үхэхийн зовлонгоос нэгэнт чөлөөлөгдсөн болохоор, үхэл зовлонд нэрвэгдэн

тарчлагсад дээр очиж, карма буюу үйлийн үрийн боолчлолын гинжнээс үүрд чөлөөлөгдөх аз жаргалант мэдээг тараахыг хичээх болно.

Дараах хүснэгтээс Абхидхармын уламжлалын дагуу, арван хоёр үүр буюу Пратъя Самудпадагын цаг хугацаа, учир шалтгаант шүтэн барилдлагыг үзэхэд ашигтай байх болно.

/ Энд хүснэгт орно./

8. Сансарын зургаан орны билэгдлийн зарчим

ба Дхьяны таван бурхан

Авалокитешвара нь хязгааргүй олон үүрэгтэй учраас сансар хорвоогийн орон бүрд өөр өөр дүрээр очиж тусалдаг.

- Тэнгэрийн оронд, тэр “Зуун буяныг үйлдэгч бүхнээс хүчтэй, Цагаан Будда

- Асура нарын оронд, “Дхарма Ража” буюу / Чойжижалбу / нэртэй уур хилэнт, саарал Будда

- Хүмүүний оронд, “Шакиа мунд” нэрт, шар Будда

- Бирдийн оронд, “Хурц хэл” буюу / Ка Барма / нэрт Улаан Будда

- Адгуусны оронд, “Нигүүлсэгч баатар” буюу / Тхагзангрис / нэрт Ногоон Будда

- Тамын оронд, “Дийлдэшгүй арслан” буюу / Сэнгэрабдан / нэрт хөх Будда байна.

Дээрх жагсаалтанд дурьдсан нэр бүхий өнгөнүүд нь бүх нийтээрээ хүлээн зөвшөөрсөн Бурханы хөрөг зурах уламжлалт аргатай зохицон нийц- дэг юм. / Жишээлбэл: Сүмийн ханан дээрх Бурханы хөрөг зурагт байдгын нэгэн адил / Энэхүү уламжлал нь зургаан тивээс туяаран гарч буй өнгөнүүдтэй Бурхадын өнгөнүүд нь тохирдог эсэх талаар зарим нэг үл ойлголцох байдалд хүргэсэн байна.

Жишээлбэл: Гавж лам Даваасамдан “зургаан тивийн өнгө нь эдгээр оронд оршин буй Бурхадын өнгөнд хамаарах ёстой гэж үзсэн байдаг. Үүнд, Тэнгэрийн орных Цагаан, Асурын орных ногоон, Хүний ертөнц алтан шар, Амьтаных хөх, Бирдийнх улаан, Тамынх хар” гэжээ. Ийнхүү тэр өөрийн зүгээс ямар нэгэн эш үндэсгүйгээр, эхний болон сүүлчийн тохиолдлоос бусад модон барын зураг нь алдаатай байсан гэж тунхаглажээ. Эндээс

үзэхэд, Гавж лам Даваасамдан нь олны танил болсон модон барын зургийн хувилбарыг хувийн сонголтоороо, өнгөнийх нь билэгдлээр ёс төдий өөрчилсөн нь харагдаж байна. Иймээс, хэрвээ бид энэ талаар улам гүнзгий ойлголт авахыг хүсвэл, нийтээрээ хүлээн зөвшөөрдөг Төвд судруудтай түүнийг тааруулан тохируулж, тэрхүү билэгдлийн зарчмууд чухамдаа хаа-наас эх үүсэлтэй болохыг мэдэж авах нь зүйтэй юм.

Буддагын эдгээр өнгө нь юунаас ч үл хамаарах бөгөөд гэрэл сүүдэр хоёрын харшил буюу өөрөөр хэлбэл, ертөнцийн оршихуйн хоёр туйл хар, цагааны хослол юм.

Бурханы эдгээр дүр төрх нь нилээд хожуу үеийн бурханы хөрөг зургийн нэмэлт болох нь эргэлзээгүй юм. Ертөнцийн зургаан тив буюу орон дахь Авалокитешварагын идэвхтэй чанарыг тайлбарт зургаар харуулахын тулд Амьдралын хүрдэн дэхь анхдагч дүрслэлийг хийсэн байна. Тэгэхлээр эдгээр тивийн анхдагч билэгдэлд тэр нөлөөлөх нь юу л бол. “Бардо тойдол” судар нь, зургаан тивд байх Бурхадын өнгийг бус, харин тэдний нэр алдрыг л дөнгөж дурдсан байдгаас үзвэл, урьд нь эдгээр өнгийг ямар нэг чухал зүйл мэт юм уу, эсвэл анхдагч сургаалын хэсэг төдий ч үздэггүй байсныг баталж байгаа юм. Үндсэн билэгдэл нь туйлын зарчимд үндэслэдэг бөгөөд “Бардо тойдол” судар дахь тэмдэглэлээс үзэхэд, таван Дхъяны бурхадын мөн чанар болон туяаралтай холбоотой, зургаан тивийн шинж тэмдгийг эдгээр өнгө-нүүд тодорхойлдог болох нь харагдаж байна.

“Бардо тойдол”-д, үхлийн дараах эхний өдөр нь, жинхэнэ бодит байдлыг мэдрэхэд Вайрочаны зүрхнээс нүд сохлом гүн хөх гэрэл цацарч байх байтал дээгүүр чинь Бурхадын бүдэг цагаан гэрэл туяарч, хөх гэрлээс зугатмаар санагдан цагаан гэрэл аятайхан мэт санагдана. Үүнийг битгий тоо, зоригоо чангал. Энэхүү үзэгдлээс болж ухарвал, чи зургаан тивийн хүрээнд татагдан орж, чөлөөлөгдөх замыг алдана гэсэн байдаг.

Хоёр дахь өдөр нь, Важрасатва Акшобхъягын зүрхнээс толь мэт цэцэн ухааны хурц цагаан гэрэл цацарч байх бөгөөд, тамын үнс, утааны бүдэг саарал гэрэл гарна. Цагаан гэрлээс зугатмаар санагдан, бүдэг гэрэл аятайхан мэт болно. Түүний зүг татагдан орвол, тамын орноо төрж, авралын замаас удаан хугацаагаар холдоно.

Гурав дахь өдөр нь, Ратнасамбхавагын зүрхнээс хурц шар гэрэл цацрах атал, хүний ертөнцийн бүдэг хөх гэрэл үзэгдэнэ. Шар гэрлээс зугатан, бүдэг хөх гэрэлд татагдвал хүний ертөнцөд дахин төрж, өтлөх, үхэхийн зовлонг эдэлнэ.

Дөрөв дэхь өдөр нь, Амитабхагын зүрхнээс улаан гэрэл цацрахын хажуугаар, сүнсний орны бүдэг шар гэрэл гарна. Улаан гэрлээс айж, аятай санагдсан бүдэг гэрэлд татагдан одох аваас, сүнсний ертөнцөд төөрч, өлсч цангахын зовлонг эдэлнэ.

Тав дахь өдөр нь, Амогхасиддхийн зүрхнээс хурц тод ногоон гэрэл цацрахын хамт, Асуруудын орноос бүдэг улаан гэрэл гарна. Тийш одох аваас, тэмцэл тулааны өгүүлшгүй их зовлонг эдэлнэ.

Зургаа дахь өдөр нь, дээрх Бурхадын таван гэрэл нийлэн хурцаар гийгүүлэхийн хамт, зургаан тивийн бүдэг гэрлүүд сүлэлдэн гарна. Үүнд: Тэнгэрийн орноос цагаан, асурын орноос улаан, хүний ертөнцөөс хөх, амьтны ертөнцөөс ногоон, бирдийн орноос шар, тамын орноос саарал өнгө гардаг. Энэхүү зургаан тивтэй холбоотой яруу тод өнгөний талаарх давтагдмал санал нь, өнгөний тухай харилцааны бүхий л боломжит тээнэгэлзлийг арилгаж байгаа юм.

Долоо дахь өдөр нь, Бурхадын таван гэрэл цацрахын хамт, амьтдын ертөнцийн бүдэг ногоон гэрэл татна. Таван өнгийн хурц гэрлээс айж, бүдэг гэрэл рүү татагдвал, амьтны оронд төрж хэлгүй, ухаангүй харанхуйд унана гэсэн байдаг.

Төвд судрын энэхүү хэсгүүдээс үзвэл, туйлын зарчим нь зургаан тивийн билэгдэлд төдийгүй, тэднээс сансрын хүрдтэй зохицох зохицолд ч ажиглагдана. Үхсэн хойноо Бурхадын гэрэл гэгээнд татагдаагүй хүмүүс нь энэ ариун туяанаас зугатаж, өөрийн ухаан санаанд ойр дөт бүдэг гэрэлд татагдан орж байна. Тиймээс ч энэ ертөнцөөс хальсны дараах долоон өдрийн өнгө гэрлийн билэгдэл нь бие биетэйгээ төстэй боловч / жишээ нь: тод ногоон, бүдэг ногоон / заавал бие биетэйгээ эсрэгцсэн байна.

Гэхдээ, нэгэн зэрэг Дхъяни Бурхад бүрийн цацарсан гэрэлтэй ямагт хамт сансарын хэмжилтийн бүдэг гэрэл бий болдог. Гэвч энэ нь эсрэг өнгөтэй гэрэл байдаг. / Тэгээд ч зургийн хэсэг болгон таван Дхъяни бурхан байх үед бүрэн туйлшрал гарах нь бэрхтэй. /

Ийнхүү таван Дхъяни бурхадын эрчим цацруулсан хүчнүүд буюу Татхагата нь, оршин тогтнохын буюу сансарын байдлын шалтгаан болох төөрөгдөл, үзэн ядалт, хомхой сэтгэл, атаархал, бардамнал гэсэн таван хорыг арилгагч ерөндөг юм. Иймээс оюун ухааныг анагаан эдгэрүүлэгч Бурхадыг агуу их Оточ / Манал / нар гэдэг. “Анагаах ухааны бурхад” хэмээн голдуу хэрэглэдэг хэллэг бол эндээс гаралтай. Үнэн чанартаа, энэ нь огт тийм биш, өөрөөр хэлбэл Бхайшажа гүүр / Оточ багш / нь дахиад л Дхъяни бурхан Амитабхагын хувилгаан болдог. Энэ нь найман өөр чиглэлд, дагуу-луудтай хамт янз бүрийн “мутра”-тай байдаг. Тэдгээр нь, ертөнцийн өвчнүүдээс биднийг дөрвөн зүг найман зовхисоос хамгаалж, дөрвөн зуун дөрвөн өвчнөөс авран анагаагч, эрхэм дээд хүчнүүдийн төлөөллүүд болно.

Ухамсарт аль нэгэн хор илүү байгаатай уялдан, амьд зүйл нь сансарын аль нэг хэсэгт нь дахин төрдөг. Ертөнцийн аз жаргалын хоосон шинж чанар / бүр дээд хэлбэрт нь ч гэсэн / болон ганц ганцаар оршин тогтнох түр зуурын шинж чанарыг үл ойлгох явдал бол Тэнгэрийн орны онцлог төрх бөгөөд ингэхдээ эсрэг талын туйлд хүргэх үзэн ядах чанар нь тамын хэсэгт байх гол шалтгаан мөн. Хүн хэлбэрээр оршин тогтнох нийтлэг шинж чанар гэдэг бол бардам бодол, өөрийгөө эрхэмд үзэх болон “би”-г баримтлах явдал юм. Гэтэл ханашгүй шунал хүсэл / рага / -д арчаагүйгээр боолчлогдох нь бирдүүдийн ертөнцөд нийтлэг байдаг. Мөнх тулалдаж тэмцэлдэж байдаг асуруудын гол шинж чанар бол атаа хорсол / иршъя / мөн бөгөөд харин адгуусны ертөнцөд бол мунхаг чанар, дээд хэмжээгээр илрэх бүдүүлэг араншин / авидъя, моха / ухамсар хөгжөөгүйн шалтгаанаар, оюуны чадвар / сэтгэх, бодох, логик сэтгэхүй / дутуу байх учраас тэдгээр шинж чанарууд давамгайлж байдаг.

Эдгээр таван хорыг дарах хэрэгсэл нь Дхъяны Бурхадын таван билэг билгүүн юм. “Дхарма-дхату” буюу Бодит байдлын дээд хүрээ нь Тэнгэрүүдийн хий үзэгдлийг буюу энэхүү ертөнцөд байх гэсэн хүслийг дарж байна. Юмсыг жинхэнэ мөн чанарт нь үзэх боломж олгогч Толь мэт мэргэн чанар нь хүний оршихуйн амин хувийн шуналыг дарж

байна. Ялгуусан эрд - мийн Билгүүн ухаан нь сүнснүүдийн орноо хөтлөгч хорхойслыг дарж байна. Бүхнийг төгсгөгч нь Асуруудын орноо дуудагч атааг дарж байна. Ийнхүү:

Вайрочаны гүн хөх гэрэл, тэнгэрүүдийн бүдэг цагаан гэрлийг

Важрасатва - Акшобхьягын цагаан туяа, тамын утааны үнсэн саарал туяаг

Ратнасамбхавагын шар туяа, хүний ертөнцийн бүдэг хөх гэрлийг

Амитабхагын улаан туяа, сүнснүүдийн бүдэг шар гэрлийг

Амогхасидхийн ногоон туяа, асуруудын бүдэг улаан гэрлийг эсэр - гүүцэж байна.

Адгуусны ертөнцийн гэрэл бол “Бардо тойдол” – д, долоо дахь өдрөө бий болдог.

Видъядхарагын бурхадын таван өнгөт цацраг / риг - зин гьи лха цхогс / нь адгуусны аймхай байдалд сөргөөр нөлөөлдөг байна. Тийнхүү ертөнцийн зарчим нь, тэнгэрийн баяр баясгалан ба тамын зовлон, хүний идэвхит чанар ба ханаж цадашгүй шунал тачаал, асуруудын хүч ба амьтны айдас хаана байна, тэрхүү оршихуйн орнуудаас эхлэн оюун санааны идэвх- жилийн бүх төвшинд үргэлжилдэг юм.

Тэдгээр нь бүгд нэг нэгэнтэйгээ тэс ондоо байх ба яг доорхи гэрлийн өнгөний хамааралтай адил байдаг. Үүнд:

Хар нь цагаантай

Цэнхэр нь шартай

Улаан нь ногоонтой.

Дотоод мэдрэмжийн бүх гадаад хүчин зүйлүүд буюу оршихуйн амгалан байдал, тэдгээрийн шинж чанарууд буюу өнгөний туяарал нь болох Дхьяны бурхадууд болон зургаан орны хоорондох шүтэн барилдлагыг бид ухаж ойлгох хүртэл, тэдгээр нь эсрэг тэсрэг байдалд орших болно.

Бид дотоод үзэхүй болон эгэл ертөнцийн оршихуйн чанад дахь бүх хүчин зүйлийн харилцан үйлдэлд хүрээгүй цагт, тэд эсрэгцсээр байх болно. Энэ нь зургаан үсэгт Их мантра, сансрын зургаан тивтэй дотоод шүтэлцээтэй болохыг харуулж байгаа юм.

9. Маанийн зургаан үсэг ба зургаан орны харьцаа

Өрнөдийн эрдэмтдээс, Маанийн зургаан үсэгний учрыг олсон хүн цөөхөн, “Ум ма ни бад мэ хум”-ын гүнзгий утгыг нээх, түүнд нуугдсан цэцэн эрдмийг ойлгох гэсэн оролдлогууд голдуу талаар болж байлаа.

Уг тайлбаруудаас, хамгийн энгийн, ойлгомжтой боловч хамгийн болхи, цэвэр гадаад харьцуулалт дээр нотлогдсон тайлбар нь юу байсан бэ гэвэл, зургаан үсгээс бүтсэн / санскрит үг / “амны уншлага” нь үнэн сүсэгт Бурханы шашинтаны итгэл бишрэлтэй хамт уншигдах тэр л агшинд, сансрын зургаан тив бүрд сайн сайханы ерөөлийг дамжуулж, адисладаг явдал юм гэсэн тодорхойлолт л байна. / Jaschke, 1949, 607- р хуудас /

Бид төвдүүдийн сэтгэц, мэдрэмжийг ойлгоё гэвэл, өөрсдийн таамаглалыг хойш тавьж, ариун судар, маанийн ая дан, ариун зан үйл, бясалгагчдын практикийн үгс гардаг шашны туршлагын хүрээнд орох ёстой. Тэгвэл бид оюуны дүгнэлт, түүхийн болон хэлзүйн шинжилгээ, хийсвэр үзэл онол ба үнэт зүйлсийн учир шалтгааны шүтэлцээ төдийгүй, шашны туршлагад урган орох зохих хэмжээгээр зөвтгөгдсөн, хамаагүй илүү гүн учир шалтгааны шүтэлцээ байгааг харж болно.

Маанийн зургаан үсэг болон оршихуйн зургаан тивийн харилцааг тодорхойлоход, цэвэр гадны хэрэгсэл ашигладаг Төвдүүдийн сэтгэлгээнд гадаад өнгөц юм юу ч байхгүй боловч, үг бүрийг ёроолд нь хүртэл ухах боломж өгдөг Авалокитешварагын дотоод мөн чанар гэж бий. Өөрөөр хэлбэл, мантрын бүх утга нь туршлагын агуулга болохоос биш, гарал зүйн юм уу, хэл зүйн утгатай холбоогүй юм. Түүхийн болон хэл зүйн үүднээс тайлбарлах нь жинхэнэ гадаад өнгөцхөн хандлага бөгөөд иймэрхүү хандлага нь сүүдрийг мөн чанар гэж, гаднах хальсыг нь өндөг гэж дүгнэхэд хүргэдэг билээ. Учир нь үг гэдэг бол амьгүй эд биш, түүнийг зоос мэтээр бие биедээ дамжуулж болохгүй, газарт булчихаад хэрэгтэй цагтаа цоо шинээр нь гаргаад ирдэг эд биш юм. Үг нь туршлагын хүрээнээс байнга урган төлжигч ухамсарын билэг тэмдэг гэвэл үнэнд илүү ойр болно. Үгээр юу хийдэг вэ гэвэл, ухамсартай ба ухамсаргүйгээр бид түүнд агуулагдаж буй бүхнийг ил гаргаж тавьдаг явдал юм. Авалокитешвара энэ ертөнцөд бууж, хэрэгтэй бүхэнд өглөг буяны мутраа дэлгэхийн адилаар, түүний мантрын үсэг бүхэн нь түүний энэрэлийн хүчээр

дүүрэн байдаг юм. Иймээс маанийн зургаан үсгийг, түүгээр зовлонг арилгаж, бодисыг хий үзэгдэл, төөрөгдлөөс ангижруулдаг зургаан тивтэй харьцуулах нь зүй ёсны хэрэг юм. Мантрын утгыг өөрөө тайлсан хүнд, өөрөөр хэлбэл, түүний хүчинд итгэсэн төдийгүй, түүнийг өөрийн шүтлэгээр дүүргэсэн хүнд, зөвхөн өөртөө санаа тавих нь хангалтгүй, харин амьд бүхнийг хүлээснээс чөлөөлөх хүсэлд автана. Энэхүү шалтгаанаар, йогч хүн бүх төрлийн бодист анхаарал тавих ба маанийн зургаан үсгийг дуудах бүрдээ, сансарын зургаан тивийг санаандаа болгоож байдаг. Тийнхүү үг үсэг бүр нь Авалокитешварагын энэрэлийн хүчийг бодьжуулах хэрэгсэл болж байдаг юм. Тийм учраас маанийн зургаан үсгийг үнэн сүжгээр дуудсанаараа, амьд бүхнийг адислаад зогсохгүй, сансарын зургаан тивд орох үүдийг хааж байна гэсэн үг юм. Ингэхээр бидэнд зовлонг төрүүлэгч, оршихуйн байдал нь биднийг татах чадвараа алдана.

“Ум” гэж дуудахдаа, бид өөрсдийн цэнгэлдээ ташуурч төөрөлдсөн тэнгэрүүдийг ухаандаа болгоож, маанийн энэхүү үсгийн хүчээр тэдэнд чөлөөлөгдөх үүдийг нээхийн хамт, тэдний энэ тивд өөрөө орох үүдийг хаана.

Ийм маягаар, бид өөр тивийн ахуйг ухаандаа болгоож, “Ма” хэмээн дуудахдаа хорсолд идэгдэн, гэрлийн хүчний өөдөөс байнга тэмцэгч асуруу- дыг чөлөөлж, өөрөө тийш орох үүдийг хаана. “Ни” хэмээн дуудахдаа ололт -доо сохорсон хүмүүсийг чөлөөлж, “Бад” хэмээн дуудахдаа, харанхуйд хүлэгдсэн адгууснуудад нөлөөлнө. “Мэ” хэмээн дуудахад өлөн сүнснүүдийн буюу бирдүүдийн ертөнцөд нөлөөлнө. Эцэст нь “Хум” хэмээн дуудахад үйлдсэн нүглийнхээ уршгаар, тамын оронд тарчлагсдын зовлонг хөнгөлнө.

Тийнхүү “Ум ма ни бад мэ хум” нь бүх амьтаныг чөлөөлөх үүд, эцсийн авралд хүргэх замын билэгдэл юм.

Энэхүү үсгүүдийг уншихад Йогчийн зүрхэнд Агуу их Нигүүлсэх сэтгэлтэний гэрэлт хөрөг гарч ирэх бөгөөд сүсэглэгчийн мөнх бус биеийг Нирманакайя Авалокитешвара болгон хувиргана. Ингэхдээ тэрхүү мөнх бусын ухааныг Ами табхагын хязгааргүй их гэрлээр дүүргэдэг. Дараа нь сансарын дээр дурьдсан мөнх бусын зовлонгийн өөрчлөлт нь зургаан үсэг авианд очно. Иймээс “Бардо тойдол”-д өгүүлэхдээ, хэрэв мөнх бусын болон

шинээр буй болох хоёрын завсарт, Агуу их танин мэдэхүйн үед Бодит байдлын анхдагч дуу хоолой, аяндын дуу мянган удаа нүргэлэхийн адил цуурайтаж, тэрбээр зургаан үсэгт авиа мэт дуугарах тийм байдал гарч болох юм.

Иймэрхүү зүйлийг бид “Шурангама судар”-аас олж уншиж болно. Үүнд: “Авалокитешварагын нууцлаг болоод дотоод дуу авиа нь юутай чимэгтэй вэ? Энэ бол орчлон ертөнцийн анхдагч дуу авиа билээ. Далайн түрэлтийн хүнгэнэсэн намуухан чимээн дундаас, тэрхүү дуу авиа сонсогддог ажээ. Харин түүний нууц дуу авиа нь зовлонд нэрвэгдэж, тусламж эрсэн амьтай бүхэнд аврал авчирч, амар амгалан Нирваан байдалд орохыг үнэн сэтгэг- лээсээ эрж хайгчдад мэдрэмжийг хайрладаг” гэжээ.

Авалокитешварагын энэхүү ариун тарнийг хад чулуун дээр тоймгүй олон сийлэн үлдээснийг харахад, Төвдүүд Бурханы энэхүү илгээлтийг ямар их бишрэлээр угтан авсан нь төвөггүй ойлгогдоно. Маанийн зургаан үсэг бүх санваартаны урууд уншигдаж, төрөл арилжигчийн эцсийн амьсгал болдог. Энэ бол Төвдийн мөнхийн аялгуу бөгөөд йогач хүн түүнийг горхины хоржигноон дунд, урсгал усны шуугианд, хар салхины исгэрэх чимээн дотор олж сонсдог. Мантра нь аянчиныг халил өндөр хад асганаас, онгон зэлүүд жингийн замд, өндөр даваан дээрээс мэндчилдэг байна. Ийнхүү бясалгагч бол Соён гэгээрэх ертөнцөд үргэлж байгаа мэт болох бөгөөд “Мани” хэмээх энэхүү үнэт чулууг ухамсарлан ойлгож, өөрийн зүрхний бадамлянхуа цэцгийг сэргээж, түүний дэлбээгээ нээхийг хүлээж байдаг байна. Амьдрал үхэл, аюул осол, гай гамшиг нь сэтгэхүйн ийм дээд байдалд орсон үед чухал бус зүйл болдог бөгөөд сансар, нирваан хоёрын хоорондох мөнхийн ялгарал, энэхүү мэдлэг ухааны гэрэл гэгээнд аажмаар замхран арилдаг байна.

“Авалокитешвара-гуна-карандавьюха”-д: “Бодхисаттва Сарва-нир вана-нишкамбхиномын хэлсэн үгийг тэрээр машид үнэмшилтэйгээр давтан өгүүлэхийг хүсдэг. Үүнд: “Хэн надад Агуу их билгүүн чанар, Маанийн зургаан үсэгт тарнийг өгнө, би түүнд долоон талт эрдэнэсээр дүүргэсэн, дэлхийн дөрвөн тивийг бэлэглэнэ. Хэрвээ хэн нэгэн, дээр нь юм бичих гэж модны холтос, бэх, цаас аль алиныг олж эс чадваас, би түүнд миний цусаар бэх хийж, миний арьсаар холтосыг орлуулж, миний яснаас нэгийг авч, үзэг хийхийг

санал болгоно. Энэ бүхэн нь миний биед зовлон учруулахгүй. Харин ингэснээрээ, тэр нь надад эцэг эх шиг минь, хүндэтгэж явдаг юмны минь хамгийн дээд нь болох байсансан билээ” гэжээ.

1. Амогхасиддхи: Ялж төгс нөхцсөн Бурхан

Бид язгуурын таван бурхан Вайрочана, Ратнасамбхава, Амитабха, Акшобхъя, Амогхасиддхи болон тэдний билэгдэл болсон хурд, чухаг гурван эрдэнэ, бадамлянхуа, очиртой нь хамт үзсэн билээ. Учир нь тэд цөмөөрөө “Ум ма ни бад мэ хум” хэмээх тарнийн дөрвөн гол үеийн аль нэгтэй нь холбоотой байдаг юм. Язгуурын таван бурханы нэг Амогхасиддхийн үүргийг бид дээр цухас дурьдсан билээ. Тэрбээр энэхүү тарнид агуулагдах боловч бусдыгаа бодвол авшиг багатай. Хэрвээ “Ум” нь төгс гэгээрлийн, “Мани” нь амьтаныг алагчлалгүй үзэх буюу нэгдэх замыг, “Бадмэ” нь үзэхүйг нээгч, “Хум” нь ижилсэх замыг зааж байгаа бол, тэдгээрийн ард бодьжих үйл, санааны нууцат хүч байдаг бөгөөд тэдгээр нь сонгосон замаараа зоригийг бидэнд өгдөг төдийгүй, бид замынхаа эцэст хүрээгүй цагт замын дунд биднийг өөрчилж байдаг юм. Буддын сургаал бол хоосон онол, хэзээ ч биелэхгүй мөнхийн үнэний хойноос хөөцөлдөгч биш, харин ч зорилгодоо хүрэхийг үнэхээр эрмэлзэн тэмүүлэгч хэн бүхэн хүрч чадах зам, зорилго, үйл, энэ бүхнийг бүтээгч үзэл санаа юм.

Түүний зам мөр буюу идэвхтэй үзэл санаа нь бүр эхнээсээ Буддизмын нэг үндсэн шинж чанар нь байсаныг “Найман мөр”, “Дундаж зам”, “Их болон бага хөлгөн”, “Зовлонг гэтлэх”, “Төгс гэгээрэлд хүрэх” гэх мэтийн үг хэллэгээс тодорхой харагддаг. Эдгээр үг хэллэгт Буддизмын тогтвортой тал, мөн чанар нь харагддаг. Гэхдээ, энэхүү чанар нь язгуурын таван Бурханаас Амогхасиддхид хамгийн ихээр илэрдэг. Акшобхъя бүрэн тайвширсан ухамсарын хурц тодыг буюу Их толь мэт билгүүн ухаан, Билгүүн ухааныг шингээсэн, Амитабха “би”, “ертөнц” гэсэн хуурамч төсөөллийг илрүүлэгч дотоод үзэхүйг тусгасан бол, Амогхасиддхи эдгээр мэдрэмжийг үр дүн, төгс үйлдэл болгон хувиргаж, бясалгал үйлдэж буй Йогачийг гэгээрэгч болгодог юм. Түүний санаа зоригийн хүч нь төрөл арилжихуйн төгсгөлгүй эргэлтэд байсаар, гэгээн Бодьсадвын үйлийн нөхцөлүүдээс

чөлөөтэй нэгэн цул хүч болох бөгөөд түүний амьдрал нь оршихуйн шуналд биш, бүхнийг багтаасан энэрэл нигүүсэлд үндэслэдэг. Түүний бие нь “өөрчлөлтийн бие” / Нирманакайя /, ухаан нь бүх Буддын “Ум”, үг хэл нь Билгүүний туйл болох “Мантра” болно.

Амогхасиддхи бол ялж төгс нөгчихүй, Бодьсадвын бодьжилтын язгуур юм. Дхармакайя, Самбхогакайя хоёр амьд биеийн хэлбэрийг олж нүдэнд үзэгдэх болсон нь Амогхасиддхи юм. Түүний энэхүү онцгой байдлыг “Бардо тойдол”- д зургаа дахь өдөр мандлууд бүгдээрээ байсан атал тав биш, дөрвөн билгүүний туяа байсан хэмээн тайлбарлажээ. “Амогхасиддхи буюу ялж төгс нөхцсөн бодьсадвагийн ногоон гэрэл нь гагцхүү, оюун санааны мэдрэмжийн төгс чадварыг бид олсоны дараа л биднээс гэрэлтэнэ” гэсэн нь Амогхасиддхи үнэхээр ялж төгс нөхцсөн, хамгийн дээд шатны гэгээрэл болохыг харуулж байна.

Үүнийг Амогхасиддхийн Вишва-важра буюу Элдэв очироор тайлбарлаж болно. Энэ нь Акшобхьягын Очир нь хос болгон хүч нэмэгдүүлсэнд бус, түүнийг шинэ агуулга, шинэ хэмжүүртэй болгосонд байгаа юм. Важра - сатвагын дотоод зам нь, бидний зүрх сэтгэлийн хамгийн мэргэн цэцэнийг хослуулсанд, энэ бүх гэрэл нь бидний амар амгалан саруул болж, жинхэнэ мөн чанараа нээж байгааг ухамсарласанд оршино. Энэхүү дотоод зам нь Амогхасиддхийн нууцад хөтлөн аваачих ба тэнд үзэгдэх үзэгдэхгүй, дотоод гадаад хоёр нэгдэн, оюун санаа нь биеийг олж, бие нь оюун санааг тээгч болно. Амогхасиддхи нь аугаа их өөрчлөлтийн эзэн болж, түүний “вахан”-аар жигүүрлэсэн хүн оршихуйн шинэ хэмжүүрт шилжинэ. Амогхасиддхи бол “хий”, “салхи”-ны язгуур махбодийг эзэгнэгч, хөдөлгөөний зарчим, амьд амьсгал, амьдралын хүч юм.

“Би түүнд бүх санаагаа төвлөрүүлэн аугаа их ертөнц, орон зайд оршиж, аугаа их ертөнц тасралтгүй хөдөлгөөнд оршиж, амьсгалыг буй болгон түүнийг дэмжиж, өөрөө / ухаан / хэрхэн хөдөлж, санаа хэрхэн ирж, хэрхэн явж байгааг харж байлаа. Эдгээрийн мөн чанар ямар ч эх үүсвэргүй, ямар ч эцсийн зорилгогүй, бүх амьд бодис, хязгааргүй орон зай дахь тоо томшгүй жижиг тооснуудын адилаар тодорхой хэмнэлд оршиж байгааг би ухамсарлаж байлаа.” / Buddhist bible, 1938, 243 - р хуудас /

Энэ бүхэн цөмийн физикийн сүүлийн үеийн нээлтүүдэд үндэслэсэн, ертөнцийг тайлбарласан орчин цагийн онолыг санагдуулах бөгөөд бидэнд дотоод үзэхүйн гүн гүнзгий агуулгын тухай төсөөлөл өгч чадах юм.

Энэтхэгийн Буддист гүн ухаантнууд Пражня парамитын диалектикийн танин мэдэхүйг тайлбарлаж болох хязгаарыг заасан бөгөөд энэхүү хязгаар нь хүний хэлний хязгаараас асар хол хальсан учраас тэр үеийн бандида нар философийн сэтгэлгээний нөгөө тал руу шагайж харах боломж олгодог парадокс хэллэг ашиглахаас өөр арагүй байлаа. Хүний ухаан нь санааныхаа дээд хязгаарт хүрчээ.

Тийнхүү, бидний өмнө санааны энэ хязгаарыг гэтэлсэн зам байгаа ба уг зам нь Дхьяни, йога хоёроор дамжин төрөлх мэдрэмжийн туршлагын гүн рүү хөтөлнө. Гэхдээ, энэ бүхнийг зөвхөн дурьдахаас бус, үгээр тайлбарлаж болохгүй.

Гэвч, Амогхасиддхийн мөн чанар нь язгуурын бусад Бурхадыг мэдрэх үндэс болж, тэдгээрийн олон чанар түүнд шингэсэн байдаг гэсэн нэг зүйл ойлгомжтой байх ёстой.

Их толь мэт Билгүүн чанараар бид субъект болон ертөнцийг хүртэх субъектив хүртэхүйг объектийн / татхата / төлөөнөөс эвдэлж байгаа юм. “Виджняптиматра сиддхи шаштра”- д өгүүлсэнээр: “Их толь мэт билгүүний танин мэдэхтэй холбоотой ухамсар нь янз бүрийн хэлбэр дүрс том толинд тусахын адилаар, бүх объектийн шинж чанарыг тов тодорхой тусгаж байдаг.

Адилсахуйн билгүүн чанараар бид субъектийн төлөөнөөс объектийг, ялгахуйн билгүүн ухаанаар бид объект, субъект хоёрыг хамтад нь эвдэлж байна. Төгс үйлдэхүйн цэцэн мэргэнээр бид объект, субъектийн аль алиныг эвдэхгүй, өөрөөр хэлбэл, бид дээд эрх чөлөөнд хүрч байгаа хэрэг бөгөөд Будда бурханы адил хамаг амьтанд туслахаар эргээд энэхүү ертөнцөд ирж болно. Учир нь бид энэ ертөнцөд хоргодохгүй. Одоо бидний хувьд уул дахиад уул болно, ус дахиад л ус болно.

“Зэнг судлаагүй байхад уул уулаараа, ус усаараа байна. Сайн багшийг дагаж Зэнгийн мөн чанарт нэвтэрвэл, уул нь уул биш, ус нь ус биш болно. Харин ертөнцийн оргилд хүрч

төгс гэгээрвэл, уул дахиад уул болно, ус дахиад ус болно” гэжээ. / D.T.Suzuki, 1953, 1 - р хэсэгт /

Буддагын сургаал нь бүх юмсын туйлын нэгдэл, эвдрээгүй адил тэг - шийн төлөөнөөс ялгахыг сургадаг. Энэ сургаал эсрэг тэсрэгийг эвдлэх юм уу, үнэ цэнэгүй болгохыг эрмэлздэггүй, харин эдгээрийн харьцангуй чанарыг тэдгээртэй хамт, тэдгээрийн дотор ба гадна оршигч нэгдэлд ухамсарлахыг сургадаг юм.

“Пражня - парамита / билэг барамид / бол ахуйн болон түүний харьцангуй чанарын туйлд байна гэж хэлж болно. Энэ нь хил хязгаарыг / оюун билгийн / тэмдэглэж, ямар ч атугай хэмжилтэнд орох геометрийн шугам гэж хэлж болох юм. Ахуйн хоёр талыг авч үзэх үед Пражняг сургаал буюу арга зам мэтээр үзэх албагүй юм. Хэрэв Пражня нь түүнийг хоосон чанаргүй / Ашунъята / - гээр зөвхөн хоосон чанарыг таньж болох / Шунъя байхгүй буюу Шунъята хэмээх харьцангуй чанар байх үед / эсвэл Хоосон чанаргүйг / Ашунъята / таньж мэдэх үед байсан бол Пражня байж болохгүй байхсан билээ. Үүнийг билэгдэн үзүүлэх зорилгоор Энэтхэгийн бурхад бол ердийн хоёр нүдний хооронд нэмэлт гурав дахь нүдийг дүрсэлж үзүүлдэг юм. Энэ бол Пражнягын буюу билгийн мэлмий болно. Соён гэгээрэгч энэхүү гурав дахь нүдээ ашиглан Бодит байдлыг / йатта бхутам / хоёр хуваалгүй, задлан ялгаж салгалгүй хүлээн авч чадна. Тэгээд ч энэ арга нь хийсвэр сэтгэлгээний ажил юм. Нэгдэл болон Олонлог / Шунъята, Ашунъята /-ийн хязгаар дээр байгаа Пражнягын мэлмий нь энэ хоёр ертөнцийг нэг бодит байдал болгож хардаг.” / D.T. Suzuki, 1947, 3 - р хэсэг, 269 - р хуудас /

Гоц юм бүр нь орон зай, цаг хугацаа, шалтгааны байдалд байгаа нэгэн бүхэл юмны гайхамшигт илрэл юм. Иймээс бид үзэгдэл, амьд юмсын хэлбэр, аливаа юмс буюу амьдралын тохиолдлыг авч үзэхдээ, “оршихуй”, “эс оршихуй” - н алинаар нь ч батлан хэлэх эрхгүй билээ.

2. Амогхасиддхигийн бүхнийг үйлдэгч билгүүн ухаан бол
үйлийн үрийн хуулиас ангижрахтай адил болох нь

Амогхасиддхи бол эрхэм дээд чөлөөний хувилал, энэхүү ертөнцөд гэгээрлийн байдлаар очих бөгөөд тэрээр өөрийн үйлдлээрээ үйлийн шинэ үр дагаврыг бий болгодоггүй юм. Тэрбээр амин хувиа хичээх төвт / “би”- г баримтлах үзэл / эрмэлзлэлээ дэвшүүлж тавихаа больдог. Тэрээр энэхүү эрмэлзлэлийг хамрагч хайр энэрэлийн хязгааргүй хүрээлэл дотор оруулж, өөрийн цэвэр тус энэрэл болгон хувиргадаг. Энэхүү “би”- г баримтлах эрмэлзлэлийг илүү дээгүүр тавьснаас, бид өөрсдийн үнэнхүү мөн чанарыг умартан, өөрийн тэнцвэр, нийцэл болон дотоод хүчиндээ тавих хяналтыг алддаг.

Хүний оюун ухааны хэмээс хэтэрсэн чадварлаг байдал нь түүний үнэн шинж байдлыг бус, харин ердөө л аливаа нэгэн зүйлд түшиглэх ёстой сэтгэхүйн үйл ажиллагааны дагавар бүтээгдхүүнийг илэрхийлдэг. Гэвч, энэ бүх түшиг тулгуур нь аливаа өвөрмөц чанарт гайхамшигтай чамин зүйлийг бий болгодоггүй бөгөөд энэ бүхэн бол ямар ч амьтай бүхэнд байдаг л нийтлэг шинжүүд юм.

Бие хүн болгон орон зай, цаг хугацаанд аль нэгэн байр суурийг эзэлдэг. Түүний ухамсар нь бүрэн төгс болсон үед ч, тэр нь эзэмшсэн давтаг - дашгүй мэдлэг туршлагынхаа хэмжээнд өөрийнхөө анхдагч чанарыг хадгал - саар байдаг юм.

Тийм ч учраас Будда хүртэл төгс төгөлдөр Бурханы мөн чанарын нэгдэл болсон хэдий боловч өөрийнхөө зан чанар, өөрийнхөө шинж байдлыг хадгалсан хэвээр л байдаг. Ийм байдал нь Дхъяни Бурхадын хувьд ч, байдаг бөгөөд тэдгээрийн салшгүй шинж чанар, мэргэн шинжүүд нь “хувийн шинж чанар”-ыг илтгэдэг. Тэгэхээр энэ утгаараа хувийн шинж чанар бол биднийг өнгөрсөн, ирээдүйтэй холбогч нэгэн дарамт буюу үйлийн үрийн гинж биш юм. Соён гэгээрсэн хүний хувьд эрх чөлөө болон хуулийн хооронд зөрчил байдаггүй. Түүний хувьд бүх туйлшралууд тэнцвэрээ олсон, нэг нэг - нээ тэтгэдэг бөгөөд хувийн хүсэл бодол болон орчлонгийн хууль жам нь нийцэлтэй байдаг. “Эго”- гийн / ”би”- гийн / илрэлүүдээс ангижирсан бидний шинж байдал бол олон талт хуулийн ухамсарт хувилал / Дхармакайя / буюу орчлон ертөнцийн хүчнүүдийн нэгдэл болдог.

Хөгжмийн ухаанд өгүүлдэгчлэн, хэмнэл гэдэг нь хууль ба эрх чөлөө нэгдмэл болж, тэдгээрийн эсрэг тэсрэг байдал үгүй болсон амьдрал турш - лагын жишээ юм. Хөгжимчин

хүний хувьд бол, хөгжмийн хэмнэлийн хуулинд албадлага байдаггүй, харин ч тэрхүү хууль жамыг мөрдөн дагах тутам тэрээр хүсэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг олж авдаг. Тэр нь хуулийн боол нь биш, бүтээгч нь юм. Учир нь хууль жамыг ухаж ойлгосны дүнд түүнтэй нэгдмэл болж, түүний бие махбод нь тэрхүү хууль жамыг төгс төгөлдөр илэрхийлэгч нь болдог. Мэдлэг бол хууль жамыг илрүүлж гаргахад тустай, гэвч тэр хууль жам нь цаашид өөртөө үнэн зөвөөр илэрхийлэх, оюуны эрх чөлөөний арга хэрэгсэл болдог. Бид зөвхөн туулсан замаа эргэн харсанаар, тэр нь бидэнд нэгэн цаг үед хууль байжээ гэдгийг санах юм. Бурханы шашны хэлээр өгүүлбэл, карма өөрийн хүчин төгөлдөр байдлаа алдаж, төгс төгөлдөр Мэдлэг ухааны хүрээнд эвдэрч нурдаг. Карма буюу үйлийн үр нь өнгөрсөн үеийн Гэгээрэлд хүрээгүй үеийн нэгэн хүч байх үед, тэрээр эсэргүүцэн тэмцээд ч хэрэггүй “рок” хөгжим мэт болж байдаг. Гэвч зөн билгийн гэгээрлийн цаг үед шалтгаан, үр дагаврыг бүх нарийн түвэгтэй бодол нь тод томруун мэдрүүлдэг. Энэ үед соён гэгээрэгч нь хуулийг бүтээгч, зураач, өөрчлөн хувиргасан хуулийн эрх чөлөөг илэрхийлэгч болдог.

Энэхүү нийтлэг байдлыг ямар нэгэн мулгуу адилтгал, нэг загварын зүйлтэй хольж хутгаж болохгүй. Тэрхүү нийцэл нь бүхнийг хамарсан шинж байдлынхаа улмаас, боломжийн бүх хувилбараар дүүрэн байдаг. Яг адилхан аяар хөгжим тоглох юм уу зохиож чаддаг, хөгжимчин ба хөгжмийн зохиолч байдаггүй билээ. Ганцаарчилсан байдал болон зохиол бүтээл нь хэзээ ч зөрчил тэмцэлд ордоггүй, хоёулаа ямагт бие биенээ нөхөж байдаг юм гэдгийг дахин нотолж байгаа хэрэг. Эс ингэвээс, хувийн ухамсар болон эрх чөлөөт хүсэл зоригийн хоорондох ялгаа хэзээ ч байхгүй байх байсан билээ.

“Орчлон ертөнц бол эрх чөлөөг бүрдүүлэгч элементээр дүүрэн юм. Од гаригаас атомд, хамгийн энгийн юмнаас хүнд шилжих замд, нэгэн зүйл юмнаас онцгой ялгагдах зүйлээр бүх юмс дүүрэн байдаг гэдгийг бид яаж сайтар тодорхойлж бичиж чадах вэ? Энэхүү оршин тогтнох дотоод чанарыг, жишээлбэл, атомын дотоод мөн чанарыг хэрхэн сайтар тайлбарлах вэ? Шингэн болон хийн байдалтай биетэд молекулын замбараагүй хөдөлгөөнийг болон хромсомын хөдөлгөөний хувилбаруудыг хэрхэн тайлбарлах, энэ тухайд бас онцлог талуудтай байдаг биеийн бүх эрхтэний гүйцэтгэх үүргийг химийн бүтэц

дэхь хувийн ялгаатай талууд зэргийг хэрхэн тайл - барлавал зохих вэ? Хүний сонголтын эрх чөлөөг хэрхэн сайтар таньж мэдэх вэ? Тиймээ, зөвхөн бидний дотор орших сэтгэл хөдлөлөөр л эрх чөлөөг таньж болох юм. / Frank Townshend, 1939, 88 - р хуудас /

“Орчлон ертөнц төгсгөлтэй боловч хязгааргүй юм. Орчлон ертөнц бол тодорхой дэг жаягт захирагддаг, энэхүү дэг жаяггүйгээр оршин тогтнож чаддаггүй юм гэсэн утгаараа, тэрээр эцэс төгсгөлтэй байдаг юм. Тэрээр сонголтын эрх чөлөөний бүрэлдхүүн элементээр нэвт шингээгдсэн байдаг гэсэн утгаараа хязгааргүй ажээ.” / Мөн тэнд үзнэ үү, 89 - р тал /

Ухамсар бол гэгээрлийн далд оч адил амьдралд нийтлэг байдаг, гэхдээ ухамсарт үй олон өнгөний ялгаанууд бий, хичнээн өнгө байна, төдий чинээ ялгаа буй. Аливаа хувь хүн өөрийнхөө хууль жамыг буй болгож, түүнийгээ мөрдөн дагах бүр, үүнийг доржилтын хувийнх нь өнгө дагалддаг болно. Бүх өнгөнүүд эрхэм дээд үзэсгэлэнт байдалтай барьцалдан нийлж хорших бөгөөд энэхүү үзэсгэлэнт байдал нь дэг жаягийн бүх шатлан захирах ёсыг бий болгон хүрээлж, чиглэл бүртээ доржилтоос чөлөөтэй болдог. Зөвхөн тэр үед л бүрэн гэгээрэлд хүрдэг. Иймээс зах хязгаараас зайлсхийсэн “Дундаж зам” буюу “Төв үзэл” гэдэг бол онолын харилцан тохиролцол биш, оюун санааны аврал биш, харин бидний ахуйн хоёр талын ухамсар бөгөөд нэг тал нь өнгөрсөн цаг үе, нөгөө тал нь өнөө үе юм. Бид оюунаараа, идэвхжилээрээ өнгөрсөн цаг үед амьдарч, зөн билгийнхээ хараа, оюуны ухамсараараа цаг хугацаагүй өнөөгийн үед амьдарч байна.

Ийнхүү бид санаа бодлыг бясалгалаар / дхъяна /, улирч өнгөрсөнийг өнөөгийн биелэлээр, цаг хугацааны хуурмаг байдлыг орон зайн мэдлэг туршлагаар тус тус гэтлэн давж чадна. Энэ орон зай бол юмс биетэйгээ зэрэгцэн оршиж байгаа, гаднаасаа үзэгдэж харагдах зүйл биш, харин урт, өргөн, өндөр гэсэн гурван хэмжээг багтаасан, гадагшаа хэмжээ хэтэрч гарсан орон зай бүхий дээд хэмжилтийн орон зай мөн. Ийм орон зайд юмс тус тусдаа салангид байдаггүй, бүхэл нэг юмны хоорондоо холбоотой хэсгүүд, эрхтэнүүд, нэг нэгэндээ нөлөөлж, хоорондоо нэвтрэлцсэн нэгэн бүхэл бүтэн цогц зүйл болно.

Энэ бол “Авамсака” / “Гандаввьюхи” хэмээх билэгдлийн чиглэлд хураангуйгаар бичигдсэн байдаг. 5 - р хэсгийн III бүлэг / гүн ухааны төв үзэл бөгөөд түүн дээр “Чань” буюу Зэн - Буддизм үндэслэгдсэн ажээ. Үүнийг мэдэхгүй бол Зэн нь оюуны тоглоом буюу сайндаа л сэтгэлзүйн шинжлэлийн сорилт болох юм. Энэ бол зүгээр нэг тоглоом болгон хэлчихсэн зүйл буюу агшин зуурын сэтгэл хөдлөл, тухайн байдлыг илэрхийлсэн зүйл бөгөөд хэн нэг хүнийг төөрөгдүүлэхэд зориулсан төдийгүй, бас бусдын уламжлалын тодорхой билэгдлүүд, зангилаа ухагдхууныг агуулсан зүйл гэвэл, хамгийн хачирхалтай нотолгоо болох юм . Энэ үндэслэлгүй бол Зэн нь утга учиргүй, шашны гүн холбогдлоо алдах юм. Олон зуун жилийн туршид хадгалагдан үлдсэн Коан ба Мандогийн уламжлалд Зэний чадамгай урчууд түшиглэдэг гэдэг баримт бол орчин үеийн тайлбарлагчид ач холбогдлыг нь хэт бууруулахыг оролддог Зэний амьд уламжлалын чухлыг нотолдог юм.

Энэ бол нүднээ үзэгдэх төдийгүй, мэдрэгддэг орон зай бөгөөд тэр нь ухамсараар дүүрэн, амьд бөгөөд сансарын ухамсар юм.

Хэрвээ бидний энэхүү Гэгээрэл нь төгс төгөлдөр болох аваас, бидний урам зориг мөн адил төгс төгөлдөр болж, тэр нь орчлон ертөнцийн хүч - нүүдтэй нэг хэмнэлд орж, бид өнгөрсөн үйлийн үрийнхээ гав гинжнээс чөлөөлөгдөх болно. Гэвч бид энэхүү өндөр төвшинд хүрээгүй цагтаа, залуу яруу найрагчид өөрийнхөө захиандаа бичсэн “Анхдагч оршихуйгаас би өөрөө өөрийнхөө хувь заяаг сонсоно гэж үү? гэж Рильке хэлсэн байдаг шиг, наад зах нь “Хэдийгээр бидэнд анхны гэхээр зүйл үгүй ч гэсэн, бидэнтэй юу ч тохиолдож чадахгүй” гэдгийг бид мэдэж болох юм. / Новалис /

3. Бодхисаттвын аймшиггүй зам

“Бидэнд ямар ч адал явдал тохиолдохгүй, тэгээд ч үнэнхүү бидний гэх юм юу ч байхгүй” гэсэн хэллэг бол Авалокитешварагаар илэрч, билгүүн Амогхасиддхи / абхайя - мудра / - ээр илэрхийлэгддэг чин зоригийн үндэс мөн бөгөөд тэр нь Аугаа их нигүүлсэхүй Майдар, гэрэлт бурхадын шинжинд шингэсэн бөгөөд түүний хүнлэг биелэл нь Амогхасиддхийн билгүүнийг тусгасан байдаг.

Аймшиггүй гэдэг бол бүх Бодхисаттвын болон түүний замаар замнагч бүхний чанар болно. Тэдний хувьд амьдрал бол гай зовлонгоос буюу өөрийгөө хамгаалах хэрэгсэлээс салж ангижирсан байх бөгөөд тэгээд ч тэдгээр нь газар дэлхий дээр оршин тогтнох явдлыг шинэ утга агуулгатай болгоод, дэлхий ертөнцийг сөргөөн хүлээн авч мэдэрдэг зарим хүний оролдлого шиг буруу гаж үйлдэл хийдэггүй юм. Олон сая хэлбэр дүрс бүхий зургаар илэрхийлсэн Бурхадын инээмсэглэсэн нүүр царай нь амьдралд дайсагнасан байдлыг гаргаж чадах уу даа? Дээд зэргээр хөгжих амьдралын бүх боломжийг дуусгаагүй байж, амьдралыг муу муухай зүйл хэмээн үзэх нь угаасаа эвгүй, үлэмж мулгуу явдал юм. Энэ бол боловсроогүй жимсийг амсаж үзээд боловсрохыг нь хүлээхийн оронд, идэж боломгүй зүйл хэмээн хаядаг бүдүүлэг хүний араншинтай зүйрлэж болох үйлдэл юм.

Бүрэн соён гэгээрч чадсан хүн л “хувь хүний онцлог чанар”-ын тухай ярьж чадах юм. Өөрийн амьдралын мэдрэмжийн болон байгалиас заяасан үүргийг зөв хэрэглэх гэж оролдож үзээгүй, түүнийг дарамталсан хэн боловч ариун бус, амьд чулуун хөшөө болдог байна. Амьдралаас холдож, үгүйсгэл дээр боссон ариун чанар нь олон түмэнд мэдээж сэтгэгдэл төрүүлэх бөгөөд олон нийтээрээ үүнийг гол төлөв өөрийгөө хянах болон оюуны эрч хүчний гэрч баримт хэмээн хүлээж авдаг. Гэхдээ энэ нь оюуны доройтолд хүргэхээс биш, Соён гэгээрэх үйл явцад хүргэдэггүй юм. Энэ нь зогсонги байдал, оюуны үхэл мөхлийн зам болно. Энэ нь амь амьдралаа золиосолж зовлон - гоос хагацах, соён гэгээрэхэд хүргэх увидастай очноос биднийг хөндий - рүүлж байгаа хэрэг юм. Энэхүү очыг өөртөө нээж олно гэдэг бол Бодхи - сатвын замын эхлэл бөгөөд энэ зам нь амьдралыг үгүйсгэх аргаар бус, чөлөөлөлтийг олох гэсэн орчин тойрныхондоо ач тус хүргэснээр зовлонгоос ангижруулдаг зам юм. Иймээс Шантидэвагын “Бодьсадвын явдалд орохуй” / Бодхичарьяаватара, 1, 8 - 10 / хэмээх мөнхийн яруу найрагт өгүүлэхдээ:

“Оёоргүй орчлонгийн түмэн зовлонгоос гэтлэх болоод

Олон амьтаныг аюулаас аврахыг хүсэх ба

Түмэн амгалан буман жаргалыг эдлэхийг горилвоос

Тэнсэлгүй бодь сэтгэл ямагтыг хэзээд бүү орхисугай.

/ Т. Булганы “Бодьсадвын явдалд орохуй” 1998 он, номоос авав /

гэжээ. Соён гэгээрэх тухай / Бодь сэтгэлийг соён гэгээрэх хэмээн томъёол - жээ. / бодол санаа хүнд бий болж бэхэжвээс, оёоргүй орчлонгийн шоронд шуналт сэтгэлдээ автагдсан азгүй тэр нэгэн агшин зуур Бурханы хүү болон хувирна. Түүнийг хүмүүсийн дунд, Бурхадын дунд хүндэтгэн дээдлэх болно. Энэхүү бодол санаа нь биеийг эзэмдвээс, тэрхүү бие нь шууд бурханы биеийн үнэт сувд эрдэнэ болон хувирна.

Иймээс тийм гайхамшигт хувирлыг олох “Бодхи”-ийн бодол санаа хэмээх шидэт зүйлийг авах нь зүйтэй.

Бодхичитта / Бодь сэтгэл / буюу Соён гэгээрэх тухай бодол санаа бол гүн ухамсарын оч бөгөөд энэхүү оч нь сүсэглэх үйл явцад бүхнийг нэвтлэгч хүч болон хувирдаг. Ийм дотоод сэрэл бий болохоос өмнө бидний оршин тогтнож байгаа байдал бол, тойрог замаар учир утгагүй гүйхтэй адил юм. Тэгээд ч бид өөрөө өөртөө учир утгыг олж чадахгүй учраас, түүнийг хүрээлэн байгаа орчлон ертөнцдөө яагаад ч олохгүй. Хэрэв бид ухамсарыг ертөнцийн үр дүн биш, харин ухамсарын үр дүн мөн / Энэ нь угтаа Махаяны үзэл баримтлал юм / хэмээн үзвээс, түүнээс ангижрах арга нь “ертөнцөөс зугтаан зайлах бус”, харин “оюун ухаанаа өөрчлөх” гэдгийг нотолж харуулсан тийм орчлон ертөнцөд бид амьдарч байгаа нь илт юм. Гэвч ийм өөрчлөлт нь бид оюун ухааныхаа шинж байдлыг ойлгосон тохиолдолд л боломжтой юм. Олон сая гэрлийн жилээр алслагдсан тэнгэрийн эрхсүүдийн цацрагийг тайлбарлах чадвар бүхий оюун ухааны хувьд бол, гэрлийн өөрийнх нь шинж төрхийг ойлгож мэдэх явдал нь боломжгүй зүйл бишээ. Бидний ухамсарын гүнд туяаран гийж байгаа, тэрхүү Гэрэл хичнээн том гайхамшигтай билээ.

Будда болон түүний олон шавь нар, энэхүү гүн ухааралд / ухамсарт / хүрэх практик ажиллагааг номлож үлдээсэн билээ. Энэхүү баримт нь бүх шинжлэх ухаан, гүн ухааны онолуудаас ч хавьгүй чухал юм болохоор бидэнд зөвхөн нэг л асуудал байгаа хэрэг. Энэ нь юу вэ гэвэл, бид өөрсдийн гүнд байгаа дотоод ухаарлаа сэргээж, Буддагын “ухаарал” буюу “соён гэгээрэх” гэж нэрлэсэн тэрхүү бодол санаанд хүрэх асуудал л байгаа юм. Энэ бол

Бодхисаттва марга / Бодьсадвын орон / бөгөөд бид өөрийн дотоод сэтгэлдээ, бурханы онцгой чанарыг хэрэгжүүлэх арга зам юм.

Цэцэгс өөрийнхөө хувьсч өөрчлөгддөг хэлбэрээрээ цаг хугацааны гаднах үзэсгэлэнт байдлын оргилыг илэрхийлдэгтэй адил, энэхүү бэрх төвөгтэй олсон биеийг боломжгүй юмны орчил, оюун ухааны цайз болгох гэдэг нь Очир хөлгөний сургаал ёсоор хүний гол зорилго юм. Бидний оюуны болон ухааны бүхий л шинж чанар, үүргийг энэчлэн авч үзэх хэрэгтэй юм. Үүний дараа “Эго” буюу “би”-д баримтлагч аминч үзэл нь хүчээр эвдэж нураах оролдлого хийлгүйгээр / ийм оролдлого хийх нь түүний хуурмаг байдлыг л ихэсгэнэ /, түүний оршин тогтнох харьцангуй байдлыг үгүйсгэх оролдлого / энэ нь зөвхөн өөрийгөө хуурахад л хүргэнэ / хийлгүйгээр, тэр даруйдаа өөрийн чухал шинжээ алддаг. Бидний хүсэл эрмэлзлэлийн үйлдэл бүр нь бие даасан байдалд чиглэж, хувийн ашиг сонирхолын ойр орчинд утга учиргүй зүйл болно. Ийм тохиолдолд бид “Эго”-г эзэмшиж байгаа бөгөөд одоогийн байдалдаа бид улирах цаг хугацааг дагаж, дараа нь “Эго”-гоос ангижрахад найдаж болно гэсэн санааг өгүүлэх нь зүйтэй.

Үүнд хүрэх найдвартай арга зам бол, зохих ёсны хэтийн зорилгодоо өөрсдийгөө олж харах явдал бөгөөд уг хэтийн зорилгыг Соён гэгээрүүлэгчдийн сургаал бидэнд нээж өгсөн бөгөөд тэдний амь насаараа үзүүлж харуулсан, их хөлгөний сургаал онцолж өгүүлсэн болно. Бид ертөнцийг жирийн ухамсарынхаа явцуу хүрээнд харж байх энэхэн цаг мөчид юмны утга учрыг олигтой таньж мэдэж чадахгүй, харин бид соён гэгээрсэн хүний ой ухаанд ертөнц хэрхэн ойлгогддог байдлаар нь орчлон ертөнцийн дүр төрхийг бүхэлд нь харах юм бол, бүх юмны учир утгыг ойлгохсон билээ. Энэхүү учир утга буюу эсвэл “дээд зэргийн Бодит чанар” гэдгийг хүний хэлээр илэрхийлж болохооргүй зүйл бөгөөд “самьяк - самбодхи”, “нирвана” эсвэл “пражня - парамита” гэх зэрэгтэй адил дохио тэмдэгээр илэрхийлнэ. Эдгээрийг тайлбарлаж болох бөгөөд Будда өөрөө бидний хувийн туршлага дээр үндэслэн сургахдаа, эдгээрийг тодорхойлж тайлбарлахаас татгалзсан билээ. Амьдралын болон орчлонгийн утга учир нь биднээс гадна бус, харин бидний дотор байгаа юм. Бидний дотоодод байгаа амьдрал маань утга учиртай юу, үгүй юм уу гэдэг нь биднээс

өөрсдөөс минь шалтгаална. Тэгэхлээр амьдралыг утга учиртай болгоно гэдэг нь бидний зорилго юм. Сэтгэл, үйлс төгөлдөр уран бүтээлч хүний гарт байгаа ямар ч үнэ цэнэгүй бөөн шавар, үнэлж баршгүй урлагийн бүтээл болдог. Түүнтэй яагаад адилтгаж болохгүй билээ. Тэгээд ч учир утгагүй юмнаас болж, гонгинож байхын оронд, бидний амьдралд байгаа жирийн нэгэн бөөн шавраар ямар нэгэн үнэ цэнэтэй зүйл бүтээж болохгүй гэж үү дээ. Бидний бүх ач тус, утга учрыг өөртөө агуулж байдаг юм. Хүний эрхэм дээд чанар мартагдашгүй үүрд байдгын адил, хүн өөрөө мартагдашгүй мөнх юм. Үүний нэгэн адил / эрхэм дээд чанартай хамт хүнд үйлчилж байдаг тэрхүү эрчим хүчтэй адил хүн болгон бодитой оршин тогтнодог хэмээн хэлсэн / гүн Кайдерлингийн энэ үг бол найдвартай чиг замыг зааж байгаа юм. Үнэт зүйл болон бодит чанарын харьцааны асуудал нь бүтээлч биелэлийн арга хэрэгсэл мөн. Иймээс Будда буюу Бурханы дүр нь бодит чанарын дээд илэрхийлэл юм. Уг чанарыг хэрэгжүүлэх гэсэн хэн боловч, Бурханы үлгэр жишээг дагаж, эскапизм огт байдаггүй Бодьсадвын замаар замнах ёстой. Гэвч үүний эсрэгээр төгс төгөлдөр, соён гэгээрэх гэдэг бол ертөнцийн зовлонг өөртөө үүрэхэд бэлэн биш бол энэ нь бүтэшгүй юм. Энэ бол Буддаг Веда болон Упанишадаас хол хальж гарахад хүргэсэн байр суурь юм. Буддизм нь Индуизмын нэг чиг урсгал болон хувирахын оронд дэлхий дахины нэг шашин болж хөгжсөнд л үүний шалтгаан нь байгаа юм. Ертөнцийн зовлонг өөртөө үүрнэ гэдэг бол зарим загалмайтан болон Индуист шашинтны дунд л байдаг шиг, зовлон эрж хайх юм уу, алдаршуулах, эсвэл түүнийг эпитимья - гийн хэлбэрээр ашиглах гэсэн үг биш юм. Энэ бол бидний сайн сайхан байдлыг дэндүү их онцолж үзэхээс зайлсхийсэнтэй адил тийм туйлшрал юм. Буддын байр суурь бол амьд бүхэнтэй, зовсон амьтадтай өөрийгөө адилтгах бодол хүслээс үүдэн гардаг юм. Ийм байр суурь бол бидэнд хувийн асуудлаа дөвийлгөхгүй, яльгүй зүйл хэмээн үзэхэд тустай.

“Кисаготамийн зам” гэдэг бол хүүхэд нь зуурдаар нас барсан залуу эх ийм үхэлтэй үл эвлэрч, хүүхдээ дахин амилуулах гэж Буддад авчирдаг ажээ. Будда түүний бодол сэтгэлийг ойлгож, ийм гуниг зовлон тохиож байгаа нь ганц чи бишээ гэж түүнд хэлжээ. “Хот яваад үхэл дайраагүй айлаас гичний хэдэн үр аваад ир” гэсэн ажээ. Тэр эх яваад эрж хайсан

боловч, тийм айл олдсонгүй гэнэ. Улмаар тэрхүү эх эл байдлыг ойлгож, Буддад эргэж ирээд хүүхдийнхээ цогцсыг түүнд үлдээгээд дотоод ертөнцийг таньж мэдсэн гэдэг. / “Важрадвхажа судар”- аас Шантидэва өөрийн “Шакмасаммучайе” хэмээх номондоо үүнийг иш татаж бичжээ. XVI /

Зовлон зүдгүүрийг ийм байдлаар ойлгох хэн боловч тулалдааныг бүхэлд нь биш юм аа гэхэд, хагаст нь ялалт байгуулж буй хэрэг юм. Будда бол зовлонгоос зайлсхийхийг сураагүй юм. Эс ингэсэн бол энэ эрин үед Дипангарууд замнаж байсан Ангижрах дөт замыг Будда сонгох байсан буй за. Түүний зам нь зовлонгоос ангижрах бус, зовлонг ялан дийлэх зам байсан юм. Иймээс Бурханы шашинтануудыг “Жин”- ууд буюу “Ялан дийлэгчид” гэж нэрлэж байсан бөгөөд тэдгээрийг амьд бүхэнд нийтлэг байдаг, өөр өөрийнх нь зовлон хэмээн үзэж байв.

Энэ утгаараа Бурханы ариун замаар замнахыг хүссэн хэнд ч гэсэн, Бодьсадвагын тангараг дараах зүйлд оршино. Үүнд: “Бүх зовлонгийн дарамтыг би өөрөө үүрье, тэрхүү зовлон гамшигийг би өөрөө авч явья. Би буцаж явахгүй, гүйхгүй, дагжин чичрэхгүй, айж мэгдэхгүй, найр тавихгүй, эргэлзэж тээнэгэлзэхгүй. Яагаад гэвэл, амьд бүхнийг Авралын замд оруулах гэдэг бол миний ам тангараг юм ... Амьд бүхэнд мэдлэг ухаан бадран гийж байхын төлөө би зүтгэж байгаа юм. Би зөвхөн өөрийгөө аврах бус, сансарын их далайгаас амьд бүхнийг аврах ёстой. Төгс оюут бие бүхнийг аврахыг эрмэлзэнэ.” / Мөн тэнд үзнэ үү. /

Авралын ийм байдалд хүрч очих гэдэг бол хувийн онцлогийн бүх хязгаарлагдмал байдлыг гэтлэн давах, биет болон хувийн ухаан бодлынхоо эрхэм дээд Бодит байдлыг ухаарч, ойлгоно гэсэн үг юм. Энэ бол хүний хүрч чадах хамгийн олон талт мэдлэг ухаан мөн бөгөөд бүр анхнаасаа энэ нь ийм олон талт байр суурьтай байхыг шаарддаг. Хамт амьдарч буй нөхдөө үл хайхран өөрийгөө аврахыг эрмэлзсэн, эсвэл дөт замаар зовлонгоос ангижрахыг хүссэн тэр хүн нь өөрийнхөө зорилго бодлыг хэрэгжүүлэх, нилээд сайн арга хэрэгслээсээ сална гэсэн үг юм.

Иймд хамаг амьтныг бодитойгоор аврах гэдэг асуудал нь хэлэлцэж судлах зүйл биш бөгөөд учир нь нэгдүгээрт, Бурханы шашинтаны хувьд “Бодит ертөнц” хэмээх юм байдаггүй, тэгээд ч бид зөвхөн өөрийнхөө таньж мэдсэн ертөнцийн тухай л ярьж чаддаг. Энэхүү ертөнц нь бясалгалд орсон хүнээс салангид байдаггүй ажээ. Хоёрдугаарт, “Ухааран бодохуй” гэдэг нь түр зуурын юм биш, харин дээд хэмжүүрийн эрдэм мэдлэг буюу цаг хугацааны гаднах мэдлэг ухаан юм.

Шакиамуни Бурхан багшийн Ухаарал нь хүн төрөлхтөний түүхийн нэгэн цаг мөчид бий болсон гэвэл, бидний ухаарлын үйл явцыг цаг хугацааны энэ мөчтэй хамааруулан үзэх ёсгүй билээ. Тэгээд ч Бурхан багшийн хэлсэнээр, түүний ухамсарт өнгөрсөн үеийн ертөнцийн тоо томшгүй, олон үе мөчүүд шингэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, үүнийг өнгөрсөн ба ирээдүй гэж нэрлэхээс үл хамаарах цаг хугацааны хязгааргүй чанар нь, түүний хувьд ямагт болж байдаг одоо цаг үе болдог ажээ.

Үргэлж хөгжин дэлгэрч байдаг цаг хугацаан дахь энэхүү үйл явцын үр дагавар нь, Бурханы оюун ухааны олон талт чанар буюу алс холын бодол сэтгэгдэл нь одоо ч байгаа нь мэдрэгддэг, бараг 3000 жилийн тэртээ асаасан Авралын билгүүний гал нь, гэрэл гэгээг шүтэгч амьд бүхэн оршин байх, тэрхүү цаг үеийн туршид хурц гэрэлтэж байгаа, гэрэлтэх ч болно.

Гүн ухаарлын төрх шинжинд нэгэн чанар байдаг бөгөөд энэхүү шинж чанар ёсоор биеллээ олсоны дараа, бодит биелэлд хүрэх замд ч, хүмүүст хүрч очих замд ч, тохиолдлын чанартай зүйл / зовлонгийн үндэс / байдаггүй. Яагаад гэвэл, Аврал нь хязгааргүй, сааршгүй цацарч байдаг нар адил бөгөөд бусдыг өөртөө татаж, өөрийн бие, өөрийн гэрлээ үзэж мэдрэх нүдний хараатай хэн бүхэнд, Гэрэл гэгээгээ хүртээж байдаг юм. Орчлон ертөнцийг хотол даяар нь бууршгүй гэрлээр гийгүүлэгч нар адил, амьд бүхний мэдрэмж, шинж чанарынх нь дагуу тэдгээрт янз бүрийн үйлдэл үзүүлдэгтэй адил, Гүн ухаарагч нь амьд бүхнийг үлдээлгүй хамардаг хэдий ч, бүгдээрээ нэгэн зэрэг ангижирч чадахгүй юм гэдгийг тэрээр мэддэг юм.

Гэвч түүний тарьж суулгасан Гүн ухаарлын үр нь эрт орой хэзээ нэгэн цагт, онцлог чанар бүхий хүн бүрт, боловсорч гүйцсэн үр жимсийг авчирч өгдөг байна.

Гэгээрсэн Бурханы хувьд, цаг хугацаа гэдэг бол орон зай адил хуурамч хэмжээ болохоор, тэрээр Гэгээрлийн дээд хязгаарт хүрээд хотол даяарыг аврах үйлсийг зөгнөж байдаг. Энэ бол Бурханы олон талт байдал, Бодьсадвагын ам өчгийн биелэлт мөн юм. Үүнд: Бүх үйлсийг бүтээн соёрхогч билгүүн ухаан бол Амогхасиддхи болно. Энэхүү бүхнийг үйлдэгч Билгүүн ухаан нь зүрх сэтгэл, оюун ухаан , энэрэл хайр, мэдлэг туршлагын нэгдэлд, хүн төрөлхтөний эрхэм дээд чанарт өөрийгөө бүрэн зориулахад, амьдралын зовлон гамшигийг хүлцэн тэвчиж, өөртөө түүнийг үүрч, дотоод бясалгалаа хэрэгжүүлэх хүчийг олоход эрмэлзэн тэмүүлэхэд л оршино.

Ум сайн амгалан болтугай.

Гарчиг

Нэгдүгээр бүлэг

УМ

БҮХ НИЙТИЙН ЗАМ

Үгийн ид шид ба өгүүлэхүйн хүч

Ум хэмээх ариун үгийн гарал ба нийтлэг чанар

Бүтээлч авианы үзэл ба вибрацийн онол

Мантрын уламжлалын уналт

Эртний Буддизмын мантрист хандлага

Буддизм амьд туршилага болох нь

Махаяны нийтлэг байр суурь ба бодьсатвагийн үзэл

Ум хэмээх ариун үгийн нийтлэг зам ба дахин сэргэлт

Хоёрдугаар бүлэг

МАНИ

НЭГДЭЛ, ДОТООД ЭРХИЙН ЗАМ

“Гүн ухааны чулуу” ба “мөнхийн рашаан”

Нагаржуна багш ба шидтэнүүдийн нууц алхими

Мани бол “Гүн ухааны чулуу” ба “прима матер”-ийн нэгэн адил оюун ухааны үнэт эрдэнэ мөн

Мани бол очир эрдэнэ мөн

Санаа ба матери

Таван скандха ба ухамсарын номлол

Ухааны хоёрдмол үүрэг (манас)

Ухамсарын гүн рүү хийх эргэлт

Бүхэл бүтний шилжилт, биелэлт

Гуравдугаар бүлэг

БАДМА

БҮТЭЭЛЧ ҮЗЛИЙН ЗАМ

Бадам цэцэг нь оюун ухааны задралын билэжг тэмдэг мөн

Тантрын хүнчлэх билэгдлийн ёс

Билэг ба хүч буюу Шактийн эсрэг Пражня

Важраяны билэгдлийн хэлэн дэхь арша, билгийн зарчмын туйл

Дотоод мэдрэмж бол бүтээлч бодит зүйл болох нь

Дхьяани таван бурхан ба таван билгүүн чанар

Төвдийн бясалгалын систем дэхь Дарь эх, Аксиобхья болон Вайрочана

Огторгуй, өнгө, язгуур махбод, мутра ба оюуны шинж чанаруудын билэгдэл

Бүтээж харах талыг удирдлага болгосон зуурдын ертөнц буюу Бардо тойдалын ач холбогдол

Дөрөвдүгээр бүлэг

ХУМ

ЭВЛЭН НЭГДЭХ ЗАМ

Ум, хум нь туршилагын нэмэлт үнэ цэнэ буюу метафизикийн билэгдэл

Буддизм ба Индуизм дахь сэтгэхүйн төвийн тухай сургаал

Огторгуй ба хөдөлгөөний зарчмууд

Кундалин йога дахь сэтгэхүйн төвүүд ба тэдгээрийн физиологийн тал

Сэтгэхүйн эрчим хүчний сургаал ба “таван бүрхэвч”

Пранагийн биений болон сэтгэхүйн үүрэг ба хөдөлгөөний зарчим

(вайю)

Хүний биен дэхь гурван гүйдэл ба тэдгээрийн сувгууд

Төвдийн бясалгалийн систем дэхь дотоод галын йога

Дотоод галын йога дахь бие, сэтгэцийн үйл явц
Дотоод галын йога дахь сэтгэхүйн хүчний төвүүд
Буддын системийн хүрдэн дэхь Дхьяаны бурхад, тарнийн үсгүүд ба язгуур махбодууд
Тарнийн үсэг "Хум"-ын билэгдэл нь таван билгүүн чанарын нэгдэл болох нь
Бясалгалын үйл явц дахь Дагинийн үүрэг ба тарнийн үсэг Хум
Бадсамбхавагийн авшиг хүртэлт
Видьядхарын мандал ба бясалгалын дээд үйлд орох нь
Бие, хэл, сэтгэлийн үйл ба Хум дахь Важрасаттвагийн дотоод зам
Тавдугаар бүлэг
УМ МА НИ БАД МЭ ХУМ
ҮЙЛДЭХҮЙН ЗАМ
Гурван биеийн онол ба бодит байдлын гурван түвшин
Майя бол ухамсарын хэмжүүр, бүтээлч зарчим
Нирманакайя бол боджилтийн дээд хэлбэр болох нь
Дхармакайя ба биеийн нууц
Их мантрын олон хэмжүүрт тал
Ертөнцийн зургаан оронд Авалокитешвара бууж ирэх нь
Пратитья-самутпата ба шүтэн барилдахын нэгдэл
Сансрын зургаан орны билэгдлийн зарчим ба Дхьяни таван бурхан
Маанийн зургаан үсэг ба зургаан орны харьцаа
Нэгтгэн дүгнэсэн төгсгөлийн бүлэг
УМ АА ХУМ
Үйлдэхүйн зам
Амогхасиддхи ялж төгс нөгчсөн бурхан
Амогхасиддхийн бүхнийг үйлдэгч билгүүн бол үйлийн үрийн хуулиас чөлөөлөгдөхийн адил болох нь
Бодисадвийн аймишиггүй зам

АНАГАРИКА ГОВИНДА

ТӨВДИЙН НУУЦ ТАРНИЙН ҮНДЭС

“УМ МА НИ БАД МЭ ХУМ” хэмээх агуу их мантрын эзотерик

сургаалын тайлбар

Орчуулагч У. Нямсүрэн. Э.Пунцаг

Ариутган шүүсэн Ш. Баясгалан

“Билгүүн судар” Хэвлэх үйлдвэрт хэвлэв

Lama A. Govinda

Foundations of Tibetan mysticism

{ according to the esoteric teaching of Great Mantra “Om mani padme hum” }

London

1959